


# ЖАЛХЫН ЦОРОНГИЙН *Амьд түүх*



WU

Халхын шоронгийн амьд түүх VI  
Зохиолч: Б.Ойдов

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

[www.bookstore.mn](http://www.bookstore.mn)

**Энэхүү номонд Халхын шоронд ял эдэлж байсан зуу гаруй хүний этгээд сонин үйлдэл, элдэв хачин адал явдалууд дурдагдсан бөгөөд зарим хүний нэрийг өөрчилсөн болно.**

**Зохиогч Б.Ойдов**

## **Соц нийгмийн үед мардай руу нэвтэрч чадсан ахмад хуульчийн яриа**

Социализмын үед орос ах нар Дорнод аймгийн Мардайд ураны томоохон үйлдвэр ажиллуулж байсан бөгөөд тухайн үед энэ үйлдвэрийн тухай ихэд нууцалдаг, тэр ч байтугай дотогш нь гадны хүн огт нэвтрүүлдэггүй байлаа. Тийм болоод ч тэр үү, цааз ял сонссон ялтануудыг Мардайн ураны үйлдвэрт ажиллуулдаг гэсэн яриа гарсан билээ. Зарим нь бүр өөрийн нүдээр харсан юм шиг «өнөө муу, алуурчин Батхүүг Мардайн ураны үйлдвэр лүү аваад явчихаж» гэж ирээд л цуурдаг байлаа. 1980-аад оны үеэс эхлээд иймэрхүү яриа их гарах болсон тул хуулийн түшмэд «Дээд хэмжээ авсан хүнийг Мардай руу явуулдаггүй. Тэднийг 24 цагийн дотор гүйцэтгэдэг» гэх зэргээр залруулга хийдэг байлаа. Гэтэл саяхан миний бие чөлөөнд гарсан ахмад хуульчтай уулзаад дээд хэмжээ авсан ялтануудыг Мардайн ураны үйлдвэрт ажиллуулж байсан тухай сонссон юм. Ингээд түүний яриаг сонирхуулья.

**-Мардайн ураны үйлдвэрийн тухай одоогийн залуус сайн мэдэхгүй. Тэгэхээр энэ үйлдвэрийн тухай товч дурдвал яасан юм бэ?**

-Мардай бол дээд зэргийн нууцлалын ангид багтдаг байсан. Учир нь оросууд эндээс цөмийн зэвсэгийн гол түүхий эд болох уран олборлож байсан юм. Яахав, нутгийн ардууд бол Мардайгаас оросууд баахан шороо зөөгөөд байна, тэр нь ямар учиртай юм бол гэдэг байсан. Энд ганц ч монгол хүн ажиллаж байгаагүй юм шүү. Мардайн ураны үйлдвэрийн оросууд өглөө ажилдаа онгоцоор ирж, орой онгоцоор буцдаг байсан. Уран бол цөмийн зэвсэгийн гол бүтээгдэхүүн гэдгийг мэдэхгүй хүн өнөөдөр байхгүй биз. Оросын Эрхүү мужид соц нийгмийн үед Ангарск гэдэг цэргийн хаалттай том хот байсан. Энэ хот руу жирийн орос иргэд хүртэл нэвгэрдэггүй онцгой объект байлаа шүү дээ. үүн шиг Мардай бол маш чанга хатуу харуул хамгаалалттай, тийшээ монголчуудыг огт нэвтрүүлдэггүй байлаа. Гэхдээ би нэг удаа нэвгэрчихсэн л юм даа.

**-Та яаж нэвгэрсэн юм бэ?**

-1980-аад оны үед Монгол, Зөвлөлтийн томоохон хэмжээний түшмэд Мардайд ажил хэргийн шугамаар очиход нь би дагалдаж явсан юм. Тэр үеийн Мардайн тосгон маш эмх цэгцтэй, алхам бүрт хатуу хяналттай газар байсан. Монголд байрлаж байсан Зөвлөлтийн мэргэжилтэн болон цэргүүдийн амьдардаг тосгоныг бодвол хамаагүй гял цал, эмх замбараатай байсан. Энд тогтоосон хатуу чанга хяналт алхам бүрт мэдрэгдэж байсан. Тухайн үед Монгол-Зөвлөлтийн томоохон хэмжээний төлөөлөгчид яагаад Мардайд очих болсон бэ гэвэл Дорнодын талын агаарын найрлагад ихээхэн өөрчлөлт гарч, хортой бодисууд их хэмжээгээр илэрсэн тухай дүгнэлтийг манай мэргэжлийн байгууллгууд МАХН-ын Төв Хороонд удаа дараа мэдээлсэн учир байдлыг нь газар дээр нь хамтран үзэхээр шийдсэн юм билээ. Ер нь атомын бөмбөгт ордог бодисууд агаарт их хэмжээгээр тархана гэдэг ямар аюултай нь ойлгомжтой. Ийм учраас манай талын шаргуу хүсэлтийн улмаас дээрх хамтарсан

арга хэмжээг зохион байгуулсан юм.

**-Мардайд ажиллаж байсан оросууд та нарыг хэрхэн хүлээж авсан бэ?**

-Хоёр улсын засгийн газрын хэмжээний арга хэмжээ болохоор сүйд болон угталгүй яахав. Харин надад янз бүрийн хүнтэй уулзаж элдэв юм асуухгүй байхыг хатуу анхааруулж байсан. Яагаад ч юм бэ, Мардан руу нэвтрэн ороход надад “Хуулийн дээд хэмжээ авсан хүмүүсийг энд авчирч ажиллууддаг гэсэн. Тэд байгаа болов уу. Тэднийг харах юмсан” гэсэн хачин бодол торж байсан. Энэ тухай орос нөхдөөс нууцаар асууя гэж хичнээн бодож байсан ч чадахгүй яваад л байв. Тэд энэ тухай надад үг алдахгүй нь мэдээж шүү дээ. Гэхдээ би Мардайд дээд хэмжээ авсан хүмүүс ажилладаг болохыг мэдэж авч чадсан шүү. Би бүр тэднийг нүдээрээ харсан.

**Та жаахан дэлгэрэнгүй яриач?**

-Бид үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцах маягаар газар дээр болон доогуур нэлээд явсан. Тэгэхэд үйлдвэрийн газар доорхи хэсэгт нэг л сонин хүмүүс ажиллаж байсан. Тэдний биеийн байдал, нүдний харц надад нэг л хачин харагдаж өөрийн эрхгүй «өнөө хуулийн дээд хэмжээ авсан хүмүүс чинь байна шүү дээ» гэсэн бодол төрсөн. Хажууд явсан Оросын мэргэжилтэн миний энэ байдлыг мэдээд Та энэ хүмүүсийг битгий хар. Бүү харьц» гээд намайг тэднээс нэн даруй холдуулсан.

**-Тэд Мардайн үйлдвэрийн ажилчин оросууд байсан байж болно шүү дээ?**

-Надад тийм бодол огт төрөөгүй. Харин өнөө л бодол толгойд эргэлдэж байсан. Хамгийн хачирхалтай нь газрын гүнд ажиллаж байсан эдгээр хүмүүсийн дундаас хэн нэгэн хүн бачимдсан дуугаар монголоор нэг юм хашгирч байсан. Гэвч үг нь цуурайндаа болоод сайн ялгарахгүй байсан. Яахын аргагүй монгол хүн монголоор хашгирсан юм шүү. үүнийг сонсоод миний өнөөх бодол бүр итгэл үнэмшилтэй болсон. Тэднийг удирдан ажиллуулж байгаа бололтой хэдэн хүн наана нь зогсч байсан. Зарим нь буу шийдэм барьчихсан ч байх шиг. Хэрвээ энгийн ажилчид байсан бол буу шийдэм барихгүй биз дээ. Ер нь тэнд ажиллаж байсан хүмүүс сүнс нь зайлчихсан юм шиг ихэд үхээнц царайтай, ядруу биетэй харагдаж байсан. Тэднийг хараад “Цаазаар авахуулах ялтай хүмүүсийг ураны үйлдвэрт явуулдаг нь үнэн юм байна” гэсэн бодол маань улам баталгаажих шиг болсон. Би ч гэсэн урьд нь иймэрхүү үнэн худал нь мэдэгдэхгүй юм сонсож яваад хөөрхий тэдгээр хүмүүсийг хараад итгэсэн. Энэ арга хэмжээний эцэст нэг орос нөхрөөс “Тэр газар дор байгаа хүмүүс монгол хүн мөн үү” гэж асуухад над руу нэг сүрхий харсанаа толгой дохиж байсан. Ер нь аливаа улс хуулийн дээд хэмжээ авсан ялтануудаа хүнд, хортой үйлдвэрт үхэн үхтэл нь ажиллуулж ялыг нь эдлүүлж байсан практик бий шүү дээ. Дээд хэмжээ авсан хүн ураны үйлдвэрээс хэзээ ч оргож чадахгүй, хэрвээ оргох өчүүхэн л алхам хийвэл өчиггүй буудуулж таарна. Тиймээс тэнд ажиллаж байгаад л үхдэг байсан болов уу.

**-Мардайд үзсэн харсан зүйлийнхээ тухай та тухайн үед бусдад ярьдаг байв уу?**

-Огт ярьж болохгүй. үүнийг надад хатуу анхааруулж байсан. Хэрвээ би энэ тухай хэн нэгэнд ярих юм бол улсын нууц задруулсан хэрэгт унаж таарна. Одоо бол өөр хэрэг. Хөөн

хэлэлцэх хугацаа дууссан. Тэр явдлаас хойш олон жилийн дараа би Мардайд очиход миний үзсэн юмнаас юу ч үлдээгүй шахам байсан шүү.

**-Та хуульч хүний хувьд Монгол улс хуулийн дээд хэмжээ авагсадаа хаана, хэрхэн шийтгэж байсан тухай эрх мэдэл бүхий хүмүүсээс асууж байв уу?**

-Мардайд харсан тэдгээр хүмүүс миний сэтгэлээс олон жил гараагүй. Биднийг явж байхад тэдний дундаас хэдэн монголын царай их хачин болцгоосон. Би хожим нь яг чиний асуусныг хуулийн зарим таньдаг нөхдөөс асуухад «Зарим хүний тогтоолыг 24 цагийн дотор гүйцэтгэдэг. Харин зарим хүнийг хаашаа ч юм бүү мэд аваад явдаг байсан. Бодвол тэр Мардай мэтийн тамын газарт аваачдаг байсан биз» гэж хариулж байсан. Тэгэхээр хуулийнхан хүртэл энэ тухай тодорхой мэддэггүй байсан юм билээ. Тэд бол хэргийг илрүүлнэ, шүүнэ, ял онооно. Харин хуулийн дээд хэмжээг төр өөрөө хаана хэрхэн гүйцэтгэдгийг тун цөөхөн хүн мэддэг бололтой. Ер нь дэлхийн олонхи оронд хуулийн дээд хэмжээг хэрхэн гүйцэтгэдгийг ихэд нууцалдаг юм билээ. Учир нь энэ бол ард түмэн, нийгмийн сэтгэхүйд сургамж дохио болохоосоо илүү цочроон хилэгнүүлэх, нийгмийг эмх замбараагүй байдалд оруулах нөлөө үзүүлж болзошгүй учраас тэр.

## Чойрогийн Дүгэрээ болбоос туйлын өрөвдөлтэй бие хүн бөлгөө

34 шоронд суусан алдарт Чойрогийн Дүгэрээг эрүүгийн ертөнцийнхөн «Монголын залилангийн ертөнцөд цагийг эзэлсэн суут сартваахи» хэмээн хүндэлдэг ажээ. Тэрбээр өнгөрөгч хавар Амгалангийн шоронгоос суллагдмагцаа хүүгийнхээ эрхэлдэг «Асмо пресс» компаний гүйцэтгэх захирал болж, таван мянган ногооноор машин авч унаад үнэхээр цоглог явсан билээ. Гэтэл мань эр саяхан дахиад л шоронгийн хаалга татах нь тэр. Алдарт Чойрогийн Дүгэрээ шүүхээс нэг жил 11 сарын ял сонсож «Ганцхудаг» руу ачигдлаа. Ачигдахдаа бас дуугүй байсангүй. Тухайлбал «Би төр засагтаа баярлаж явдаг юм шүү. Намайг Улаанбаатарын энэ их угаанд хордчихно гээд дандаа хотын захад байрлуулж, бас өс хонзонтой есөн шидийн хүмүүс хорлочих вий гээд үүдэнд нь харуул манаа тавиад төрийн хамгаалалттай буруу хойшоо харсан өрөөг 35 жил үнэ хөлсгүй эзэмшүүлсэн. Одоо дахиад л нөгөө өрөөндөө нэг жил арван нэгэн сар байлгах нь. Ер нь надад энэ 11-ын тоо иж харшилтай» гэж мэдэгдэв. «Төр засагтаа баярлаж явдаг» гэдэг үгийг тэр жаахан гоморхсон утгаар хэлэв бололтой. Харин өнгөрөгч хавар арай өөр утгаар хэлж байсан шиг санагдаж байна. Тухайлбал «үнэнийг хэлэхэд маш их хөдөлж байж амьдрахгүй бол болохгүй нь. Одоо би дандаа зөвөөр амьдарна. Буруу юм нэг ч хийхгүй. Би энэ төр засагтаа гомддоггүй. Төр засаг маань намайг өдий зэрэгтэй өсгөж хүмүүжүүлсэн. Намайг гарын уртай, авьяастай, чадалтай гэж хүмүүс ярьдаг. Хэрэв тийм л юм бол миний эх орон, миний төр засаг одоо намайг ашиглах хэрэгтэй. Би төр засагтаа нэг ч гэсэн сайн юм хийчихье гэсэн бодолтой явж байна. Эх орон хаанаас эхэлдэг вэ? гээд ярьдаг шүү дээ. Эх орон ерөөсөө надаас л эхэлнэ. Би л зөв явбал болох нь тэр» гэж ирээд л авч өгч байлаа. үүний дараахан надтай тааралдаад «Би эртээд чамд зөв явна гэж хэлж байсан байх аа. Ямар сайндаа л би сая шинэ гар утас худалдаж аваад гаднаас дуудах дуудлаганд нь «Зөв явбал зөөлөн зөөлөн замбуулин» гэдэг дууны үгийг суулгаж байгаа юм. Одоо над руу залгасан хүн болгон «Зөв явбал зөөлөн зөөлөн замбуулин» гэдэг дууг сонсох болно. Юуны чинь нөгөө буруу замын Дүгэрээ. Амьхандаа би зөв явах гээд байна шүү дээ. «Зөөлөн зөөлөн замбуулин»-г манай Увс нутгийн хүү Жавхлан дуулдаг юм байна. Энэ хүүхдийг би хүндэлж дууг нь сонсдог. Аз байвал уулзах биз. Ерөөсөө би их оройтож зөв зам руугаа орж явна. Одоо 57 настай. Нийтдээ 34 жил шоронд суучихлаа шүү дээ» гэж билээ. Саяхан тэр өдүүлсэн гэмт хэргийнхээ талаар хуучлахдаа «Би хувийн унаа хөлслөн компанийнхаа тавилгыг ачиж яваад нэг жолоочтой зам булаацалдаж маргалдсан юм. Хотын замд өдөр болгон л болж байдаг маргаан шүү дээ. Дараа нь бид эвлэрээд би нөгөө жолоочоосоо уучлалт гуйж хэдэн төгрөг өгсөн. Захиргааны хариуцлагын хуулиар 5000 төгрөгөөр торгуулаад энэ хэрэг хаагдсан юмсан. Гэтэл прокурор нь энэ Дүгэрээгийн хэргийг яагаад хаадаг билээ, сэргээ гээд эхлээд 180-ын нэг гэж зүйлчилж явсанаа сүүлдээ 181-ийн гурав болгосон. Чулууг зэвсэгийн чанартай ашиглаж хохирогчийн эрүүн тус газар нь цохьсон гэсэн ялын дүгнэлт бичигдсэн. Гэтэл хавгаст хэрэгт тийм нэг ч үг, өгүүлбэр байхгүй. Нөгөө хохирогч нь хүртэл шүүх хурал дээр «Дүгэрээ намайг чулуугаар цохиж барьсан юм байхгүй» гэсэн. Тэгтэл прокурор «Чи Дүгэрээгээс хэдэн төгрөг авчихаад ингэж хэлж байгаа юм бэ» гэж зүтгэсээр байгаад хорих ял өгчихлөө. Одоо ингээд ачигдах нь. Гэхдээ ах нь давж заалдана» гэж байлаа. өнгөрөгч хавар мань эр хуульчдыг овоо магтаж байсан. Тухайлбал «Хуулийнхан чинь бас дандаа тийм харанхуй бүдүүлэг хүмүүс байдаггүй юм байна. Бас их гэгээлэг, ухаалаг айхтар улс. Нийслэлийн прокурорын Төмөрчөдөр, Баянзүрх дүүргийн шүүхийн дарга Цогтзандан гэх зэрэг ухаалаг хүмүүс надад амьдрал хайрлалаа. Намайг таван

сарын өмнө сулласан. Сайхан амьдраарай гэж ерөөсөн. Би сайхан амьдарна гэж бодож байгаа. Би шоронгоос суллагдаад ердөө гурав дөрөвхөн хонож байна. Тэгтэл би хоёр хоногийн өмнө хэвлэл, худалдаа үйлчилгээний «Асмо пресс» компаний гүйцэтгэх захирал болчихоод явж байна» гэж ярьж байлаа. Харин эдүгээ хуульчдад жаахан сэтгэл дундуур үлдэв бололтой. Хэрэгт орохоос нь өмнө түүнтэй тааралдахдаа «Та хэрвээ Манжийн үед төрсөн бол жинхэнэ шилийн сайн эр байж чадах байсан уу?» гэж асуухад «Чадах байсан. Муусайн ноёд баядыг толгойг нь эргэтэл луйвардах байсан. Тэр есөн ембүүг нь дуурайлгаж хийх байсан. Манжийн хааныг хүртэл залилах байсан. Тэр ч байтугай Манжийн хааны тамгыг хуурамчаар үйлдээд Бээжинд очиж хятадуудыг луйвардах байсан. Манай монголчууд их сонин. Шоронд орохыг дэмждэггүй. Тэгсэн мөртлөө эртний уламжлалаа дагаад шилийн сайн эрсээ бас их хүндэлдэг. «Цахиур» Төмөр, «Тоорой» Бандийгаа их хүндэлдэг. Эд нар чинь яс юман дээрээ адууны хулгайч л шүү дээ. Ноёд баядыг тонодог байсан болохоор нь ард түмэн хайрладаг байж. Тэгтэл өнөө цагийн Чойрогийн Дүгэрээ сайд дарга, ноёд баядыг луйвардчихсан байхад шилийн сайн эр гэж хүндлэгддэггүй. үүгээрээ их ялгаатай» гэж билээ. Тэрбээр олон удаагийн залилангийн хэргээр 34 жил шоронд суухдаа хэд хэдэн хүний ялыг үүрсэн ч эргээд хэн нь ч түүнд тус дэм болоогүй гэдэг. Энэ тухай тэрбээр «Би мөнгө олж байсан ч одоо эргээд бодоход дандаа бусдад зарцуулж, олон хүнийг амьдралд нь залгуулж олон айлыг хөл дээр нь босгосон байдаг. Харин ялыг нь би л үүрдэг байлаа» хэмээн шүүрс алдаж байхыг би олон удаа харсан. Түүний эрт цагийн хам хэрэгтэн Мягмарсүрэн, Бямбагарав нар ч үүнийг нь нотлон ярьдаг байлаа. Ялангуяа түүний «Эрдэнэт» үйлдвэрээс залилсан их хэмжээний мөнгөнөөс хам хэрэгтэн Мягмарсүрэн, Бямбагарав, Цогтбаяр нар хангалттай хүртсэн байдаг. Тухайн үед Чойрогийн Дүгэрээ Цогтбаяр гэгчид хөргөгч, угаалгын машин, өнгөт зурагт, шарах шүүгээ зэргийг өгч сайхан айл болгожээ. Гэтэл түүнийг шоронд ороход Цогтбаяр огтхон ч харж үзээгүй гэдэг. Энэ мэтээр тэр олон хүнийг баяжуулсан гэдэг билээ. Тэрбээр «Голомт», АПУ, «Эльба» зэрэг том том байгууллагаас өч төчнөөн сая төгрөг луйвардсан хирнээ эцэст нь өөрөө хов хоосон хоцорсон байдаг. Луйвардсан тэр их мөнгөөрөө ганц байр байтугай хоосон хашаа ч өөртөө наагаагүй байдаг нь хачирхалтай. үгүй ядахнаа өөртөө ганц «Эксел» машин аваад үлдэж байсан түүх байдаггүй. 2000 оны үед үйлдэгдсэн нэг хэрэгт гэхэд л НИК концернээс 20 тонн дизель масло авсан байгаа юм. Гэхдээ Зоригбат гэдэг залуу эхнэртэйгээ ирээд түүнийг хатгасаар байгаад авахуулжээ. Ингээд Дүгэрээ хадамынх нь гадаа 104 поошиг масло буулгаж өгсөн ч эргээд тэднээс нэг ч кг масло авч чадаагүй байна. Учир нь Зоригбат зарсаар байгаад найман поошиг масло үлдэнгүүт цагдаад очоод «Дүгэрээ гэдэг нөхрийн залилангийн юмыг зарж байснаа би сая л мэдлээ» гэж үнэнч царайлаад муу нэртэй луу данстай Чойрогийн Дүгэрээгийн халуун чихийг цагдаагийнханд атгуулчихсан гэдэг. Ингээд л тэр огт идэж уугаагүй хэргийнхээ ялыг үүрчээ. Тэгэхдээ Зоригбатыг хам хэрэгтэнээр татсан байна. Гэтэл нэг өдөр мань хоёрын хэргийг мөрдөж байсан байцаагч нь «өнөө муу Зоригбатын эхнэр сэтгэл санаагаар унаж зүрхний хууч нь гэнэт хөдлөөд мэс засалд орсон ч даалгүй өнгөрчихөж. Харин Зоригбат өөрөө согтуу машин барьж яваад осолд орж хоёр хөлөө хугалчихаад хэвтэж байна» хэмээжээ. Энэ нь Дүгэрээгийн өрөвчхөн сэтгэлийг хөндөж орхижээ. Тэгээд тэр «Эхнэр нь үхээд өөрөө хөл гар нь хугарчихсан юм бол тэр мууг хэрэгт чирээд яахав» гээд хэргээ ганцаараа даагаад шоронд орсон байх жишээтэй. өнгөрөгч хавар тэрбээр шоронгоос суллагдаад «Зоригбаттайгаа нэг уулзъя, амьдрал нь ямар яваа бол» гээд НИК-ийн өр барагдуулах тасгаас хаягийг нь аваад гэрт нь очтол нөгөө үхсэн гээд байсан эхнэр нь хаалга тайлж өгсөн гэдэг. Харин нөгөө Зоригбат нь огт тоосон шинжгүй «Ингээд хоёулаа хэн хэндээ хал балгүй салья даа» гээд түүнийг илт түвэгшээсэн байдалтай гэрээсээ

гаргаад хаалгаа дан хийгэл түгжсэн байгаа юм. Уг нь Дүгэрээг шоронд суулгасан 108 поошиг маслын 96-г нь Зоригбат зараад идчихсэн хүн шүү дээ. Энэ мэтээр хам хэрэгтэнүүдийнхээ хэргийг ганцаараа даагаад өнгөрсөн олон тохиолдол байдаг аж. Эцэст нь түүнд тохиолдсон ядал явдал, гэмт үйлдлийг ерөнхийд нь багцлаад хэлье. Анх тэр 1973 онд мотоцикль хулгайлж гэмт хэргийн ертөнцөд хөл тавьжээ. Түүнд эцгээс нь уламжилсан гарын ур дуй, жаахан хэтийдсэн овсгоо, гярхай ухаан, гандан бууршгүй ой санамж, хоёр гурван алхмын цаадахыг харчихдаг сэргэлэн чанар заяасан бөгөөд ямар сайндаа л хулгайлсан 17 мотоциклио хаанаас, хэний хэнээс авсан болохоо овог нэр, удам судартай нь, хулгай хийсэн он, сар, өдөртэй нь мөрдөн байцаагчид яг таг мэдүүлж байсан гэдэг. үүний дараа «Дүгэрээг шоронгоос чөлөөл» гэсэн хуурамч бичиг баримт үйлдэж дөрвөн сарын турш ял янханаас оргосон байдаг. Мөн нэг удаа ЗИЛ-130 машин хулгайлж дээд хэмжээ сонсож байсан боловч цаазын өрөөнд 93 хоноод амь хэлтэрсэн. За тэгээд «Сансар» Нацагдоржтой хамтарч төрийн тамга хуурамчаар үйлдсэн. Мааньтын шоронгоос найман хүний хамт оргож улс орон даяар томоохон дуулиан дэгдээж байсан. 25 мянгатын хэргийг илрүүлэхэд чухал сэжүүр гаргаж өгсөн тул цаазаар авхуулахаас мултарч байсан. Солонгосын визийг хуурамчаар үйлдэж Эрүүгийн хуулийн тусгай ангийн 157-р зүйлээр шийтгэгдэж даалтанд байх хугацаандаа төлбөрийн даалгавар хуурамчаар үйлдэж «Голомт», «АПУ», «Элба», «Хөх чоно», «Мон Ази» компаниудын тамгыг ялгахын аргагүй дууриалган сийлж боломжийн мөнгө тоншсон. Гэвч тэр мөнгөнөөс өөртөө юу ч үлдээгээгүй. Түүнээс илүү зальтай хүмүүс Чойрогийн Дүгэрээг тойрон хүрээлж байсан тул хамаг мөнгө нь зальтнуудын гарын салаагаар урсаж муу нэртэй луу данстай Дүгэрээд хамаг хэрэг тохогдсон. Нэгэн цагт тэрбээр «Ганц худаг»-ийн эмч Оюунсүрэн гэдэг бүсгүйтэй амьдралаа холбож байлаа. Гэвч ялтан хүнтэй янаг амрагийн холбоо тогтоосон гэдэг шалтгаанаар шоронгийн удирдлага эхнэрийг нь ажлаас халж байлаа. үд хэвийсэн насандаа үрийнхээ зулайг үнэрлэж ухамсартай амьдарья гэсэн бодол сэтгэл түүнд дүүрэн байсан боловч бүтээгүй. Монгол улсынхаа хуулийг дээдэлж яваарай! гээд хүүдээ Шихихутаг гэдэг нэр өгсөн. Мод, чулуу сийлэх гарын ур чамгүй хөгжсөн болохоор эзэн Чингис хааны хөшөөг таван метрийн өндөртэй, есөн өрлөг жанжинтай нь бүтээхэд шаардагдах 20 сая төгрөгийг төр засгаасаа хүсэмжлэн, төсөл тооцоогоо бариад гутлынхаа улыг ханзартал хөөцөлдсөн боловч тусыг эс олсон. Харин 1998 онд Эдийн засгийн цагдаагийн алба байгуулагдсаны 60 жилийн ойн эмблемийг модон дээр товойлгон сийлээд түр хугацаагаар даалтанд гарч байсан удаатай. Төлбөрийн даалгавар хуурамчаар үйлдсэнийхээ дараахан Хятадын Эрээн хотод явж байгаад захиалгаар хүн алахаар завдаж байсан сүх барьсан хоёр монгол этгээдтэй учирсан гэдэг. Энэ тухайгаа цагдаагийнханд ирж мэдэгдсэн боловч түүний үгийг тоож авч хэлэлцээгүй. Халхын шоронгийн түүхэнд хамгийн бүтэлгүй орголтонд тооцогддог Мааньтын орголтыг тэр бас зохион байгуулсан. Оргосон хоригдолуудын тухай гардаг «Түгшүүрт шөнө» хэмээх киног түүний амьдралаас сэдэвлэсэн билээ. Иймэрхүү маягаар тоочоод байвал түүнтэй холбоотой янз бүрийн адал явдал улам бүр сөхөгдсөөр бүхэл бүтэн ном болно. Ямар сайндаа л өөрийнхөө тухай ном бичүүлэхээр надад хандаж гурван кассет дүүрэн бичлэг илгээчихээд байлаа. «Та өөрийнхөө дурсамжийн номыг гаргах гэж байгаа гэл үү?» гэсэн сурвалжлагчийн асуултанд тэрбээр «Тиймээ. Нэг сэтгүүлчтэй хамтарч өөрийнхөө тухай ном гаргах гэж байгаа. Дурсамжийн ном гэх нь хаашаа юм бэ дээ. Гэхдээ дурсамж л юм даа. 34 жил шоронд суусан Чойрогийн Дүгэрээгийн дурсамж дан хар бараан байх болов уу гэж хүмүүс бодож магадгүй. Надад чинь бас гэгээн сайхан дурсамж байлгүй яахав. Чойрог гэдэг хүний өргөмөл хүү болохоос эхлээд ямар замаар явсан, яаж сургууль соёл төгссөн, яаж алдаж хазгай гишгэсэн, ядаж хэргээ хийж байхдаа



хүртэл ямар системээр гүйцэлдүүлсэн гээд ярих юм их байна. Би чинь зүгээр нэг тохиолдлын хармаа ухдаг хүн биш шүү дээ. Ер нь зүгээр түүхийг минь бичих юм. Энэ бол гавьяа биш. Гэхдээ залуус уншаад ингэж явбал алддаг юм байна, амьдралын өчнөөн жил ингэж үрэгддэг юм байна гэдэгт бас нэг санамж авчих болов уу» гэж хариулж байлаа. Одоо энэ нь бас л бүтэхгүй тийшээ хандлаа. Ер нь түүний хийж бүтээе гэсэн санаа сэдэл ерөөсөө бүтэж байсан түүх байдаггүй. Ингээд бодоход Чойрогийн Дүгэрээ гэдэг хүн туйлын өрөвдөлтэй бие хүн бөлгөө.

## Соц нийгмийн үеийн шоронгийн цуутай дарга нар

Харин өнөөгийн шоронгийн дарга болон ялтануудыг улсаас тусламж горьдсон арчаагүй сүгнүүд болсон тухай учир мэдэх хүмүүс ярилцдаг. Харин дээхэн үеийн шоронгийн дарга нар ялтануудаар үнэхээр ажил хийлгэж чаддаг, өөрсдөө ч ажилч хичээнгүй сүрхий улс байжээ. Тухайлбал 1980-аад оны үед Мааньтын шоронгийн дарга Лувсанпэрэнлэй гэж хурандаа байсан бөгөөд энэ хүн жинхэнэ үйлдвэрлэлийг хөгжүүлэх, улс орондоо хувь нэмэр оруулах, хоригдолуудыг жинхэнэ хөдөлмөрөөр нь засч хүмүүжүүлэхийн төлөө ажилладаг байж. Тийм ч учраас тухайн үед шоронд байсан хүмүүс «Лувсанпэрэнлэй хурандаа бол агуу хүн. Монголын шоронд Лувсанпэрэнлэй хурандаа шиг хүн дахиж хэзээ ч төрөхгүй. Тэр бол хуулийг жинхэнэ ёсоор сахиж биелүүлдэг, ялтан хүнийг ямар цагт нь шийтгэж, ямар цагт нь хайрлах вэ гэдгийг мэддэг хүн байсан» гэж бахархан дурсах нь олонтаа. Мөн тухайн үед Дорж хэмээх хурандаа байжээ. Энэ бас л лут хүн байсан бөгөөд хоригдолууд, албан хаагч нартайгаа ямар үед нь яаж харьцах, яаж тэднийг номхотгох, хааяа бас хоригдол биш хүн гэдэг утгаар нь яаж хамгаалах вэ гэдгийг мэддэг хүн байж. Одоо цагт сав л хийвэл хүний эрх гэж солиордог болж. Харин ч дал наяд онд жинхэнэ хүний эрхийг хамгаалдаг газар бол Засан хүмүүжүүлэх байгууллага байсан гэдэг. Тухайн үед ял эдэлж байсан дөч гаруй насны нэг эр ярихдаа «Засан хүмүүжүүлэх байгууллагуудыг удирдах газарт Содном гэдэг генерал байлаа. Энэ хүн бол Монгол улсад маш их юм хийсэн. Энд тэндэхийн шоронгийн хашаанд өрнөдөг байсан бүхий л үйлдвэрлэлийг Содном генерал удирдан зохион байгуулж байсан юм. Энэ хүн Засангийн удирдах газрын дарга хийж байхдаа бүх шоронгийн дарга нарыг гарынхаа арван хуруу шигээ мэддэг, захирч чаддаг, тэд нараараа юм хийлгэж чаддаг, шаардлагатай нөхцөлд өөрийн биеэр шоронгуудад очиж биеэрээ шалгадаг байсан. Тэр үеийн хуяг дарга нар ч тэр, хулгайч нар ч тэр жинхэнэ эр хүн байсан юм. өнөөгийн хоригдолын зарим нь хоригдол ч юмуу, энгийн хүн ч юмуу, бүү мэд жигтэйхэн ганган үнэтэй өмд, гутлаар гоёж гоодоод зогсохгүй үнэтэй утас өвөртөө хийчихсэн цохиж явна. Бүхнийг мөнгө төгрөг рүү чиглүүлсэн шуналтай дарга нар л ялтан хүнийг ингэж давраулдаг юм даа» гэсэн юм. 1980-аад оны үед Авдрантын гяндангийн дарга Дашхорлоо гэж хошууч байсан бөгөөд тэрбээр маш их хөдөлмөрч, маш шударга хүн байж. Дашхорлоо дарга хоригдлуудад хандаж «Та нар хамгийн хүнд гэмт хэрэг хийчихээд тэгээд бас ард түмний мөнгөөр гэдсээ цатгуулаад ингээд сууж байна гэж битгий горьдоорой» гэж зандардаг байж. Нэг талдаа ингэж зандардаг ч гэсэн нөгөө талдаа гяндангийнхаа хоригдолуудыг хараад өрөвддөг байсан гэдэг. Турж эцсэн, өдөр шөнөгүй хоол цай бодсон, хагас өлсгөлөн байдаг хүмүүсийг хөдөлмөрт оруулаад, тэгээд жаахан хоол ундан дээр нь урамшуулал өгөөд ирэхээр сэтгэл нь сэргээд ирдэг байжээ. Ямар сайндаа л гурван жилийн дараа гарах гэж байсан хоригдолын урам сэргэж жил зургаан сар чулуу өнгөлөөд шоронгоос суллагдаж байсан гэдэг. өнөөдөр ийм л юмыг буцаагаад сэргээмээр байгаа юм. Хуучин Засангийн дарга нарын зарим нэг нь тэтгэвэрт гарсан л байх. Энэ хүмүүс засангийнхаа удирдах газарт цугларалтанд ирдэг бол үгээ хэлэх хэрэгтэй. Мөн Ганбат хэмээх сүрхий хурандаа байжээ. Түүний гар дээр хүмүүжсэн зарим хүн Ганбат даргыг Засангийн удирдах газар байтугай шоронд ороод гарсан хүн болгон мэднэ. Тэр бол жинхэнэ эр хүн байлаа» гэж онцолдог. 1980-аад оны үед Зүүнхараагийн чангад «Мангар улаан» Даваадорж хэмээх ялтануудаар жинхэнэ ажил хийлгэж чаддаг сүрхий хянагч байжээ. Гэвч мань хянагчийг нэгэн цагт гяндангийн атаман байсан Дарханы Нямсүрэнгийн өлзийхишиг хэмээх цуутай ялтан нам цохиж унагасанаар Даваадорж нь мэдрэлийн өвчтэй болж

албанаасаа халагдсан гэдэг. Мөн соц нийгмийн үед Засангийн зам ангийн дарга хийдэг байсан «Хар» Бухаа гэгч өндөр бүдүүн эр ялтануудыг жинхэнэ язгануулж байсан гэдэг. Энэ тухай Яармагаас тодорсон Э.Борхүү өгүүлэхдээ «Нэг өдөр Засангийн зам ангийн дарга «Хар» Бухаа гэгч мундаг эр «Эрхэмбаярын Борхүү гэж ямар ялтан байна аа» гэсээр орж ирсэн. «Би байна» гэтэл «За, намайг дагаад явна аа. Авах юм байвал аваад ир» гэлээ. Баасангийн Жанцан миний тухай Бухаад «Хүн удирдах чадвартай сүрхий ялтан байгаа юм» энэ тэр гэж баахан ярьсан юм билээ. Тэгээд л тэр намайг сонирхсон хэрэг. Тухайн үед «Бухаагийн отряд» гээд 80 гаруй ялтантай сүрхий отряд байсан юм. Намайг авч явдаг яг тэр үед Бухаагийн отряд «Дунд хориуд»-ын гүүрийг барих гэж байсан. «Дунд хориуд» гэдэг нь Хэрлэнгийн гүүрний доохон талд байдаг гүүр шүү дээ. Энэ гүүрийн нүсэр ажлыг «Хар» Бухаа л эрийн сайнаар нугалсан юм даа» гэж билээ. Бас «Эцэг» Шархүү гэдэг хүний тухай яригддаг. Гэхдээ Шархүү нь шоронгийн дарга биш харуул хамгаалалтын дарга хийдэг байж. «Эцэг» Шархүү нь задарсан ялтаны хандыг хага дардаг, ядарсан ялтаныг өрөвдөөд дээш нь гаргаад ирдэг. Тэр хоригдол нь дээшээ гарч ирээд ор лүү нь өшиглөх юм бол нэг мөсөн доош нь хийж чаддаг хүн байж. Энэ ч утгаараа 70, 80, 90-ээд оны хоригдолууд Шархүү хошуучийг «Эцэг» гэдэг байжээ. Мөн тухайн үед «Майга» Төмөрбаатар хэмээх хошууч алба хааж байсан бөгөөд түүнийг «Ганц худаг»-ийн шоронд гяндангийн дарга хийж байх үед халхын сайн эрчүүд сүнсээ зайлтал айдаг байсан гэдэг. Жараад оны үед Хамгаалах гарнизоны Далай гэгч хурандаа ид мандуулж явсан гэдэг. Тэрбээр Монголд анх онцгой дэглэмийн шорон байгуулагдахад үнэтэй хувь нэмэр оруулсан бөгөөд тэрбээр энд тэндхийн шоронгуудаас хэрцгий зан чанартай 88 хоригдолыг онцгой дэглэмийн шоронд түүж авчираад жинхэнэ номонд нь оруулж байсан гэдэг. Эцсийн эцэст юу хэлэх гээд байна вэ гэвэл төр засгийн эрхэмүүд ард түмэнд, ялангуяа залуучуудад хуулийг их сайн сурталчилах хэрэгтэй болсон байна. Шоронд ял эдлээд гарч ирж байгаа хүмүүс дахин дахин гэмт хэрэгт ороод байгаа нөхцлийг хааж боох талын юм хийх нь зүйтэй мэт. Хааж боох гол асуудал нь юу вэ гэхээр эрхлүүлээд байгаа ялтануудаа жаахан диктатуртай болгох хэрэгтэй. Шоронд ял эдэлж байгаа хүмүүстээ хууль эрх зүйн мэдлэг олгож, зарим чухал хуулийг бүр зааж өгч цээжлүүлээд гаргасан ч болохгүй гэх газаргүй. Соц нийгмийн үед арав гаруй жил шоронд суусан нэг эр ярихдаа «Би арван хэдэн жил шоронд суугаад гарч ирсэн цагаасаа хойш шоронд орвол эргээд арван хэд орчих хугацаа боллоо. Тэгтэл яасан гээч. Соц нийгмийн үед Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль, Монгол улсын эрүүгийг хууль, Монгол улсын хөдөлмөрийн хууль гээд шувтан хуулиар лантуудуулаад, нүдүүлээд цээжилсээр байгаад гараад ирчихсэн хүн чинь яах юм бэ. Тэгвэл шоронд орчихно, ингэвэл гэмт хэрэгт орчихно гээд ердөө өөрийгөө сэрэмжилдэг болчихдог юм байна. өнөөгийн ялтануудад ийм хүмүүжлийг олгож гэмээнэ Монгол улсад гэмт хэрэг багасна» гэж онцолсон юм.

## **Атамануудын тэмцлээс болж Авдрантын шорон татан буугдсан уу?**

Авдрантын шоронгийн ялтануудыг хоёр хэсэг хувааж, нэг хэсгийг нь Булган аймагт, нөгөө хэсгийг нь Дарханд цөлчихөөд байгаа. Аль соц нийгмийн үеэс эхлээд олон жил оршин тогтносон Авдрантын шорон татан буугдах болсон шалтгааныг хүмүүс олон янзаар тайлбарлаж байна. Нэг хэсэг нь «Авдрант хавийн чулууны нөөц дууссан тул ялтанууд хийх ажилгүй болсон. Ажлын фронт байхгүйн улмаас тус анги татан буугдахад хүрсэн» гэхэд нөгөө хэсэг нь «Авдрантын шоронд олон жилийн турш амь бөхтэй зууралдсаар байгаа атамануудын тэмцлийг таслан зогсоохын тулд тус ангийг татан буулгасан байгаа юм. Ийм явдал Халхын шоронгийн түүхэнд хэд хэдэн удаа тохиолдсон» гэх зэргээр ярьж байна. Юутай ч Авдрантын шоронд ял эдэлж байсан нэрээ нууцлахыг хүссэн нэг эрийн яриаг сонордуулья.

**-Авдратын шоронд хэд хэдэн ноцтой аллага гарсан. Тэнд ял эдэлж байсан хүмүүс нарийн ширийнийг нь сайн мэдэх байх. Ямар өш хонзон байдаг юм бэ? Эсвэл бие биенээсээ атаманы суудал булаацалддаг юм уу?**

-Монгол улсад жирийн дэглэм, гяндан гээд байж байгаа. Харин онцгой дэглэмийн шорон бол ерөөсөө ганцхан байдаг. Тэр нь Авдрант. Энд өстөн дайсан хоёр нэг дор амьдарч байна. Нэгийг нь зайлуулаад өөр тийш нь аччихна гэсэн юм байхгүй. Тиймээс ноцтой аллага гаргахад хүргэж байгаа юм. Онцгой дэглэмийн шоронд 20-30 жилийн ялтай, хэзээ гарахаа мэдэхгүй хүмүүс хутга, шөвгөөр зэвсэглэж явдаг нь нууц биш. Наранд хэзээ гарах нь мэдэгдэхгүй, амьдаръя гэсэн итгэл байхгүй. Ийм болчихсон хүмүүс тэнд байдаг. Ер нь онцгой шорон гэдэг байх ёстой юм уу? үгүй юм уу? гэдгийг манай хууль хяналтын байгууллагууд бодох л асуудал. Яагаад гэвэл онцгойд хоригдож байгаа ялтануудыг рецидив хүнд гэмт хэрэгтэнүүд гэж үздэг л дээ. Гэтэл үүнээс дутахааргүй гэмт хэрэг хийсэн хүмүүс жирийн дэглэмтэй шоронгуудад зөндөө байдаг. 20 жилийн ялтай гэмт хэрэгтэн байлаа гэхэд таван жилийг нь гянданд эдлээд, 15 жилийг нь чангад эдэлнэ гэж заадаг. Гэтэл хугацаанаасаа өмнө гяндангаас суллагдахаар нөгөө ялаа онцгойд эдлээд үлдсэн ялаа чангад эдэлдэг. Ингэхэд ер нь онцгой дэглэм гэдэг нь байх нь зөв юм уу? буруу юм уу? Чангад рецидив болон хүнд ноцтой хэрэгтнүүд байж л байгаа юм чинь. Гэтэл Авдрант гэдэг газар “онцгой” гэдэг газар байгуулчихаад, тэнд хүмүүсийг ямар ч амьдрах итгэлгүй болгочихоод байгаа юм. Онцгойд хорих ялынх нь бодлого өөр байдаг шүү дээ. Эмнэлэгт хэвтэнэ гэхэд газрын даргаас зөвшөөрөл авдаг. Энэ нь маш хүнд сэтгэлийн дарамт болж байгаа юм. Онцгой шоронд байгаа хүмүүсээс хамгийн анх аллагад өртсөн нь “Бүдүүн” Нармандах гэдэг сайхан залуу байсан. үүнийг өмнөговийн “Нохой” Равжих гэдэг залуу алсан. “Бүдүүн” Нараа уг нь хэнд ч саад болоогүй. Гэхдээ тэр үнэхээр нөлөөтэй ганц хоригдол байсан л даа. Гэтэл “Бүдүүн” Нараа, Нямлхагвад саад болсон юм байх. Ингээд л ил далд явуулга явагдаж байгаад “Бүдүүн” Нарааг Равжих алах байдалд хүрсэн байгаа юм. Нэг үгээр хэлбэл суудал булаацалдаж байхгүй юу.

**-Суудал булаацалдсан атамануудын тэмцлээс болж Авдратын шоронг татан буулгасан гэж зарим хүн ярих юм. Энэ хир ортой вэ?**

-Энэ ч арай үгүй байх аа. Ер нь тэндхийн чулууны нөөц дуусч байгаа. Хоригдлууд хийх ажилгүй болсон. үүнээс болж татан буугдсан болов уу. Уг нь Авдрантын ялтанууд ажил хийх

юм бол маш сайн чадвартай. Монгол банкны үүдэн дээр хоёр чулуун арслан байгаа. Тэрнийг хэрэг болгоод очоод үзээрэй. Авдрантынхан хийсэн юм. Улаанбаатарт ийм арслан байхгүй. Өөр нэг асуудал гэвэл миний дээр өгүүлсэн «Онцгой шорон гэдэг байх ёстой юм уу? үгүй юм уу?» гэдэг асуудал байгаа юм. Ер нь «Онцгой» гэж онцгойлж үзэх шаардлага байхгүй гэж хянагч, дарга нар ярьдаг. Жир, чанга, тэгээд гяндан. Олон дамжлага байх шаардлагагүй. Гадаад орнуудад ч ийм л байдаг гэсэн. Гэвч монголчууд олон шат дамжлаганд аягүй дуртай. Яагаад гэвэл «Дарга улс» болохоороо дарга нарынхаа тоог ихэсгэх гэж олон шат дамжлагатай олон жижиг шоронтой байхыг хүсдэг бололтой. Монголд нийтдээ зургаан мянга гаруй хоригдол ял эдэлж байгаа. Ердөө мянга мянган хүнтэй зургаан том шорон байхад л хангалттай. Тэгтэл зуун ямаанд жаран ухна гэгчээр хоёрхон сая хүнтэй Монголд хорь гучин шорон байна шүү дээ. Аймгуудын мөрдөнг тооцох юм бол хорь гучаас илүү гараад явчихна. Чухам энэ л утгаар онцгой дэглэмийн шорон Авдрантыг татан буулгах гэж байгаа болов уу гэж бодож байна. Батлан хамгаалах яам ямар ч ажил үүрэг гүйцэтгэдэггүй барилгын цэргийн нэлээд хэдэн ангийг татан буулгалаа шүү дээ. үүн шиг зарим нэг шоронг татан буулгаж байгаа нь сайн хэрэг. Нэмж шорон барихын оронд татан буулгаж байсан нь дээр биз дээ.

-1995 онд Авдрантын шоронд хэд хэдэн хүн алаад оргож явахдаа амь алдсан Чулуунбаатарын урхаг Авдрантын шоронд өнөө хүртэл үргэлжлээд байгаа гэж ярих юм.

-Тэр үнэн. Хоригдлууд ч ингэж ярьдаг юм. Чулуунбаатар 1988 онд Авдрантын шоронд очсон. 1988-95 он хүртэл тэнд хоригдсон. Тэндээ байр сууриа олчихсон байсан. Төмөр чулуугаар юм хийдэг гарын уртай залуу байсан. Чулуунбаатарын хувьд өмнө нь Авдрантын онцгой шоронд байхдаа нэг удаа оргосон юм. Яагаад оргох болсон бэ? гэвэл түүнийг тэндхийн хянагч нар сахлаа ав гэж тушаасан юм. Чулуунбаатар ер нь сахалтай л даа. «Сахал» Чука гэдэг байхгүй юу. Тэгээд Чулуунбаатар сахлаа авахгүй гэж зөрүүдэлсэн. Гэтэл нэг халамцуу офицер хянагч нартайгаа нийлж байгаад Чулуунбаатарыг бороохойдон зодож байгаад сахлыг нь хусаад хаячихгүй юу. үүнд нь Чулуунбаатар их гомдсон байгаа юм. Тэгээд бүр яснаасаа хорсож нөгөө офицерыг алахаар шийдсэн байна. Чука тэгээд нэг хянагчтайгаа архи уугаад халамцуу хянагчийг цаашаа харж байх хооронд сейфнээс нь нэг гар буу сумтай аваад хармаалчихгүй юу. Тэр даруйдаа гадагш гарч нөгөө офицерынхоо гэрийн гадаа очоод гарч ирэхийг нь хүлээгээд зогсч байтал нэг жаахан охин гараад ирж. Чулуунбаатар өөрөө ганц охинтой. Уг нь сайхан сэтгэлтэй залуу шүү дээ. Тэгээд өөрийнхөө охинтой адилтаж үзээд “За за энийг алаад ч яахав. Эцгийг нь алж өнчрүүлээд ч яахав” гэж шийдээд тэр чигтээ оргочихсон байгаа юм. Тэгээд тун удалгүй баригдаж дахин ял нэмүүлээд буцаад Авдрантын шоронд очтол нөгөөдүүл нь аймшигтайгаар зодсон байгаа юм. Дараа нь тэгээд тувт дарамтанд байлгасан. Бараг л ер нь амийг нь авчих гээд байж. Тиймээс Чука дахиад оргохоор шийдсэн. Оргохоосоо өмнө нэг хоригдолд ингэж ярьсан байгаа юм. “За, би ер нь эд нарын гарт үхэх юм байна. Маш осолтой болж ирлээ. Намайг арай ч шууд алчихаж чадахгүй болохоор элдэв янзын дарамтаар хөнөөх гэж шийдсэн бололтой. Тэгэхээр би эд нараас өрсөж өөрийнхөө амийг хамгаалах хэрэгтэй болж байна. Оргохоос өөр арга алга” гэж ярьж байж. Хүний сэтгэлд юм хийх ийм л аюултай. Хүчирхийлэл хүчирхийллийг төрүүлдэг гэдэг нь энэ. Хутгаар алснаас үгээр алах нь айхтар байдаг ч үе бий. Эцсийн эцэст Чулуунбаатарын онц ноцтой аллага хийх бүх шанс нь ингэж бүрдсэн байгаа юм. Ингээд тэр нэг л шөнө бужигнуулаад хаячихсан. Тэнд хоригдож байсан хоёр хүүхнийг аллаа. өстэй хүнээ аллаа. Түүний гарт алагдсан нэг хянагч нь Чулуунбаатартай бараг хар багаасаа тоглож өссөн байгаа

юм. Аллага болох учир шалтгаан нь хянагч нарт, үр дагавар нь Чулуунбаатарт байгаа биз. Овоо босгоогүй бол шаазгай хаанаас суух вэ? гэдэг үг ч бий. Яг л ийм юм болсон юм. Манай өнөөгийн нийгэм чинь хуучин социализмын үеийн нийгэм биш. Гэтэл Монголын шоронгууд бахь байдаг хэвээрээ. Юм болгон нийгэмтэйгээ зохицож байх ёстой. Гэтэл манай хоригдолуудын ухамсар тэр хэмжээнд хүрэх яагаа ч үгүй байна. Яахав олон улсын жишигт хүргэж байгаа нь ч тэр юмуу, хоригдолуудын халимаг тавихыг зөвшөөрсөн л дөө. Гэтэл хэн нэгэн хоригдол оргоход зарим нэг хүн “Хөөе, үсийг нь авчихгүй яасан юм бэ? үстэй болохоороо оргочихож байгаа юм” гэдэг. Ийм юм бол байхгүй. Би хоёр ч удаа шоронгоос оргож байсан. Дандаа үсгүй оргож байлаа. Монголчуудын нэг бодол гэвэл аливаа юмыг шууд л таслан зогсоочихно гэж боддог. Энэ чинь болохгүй байхгүй юу? Эхлээд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, шалтгаан нөхцөлд нь дүн шинжилгээ хийж байж аливаа асуудлыг таслан зогсоодог юм. Бидний үеийнхийг бодвол одоо үед орголт маш багассан, Энэ бол их том үзүүлэлт. Дээхэн үед чинь нэг шөнийн дотор л гэхэд долоо найман хүн оргочихсон байдаг байлаа. Одоо бол харуул хамгаалалт илт сайжирсан. Чанга дэглэмтэй шоронгуудыг хянагч нар манаж байна. Гадна талаар нь дотоодын цэрэг хянаж байна. Ийм байхад л тэндээс хүн алдаад байгаа юм. Хэн нэгэнтэй тооцоо боддог хариуцлагын тогтолцоо алга.

**-Авдрантын шорон хоригдлуудад яагаад бие биенээ алах боломж олгоод байсан юм бол?**

-Сүүлийн жилүүдэд гайгүй болсон шүү дээ. Хутга мэсний асуудал дээр өглөө болгон үзлэг хийдэг. Нэг хүн хутга хураалгахад цаана нь өөр газар бас нуучихсан байдаг. Амьдрах итгэл байхгүй болчихсон хүмүүс яаж ийгээд амьд байхыг боддог. Зарим нь биеэ хамгаалахын тулд хутга ханцуйлж явдаг нь нууц биш. Авдрантын шоронд хэрцгийгээр алагдсан Нямлхагвын хувьд бол ахлах тогооч, зөвлөх хийж байсан. Тусдаа нэг өрөөнд байдаг байлаа. Түүнийг хэн нэг нь зүгээр цохиод унгачихаж чадахгүй. Нямлхагва бодибилдингээр хичээллэдэг, сайхан бие бялдартай залуу. Аргагүйн эрхэнд хүчинд автагдаад 30 гаруй хутгалуулаад үхсэн. Уг нь түүнийг алсан Баянмөнх Нямлхагвын хаана нь ч хүрэхгүй. Ер нь бие биенээ алах боломж бүрдчихсэн газар. Тэгээд ч бүх хоригдолыг нэг бүрчлэн хянаад байх боломж байхгүй. Нэг хүн дээр нэг хянагч тавилтай нь биш дээ. Тэгвэл шорон гэдэг чинь утгаа алдана биз дээ. Одоо бол Авдрантын шорон арай өөр болчихсон. Бүр өрөөнүүдийг ажигладаг камертай болсон. Ер нь эцсийн эцэст бие биенээ хөнөөнө гэдэг чинь тухайн хүний ухамсартай л холбоотой.

**-Зарим ялтан өрөөндөө хивс хадчихсан, бас тэгээд архи зөөлгөөд уудаг гэж ярьдаг. Онцгой дэглэмийн шоронд яагаад ийм боломж олгоод байдаг юм бол?**

-Одоо өөр болсон. Нэгэнт л хүн амьдарч байгаа болохоор өрөөгөө тохижуулах нь тэр хүний асуудал. Хивсний хувьд гэвэл агаман хоригдлууд бүгд хивстэй. Гэвч энэ нь зурагтаар харахад эрээн мяраан хивс мэт харагддаг. үнэн хэрэгтээ тэр чинь хивс биш. Хятадын эрээн аравч л байхгүй юу. Мөн улс орны эдийн засаг хүнд байгаа болохоор нэгэн жигдийн хувцсаар хангаад байж чадахгүй байна. Ар гэрээс нь хувцас ирүүлэхийг зөвшөөрсөн болохоор нэг л их гоё ганган хүмүүс харагдаад байдаг. Хэн ч цэвэрхэн, бөөс хуурсандаа баригдчихгүй явахыг хүснэ шүү дээ. Тэрнээс биш илүү эрх эдэлсэн юм байхгүй.

**-Шандын Батсайхан гэдэг цуутай эр мөн л Авдрантын шоронд алагдсан. Энэ бас л**

## захиалгат аллага уу? Жамьянпэрэнлэйн Цогтсайхан яагаад алах болов?

-Түүнийг Жамьянпэрэнлэйн Цогтсайхан алсан. Энэ эр гяндангаас дэглэм буугаад Нямлхагватай гал хам болсон юм. Ер нь эрүүгийн ертөнцөд олон жил гал хам явчихсан хүмүүс их аюултай байдаг. Цогтсайханыг бид мэднэ л дээ. Цогтсайхан хүн чанарын хувьд дажгүй залуу байгаа юм. Энэ хүн архи уухаараа хүн дүрсээ алддаг. Аллага гардаг өдөр архи уусан байгаа юм. Цогтсайхан, Нямлхагва хоёр нэг өрөөнд амьдардаг гал хамууд. Гэтэл Шандын Батсайхан гэдэг нэлээд атамандуу залуу онцгой шоронд хүрээд ирэхгүй юу. Энэ залуу хэл ам их гаргадаг, бас их нөлөөтэй. Нямлхагва тэр үед «Бидний эрх мэдлийг булааж мэдэх, хамгийн аюултай хүн бол Шандын Батсайхан байгаа юм» гэж Цогтсайхан хэлж л дээ. Гэтэл Цогтсайхан шууд хайч барьж гараад Шандын Батсайханы өрөөний үүдэнд очоод түүнийг дуудаж гаргаад үгийн зөрөөгүй хайчаар хатгасан. Ингээд л нэг нь хорвоогоос талийчихаж байгаа юм. үүний дараа Баттогоогийн өлзийсайхан гэдэг залуу гяндангаас дэглэм буугаад Авдрантад очсон. Энэ залуу мөн л олон жил онцгой, чангаар явчихсан хүн. Тэгээд өлзийсайхан Нямлхагвын эрх мэдлийг булаах гээд баахан явуулга хийж байж Баянмөнх гэдэг залуугаар Нямлхагвыг алуулсан шүү дээ. Авдрантын шоронд иймэрхүү нэг хий үзэгдэл тэнүүчилж явна. Тэгээд энэ нь ихээхэн амь бөхтэй. Нэг үгээр хэлбэл «Бүдүүн» Нарааг алсан өш хонзон л яваад байгаа юм шиг. Одоо Шандын Батсайханы буюу Нямлхагвын өш хонзонг хэн нэгэн авах гээд бэлтгэж байхыг үгүйсгэхгүй. Мөн Дарханы атаман Даваабаатар гэдэг залуу Авдрантын шоронд дээгүүр зиндаанд морилж байсан. Энэ залууг мөн л хэн нэг нь алах захиалга өгсөн ч юмуу нэг суурин дээр хэд хэдэн удаа хутгалуулаад бараг л үхээд боссон. Хууль хяналтын байгууллагынхан энэ тал дээр бодож үзэх хэрэгтэй. Хулгайч нар нэг нэгнийгээ устгаж байдаг юм гэж тоохгүй байхын аргагүй. Нарны хүмүүс хуулийг чангалаад өг гээд л байдаг. Гэтэл яаж чангалахаа ч мэддэггүй. 20 гаруй жил шоронд суусан би л гэхэд л чанга, зөөлөн хоёрыг ялгахгүй байна шүү дээ. 15 жил бол урт хугацаа, үүнийг манай хуульчид 25 жил болгосон. Ингэж хүнийг залхаах хэрэг байна уу. Би 20 жил гаруй ял эдэллээ. Тэргүүний хүмүүжүүлэгч, Зөвлөлтийн дарга гээд л хамаг юмыг нь аваад гараад ирсэн. Гэтэл ингэж хүмүүжүүлээгүй, хүн амины хэрэгтэй хүмүүс Авдрантаар дүүрэн байна. Дарга нарыг томилохдоо нэг газар ганц хоёр жил болгоод л өөр тийш нь шилжүүлчихдэг. Ажиллаж байх хугацаанд нь онц ноцтой аллага гарсан гээд зайлуулах бол ердийн үзэгдэл. Ажлынх нь амжилтыг бүрэн дүүрэн үзэхгүйгээр жаахан нээнтэг гаргаад зайлуулаад байна гэдэг чинь боловсон хүчний бодлого алдагдаж байгаагийн нэг хэлбэр. үүнээс чинь их хор уршиг гардаг юм шүү дээ. Шинэ хүн очоод хүнээ танихгүй, ажлаа мэдэхгүй, арга барилаа олохгүй нэг хэсэгтээ мунгинана. Авдрантын шорон бол хамгийн хүнд нөхцөлтэй газар. Чанга дэглэмтэй шоронгуудад байгаа хамгийн болохгүй, үл бүтэх ялтануудыг Авдрантын онцгойд аваачиж цөлдөг. Ер нь хүмүүс энэ газрыг цөллөг ч гэж ярьдаг. Албан хаагч нараа цөллөг маягаар энд томилдог гээд хэлчихвэл нэг их алдахгүй. Хулгайч нар хэн нэгэн албан тушаалтныг томилогдоод ирэхэд «өө, энэ ямар олигтойдоо энд ирж цөлөгдөх вэ дээ» гэж ярьдаг. Тэгэхээр Авдрантын шорон ямархуу нөхцөлтэй газар байсан бэ гэдэг нь эндээс харагдаж байгаа биз.

## Орчин үеийн «Уулын» Төмөр 24 жилийн ял авсан

Төв аймгийн Жаргалант сумын Бугын ам гэдэг газар 2002 оны 9-р сарын 2-ны өглөө буун дуу гарч олныг цочирдуулжээ. Анх тус сумын иргэн Ш.Энхтүвшингийн гэрт шоронгоос оргосон хоёр хулгайч дайран орж эхнэрийг нь хүчирхийлэхээр завдах үед Энхтүвшин зэвсэг хэрэглэж гэр бүлээ хамгаалжээ гэсэн цуу яриа дэгдэж байв. Гэвч шоронгийн шийдчихсэн хулгайчуудаас гэр орноо хамгаалаад нухчихсан мөртлөө яагаад бүрэн зэвсэглэж аваад ХанХэнтийн салбар уулсын хэсэг болох тайга руу зугтаасан нь ойлгомжгүй байлаа. Гэтэл удалгүй мөнөөх алуулдаг хоёр нь шоронгоос оргосон улс биш болж таарсан. Ингээд Ш.Энхтүвшин хоёр хүнийг буудан хөнөөж ууланд бүгсэн тухай радио телевиз, сонин хэвлэлээр ярьж бичиж, цагдаагийнхан ч хэд хоног уул хөвчийг нэгжиж самнан байж хэрэгтнийг баривчилсан билээ. үүний дараахан хохирогчдыг нутгийн хүмүүст маш дээрэнгүй ханддаг, дуртай цагтаа хоттой хониноос нь авч идшиндээ хэрэглэдэг, өмнө нь ял эдэлж байсан танхай балмад этгээдүүд гэж буруутгасан. Мөн Энхтүвшинг зартай дээрэмчдийг дарж өгч нутгийн олны санааг амрааж, бараг л буянтай үйлс бүтээлээ гэх нь холгүй шуугисан. Тиймдээ ч түүнийг ялаас чөлөөлж өгөөч гэсэн хэдэн зуун хүний гарын үсэгтэй захиаг хуулийн байгууллагад илгээжээ. Гэвч Ш.Энхтүвшинд холбогдох хэргийг анхан шатны шүүхээр авч хэлэлцээд «Хүний амь санаатайгаар хөнөөсөн» хэмээн цаазаар авах ял оноосон юм. Энэхүү шийдвэрийг түүний өмгөөлөгч эс зөвшөөрч дээд шатны шүүхэд давж заалдсан байна. Тиймээс түүнийг хэрэг үйлдэх үедээ гүн цочролд орсон байсан, өөрийнхөө амийг хамгаалахын тулд өрсөж буудсан хэмээн цаазаар авах ялыг нь хөнгөвчилж, чанга дэглэмтэй хорих ангид 24 жил хорих шийдвэр гаргасан байна. Тэглээ ч энэ шийдвэр өмгөөлөгчийн сэтгэлд хүрсэнгүй. Тэрбээр Ш.Энхтүвшинд холбогдох хэргийг мөрдөн байцаалтад буцаахыг хүссэн өргөдлөө Улсын дээд шүүхэд гаргасан байна. Хохирогчийн талынхан ч анхан шатны шүүхээс түүнд оноосон цаазаар авах ялыг хэвээр үлдээхийг хүссэн гомдлоо шүүхэд гаргажээ. Тэгвэл 2002 оны 9-р сарын 2-ны орой Төв аймгийн Жаргалант сумын Бугын ам гэдэг газар нутаглаж байсан. Ш.Энхтүвшингийн юу болсон бэ гэвэл тэр өдөр Эрдэнэбаатар, Лхагвадаш хоёр тэднийд ирж түүнтэй архиджээ. Тэд анх гурван литр нэрмэл архи уусан байгаа юм. Дараа нь гурван шил «Ноёд» архи ууж нэлээд халцгаажээ. Эцэстээ хоорондоо маргалдаж эхэлсэн бөгөөд хохирогч Эрдэнэбаатар гэрийн эзэнд агсам тавьж «Би танай эхнэртэй нууц амрагийн холбоотой. Чамайг эзгүйд хоймрын орыг чинь эзэгнэдэг» гэх зэргээр доромжилжээ. Энэ явдлаас болж тэд зодолдсон бөгөөд Эрдэнэбаатар Энхтүвшинг буудахаар ханын толгойноос буу авах гэхэд нь Энхтүвшин амиа хамгаалахын тулд өрсөж буудсан юмсанж. Ш.Энхтүвшин нутаг усандаа тохитой томоотой нэгэн гэгддэг боловч түүний хувийн зан чанарын тодорхойлолт тийм ч сайн байсангүй. Мань эр сүүлийн үед архи уух нь их болсон, нэг удаа архины эмчилгээнд явсан боловч засраагүй, согтуу хөлчүү байх үедээ эхнэрээ буудна, ална тална гэж заналхийлдаг болж бүтэхгүй хүмүүсийг удаа дараа гэртээ орогнуулж байснаас сумын захиргаанаас хоёр ч удаа анхааруулга авч байсан аж. Харин хохирогч Эрдэнэбаатар нь орон гэргүй, мэргэжил боловсрол бага, 2000 онд хулгайн хэргээр ял эдэлж байгаад зарлигаар суллагдсан. Хохирогч Лхагвадаш нь эхнэр хүүгийн хамт амьдардаг, 1999-2000 онд танхайн хэргээр ял эдэлж байсан нэгэн аж. Хэргийн гол гэрч болох Энхтүвшингийн эхнэр Гансүрэн мэдүүлэхдээ «Нөхөр маань ширдэгэн дороос арван ширхэг сум авч бугаа сумлаад «Бүгдийг чинь ална, чамайг ч бас ална» гэж надруу агсамнаж эхэлсэн. Энэ үед хохирогчид унтаж байсан. Намайг үнээгээ саах гээд гарсан хойно удалгүй буун дуу



гарсан» гэжээ. Гэрчийн мэдүүлэг болон хохирогчид хэвтээ байдалд буудуулсан байна гэсэн шинжээчийн дүгнэлт, хэргийн газрын үзлэг зэргээс үзэхэд Ш.Энхтүвшин амиа хамгаалахын тулд өрсөж буудсан, гэнэтийн цочролд орсоноос болж уг хэргийг үйлдсэн гэдэг нь нотлогдсонгүй. Тиймээс шүүгч нар өмгөөлөгчийн гаргасан гомдлыг хүлээж авах боломжгүй гэж мэдэгдээд давж заалдах шатны шүүхээс Ш.Энхтүвшинд оноосон 24 жилийн ялыг хэвээр үлдээжээ. Харин Жаргалант сумынхан сумын заан цолтой энэ залууг хурдан буу мөрөвчлөөд ууланд гарсаныг сонсмогцоо «Манай сумаас шинэ цагийн Уулын Төмөр гарч ирлээ» хэмээн бөөн баяр болцгоосон нь хачирхалтай. Ер нь Жаргалант сумыг сайн эрс бүгж байсан олон хад агуйтай гэж эртнээс ярьсаар ирсэнийм.

## **«Ганц худаг»-ийн мөрдөнд байгаа сэжигтнүүд камерийнхаа хогийг шүүрдэх гэж зүтгэдэг болжээ**

Халхын шорон янз бүрийн арга домоор дүүрэн байдаг бөгөөд мөрдөнгийн өрөөний ханан дээр «Тэр овогтой тэр наашаа ирж жангаа идэж, боргиогоо уу» гэж бичээд хэн нэгнийг шоронд оруулчихдаг, тэр ч байтугай өс хонзонтой хүнээ засаг цагаан түмпэнгээр даллаад хажуудаа авчихсан тохиолдол хүртэл гарчээ. Мөн наранд байгаа хэн нэгнийг гайтуулахын тулд «Хар савны дуудлага» гэгчийг хийдэг бөгөөд хөөтэй хар тогоонд адууны цувдай буцалгаад бүтэн өдөр битүү дарчихдаг аж. Ингэсэн тохиолдолд наранд байгаа өс хонзонтой хүн нь осол аваарт орж үхэж үрэгдэх ч юмуу, ямар нэгэн гэмт хэрэг үйлдээд шоронд морилдог байна. Улс орон даяар өдөр өнжилгүй осол аваар гарч хүн амьтан үхэж үрэгдээд байгаа нь үүнтэй холбоотой байж ч магадгүй юм. Энэхүү домоос гадна байнга өвчин ороогоод байдаг нялх хүүхдийг «Ганц худаг»-ийн харанхуй камерт оруулаад гаргахад өвчин нь илааршдаг, хүүхэд тогтдоггүй айл сүүлд гарсан нялх хүүхдээ мөн л шоронгийн өрөөгөөр оруулаад гаргахад тэр хүүхэд нь тогтдог гэх мэтийн дом байдаг. Энэхүү домьг хэрэглээд дал ная насалсан хүн ч байдаг аж. Харин сүүлийн үед «Ганц худаг»-ийн мөрдөнд камерийнхаа хогийг шүүрддэг нэг дом бий болжээ. Учир нь камерийн хог шүүрдсэн хэн боловч түр хугацаагаар батлан даалтанд гардаг ч юмуу, эсвэл бүрмөсөн суллагддаг юм байх. Гэхдээ хүн амины хэрэгтэй, яагаад ч батлан даалтанд гарахааргүй хүн энэ домьг хэрэглээд явдлын гарз. Харин бүрмөсөн суллагдах буюу батлан даалтанд гарах магадлалтай хүмүүс энэхүү домьг хэрэглэх гэж зүтгэдэг болсон байна. Саяхан Баянгол дүүргийн харъяат Намхайцэрэнгийн Болдхуяг гэгч залуу уг домьг хэрэглээд бүрмөсөн суллагджээ. Тэрбээр өнгөрөгч гуравдугаар сард нэг албан газрын агуулахыг ухаж ойр зуурын юм хулгайлаад «Ганц худаг»-т хоригдсон бөгөөд ар гэрийнхэн нь мөнөөх албан газрыг хохиролгүй болгохоос гадна дарга даамалтай нь сайн сайхнаар сүжрээд, бараг л хуурай ах дүү болцгоосон юмсанж. Гэвч улсын яллагч Болдхуягийг заавал ял эдлүүлэх гэж зүтгээд байж. Ингээд тэр тун эргэлзээтэй байдалд орсон бөгөөд камерийнхаа хогийг шүүрдвэл ялнаас мултардаг гэсэн домьг хамт хоригдож байсан нэг архаг ялтанаас сонсчээ. Тэгээд туршаад үзэхээр шийдэж бүтэн өдрийн турш камерийнхаа хогийг шүүрдсэн байна. Сүүлдээ бүр хог олдохгүй болохоор нь цамцаа тайлаад мөрдөнгийн цементэн шалыг гялалзтал зүлгэж гарчээ. Тэгтэл ердөө маргааш өглөө нь гэхэд л хийсэн хэрэг нь хэрэгсэхгүй болж Болдхуяг мөрдөнгөөс суллагдсан байна. Энэ мэдээг сонссон сэжигтнүүд сүүлийн үед камерийнхаа хогийг шүүрддэг «өвчтэй» болчихоод байгаа юмсанж.

## Заргын цагаан солиотой Галсангийн Баянсан халхын шоронд дүүрэн жаргалтай амьдарч байна

Монгол улсад сүүлийн жилүүдэд сэтгэцийн өвчтэй хүмүүс ихсэх хандлагатай болжээ. Сэтгэцийн өвчин яагаад ихэсдэг вэ гэвэл нийгэм эдийн засгийн шилжилт, амьдралын доройтол, дайн байлдаан, нийтийг хамарсан газар хөдлөлт, онгоцны сүйрэл зэргээс үүддэг бөгөөд ямар ч стрессгүй ард түмэн гэж байдаггүй юмсанж. Иракт байнгын дайн байлдаан болж байхад Монголд дайн байлдаангүй амар амгалан байгаа хэдий ч нийгэм эдийн засгийн шилжилт, амьдралын доройтол гээд эсэн бусын шалтгаан байна. Америк, Япон, Англи, Франц мэтийн өндөр хөгжилтэй орнуудад дайн байлдаан байхгүй, амьдрал нь баталгаатай сайхан юм шиг байдаг ч жаргалдаа хэт ташуурсан хүмүүс элдэв янзын стресст орж хар тамхинд донтох, ижил хүйстэнээ сонирхох гэх мэтийн ямар нэгэн гаж зуршилд автдаг байна. Стресс нь хүний биед гурван нөлөө үзүүлдэг юмсанж. Нэгдүгээрт, бие даагаад өвчин үүсгэнэ. Хоёрдугаарт өвдөх гентэй байсан хүний далд байсан сэтгэцийн өвчнийг ил гаргаж ирдэг аж. Гуравдугаарт бие организмд байгаа архаг хууч өвчнийг сэдрээн хүндрүүлдэг юмсанж. Эдүгээ манай улсад 50 гаруй мянган сэтгэцийн өвчтэй хүн байгаагийн 80 гаруй хувь нь архаг өвчтэй, үүнээс гурван зуу орчим нь нийгэмд аюултай гэмт хэрэг хийхэд бэлэн гэж тооцогддог ажээ. Эд нарын арав орчим хувь нь шоронд ял эдэлж байгаа бөгөөд тэднийг энгийн нүдээр харахад сэтгэцийн өвчтэй гэж хэлэхийн аргагүй. Тиймээс эмч нар «Муусайн ялтанууд шоронгийн хүнд хүчир ажлаас зугтаж сэтгэцийн өвчтэй болж жүжиглээд Шар хадны эмнэлэгт тарвалзах гэж байна» гээд огт тоодоггүй юмсанж. Эдүгээ Галсангийн Баянсан гэгч ялтаны сэтгэцийн өвчин дээд цэгтээ хүрч байгаа юмсанж. Тэрбээр заргын цагаан солиотой нэгэн бөгөөд тун шалихгүй юман дээр зарга үүсгэж бөөн дуулиан дэгдээдэг аж. Тухайлбал нэг хянагч түүнийг хоолонд орж байх үед нь «Ялтан Баянсан гуай та тавагаа долоо» гээд хэлчихэж. Тэгтэл Баянсан «Батхуяг хянагч надтай маш эвгүй харьцлаа. Би ямар Ромын боол юмуу. Би ганцхан жилийн дараа суллагдах гэж байгаа эрх чөлөөтэй ялтан хүн. Тиймээс жирийн иргэнийг боол мэтээр доромжилсон хянагч Батхуягт арга хэмжээ авч өгнө үү» гэх зэргээр ангийнхаа удирдлагад өргөдөл бичсэн байгаа юм. Гэвч тавагаа долоо гэж доромжлох нь байтугай ташуур бороохойгоор ялтнуудын ясыг цайлгадаг удирдлага нь түүний өргөдлийг даанч авч хэлэлцсэнгүй. Естой хөх инээд нь хүрч Баянсангийн бичсэн өргөдлийг нүдэн дээр нь ураад хаячихжээ. Тэгтэл Баянсан ангийнхаа удирдлагыг асуудал шийдсэнгүй гэж гомдоллон дээд газарт өргөдөл бичсэн байна. Дээд газар нь энэ зэргийн юмыг яаж тоох билээ дээ. Тиймээс ямар ч хариу өгсөнгүй. Тэгтэл Баянсан шоронгийн хэвлэл түгээгчийг заамдаж аваад «Чи миний өргөдлийн хариуг заавал олж ир. Ерөнхий газраар ороод шавдуулах хэрэгтэй. Одоо энэ өргөдлийг хамгийн том даргынх нь гарт заавал атгуулна шүү» гээд мөнөөх л өргөдлөө дахин дахин бичиж өгч зовоодог болж. Сүүлдээ ангийнх нь удирдлага түүний сэтгэлийг амрахын тулд Батхуяг хэмээх хянагчийг нүдэн дээр нь худлаагаасаа хатуу донгодож шийтгэжээ. Тэгтэл Баянсан бахдалтай нь аргагүй маасайтал инээснээ «Миний тэмцэл амжилтанд хүрчихлээ. Би ялчихлаа шүү дээ. үнэнээр явсан хүн үхэр тэргээр туулай гүйцдэг юм байна» гэх зэргээр цээжээ дэлдсэн байгаа юм. Мөн нэг хянагч ажлын цагаар архи сэнгэнүүлж яваад Баянсанд хар авхуулчихжээ. Тэгтэл Баянсан асар том хэрэг илрүүлчихсэн аятай шоронгийн даргын өрөөнд амьсгаадаж ороод «За Нямдаваа хянагчийг ажлаас хал. Цаадах чинь шал согтуу явж байна. Одоо тушаалаа гарга» гэх зэргээр шавдуулжээ. Шоронгийн дарга ширээ шааж босч ирээд «Новшийн муу ялтан чи эндээс зайл. Хэн, хаана,

яаж явах нь чам шиг муу ялтанд огт хамаагүй» гэж хашгирсан байна. Тэгтэл Баянсан «Шоронгийн дарга согтуу хянагчаа өмөөрч ялтан намайг хэлэх хэлэхгүй үгээр дайрч доромжилсон» гэх зэргээр дээд газарт өргөдөл бичиж маанагтжээ. Тэр ч байтугай «Ард Аюуш» кинон дээр гардаг шиг «үнэн худал хоёрын хооронд дөрвөн хуруу зай байдаг юм гэсэн. үнэн үнэнээ дагадаг юм, үнээ тугалаа дагадаг юм. Ажлын цагаар архи уусан хянагч Нямдаваа, согтуу хянагчаа өмөөрсөн шоронгийн дарга бид гурав үнэний төлөө шахаан доогуур орж байж энэ хэрэг дуусгавар болно. үүнийг дээд газраас зохион байгуулах ёстой» гэх зэргээр мунхагласан байгаа юм. Түүний энэхүү заргын цагаан солио нь сэтгэцийн өвчний хамгийн хурц хэлбэр ч байж мэднэ. Заргын цагаан солиотой хүмүүс заргалдах тусам түүнээсээ таашаал авдаг юм гэсэн. Хэрвээ зарга заальхай байхгүй хэд хонох л юм бол сэтгэл зүрх нь ямар нэгэн зарга шаардаад, өчүүхэн жижиг маргааныг хүртэл тордож хэрүүл тэмцэл болгочих гээд байдаг юмсанж. Гэхдээ заргын цагаан солиотой хүмүүс хэн нэгэнтэй зодолдоно гэж түүхэнд байхгүй. Хамгийн гол нь аманд нь байнгын хэрүүл тэмцэл урсч байхад л тэр хүн дүүрэн жаргалтай амьдарч байна гэсэн үг. Энэ утгаараа Галсангийн Баянсан халхын шоронд дүүрэн жаргалтай амьдарч байна. Түүнийг шоронгоос гарч ирмэгц оюун ухааныг нь жаахан цэнэглээд иргэний хөдөлгөөнүүд рүү илгээчихвэл муусайн луйварчин улс төрчдийн бодийг хөтлөх биз ээ.

## **Шоронд хар перец зарж баяжсан Б.Цэгээн хурандаа Санжаасүрэнг хүндэлдэг**

Шоронд орсон ихэнх хүмүүс эвдрээд гарч ирдэг. Харин зарим нэг хүн амь зуух ухаанд туршлага суугаад гарч ирдэг. Энд өгүүлэх Болдын Цэгээн гэгч эр 1990 оноос хойш гурван удаа шоронд орсон нэгэн бөгөөд тэрбээр нэлээд туршлага хуримтлуулжээ. Мань эр шоронд зөвхөн туршлага хуримтлуулаад зогсохгүй бизнес хийж мөнгө цуглуулсан байна. Хамгийн наад захын жишээ гэхэд л «Ганцхудаг»т мөрдөгдөж байхдаа хар перец зарж нэлээд хөлжжээ. Учир нь чийгтэй өрөөнд хоригдож буй сэжигтнүүд хар перецийг их хэмжээгээр хоолондоо хийж иддэг бөгөөд энэ нь бие тэнхрүүлж, харшаа тайлдаг сайн талтай юмсанж. Б.Цэгээн энд хоригдож байхдаа эхнэртээ хар перец их хэмжээгээр захиж өөрөө борлуулдаг байж. Тэрбээр 100 төгрөгийн перецийг 1000 төгрөгөөр зардаг байсан бөгөөд 1996-2000 оны хооронд зөвхөн перец зараад хоёр сая төгрөг олсон байх жишээтэй. Тэгээд уг мөнгөөр эхнэр нь ТүЦ ажиллуулж амьдрал ахуйгаа дээшлүүлсэн байна. Мөн тэрбээр янз бүрийн сийлбэр хийж түүнийгээ жуулчны баазуудад илгээдэг байснаас гадна чулуугаар хөөрөг, шатар зэргийг хийж хувь хүмүүст өндөр үнээр зардаг байжээ. Б.Цэгээн 2005 оны 8-р сард шоронгоос суллагджээ. Эдүгээ тэрбээр хоёр ч дэлгүүртэй бөгөөд уг дэлгүүрүүдийг Цэгээн шоронд байхдаа янз бүрийн наймаа, гар урлал хийж олсон мөнгөөрөө босгожээ. Тэгэхээр шоронд бизнесийн болоод амьдрах ухааны асар их орон зай байгаа нь ойлгомжтой. Дашрамд хэлэхэд Б.Цэгээн хорих байгууллагуудын дарга асан хурандаа Санжаасүрэнг ихэд хүндэлдэг аж. Учир нь Санжаасүрэн хурандаа шоронд гар урлал болон бизнес хийх орчин бүрдүүлснээс гадна хоригдлуудыг гараа толгой дээрээ салаавчлуулан буруу харуулан зогсоодог арга барилыг хориглох шийдвэр гаргасан юм байх. Мөн мань хурандаа атаман хоригдлуудаар зөвлөлийн дарга тавих явдлыг эсэргүүцдэг нэгэн бөгөөд энэ нь бие биенээ дарамтлах их суурийг тавьдаг байна.

## Олон жил орон шоронгоор явсан хүн байнга цагдаагийн хараанд байдаг

Цагдаад эрүүгийн төлөөлөгч нэртэй, цолтой хүмүүс хэдэн зуугаараа байдаг. Тэдний хэн нь ч хэн нэгэн хүнийг хорьё, шоронд хийе гэж бодвол шууд л хийчихдэг хүмүүс. Хэрэг хийсэн хийгээгүй огт хамаагүй. Яагаад гэвэл тэдний хяналт тавьдаг байгууллага нь устчихсан юм шиг, хяналт тавьдаг хүмүүс нь ус балгачихсан юм шиг байдаг тул тэд ийнхүү дураараа загнадаг ажээ. Саяхан нэг эрүүгийн төлөөлөгч «товарищ» Сонгинохайрхан дүүргийн цэргийн хотхонд байх ахындаа сууж байсан Тамир гэгч залууг шууд барьж аваад шоронд суулгана энэ тэр гэж айлгажээ. Тэгэхээр нь Тамир «Ямар үндэслэлээр хорих гэж байгаагаа хэлчих» гэхэд мань төлөөлөгч «Бусад үндэслэлээр хорих гэж байна» гэж томорчээ. Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд «Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлж болох буюу эрүүгийн хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулж болох, эсвэл гэмт хэрэг үйлдэж болох үндэслэлтэй бол таслан сэргийлэх арга хэмжээ авна» гэсэн ганцхан заалт байх юм. Өнөөх «Бусад үндэслэл» гэдэг нь хаана ч байгаа юм бүү мэд. Зарим цагдаа хэн нэгэнд үзлэг хийхдээ халаасанд нь байгаа мөнгө төгрөгийг яг л дээрэм хийж байгаа байдлаар хурааж авдаг. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 179-д үзлэг хийхдээ тогтоол үйлдэнэ, хөндлөнгийн гэрчийг байлцуулна гэсэн заалт байдаг. Мөн тус хуулийн 180-д «үзлэг хийхдээ протокол үйлдэж, үзлэгээр илэрсэн зүйлийг тэмдэглэж холбогдох хүмүүсээр гарын үсэг зуруулна» гэсэн заалт бий. Хууль бусаар үзлэг нэгжлэг хийж хүний эд зүйлийг хурааж авна гэдэг ерөнхийдөө дээрэм юм. Одоогоос хэдэн жилийн өмнө Сонгинохайрхан дүүргийн харъяат Оюунбадрах гэгч залууг нэг эрүүгийн төлөөлөгч ямар нэгэн хэрэгт сэжиглээд халаасанд нь байсан 60 гаруй мянган төгрөгийг хурааж аваад «Ганц худаг»-т гурав хонуулжээ. Оюунбадрах яаснаа мэдэхгүй гурав хоног шоронд суугаад гарч ирмэгцээ «Би яагаад шоронд суух болов, хэлээд өг» гэтэл төлөөлөгч «Таньтай адилхан шар царайтай хүн энэ хавьд алагдсан хүний курткийг зах дээр зарах гээд явж байсан гэж дуулсан учир таныг хорьсон юм» гэж хэлсэн байгаа юм. Энэ байдлаас үзвэл шар, хар, улаан гэх мэт онцгой царайтай байна гэдэг их осолтой зүйл бололтой. Улаан царайтай хүн сүх бариад явж байвал сүхдүүлж үхсэн хэн нэгнийг алсан хэрэгт сэжиглэгдэн шоронд суух жишээтэй юм болох нь. Оюунбадрах хураалгасан мөнгөө авья гэтэл тэр мөнгөнөөс нь 15 мянган төгрөг дутуу байсан бөгөөд энэ тухай төлөөлөгчид хэлтэл «Чамд байсан мөнгө ердөө л энэ шүү дээ» гээд гүрийчихэж. Тогтоол номыг гүйлдэлгүй, хөндлөнгийн гэрч оролцуулалгүй «булааж авсан» хүн гүрийхээс ч яахав дээ. Ингээд Оюунбадрах гэдэг хүн ямар ч гэм зэмгүй явж байгаад шар царайнаасаа болж гурав хоног шоронд суугаад, арван таван мянган төгрөгөө алдаад өнгөрсөн байгаа юм. Магадгүй үүнийг бичигч миний бие өш хонзонгийн золиос болж үзгээр хүний нүд сохолсон /үзэгнээс өөр юм надад байхгүй л дээ/ хэрэгт сэжиглэгдэж шоронд суучихаж магадгүй л юм. Бараан царайтай хүн үзгээр шаасан гэсэн, чамтай төстэй юм гэвэл дууслаа шүү дээ. Самбуудоржийн Ганбаатар гэж өөрийгөө танилцуулсан нэг нөхөр хэдэн жилийн өмнө «Дуулиант хэрэг» сонины редакци дээр ирж «Би хохирогч мөртлөө хорь хоног «Ганц худаг»-т сууж байгаад гарч ирлээ» гэж билээ. Ганбаатар нэг нөхөрт мөнгөө зальдуулаад шүүхдэж байгаад авахаар болоод байтал өнөөх залилагч нь Эрүүгийн цагдаагийн газар ажилладаг нэг найздаа хэлчихэж. Гэтэл өнөөх найз нь Ганбаатарыг дуудаж аваачаад «Чи юу гэж хүнээс мөнгө нэхээд байгаа юм бэ. Мөнгөө авна гэж бодож байна уу чи» гэсэнд Ганбаатар «Авна аа» л гэж. Тэгтэл төлөөлөгч «Тэгвэл чи С.Зоригийг алагдсан 10-р сарын 2-ны шөнө хаана байсан бэ» гэж. Ганбаатар «Санахгүй байна аа» гэсэнд байцаагч «Санах л болж дээ чи. Сануулдаг

газар байдаг юм» гээд «Ганц худаг»-т аваачаад хорьчихсон байгаа юм. Түүнийг мөрдөнд ороод цаг ч болоогүй байтал гурван архаг хулгайч орж ирээд «С.Зоригийг яаж алснаа ярь» гэсэн байна. «Би алаагүй шүү дээ» гэтэл түүнийг наарны банзаар цохиж унагаад дөрвөн мөчийг нь хүлж 220 вольтоор «ойлгуулж» эхэлсэн байгаа юм. Мөн түүний хөлийн ороолтыг норгож байгаад аманд нь чихэж тогтой утас хүргэмэгц Ганбаатарын хоёр нүднээс гал бутран, үсчиж эхэлсэн байна. Энэ мэтээр түүнийг хэсэг яргалж байгаад «Хэлэх үү чи» гэхээр нь Ганбаатар «Хэлье» хэмээжээ. Гэтэл гурван хулгайч үзэг цаас гаргаж ирээд «Бич» гэсэн байна. Ингээд мань эр алуулахгүйн тулд радио телевизээс сонссон болон сонин хэвлэлээс уншсан зүйлээ бодож байгаад С.Зоригийг «яаж алсанаа» бичиж өгөөд явуулчихаж Тэгтэл маргааш нь эрүүгийн цагдаагийн газрын нэг дэд хурандаа давхиж ирээд байцаалт авах юм болжээ. Тэр үед нь Ганбаатар яаж яргалуулсан хийгээд хэрхэн хуурмагаар хэрэг үйлдсэнээ хэлээд орхиж. Гэтэл дэд хурандаа «Чи яасан их хуулиар тоглодог хүн бэ?» гэх зэргээр баахан зандарч байгаад яваад өгчээ. Ганбаатар ингээд л 20 хоног шоронд шомбойсон байгаа юм. Энэ бол дэндүү харгис хэрэг бөгөөд Ганбаатар нь С.Зориг агсаныг алсан хэргээр шоронд суусан эхний хүн ч биш, эцсийн хүн ч биш. Миний дуулснаар энэ хэрэгт зуу орчим хүн хоригдсон юм гэсэн. Зуун хүн нэг хүнийг ална гэж юу байх билээ. Мөн олон жил орон шоронгоор явсан хүмүүс байнга цагдаагийн хараанд байдаг бөгөөд энд тэнд ямар нэг эзэн холбогдогчгүй хэрэг гарсан тохиолдолд заавал ч үгүй байцаагддаг аж. Дархан-Уул аймагт оршин суудаг Гансүх гэгч залуу саяхан ярихдаа «Би хүн амины хэргээр арав гаруй жил орон шоронгоор явсан минь үнэн. Гэвч Дарханы цагдаа нар ямар нэг хэрэг гарахад заавал ч үгүй намайг хардаж сэрддэг. өнгөрсөн жил Дарханд нэг айлын гурван хүний амийг хороосон хэрэг гарсан. Энэ хэрэгт Дарханы цагдаа нар зуу гаруй хүнийг шалгасан. Намайг хүртэл хардаж сэжиглэн гурав хоног мөрдөнд суулгасан. За тэгээд ганц нэг хүн амины хэрэг, хулгай дээрмийн хэрэгт намайг байнга дуудаж байцаадаг. Ёстой ядаргаатай. Нэг өдөр намайг ажлаа тараад гэртээ иртэл манайд нэг байцаагч ирчихсэн байлаа. Би дотроо «Бас л нэг хэрэг гарч дээ» гэж бодож суутал байцаагч «Чи өнөөдөр гол руу очсон уу» гэлээ. Би «Очоогүй» гэж хэлээд «Надаас яагаад ингэж асуув аа» гэхэд мань байцаагч «Гол дээр нэг хүн үхчихсэн байна. Тэгээд л чамаас асууж байгаа юм» гэдэг байгаа. Энэ үгийг сонсоод миний дотор бачимдаад л явчихсан. Гол дээр нэг хүн үхчихсэн байхад л надаас ирж асууж байгаа юм даа. Ёстой гомдмоор. Нэг согтуу хүн гадны нөлөөтэй нас барчихсан байхад л намайг дуудаж байцаадаг. Тэр хүнийг би таньдаг, таньдаггүй нь хамаагүй. Хамгийн гол нь тэр хүн гадны нөлөөтэй нас барсан, би хүн амины хэргээр шоронд ял эдэлж байсанд л асуудлын гол оршино» гэсэн юм.

## Сайхан эр хүн муухай гаж зуршилтай болох шиг хөгийн юм байхгүй

Аливаа орчин нөхцөл хүнийг ямар нэгэн гаж буруу зүйлд дасгахдаа амархан байдаг. Ялангуяа шорон гээч нь хүнийг хүмүүжүүлэхээсээ урьтаж хулгайч хүнийг улам хулгайч болгож, алуурчин хүнийг улам л хүн алахад сургадаг гэлтэй. Мөн зарим ялтан орчин нөхцөлтэйгөө уялдаад гомо буюу цэнхэр болох нь олонтаа. Энэ нь төрөлхийн гаж буруу зуршил бус амьдралын явцад олж авсан олдмол гаж зуршил юмсанж. өнгөрсөн жил өршөөлийн зарлигаар сулагдсан Норжингийн Бархас гэгч бие бялдар сайтай царайлаг эрийг найз нөхөд нь «Хүүхэнд нугасгүй дуртай байсан Бархас шоронд найман жил сууж гарч ирээд цэнхэр болчихож» гэж ярьдаг болжээ. Нээрээ ч мань эр шоронгийн нөхцөл байдлаас болж олдмол гаж зуршилтай болсон бөгөөд эхнэр нь анхандаа түүнийг өөр хүүхэнд хайртай болчихож хэмээн гэнэхнээр төсөөлдөг байсан байна. Бархас шоронгоос гарч ирсэнээсээ хойш эхнэртэйгээ огт хавьтаагүй гэх бөгөөд хамт ял эдэлж байсан Энх-Амгалан хэмээх гуч гаруй насны царайлаг залуу түүнтэй байнга уулздаг аж. Бархасын эхнэр Хажидмаа мань хоёрыг эхэндээ «гал хамууд» гэж ойлгодог байж. Тэгтэл нэг өдөр хэрэг бишдэх нь тэр. Хажидмаа Шар хаданд байх ээжийндээ очихоор гэрээсээ гарах үед өөдөөс нь Энх-Амгалан гарч ирээд «Бархас гэртээ байгаа юу» хэмээжээ. Хажидмаа түүгээр тоглоом шоглоом хийхээр шийдэж «Чиний хайртай залуу чинь гэртээ байж л байна» гээд санаандгүй хэлж орхисон байна. Тэгтэл Энх-Амгалангийн царай нэг л сэжигтэйгээр хувьсхийгээд явчихаж. Тиймээс Хажидмаа мань хоёрыг гомо байж магадгүй гэж хардаж эхэлсэн бөгөөд хэдэн минутын дараа хашаандаа сэмээрхэн явж ороод байшингийнхаа цонхоор хартал Бархас, Энх-Амгалан хоёр диван дээр суучихсан учиргүй үнсэлцэж байсан байна. үүнийг хараад Хажидмаа гүн шоконд оржээ. Гэхдээ тэр мань хоёрыг эвгүй байдалд оруулахыг хүссэнгүй. Хий дэмий л найман жил шоронд суусан нөхрөө үзэн ядаж «Арай ч дээ. Бархас минь чи ямар сайхан эр хүн билээ. Ийм муухай гаж зуршилтай болчих ч гэж дээ. Чи яагаад намайг сонирхохгүй Энх-Амгалан гэдэг энэ шаамийсан залууг сонирхоод байдаг юм бэ» гэж бухимджээ, Сайхан эр хүн муухай гаж зуришлтай болох шиг хөгийн юм байдаггүй бололтой. Бархас үүнийгээ батлах гэсэн аятай нэг найздаа «Энэ Монгол ёстой дүүрчихсэн орон юм. Нөгөө хүний эрх гээч юм нь хаана байна. Гадаад оронд бол гомо нар цуглардаг тусгай газар байдаг л гэсэн. Тэгтэл манайхан бие биенээсээ айж цэрвээд ёстой зүрхээ зүсүүлчихсэн улс юм» гэх зэргээр үг алдсан байх жишээтэй.



## Хүн худалдаалах гэмт хэрэг Монголд 15-р зуунаас эхэлсэн

Орчин үеийн арилжаа наймаа, олон улсыг хамарсан бизнесийн үйл ажиллагаанд Монгол улс амжилттай оролцож шинэ хөгжлийн замд эргэлт буцалтгүй орлоо. Мянгаад жилийн тэртээх түүхийг сөхөж үзэхэд Монгол улс хөрш хоёр их гүрнээс гадна алс холын Франц, Самарканд зэрэг олон оронтой арилжаа наймаа хийж эвтэй найрсаг явахын зэрэгцээ эвдэрч дайтаж байлдах нь ч цөөнгүй байжээ. Ер нь худалдаа наймааны үйл ажиллагаа Монголд эрт дээр үеэс эхэлсэн бөгөөд харамсалтай нь сөрөг үр дагавартай явж иржээ. Тухайлбал эдүгээ дээр дооргүй халаглаад байгаа «Хүүхэн худалдаалах гэмт хэрэг» гээч нь Монгол улсад нэлээд эртнээс хэрэгжиж эхэлсэн байгаа юм. 14-15-р жарны үед Түшээтхан аймгийн Ганжуур гүнгийн хошуунд «Сахалт» Соном хэмээх мал малын захтай, тариа будаа ургуулан илжиг, луусаар морин тээрэм хөллөн гурил бэлтгэдэг, хол ойрын танил тал ихтэй, хойшоо буриадууд, урагшаа хятад, тангад, түвд, цахар, барга, үзэмчин зэрэг долоон хэлийн их гарынхантай наймаа арилжаа хийж аян жин тээдэг гүйлгээ ухаантай эр байжээ. Ёстой л нөгөө «Тунгалаг тамир» кинонд гардаг Луу гүний хошууны баян Итгэлт шиг нөхөр байж. Соном өөрийн зарц Янжин эмгэний зээ охин Цэвэлийн онгоныг цоолж, үүлэн борооны ажилд сурган өдөрт малын бэлчээрт, тариалангийн талбайд, шөнөд нь дөрвөн ханатай бор гэрийг нь нураачих шахан зайдагнасаар байгаад жирэмсэн болгож орхижээ. Төдөлгүй Цэвэлээс охин төрсөн байна. Эхээсээ өнчирсөн Цэвэл ийнхүү «Баян» Сономын зарц буюу «нууц амраг» нь болж олон жилийг элээсээр нэг мэдэхэд л гучин насыг зооглосон байв. Тэгтэл «Баян хүн бачтай. Сонин дээрээ соохолзоно, сониноо буурахаар гоохолзоно» гэгчээр зальт Сономын сэтгэлд сул олз олох нэгэн бодол байнга эргэлддэг болж. Тэгээд тэр Вангийн хүрээнд арав гаруй хонохдоо хятад пүүсний дэд тэргүүн «Цоохор» хэмээх Дэн овогт данжаадтай «маш нууц» хэлцэл хийж урьдчилгаа мөнгө хангалттай аваад нутагтаа иржээ. Мань эр ирсэн даруйдаа хайлсан тугалга шиг зан гаргаж эх охин хоёрыг Вангийн хүрээний гол шүтээнд мөргүүлж хиймэл уул «диваажин»-г үзүүлнэ гэж хөөрцөглөж эхлэх нь тэр. Тэгээд явах бэлтгэлийг яаравчлан хангуулаад 15-р жарны хар бар жилийн намрын адаг сард арав гаруй үхэр тэргэнд арвай буудай, цагаан идээ ачаад Вангийн хүрээг зорьжээ. Эхний түүчээ тэргэнд тусгайлан зассан гоёмсог тохилог жуузанд Цэвэл найман настай охин үзмээгийн хамт заларсан байна. Цэвэл амьдралдаа өмсч зүүж үзээгүйгээ үзэж хааны бага хатан аятай заларч явахдаа эзэн Сономынхоо нүнжигийг шагшин магтаж байсан гэдэг. Харин өвгөн хөтөч Жамц «Баян» Сономын арга заль, далд муу санааг гадарлах учир сэтгэл нь ихэд гонсойж эх, охин хоёрын ирээдүйн хувь заяа яаж төгсөхийг сэтгэл оюундаа бясалган бурханд залбирч явсан гэдэг. өсч төрсөн өргөн Сэлэнгэ мөрний хөвөөгөө, үржил шимт Цагаан голын нуга тохойгоо үүрд орхин явж буйгаа эх, охин хоёр яахин мэдэх билээ. Соном баян өдөр нь жороо борлог мориороо замын дагуух айлуудаар бууж мордон айраг сархад хүртэж «улаан зээрд» болсоор, шөнийн бор хоногт майхандаа ирж Цэвэлийг зайдагнасаар нэг мэдэхэд Вангийн хүрээнд иржээ. Тэгээд тэр хөсөг хөтлөө жинчдийн дэн буудалд байрлуулаад эх, охин хоёрыг «цоохор» данжаадад бараалахуулахаар тусгайлан бэлтгэсэн тохилог өрөөнд гаднаа харуултай дотроо үйлчлэгчтэйгээр суурьшуулсан байна. Төдөлгүй Соном наймаа арилжаагаа богино хугацаанд бүтээхийн зэрэгцээ эх, охин хоёрыг хүрээ хийдэд мөргүүлээд «үхэр мал өлдөж байна. Жаргалантын ууланд хэд хоног идээшлүүлье. Тэр болтол Цэвэл чи охинтойгоо Дэн овогтын байж бай» гэж хуурч үлдээгээд хэл сураггүй алга болжээ. Энэ хооронд хөгшин данжаад эх, охин хоёрыг гэрийн хорионд оруулж хамгаалалтыг улам чангатгасан байна. Нэг

орой охиныг унтмагц «Цоохор» данжаад Цэвэлийг өргөөндөө урин цайлаад «Чамайг би охины чинь хамт Сономоос гучин лан алт, зуун лан мөнгөөр худалдаж авсан. Наймаа буцахгүй гэсэн баталгаа энэ байна» гээд нэгэн бичиг үзүүлээд далд хийжээ. Тэгээд «Одоо охин та хоёр миний мэдлийнх болсон. Та нар надтай жарганаа. Сайхан унтваа» гээд Цэвэлийн бүх хувцасыг хүчээр тайлаад хүчирхийлжээ. Эхний шөнө данжаад тав дахин ноолсон боловч Цэвэлд ямар ч сэрэл ирэлгүй хөгшин данжаадын ой гутам үнэрээс сэжиглэн бөөлжис нь цутгасан байна. Яваандаа харин дасмаар аядаж хөгшин данжаадын хуял тачаалыг тайлсаар бордооны гахай шиг юу ч хийлгүй хэдэн жилийг ардаа орхижээ. Нэг удаа Цэвэл Жанчхүүгээс бараа татах жингийн дэд даамлаар явах болсон бөгөөд ингэж явахдаа өөрийн зовлонт амьдралаа жингийн бичиг данс хөтлөгч Авир гэгч хүнд аминчлан ярьсанаар «Баян» Соном болон «Цоохор» данжаад нарын нууц илэрч чихтэй бүхний сонорт хүрчээ. Цэвэл алс хол явахдаа Вангийн хүрээнд үлдсэн 15 настай охин үзмээгийнхээ хувь заяанд сэтгэл эмзэглэж яваагаа Авир бичээчид ярьсан байдаг юм. Жинчдийг Жанчхүүд очиход гурван данжаад Цэвэл хүүхнийг «Цоохор»-оос илгээсэн бичгийн хамт гар дээрээ өргөн хүндэтгэл үзүүлж тусгайлан бэлдсэн буудал руу авч одсон гэдэг. Үүнээс хойш монгол жинчид Цэвэл хатагтайн барааг үзсэнгүй. Тэд «Цоохор» данжаадаас Цэвэлийн талаар асууж лавлахад «Хай Цэвэл хатан замдаа их ядарсан байнаа. Түүнийг Бээжин, Шанхай хотуудаар амарч зугаалан сувилуулахаар явуулсан. Удахгүй энд ирээд та нарын хойноос очвоо» гэдэг байж. Гэвч Цэвэл хатагтай хүний мөсгүй хөлдүү дотортой «худалдаачин» нэртэй наанаа инээж, цаанаа мэс ирлэж, хор найруулсан Соном, «Цоохор» данжаад нарын дэвсгэр болсондоо гуниж гутаад амиа хорлочихсон гэдэг. Харин түүний 15 настай охин үзмээгийн хувь заяа яаж шийдэгдсэн нь тодорхой бус. Цоохор данжаад түүнийг насан туршдаа эдэлж хэрэглэж байгаад амьсгал хураасан, эсвэл цааш нь өөр луухаануудад дамлан худалдсан биз ээ. Ер нь бидний дуулж сонссоноор бол хүүхэн худалдаалах гэмт хэрэг Монголд 15-р зуунаас эхэлсэн гэж хэлж болно. Энэ цагаас хойш хятадууд монгол хүүхнийг гар дамжуулан худалддаг болсон бөгөөд энэхүү бусармаг явдал 1921 оны ардын хувьсгал хүртэл үргэлжилсэн байдаг билээ.

## Эвдэрхий аппаратаар тавин хүн залилсан

### Э.Зуунайгийн ээдрээт амьдрал

Залилан, хулгай, дээрэм гурав хүйн холбоотой юмсанж. Нэг ёсондоо залилан хийдэг хүн хулгай хийхэд бэлэн байдаг аж. үүн шиг хулгай, залиланг хоёуланг нь хийгээд гаршчихсан хүн дээрэм хийхэд бэлэн байдаг юмсанж. Зарим хүн, тухайлбал «90 сая»-ын Гансүх, «Банкны» Цолмон, Чойрогийн Дүгэрээ мэтийн хүмүүс «Би залилан хийдэг болохоос биш хулгайч, дээрэмчин биш» гэж томордог. Гэвч ингэж томорч болохгүй. Хамгийн гол нь залилан хийх хөрс суурь нь байнга бэлэн байдаг болохоор хулгай, дээрэм хийх шаардлага байхгүй. Тэр жил «90 саяын» Гансүх нь Дэлгэрбат гэгч этгээдтэй хамт шоронгоос оргож явахдаа залилан хийх боломж олдохгүй болохоор машин дээрэмдсэн удаатай. Энд өгүүлэх Элдэв-Очирын Зуунай гэгч эр эхлээд луйвар хийж байгаад сүүлдээ хулгай хийгээд, эцэст нь дээрэм хийжээ. Тэрбээр 1990 оны эхэн үед Монголд гараагүй цоо шинэ луйврыг санаачилсан байдаг. Тэр нь юу гэвэл Сүхбаатарын талбай дээр зураг авах явдал байсан бөгөөд дотроо плёнк ч байхгүй нэг муу эвдэрхий зургийн аппаратаар тавь гаруй хүнийг залилсан байгаа юм. үүний тулд мань эр хуурамч тасалбар шиг юм авч явах бөгөөд түүн дээрээ хүмүүсийн овог нэрийг бичээд «Маргааш гурван цагт ирж зургаа аваарай» гээд мөнгийг нь урьдчилж авдаг байж. Плёнк байхгүй эвдэрхий аппарат нь гялс хийх нь байтугай «Чад» гэж ч дуугарахгүй. Хэрвээ плёнк хийх юм бол бусдыг луйвардаж мөнгө олох гэж байгаа Зуунай хиншүү ханхалтал шатна биз дээ. Тиймээс тэр зургаа авахуулах гэсэн хүмүүсийг өмнөө зогсоогоод эвдэрхий аппаратаа хэсэг шагайж байснаа «За болчихлоо» гэдэг байж. Цаадуул нь «Ийм хурдан уу. Наад аппарат чинь гялс хийдэггүй юмуу» гэхэд мань эр «Сүүлийн үеийн зургийн аппарат гялс хийхээ байчихсан шүү дээ. Тэр гялс хийдэг аппарат чинь социалист нийгэмтэй цуг авслагдсан. Та нар соёлоос их хоцорч байна шүү. Харин би бол хөрөнгөт ертөнцөд сурч боловсроод ирсэн хүн. Миний энэ аппарат Сингапурынх» гэж ханхалздаг байж. 1990-ээд оны эхэн үеийн монголчууд Сингапурыг «Бар улс» гээд шүтчихсэн, Зуунай мэтийн луйварчны үгэнд шууд л итгэчихдэг ийм л гэнэн цайлган байлаа шүү дээ. Тийм ч учраас «Банкны» Цолмон бусдыг луйвардаад шоронд орж гарч ирээд дахиад хэд хэдэн удаа луйвар хийсэн удаатай. Тэр ч байтугай нэг хүн Цолмонд байраа луйвардуулаад түүнийг шоронд өгсөн хэрнээ гурван жилийн дараа суллагдаад гарч ирэхэд нь дахиад луйвардуулсан байх жишээтэй. Монголчууд ийм л гэнэн тэнэг байлаа. үүнийг нь улс төрчдөөс эхлээд банкны ажилчид, хулхи бизнесменүүд мөн ч их ашиглаж баяжсан даа. Хэрвээ монголчууд гэнэн бус ухаалаг сэргэлэн ард түмэн байсан бол хулхи улс төрчид болон луйварчид хэзээ ч өөдөө гарч ирж чадахгүй байх байлаа. Мулгуу ард түмэн муу удирдагч төрүүлдэг гэдэг л энэ дээ. Дээр өгүүлсэн Элдэв-Очирын Зуунай эвдэрхий аппаратаар нэг хэсэг луйвар хийж байгаад яг баригдаад ирүүт жуулчлал нэрийн дор ганзагын наймаанд морджээ. Тэрбээр хуурамч бичиг баримтаа бүрдүүлж, хэсэг хүмүүсийн хөлөглөсөн «ПАЗ» автобусанд хөл дүүлэн ОХУ-д очиж их луйврын замд гарсан байна. Учир нь тэнд Зуунай мэтийн луйварчинд хялбархан өгөөш болчихоор гэнэн итгэмтгий монгол наймаачид язганаж байлаа. Зуунай тухайн үед бэл бэнчин муутай, ашиг орлого гэх юмгүй явсан ч Эрхүү хотод өөрөөсөө нэлээд хэдэн насаар эгч орос хүүхэнтэй танилцжээ. Тэр түүнд итгэл олж авахын тулд нэг хэсэгтээ л энгийн томоотой хүний дүр эсгэжээ. Тэгээд нэг л өдөр эгчмид орос хүүхнийг эзгүй хойгуур нь 200 гаруй мянган рублийн үнэ бүхий эд зүйлийг нь хулгайлж аваад зүг буруулсан байна. Тэгээд

хулгайлсан зүйлээ зарж борлуулан хэд хоног орос янхан энэ тэрийг сонирхож байсаар элэг нэгтнүүдээ луйвардах ажиллагаанд орсон байна. Түүний хавтаст хэрэгт дурьдагдсанаар» Иргэн Энхцэцэгийн 200 мянган рублийг залилан авсан. Мягмарсүрэн, Ганбат нарын барааг хулгайлсан. Энхчимэг, Одноо нарын цүнхтэй эд зүйлийг вокзал дээрээс хулгайлсан. Батсүх, Энхжаргал нарын курткануудыг залилж авсан. Дамдинсүрэнгийн гадаад паспорт, 50 ам.доллар, хоёр цүнх барааг хулгайлсан, Эрдэнэсүрэнгийн 20 ширхэг савхин хүрэм, 2000 рубль зэргийг залилсан, Унгарт явахдаа машин авахаар зорьж очсон Ганхуяг, Батсүх нарын нэг сая долоон зуун мянган злотыг залилж авсан. Москва хотод иргэн Бурмаагийн ноолууран цамцнуудыг зарж өгнө гээд булааж авах шахам зугтсан» гэх зэрэг тоолж барамгүй өчнөөн хэрэг үйлдсэн байна. Сүүлдээ монгол наймаачид байрладаг буудлуудаар хоноглож цүнхтэй бараа, эд зүйлсийг нь хулгайлж нэг хэсэг манаргажээ. Ингэж байсаар 1996 оноос эхлээд «Маахуур» Тулгаа гэгч этгээдтэй нийлж дээрэм хийжээ. Тулгаа гэгч нь Маахуурын дэнжид олон жил «атаман» хийсэн, арваад жил ял эдэлсэн этгээд аж. Гэвч мань хоёр хамгийн сүүлд дээрэм хийж байгаад монгол наймаачдын отолтонд орсоноор «Маахуур» Тулгаа цээжиндээ хутгалуулж нас баржээ. Зуунай түүнийг хутгалуулсаныг мэдсээр байж шууд л хаяад зугтчихсан байна. Энэ явдлаас хойш мань эр монгол наймаачдын хараанд өртжээ. Учир нь «Маахуур» Тулгааг хутгалж алсан нэг монгол наймаачин хэргээс мултрахын тулд Зуунайг бариад буучихаж. Зуунай энэ удаад Оросын цагдаа нараас зугтаж шууд л Монгол руу зүглэжээ. Тэгээд нутагтаа ирээд нэг л их гэм зэмгүй амьтан «Оросод наймаа хийх ерөөсөө явцгүй юм. Би тэнд наймаа хийх гэж хэдэн жил зүтгээд ямар ч амжилт олсонгүй» гэх зэргээр бурдаг болж. Ингэж явахдаа бас зүгээр байсангүй. Шар хадны орос цэргийн казармагт байрлах «Тэрэгчин» компаний захирал Сэлэнгэ гэгчийг сэнхрүүлж монгол гэрийн тавилга хийж Унгар луу гаргахаар болжээ. Учир нь тэр Унгарт луйвар хийж явахдаа тэндхийн нөхцөл байдлыг нэлээд сайн судалсан юмсанж. Бүр Унгарын зарим нэг компаний нэрийг мэддэг, унгар хүнтэй ганц нэг үг солилцчихдог байсан нь Сэлэнгэд итгэл олж авах үндэс болсон байна. Тэр Сэлэнгэтэй уулзаж учрахаасаа өмнө зах дээр явж байгаад гадаадын нэг хүн харуутаа унгараар үг солилцтол тэр нь аз болж Монголд суурин амьдардаг унгар хүн байж. Тэгээд л түүнтэй холбоо сүлбээ тогтоож, сүүлдээ бүр хамтарч залилан хийхээр тохиролцжээ. Чухам энэ үед Сэлэнгэ дээр давхиж очоод Унгар луу монгол гэр гаргая, надад таньдаг унгар хүн байна гэх зэргээр итгүүлсэн бололтой. Тэгээд тэр «Тэрэгчин» компаний ажилчдаар иж бүрэн тавилгатай монгол гэр гурвыг хийлгэж машинд ачуулан авч яваад ор сураггүй алга болжээ. Мань эр мөнөөх унгар эрийн хамт гурван гэрийг ачаалаад вокзал дээр очихоор болж, харин Сэлэнгэ захирал Гаалийн ерөнхий газраар бичиг баримт бүрдүүлэх ёстой байж. Тэгээд мань гурав 12-р таваарын вагоны дэргэд уулзахаар тохиролцжээ. Гэтэл Зуунай ч байдаггүй, унгар эр ч байдаггүй, иж бүрэн тавилгатай гурван гэр ч байдаггүй. Гэхдээ Сэлэнгэ захирал сэргэлэн хүн байсан тул гурван гэрийг урагш нь гаргаж магадгүй гэж бодоод хэдэн өдрийн турш вокзал хавиар эргэлджээ. Тэгтэл нээрээ ч хэд хоногийн дараа Зуунай нэг өвөрмонгол эрийн хамт таваарын галт тэрэгний дэргэд зогсч байх нь тэр. Ингээд тэр шоронгийн тав болсон бөгөөд үүний хажуугаар дээр өгүүлсэн ОХУ-д үйлдэгдэж байсан бүхий л гэмт хэрэг нь илэрсэн байна. Нэг ёсондоо Орос, Монголын цагдаа нар түүнийг эрэн сурвалжилж байсан хэрэг. Шүүх түүнд 16 жилийн хорих ял өгсөнд зарим хохирогч ундууцаж «Түүнийг цаазаар авсан ч багадна. Бид яаж хохирлоо барагдуулах болж байна. Тэгэхээр хувхай хоосон Зуунайг шоронд муурч унатал нь ажил хийлгэж бидний хохирлыг төлүүлэх хэрэгтэй» хэмээн шүүх, сэргийлэхэд баахан өргөдөл өгсөн боловч талаар өнгөрсөн байна.

## Шорон дотроос тодорсон өшөө авагч

1990-ээд оны үед зохиолч, сэтгүүлч асан Ж.Барамсайн «Шорон дотроос өшөө авагчид байдаг юм биш биз» гэсэн гарчигтай нийтлэл «үнэн» сонинд гарч Монголыг донсолгосон билээ. Энэ цагаас хойш шорон дотроос өшөө авсан, хэн нэгнийг заналхийлсэн өч төчнөөн хэрэг гарсан бөгөөд хамгийн сүүлд гарсан нэг хэргийг толилуулъя. Ховд аймгийн харъяат Шагдарын Түвдэнням хэмээх жолооч залууг шорон дотроос өширхөн хилс хэрэгт гүжирдэж эгээтэй л хүн амины хэрэгтэн болгочихсонгүй. Харин тэр сайн хуульчийн ачаар амь аврагджээ. Хэрэг гардаг орой Ховд аймгийн төвд оршин суудаг Сэрээнэнгийн Ганбат гэгч эр Түвдэннямтай тааралдаад «Чи манай завхай гичийг харав уу. Энэ гичий эсэн бусын юмнуудыг дагаж гүйгээд намайг их зовоож байна. Гэсэн хэдий хөгшин чинь гутрахгүй ээ» гээд өврөөсөө нэг шил архи гарган ирж Түвдэннямтай хувааж уужээ. Төдөлгүй тэр гэр лүүгээ явсан бөгөөд мань эр тэр шөнөдөө толгой руугаа хүнд юмаар цохиулаад нас барсан байна. Цагдаагийнхан энэ хэрэгт Ховд аймгийн нэлээд хэдэн хүнийг сэжиглэн саатуулжээ. Ш.Түвдэнням ч тэр орой Ганбаттай тааралдаж ганц шил юм хувааж уусныхаа төлөө 72 цаг мөрдөнд суугаад авсан байна. Тэгтэл нэг шөнө түүнийг гэртээ унтаж байтал хаалгыг нь хүчтэй тогших сонсогджээ. Очиж тайлбал хэдэн цагдаа орж ирээд “Бос, хувцасла” гэж зандраад үг хэлэхийн завдалгүй түүний хоёр гарыг гавлаад авч гарсан байна. Юуны учир баривчлагдах болсноо ойлгосонгүй. Түвдэнням аймгийн мөрдөнд гурав хоног хоригдоод Улаанбаатар хот руу ачигдахаар болов. өглөө түүнийг хэдэн цагдаа гавтай нь шоронгоос авч гаран нисэх онгоцны буудал руу машинаар хүргэжээ. Онгоцны буудлын эргэн тойронд цагдаагаар хамгаалуулаад их л сүртэй юм болсон байна. Түвдэнням хотод ирээд Баянзүрх дүүргийн саатуулан хориход 72 цаг суугаад алдарт “Ганц худаг”-т хүргэгджээ. Түүнийг хот руу авч явсаны маргааш ээж Дуламжав, эхнэр Сараа нар нь нулимс дүүрэн нүдтэй Улаанбаатар хот руу нисчээ. Тэмээ хариулсан хүн буурныхаа занг анддаггүй гэгчээр Дуламжав хөгшин “Миний хүү яагаад ч хүн алахгүй” хэмээн бүрэн итгэж энэ явдлын эцсийг үзэхээр шийдсэн байна. Тэгээд хотод ирээд хүүгийнхээ мөрдөн байцаагчтай уулзвал түүний яриаг огт авч халэлцсэнгүй. Гэвч хүүгээ гэсэн эхийн сэтгэл цөхөрсөнгүй. Цаг хугацаа өнгөрсөөр нэг л мэдэхэд 14 хоног өнгөрчээ. Нэг өдөр Дуламжав гуайг Улсын мөрдөн байцаах газрын 4-р хэлтэсийн мөрдөн байцаагч, хошууч Д.Цогтбаяр дууджээ. Дуламжав гуай яаран сандран өрөөнд нь очвол хошууч тун баяртайгаар “За эгч минь таны хүү ямар ч холбогдолгүй болох нь тогтоогдсон шүү. үүнийг үз дээ” гээд нэг бичиг өгсөн нь хүн амины хэргийг хэрэгсэхгүй болгох тухай УМБГ-ын даргын тогтоол байж. Энэ хэрэг Ховдын шоронд хоригдож байсан Т.Болдбаатар гэгч ялтнаас болж үүджээ. Мань эр талийгаач Ганбатыг нас барсаны дараахь шөнө Ш.Түвдэннямтай нэг камерт хоригдож байсан юм байх. Тэрбээр мөрдөн байцаагчид хандаж “Талийгаач Ганбатыг Түвдэнням алсаныг би мэднэ. Тэр өөрөө надад үг алдсан. Түвдэнням Ховд аймгийн мөрдөнд надтай хамт хоригдож байхдаа “Яанаа би Ганболдыг алчихсан юм шүү дээ. Гэхдээ цагдаа нар намайг хардаж сэрдлээ гэж бодоход ямар ч нотлох баримт байхгүй. Нотлох баримтгүйгээр хүн алж болдог юм байна. өс хонзонтой хүнээ нотлох баримтгүйгээр алаад байж болох юм биш үү” гэж надад ярьсан” гэж худал мэдүүлжээ. Энэ нь Түвдэннямыг баривчилж хүн амины хэргээр «Ганц худаг»-т хорих үндэслэл болсон байна. Гэвч цагдаагийнхан Т.Болдбаатарын мэдүүлгийг нарийн шалгаж үзэхэд худлаа байлаа. Т.Болдбаатар ганц хоёр хоног чөлөө авахын тулд л ингэж худлаа мэдүүлэг өгсөн бөгөөд яагаад Түвдэннямыг хүн амины хэрэгт гүтгэх болов гэвэл өмнө нь

мань хоёр нэг бүсгүйгээс болж зодолдож байсан юм байх. Тэгээд өш хонзонгоо авч байгаа нь тэр. Хэрвээ цагдаагийнхан Болдбаатарын мэдүүлгийг нарийн шалгаж үзээгүй бол ямар ч гэм зэмгүй Түвдэнням цаазын илдэнд толгойгоо тавьж өгөх байлаа. Гэхдээ л тэр эд материал болон сэтгэл санаагаар хөөрхөн хохироод авчээ. Хаа холын Ховдоос гэрч болохоор ирсэн хүмүүсийн замын зардал, хүний нэр төрийг гутаасан хариуцлагыг хэн хүлээх ёстой вэ? Орон шоронгоор олон жил тэнүүчилсэн Т.Болдбаатар гэгч ялтаны үгэнд сохроор итгэн гэмгүй хүнийг гэмтэн болгосонд хамаг учир оршино. Сүржигнэн баривчилж хотод авралгүйгээр тэнд нь шийдчих боломж байлаа. Тэгээд ч талийгаач Ганбатыг алсан алуурчин тун удалгүй тодорсон бөгөөд тэр нь хэн бэ гэвэл хэрэг гардаг шөнө эхнэртэй нь самуурч байсан Надмидын Галбаатар гэгч ажээ.

## Хянагч Баагий члтануудад эхнэр, охин хоёрынхоо

### биеийг үнэлүүлж байгаад азааргжээ

Эхнэр, охин хоёроо хоригдлуудад биеийг нь үнэлүүлж мөнгө олдог нэг хянагчийн тухай яриа чих дэлссэн юм. Айл гэр салж сарних, цаашлаад ажил төрлөөсөө хусагдаж мэдэх ор хөнжлийн эмзэг асуудал хөндөж байгаа болохоор тэрхүү хянагчийн нэрийг Баагий гэж товчлох нь зөв болов уу. Эдүгээ дөчин нас зооглож байгаа хянагч Баагий одоогоос хорин жилийн өмнө эхнэр Нандиатайгаа танилцсан бөгөөд тухайн үед мань хоёрын зүрх сэтгэлд гал халуун хайр дурлал дүрэлзэн байжээ. Гэвч энэ нь нэг их удаан үргэлжилсэнгүй. Цэргийн анги, засан хүмүүжүүлэх колони хоёрыг насаараа дамжсан офицер, хянагч нарын эхнэр, охид заавал нэг эр сүвтэй юмтай орооцолддог нь хууль билээ. Арга ч үгүй юм. Орчин нөхцөл нь хагсарсан эрчүүдээр дүүрсэн болохоор эм сүвтэй амьтан яаж л зүгээр суух билээ дээ. Баагийгийн эхнэр Нандиа ч энэхүү замаас гажсангүй. Гэхдээ Баагий түүний хоригдлуудтай явалддаг завхай зайдан явдлыг мэдэлгүй нэлээд хэдэн жил болсон байгаа юм. Харин одоогоос гурван жилийн өмнө эхнэрээ нэг ялтантай сэм явалдаж байхыг хоёр нүдээрээ хараад зүрх нь дэлбэрэх шахсан байна. Тэгээд салж сарних юм болж нэг хэсэг ундууцсанч гурван хүүхдээ бодоод, мөн арай гэж төвхнүүлсэн амьдрал ахуйгаа үрэн таран хийхгүйг хичээж сохрын газар сохор, доголлонгийн газар доголлон явахаар болжээ. Нэгэнт нь сэтгэлд нь сэв суучихсан болохоор Баагий өөрөө ч бас хүүхэн шуухан эргүүлдэг болсон бөгөөд байсхийгээд л хэд хоногоор хот руу явж элдэв хүүхэнтэй унтаж хэвтэж байгаад ирдэг болж. Энэ цагаас хойш Баагийгийн гэр бүл Барууны маягийн чөлөөт гэр бүл болж хувирсан бөгөөд хорин настай том охин нь хүртэл ялтануудад биеэ үнэлдэг болсон байна. Байдал нэгэнт ийм зам руугаа хэлбийсэн болохоор Баагий эхнэр, охин хоёроороо бизнес хийхээр шийджээ. Нэг ёсондоо тэр эхнэр, охин хоёртоо клиент олж өгч мөнгийг нь хураадаг санхүү, бизнесийн лут ажилтан болох нь тэр. Сүүлийн жилүүдэд шоронд мөнгөтэй хоригдлууд их ирэх болсон бөгөөд тэд дуртай хоолоо захиалж идэхээс гадна дурласан хүүхнээ ч мөнгөөр худалдаж авдаг болсон байна. Нямсүрэн гэгч мөнгөтэй ялтан нэг өдөр хянагч Баагийтай уулзаад «Хүүхэн хэрэгтэй байна. Хоногийн тавин мянган төгрөг өгье. Танай эхнэр надад их таалагдаад байна» гэхэд цаадах нь худлаа уурласан дүр эсгээд «Та нар намайг битгий доромжлоод байгаарай. Би тэгж эхнэрээ хуваачихмаар харагдаад байна уу» гэж хэсэг омогдсоноо «За яахав, би чамайг ойлгож байна. Гэхдээ хоногийн тавин мянга бага байна. Зуун мянгыг өгчих» гэж тулгажээ. Хадгаламж зээлийн хоршоо байгуулж байгаа нэрийдлээр бусдын олон сая төгрөгийг шамшигдуулсан ялтан Нямсүрэнд бол зуун мянган төгрөг үнэндээ юу ч биш байлаа. Тиймээс тэр «Таньд би зуун хорин мянгыг өгье. өнөө шөнө та авгайгаа дагуулаад, дөрөв таван шил архитай хүрээд ир. Архины мөнгийг би гаргана. Хэдүүлээ танай өрөөнд архидаж байгаа нэрийдлээр жаахан цэнгээд авья» хэмээжээ. Хянагч Баагий ч дуртайяа зөвшөөрсөн байна. Тэгээд тэр гэртээ очоод эхнэртээ хандаж «Зуун хорин мянган төгрөгийн ажил байна. Хувцас хунар, нүүр амаа янзлаад одоохон намайг дагаад яв» гэхэд цаадах нь төвөггүй ойлгож нүүр амаа будаад, байдгаараа гоёж гооджээ. Төдөлгүй Баагий эхнэрээ дагуулаад, замаасаа дөрвөн шил архи аваад иржээ. Тэр юуны өмнө ялтан Нямсүрэнгээс зуун хорин мянган төгрөг авч сейфиндээ хийж цоожлоод архидах ажилдаа орсон байна. Нямсүрэн ганцаараа биш байлаа. өөрийн гал хам болох Дарханаас ирсэн Сүхбаатар гэгч ялтаныг дагуулан иржээ. Ингээд мань дөрөв өрөөгөө дотроос нь түгжиж аваад архидаж гарсан байна. Хянагч Баагийгийн хувьд

гэвэл архианаас чадах чинээгээрээ уугаад тасарч унах байлаа. Харин энэ хооронд Нямсүрэн, Сүхбаатар хоёр эхнэрийг нь янзлахаар тохиролцжээ. Эдний төлөвлөгөө ёсоор болж төдөлгүй Баагий ч тасарч унасан байна, Нямсүрэн, Сүхбаатар хоёр ч эхнэр Нандиаг нь санасныхаа зоргоор эдэлж хэрэглэжээ. Цаад Нандиа нь ч дуртай нь аргагүй биеэ тушаасан байгаа юм. Ийм байдал тав зургаан удаа давтагдсан бөгөөд хянагч Баагий сүүлдээ бүр цагаандаа гарч хорин настай охиноо мөнгөтэй ялтануудад эдэлж хэрэглүүлдэг болсон байна. Гэвч олон хавар нэгэндээ гэгчээр хянагч Баагийгийн бузар булхай нэг л өдөр илчлэгджээ. Улаанбаатарын ойролцоох хорих ангиудаар зарим шөнө дээд газраас эргүүл тойруул явж шалгалт хийдэг бөгөөд нэг шөнө шалгалтынхан хянагч Баагий, түүний эхнэр Нандиа, ялтан Нямсүрэн, Сүхбаатар нарын наргиж цэнгэж байсан өрөөний хаалгыг эвдээд ортол Баагий тас үсэрчихсэн, харин эхнэр Нандиа нь Нямсүрэн, Сүхбаатар хоёрын дунд чармай шалдан хэвтэж байсан байна. Гэхдээ шалгалтын хүмүүс хүний муу үзэх дургүй, бусдын амьдралыг бусниулах сэтгэлгүй дажгүй сайхан улс байсан тул хянагч Баагий болон эхнэр Нандиад нь хатуу сануулга өгч, харин ялтан Нямсүрэн, Сүхбаатар хоёрыг арав хоног сахилгад суулгахаар шийтгэсэн байна. Гэвч энэ явдлаас болж хянагч Баагий, эхнэр Нандиа хоёрын талаар хорих ангиар нэг яриа болжээ. Тиймээс мань хоёр байж суух газаргүй болоод өөр хорих анги руу шилжсэнээр энэхүү бусармаг явдал дуусгавар болжээ.



## Мал адгуустай хурьцал үйлддэг хүмүүс төрсөн

### охиноо хүчиндэхэд хэзээд бэлэн байдаг

Булган аймгийн харъяат Монхооны Самбуу гэгч эр хүчин, дээрэм, танхайн хэргээр гурван ч удаа шоронд сууж нийтдээ 18 жил ял эдэлжээ. Тэрбээр баян айлын эрх танхи өссөн ганц хүү байж. Хамгийн сонирхолтой нь тэр архи дарс хэрэглэдэггүй нэгэн. Гэтэл дийлэнх хүчингийн хэрэг үйлдэгчид согтуугаараа гул барьсан байдаг. Судалгаанаас үзэхэд тэдний 80 хувь нь дагавар охидоо, 18 хувь нь үл таних хүмүүсийг, үлдсэн хоёр хувь нь хамаатан садан буюу төрсөн охидоо хүчирхийлсэн тооцоо гарчээ. Энэхүү хоёр хувь нь жинхэнэ манъяк буюу гаж донтонуудаас бүрддэг бололтой. Ихэвчлэн оюун ухааны доголдолтой, муйхар өссөн зарим нэг хүн төрсөн охиноо өвөртөө оруулдаг юмсанж. Бэлгийн гаж дон, аллагын гаж дон гэгч нь оюун ухааны хомсдолтой салшгүй холбоотой байдаг аж. Одоогоос хэдэн жилийн өмнө Төв аймгийн нэг суманд Хүрэлбаатар гэгч 24 настай залуу 13 настай төрсөн дүүгээ хүчирхийлээд баригдсан. Эцэг эх нь хүүгээ өмөөрч давхисны эцэст уг хэрэг дарагдсан ч өнөөг хүртэл нутгийн хүмүүс шуугисаар байна. Хүрэлбаатар нь хар нялхаасаа сургууль соёл дамжаагүй, бичиг үсгийн боловсролгүй, жаахан танхайдуу зантай нэгэн байжээ. Өнөөдөр иймэрхүү хүмүүс Монголд хэдэн мянгаараа байгаа. Иймэрхүү хүмүүс архи дарс их хэмжээгээр уусан үедээ адгууслаг чанар нь хүчтэй илэрч төрсөн эхийгээ хүртэл хүчиндэхэд бэлэн болдог байна. Үүнээс гадна бүрэн дунд боловсролтой, ном сонин хэвлэл гаргууд уншдаг 45 настай хижээл эр төрсөн охиноо хүчиндээд ял авч байсан тохиолдол бий. Эдгээр хүмүүсийн оюун ухаан юугаар хомсдсон бэ гэвэл сэтгэл санааны хүмүүжил дутсаных бололтой. Юмны учир начрыг ойлгодог атлаа цаанаа ёс зүй, хайр энэрэл, нүгэл хилэнц, хүн болсоны утга учир гэж юу байдгийг гадарладаггүй. Ийм хүмүүс бидний дунд бас л хэдэн мянгаараа бий. Тачаал хүслээ хар нялхаас нь зоргонд нь тавьж өссөн, тэвчээргүй хүмүүсийн дундаас жинхэнэ манъякууд гарч ирдэг бөгөөд энэ талаар судалгаа хийсэн нэг эмч бэлгийн гаж донтонуудыг гурван үндэслэлээр дүгнэж байна. Түүний ажигласнаар мал адгуустай хурьцал үйлддэг хүмүүс төрсөн охиноо хүчиндэхэд хэзээд бэлэн байдаг аж. Ингээд Монхооны Самбуугийн хэргийн талаар өгүүлье. Тэрбээр боловсролгүй, бүдүүлэг, танхай өссөн нэгэн бөгөөд 1980-аад оны үед 22-16 насны гурван охиноо эхнэрийнхээ нүдэн дээр дарамтлан бэлгийн харьцаанд оруулдаг байж. Энэ хэрэгтээ тэр 25 жилийн ял авч онцгой дэглэмийн шоронд очжээ. Тэр хамгийн анх эхнэрээ сумын эмнэлэгт хэвтэж байх үед том охиноо эрхэндээ оруулсан байна. Самбуу нь 12 настай байхдаа малтай, тухайлбал эдэлж хэрэглэхэд гарын дор хонь, ямаа зэрэгтэй явалдаж эхэлсэн бөгөөд 19 настайдаа шоронд очоод энэ зангаа тавилгүй айлын хонь, ямаа дагаад гүйчихдэг байсан гэдэг. Энэ утгаараа зоонд бус ууланд мод хийх туйлын дуртай байжээ. Нэг удаа хянагч нар хоригдлуудын хоол хүнсэнд ойролцоох айлаас нэг охин ямаа авчирсан бөгөөд Самбуу түүнийг хармагцаа «Хүүш яасан гоё юм бэ. Наад ямаагаа надад ганцхан цаг хэрэглүүлчих. Оронд нь би төлөвлөгөөгөө давуулан биелүүлнэ» гэсэн гэдэг. Хариуд нь хянагч нар «Чиний тэр төлөвлөгөө энд ямар хамаатай юм бэ. Энэ ямааг үнэхээр хүсээд байгаа бол биднийг нядлахаас өмнө эдэлж хэрэглэж болно шүү дээ. Гэхдээ бидний нүдэн дээр. Хэрвээ ингэж чадахгүй бол энэ ямааг яг одоо нядаллаа» гэхэд Самбуу «За байж байгаарай. Би бодож үзье» гээд хэсэг тээнэгэлзсэнээ хянагч нараас ичсэн ч юмуу «За би ерөөсөө болилоо. Наад ямаагаа ал, ал» гэсэн гэдэг. «Мал адгуустай хурьцал үйлддэг хүмүүс төрсөн охиноо хүчиндэхэд хэзээд бэлэн байдаг» гэсэн дээрхи эмчийн

судалгаа Монхооны Самбууд яг тохирч байна. Самбууг 1970-аад оны сүүл үед Мааньтын шоронд байхад Эрхүүгийн их сургуульд сурч байгаад дээрмийн хэргээр хөөгдөж ирсэн Гантайхүү гэгч залуу түүнтэй гал хам болжээ. Энэ залуу тухайн үед гадаад дотоодын ном их уншдаг байсан бөгөөд тэрбээр соц нийгмийн үед хөрөнгөт ертөнцийн нүүр царайг уудлан илчилдаг байсан Оросын сэтгүүлч Валентин Зорин гэгчийн товхимолыг их уншдаг байж. Гантайхүү нэг удаа В.Зорины товхимолыг эргүүлж тойруулж байгаад «Английн хошин киноны од Чарльз Чаплин төрсөн охинтойгоо явалдаж байгаад хүүхэдтэй болгож байжээ» гэсэн мэдээлэл олж уншжээ. үүнийг гал хам Самбуудаа хүртэл уншиж өгсөн байгаа юм. Тэгтэл Самбуу «Би чинь гурван охинтой хүн шүү дээ. Одоо тэд нар их том болж байгаа байх. Ялангуяа манай том охин их хөөрхөн. Би түүнийг харахаараа боов босчихоод байдаг юм. Чаплин төрсөн охиноо эдэлж хэрэглэж болж байхад би яагаад болдоггүй юм бэ» хэмээжээ. Хариуд нь Гантайхүү «Самбуу чи болиоч дээ. Тэр хөөрхөн охиноо надад бэлэглэчих. Ер нь би жилийн дараа суллагаад танай том охинтой сууж чиний хүргэн больё байз» гэх зэргээр нарсанд хүний эрхэнд байгаа мөртлөө нарны охинд сээтэн хаяж шүлэнгэтсэн байгаа юм. Гэвч тэр жилийн дараа суллагаа нь бүү хэл хоригдол хутгалж алсан хэргээр гяндлуулчихжээ. Харин малтай явалддаг мунаг Самбуу жилийн дараа суллагаад эхнэр, гурван охин дээрээ тачаал ханхлуулсаар давхиж хүрсэн байна. Тэгээд тэр хамгийн түрүүнд том охиноо эрхэндээ оруулаад, үүнээс жилийн дараа 8-р ангид сурдаг дунд охиноо мод түүх нэрийдлээр ой руу дагуулж яваад хүчирхийлжээ. Харин бага охиноо жилийн дараа сумын сургууль руу хүргэж өгч явахдаа хүчиндсэн байгаа юм. үүнээс хойш тэр гурван охиноо удаа дараалан ээлжлэн хүчирхийлсээр сүүлдээ бүр эхнэрийнхээ нүдэн дээр охидынхоо өвөр лүү шургаж ордог болжээ. Ингэхдээ «Хэрвээ та нар хүн амьтанд мэдэгдсэн байвал дэмий шүү. Бүгдийн чинь хоолойг хэрчиж алаад гэртэй юутай хээтэй чинь шатаачихна шүү. Тэгээд би өөрөө Хөвсгөлийн тайгад очоод бүгчихэж чадна шүү» гэж сүрдүүлдэг байж. Энэхүү заналхийллээс айсан эх, охид түүний аяыг дагаж атганд нь чичирсээр бүтэн гурван жил болсон байна. Нэг удаа зэргэлдээ суманд байдаг хамаатныдаа очсон бага охин нь «Би гэртээ харихгүй» гээд уйлаад суучихаж. Ах дүүс нь элдвээр ятгасны эцэст охин бүх үнэнийг ярьсанаар Монхооны Самбуугийн бузар хэрэг хуулийнхны сонорт хүрсэн гэдэг. Ийм дарамт өнөөдөр ч хаа нэгтэй байж л байгаа. Гагцхүү бүх хэрэг явдал болоод өнгөрсөн хойно ариухан охид жирэмсэн болж, мунаг эцэг нь шоронруу морилдог бичигдээгүй хууль үйлчилсээр байна. Хорин жилийн ял сонссон Самбуу Авдрантын хориход 11 жил хоригдоод дэглэм буурч Мааньтын чангад ирсэн боловч үлдсэн ялаа даалгүй хилэнцэт биеэ орчлонд орхижээ. Шоронд угаасаа улаан махны хэрэгтнүүдийг үзэж чаддаггүй бөгөөд энэ хугацаанд мань эр хэрхэн зовж тарчилсан нь тодорхой. Бурхан багш «Хүн ямар нүгэл үйлдэнэ, түүнийхээ уршгийг заавал эдэлдэг» гэж сургасан байдаг. Монхооны Самбуу яг л тэр жамаар хорвоо ертөнцийг цэвэрлэжээ.

## **Уйдаж цөхөрсөн ялтанууд өширхөж хорссон хянагч нараа юу гэж доромжилдо вэ?**

Энд тэндэхийн шоронгуудын уйдаж цөхөрсөн ялтанууд өширхөж хорссон хянагч нартаа элдэв янзын хоч өгөх нь их байдаг юмсанж. Ер нь тэд ингэж л зугаагаа гаргадаг бөгөөд зарим хянагч бүр гурав дөрвөн хочтой гэж байгаа. 1980-аад оны үед халхын шоронд «Мангар улаан» Даваадорж, «Унгараа» Жамган, «Хошноогоо ухдаг» Дамдинсүрэн, «Эхийгээ алмар» Батсүх, «Хүүхний салтаа» Болдбаатар, «Умалздаг улаан» Дашчийрэв, «Гүүний умдаг» Энхбаатар, «үнээний дэлэн» Сүхбалсан, «Нохойн жогорхой» Бат-Эрдэнэ гэх мэтийн хянагч нар алба хашдаг байжээ. Эндээс дүгнэлт хийхэд 1970-аад оны ялтанууд өс хонзонтой хүнээ ихэвчлэн бүсгүй хүн, охин малын нууц эрхтэнээр хочилж бах таваа хангадаг байсан бололтой. Хэрвээ дээр өгүүлсэн Энхбаатар гэгч хянагчийг «Гүүний умдаг» гэж шоолохын оронд «Азарганы сэлдий» гэж хочилбол магтан дуулсан хэрэг болох биз. Мөн тухайн үед «Ал» гэдэг хоч ид «мода»-нд орж байсан бөгөөд хулгайчууд бие биенээ занаж зүхэхдээ «Муу ал минь» гэж хэлэх нь энүүхэнд байж. Тийм ч учраас дургүй хүргэсэн хянагч нарыг ерөнхийд нь «Ал» гэж доромжилдог байж. Харин 1990 оны хоригдолууд цаг үеэ дагаад хянагч нартаа хоч өгөхдөө бүсгүй хүн, охин малын эрхтэнээс ангижирчээ. үүний оронд «Мангас», «Чөтгөр», «үлэг гүрвэл», «Цуврал алуурчин», «Маньяк», «Хар гар», «Амьсгаа», «үхдэл», «Цогцос» гэх мэтийн хоч өгдөг болсон байна. «Ганц худаг»-ийн урьдчилан хорих төвд «Чөтгөрийн бөөс» хочтой нэг хянагч саяхан болтол алба хашиж байлаа. Харин эдүгээ «Ганц худаг»-т «Цүдгэр хээр», «Хонины бор», «Цөөвөр чоно», «өмхий хүрэн», «Алаан талаан», «Цус нулимс» гэх мэтийн хочтой нэлээд хэдэн хянагч алба хашиж байгаа юмсанж.

## **Г.Намжаа: Би шоронд 15 жил болсоноо аз гэж боддог**

«Сэтгэшгүй» эмнэлэгийн захирал, ховсчин Хүрэлбаатарын «Монгол эр хүн олон эхнэртэй байх» тухай үзэл бодлыг дэмждэг, дэмжээд зогсохгүй хоёр эхнэр авч амьдрал дээр хэрэгжүүлж байгаа нэг шаггүй эр Баянхошуунд амьдарч байна Түүнийг Гантөмөрийн Намжаа гэх бөгөөд 1978-1993 он хүртэл 15 жил шоронд суусан, нас нь дөч гарчихсан мөртлөө бие хаа нь ямар ч өвчин хуучгүй цоо эрүүл, хар ажилд махруун гэж жигтэйхэн. Энэ ч чанараараа хоёрын хоёр эхнэр тэжээгээд гялалзаж яваа нэгэн юмсанж. Түүнтэй ийнхүү ярилцлаа.

**-Таныг хоёр эхнэртэй гэдгийг хавь ойрын хүмүүс чинь гадарлах болжээ. Та ч өөрөө илэн далангүй ярьчихдаг бололтой. Хоёр эхнэрийн чинь тухай хоёулаа буу халбал яасан юм бэ?**

-Энэ бол нийгэмд байдаг ердийн л нэг үзэгдэл. Над шиг ийм илэн далангүй уур амьсгал бүрдүүлж чадаагүй л болохоос биш хоёр битгий хэл гурав дөрвөн эхнэртэй хүн ч байгаа болов уу? Муу нуухаар сайн илчил гэдэг. Тэгээд ч миний энэ явдал нэгэнт ил болчихсон болохоор би нуугаад байдаггүй. «Сэтгэшгүй» эмнэлэгийн захирал Хүрэлбаатарын үзэл бодлыг би бүрэн дүүрэн дэмждэг. Гэхдээ түүнийг эсэргүүцдэг хүн олон байдаг юм билээ. Ялангуяа өөртөө байгаа ганц эхнэрээ тэжээж тэтгэж чаддаггүй доожоо муутай архичин эрчүүд Хүрэлбаатарыг бүр үзэн яддаг гээд бодчих. Би амьхандаа тэд нарын үзэл бодлыг сонсох санаатай «Цаана чинь Хүрэлбаатар гэдэг хүн олон эхнэртэй байх тухай хууль батлуулах гээд манаргаж явна. Ер нь цалин мөнгө муутай мань мэтийн юманд эм сүвтэй юм олдохгүй нь бололтой» гэх зэргээр яриа өдөхөд «Яршиг л байна ш дээ. Дуртай юм бол өөрөө л тэр олон эхнэрээ авдаг юм байгаа биз» гээд их таагүй ханддаг. Хөөрхий минь, бас эд нарын зөв л дөө. Эхнэр хүүхдээ битгий хэл өөрийгөө ч аваад явж чадахгүй найгаа алдсан эрчүүд Монголд маш олон байна. Би тэд нарыг хараад ёстой уур хүрдэг. Мал бол заазалчихмаар санагддаг. Ялангуяа нэгэн цагт надтай шоронд хамт байсан хэдэн найгүй эр өнөөдөр амьдрах гэж ёстой үйлээ үзэж байна. Зарим нь өвчин хуучинд баригдаад, зарим нь авгай хүүхдийнхээ гутал хувцасыг хулгайлж зараад архидчихаж байна шүү дээ. Ийм хүмүүс чинь юун хоёр эхнэр тэжээхдээ манатай. Архи ууж, эхнэр хүүхдэдээ агсам тавьдаг эрчүүдэд би үнэн голоосоо дургуй. Хамгийн арчаагүй эрчүүд л өөрийнхөө гарын дор хүмүүсийг дарамталдаг юм. Миний хувьд гэвэл янаг амрагийн талаар өөрийн хатуу бодолтой, өөрийн гэсэн хэвшмэл загвартай. Харин социализмын үед миний энэ хэвшмэл загвар будаа болох байсан. Тэр үед чинь эр, эм хоёрын хөнжлийг сөхөж хөлийн хурууг нь тоолохоос наахнуур байдаг байлаа. Одоо бол зарим нэг компаний захирлууд албан өрөөндөө нарийн бичгийн дарга хүүхнээ янзалчихаад, орой нь гэртээ очоод эхнэрээ зайдагнах жишээтэй. Эдний хажууд би бол ямар ч өвчин хуучгүй, өгөөмөр сэтгэлтэй, цэвэрхэн цэмцгэр хүн.

**-Өвчин хууч гэснээс та арав гаруй жил ял эдэлсэн мөртлөө бие чинь чулуу юмаа. үүний нууц юунд байна вэ?**

-Нууцсаад байх юу байхав. Ердөө л хар ажил хийснийх. Гэхдээ би тэр жонш монш зэрэг эрүүл мэндэд хортой, уушиггүй болгодог аймаар газар ял эдэлж байгаагүй. Ердөө

ууланд мод цагаалж байгаад л суллагдсан. үүний л ач байхгүй юу. Мөн шоронд өнгөрүүлсэн арван таван жил маань надад архи дарснаас хол хөндий явах сайхан завшаан бүрдүүлсэн. Хэрвээ би шоронд арван таван жил болоогүй бол аль хэдийн архи дарс, зугаа цэнгэлд шунамхайраад өдийд амьд сүг болчихсон, эсвэл үхчихсэн байх байлаа. Тиймээс би шоронд арван таван жил болсоныгоо аз гэж боддог. Нэг ёсондоо миний амьдралын зовлон нь урдаа, жаргал нь хойноо орчихсон бололтой. Гэхдээ нэг асуудал бий. 1990-ээд оны үед надтай цуг шоронгоос суллагдсан зарим хүн «Дутуугаа гүйцээж, дундуураа дүүргэнэ» гээд архийг шил шилээр нь залгилж эхэлсэн. Арав гаруй, зарим нь хорь гаруй жилийн турш биеэ архи гэдэг хорноос хол авч явсан мөртлөө гэв гэнэтхэн л дутуугаа гүйцээх гээд архичин болчихож байгаа юм. Ингэж амьдрах юм бол хэрэг алга. Харин миний хувьд гэвэл шоронгоос суллагдаад ерөөсөө архи уугаагүй. Уугаад байх ч сайхан ундаа биш шүү дээ. Тэгээд ч миний хувьд анхнаасаа л архи ууж сураагүй болохоор сурах гэж үхэн хатан тэмүүлээд байсангүй.

### **-Та ямар хэргээр арван таван жил шоронд суучихсан юм бэ?**

-Би тэгсэн ингэсэн гэж нэг их тодорхой яримааргүй байна. Зүйл ангиар нь ярьчихъя. Хууль мэддэг хүмүүс аяндаа ойлгоно биз. Хууль мэдэхгүй нэг нь харин үүгээр далимдуулж хуулиа судлаад авах хэрэгтэй. Яагаад гэвэл хүн гээч амьтан чинь хүний мууд жигтэйхэн дуртай гээ биздээ. Миний хувьд гэвэл 1978 онд Эрүүгийн хуулийн 88-р зүйлийн Б-д зааснаар дөрвөн жилийн хорих ялаар, 1982 онд Эрүүгийн хуулийн 169-р зүйлийн «б»-д зааснаар таван жилийн хорих ялаар, 1987 онд Эрүүгийн хуулийн 153-р зүйлийн нэг, 154-р зүйлийн нэг, 155-р зүйлийн хоёр, 167-р зүйлийн хоёр, 88-р зүйлийн Б-д зааснаар бүгд 12 жилийн хорих ялаар шийтгүүлсэн. Харин аз болж 1990 онд ардчилсан хувьсгал гарч ирсэнээр би 1993 онд хугацаанаасаа өмнө суллагдсан.

-Уучлаарай. Таны ярианд соц нийгмийн үеийн 88-ын Б гэдэг анхдугаар зүйл анги хоёр ч удаа дурдагдчихлаа. Ер нь та дөч гарсан хойноо хоёр эхнэр авчихсан, мөн залуу зандан насандаа ихэвчлэн хүчингийн хэрэгт орооцолдож байсныг бодоход бэлгийн чалх сайтайгаас гадна дур тачаалаар дүүрэн хүн юмаа даа?

-Ямар хачин юм ярьдаг хүн бэ чи. Гэхдээ яахав зоригтой асууж байгаа чинь сайн хэрэг. Худлаа тойруулж манжлаад байдаг хүнд би дургүй. Бэлгийн чалх сайтайгийн хувьд сайтай шүү. Энэ ч утгаараа залуу зандан насандаа тун тэвчилгүй хүчингийн хэрэг үйлдэж явсан хүн. Харин одоо бол хүчин хийдэг цаг биш. Учир нь би арван таван жил шоронд суухдаа ухаан суусан, ажил сурсан. Ингэж хатуужсан хүн чинь ганц хоёр зэргийн хүүхнийг аргална биз дээ. Хоёр эхнэр маань бие биенээ таньдаг. Би хоёуланд нь хайртай. Би 1993 онд шоронгоос суллагдаад анхныхаа ханьд дурлаад суусан. Дараа нь 1998 онд өөр нэг хүүхэнд сэтгэл алдарсан. Анхны авгай маань намайг өөр хүнд хайртай болсныг мэдсэн мөртлөө надаас салаагүй. Хүүхдээ өнчрүүлэхгүй гэж тас гүрийсэн. Би ч хүүхдээ хойд эцгийн царай харуулахыг бодоогүй. Хоёр дахь эхнэр маань намайг авгай хүүхэдтэй гэдгийг мэдсэн мөртлөө суусан. Эхнэрээсээ салж чадах уу? гэхээр нь би чадахгүй гэсэн. За, тэгвэл одоо яая гэхэв гээд надтай суусан. Би ийм л эргүүлгэнд орчихсон хүн дээ. Харин надад ааш зан сайтай, амьдралын нарийн учрыг ойлгодог хүүхнүүд тааралдсан юм. Хартай, хортой хүүхнүүд таарсан бол дөч гарсан би өдийд юу гэж ингэж явах вэ дээ.

**-Таныг дуурайгаад хоёр эхнэртэй болох гээд тэнэгтэх эрчүүд гараад ирвэл яах вэ?**

-Эхнэр бүхний чинь ард итгэл, сэтгэл, амьдрал, мөрөөдөл гэж байдгийг ухаарах хэрэгтэй. Тэгээд хоёрын хоёр хүнийг юугаар ч гачигдахын зовлонгүй тэжээж тэтгэж чадаж байвал болох нь тэр. Би юугаараа бардам байдаг вэ гэвэл хоёр эхнэрийнхээ дунд ямарч нууж хаах юмгүй, илэн далангүй уур амьсгал бүрдүүлж чадсандаа бардам байдаг. Саваагүй нохой саранд хуцна гэгчээр иймэрхүү уур амьсгал бүрдүүлж чадахгүй бол дэмий биз дээ. Тэгээд ч миний хоёр эхнэр шиг бие биеэ ойлгодог төлөв даруу хүмүүс тэр бүр тааралдахгүй. Новшийн хүүхнүүд тааралдах юм бол бие биетэйгээ барьцалдаад, нөхрийгөө булаацалдаад нүдний булай болох байлгүй. Харин О.Дашбалбар агсан гурван эхнэртэй байсан гэж яригддаг. Монголын нэг том яруу найрагчийг дор бүрнээ хүндэлсэн нинжин сэтгэлтэй хүүхнүүд тааралдсан бололтой. Тийм учраас хэрүүл шуугиан гараад байдаггүй байсан биз. Миний хувьд гэвэл хүмүүс намайг яаж хүлээж авах нь надад хамаагүй. Би хоёр эхнэртэйгээ зөв зохицож, эхнэрүүд маань хэн хэнийгээ ойлгож байвал болох нь тэр. Би хоёр газар амьдардаг. Хоёр эхнэр маань юугаар ч гачигдах зовлонгүй сайхан л амьдарч байна. Гэтэл эхнэрээ тэжээх нь байтугай өөрөө тэжээлгэчихээд сүүлрээд яваад байдаг хүмүүс байж л байдаг. Ингэж амьд явсанаас илэн далангүй үнэнээ хэлчихээд эхнэрүүдээ тэжээж явсан нь хамаагүй дээр.

**-Амьдрал ер нь юун дээр тогтдог юм бэ?**

-Амьдрал ганц хайр сэтгэл дээр биш, бүхий л юман дээр тогтдог. Хоёр эхнэртэй байна гэдэг чинь хоол идчихээд, хонож өнжөөд байхын нэр биш. Ухаандаа би чинь бусад хүмүүсээс хоёр дахин илүү сэтгэж, хоёр дахин илүү хөдөлмөрлөнө гэсэн үг.

**-Ингэхэд та өөрийнхөө ажлыг танилцуулна уу?**

-1993-98 онд би вокзал дээр тэрэг түрдэг байсан. Хар ажил хийж сурсан хүнд тэрэг түрнэ гэдэг бол хачин гоё ажил. Эцэж цуцна гэж байхгүй. Энэ ч утгаараа би вокзал дахь тэрэгний бизнесийн хамаг л орон зайг атгаж байлаа шүү дээ. Мөнгийг ёстой өм цөм хийдэг байлаа. Надтай хамт ял эдэлж байсан «үхэр» Гончигоо гэгч нөхөр миний баруун гарын туслах байлаа. Энэ эр ёстой үхэр шиг зүтгэдэг, би түүнд болон өөртөө тэрэгний ачаа олох гэж адуу шиг пижигнэдэг байлаа. Ингэж таван жил нойр хоолгүй зүтгэсний хүчинд би өөрийн гэсэн хашаа байшинтай, машин тэрэгтэй болсон. Тэгтэл 1998 онд «үхэр» Гончигоо маань зуурдаар нас барж миний гарыг мухарласан. Тэр цагаас хойш би урагшаа хойшоо явж бизнес хийхийн хажуугаар зарим нэг албан газар захиалгаар тавилга хэрэгсэл хийж өгч байсаар 2003 онд өөрийн гэсэн мужааны цехийг нээсэн. Одоо манай цех долоон хүнтэйгээр үйл ажиллагаа явуулдаг. Би “Нарантуул” зах дээр тавилга зарах гэж үйлээ үздэггүй. Зардаг хүмүүст нь бөөндөөд өгчихдөг. Намар болохоор баахан гэрийн тавилга хийж аваад хөдөө нутгийг зорьдог. үүний хажуугаар би хоёр ч дэлгүүр ажиллуулдаг. Хоёр эхнэр маань нэг нэгээр нь ажиллуулдаг. Би бүх барааг нь татаж өгнө. үүгээр зогсохгүй нярав, ня-бо, ачигч, ченж гээд бүхий л ажлыг нь хийж гүйцэтгэнэ. Эхнэрүүд маань дэлгүүртээ суух л үүрэгтэй. Хоёулангаас нь гарсан миний хүүхдүүд байна. Тэд бас ээж нартаа тусална. Амьдарч чадаж байгаа хүнийг хэн ч өөлж чаддаггүй юм. Намайг хоёр эхнэртэй гэж өөлөх хандлага байдаг. Гэвч хоёр талд амьдрал цэцэглүүлж чадаж байгаа болохоор яаж ч чаддаггүй. Атаархал гэдэг чинь арчаагүй хүний араншин шүү дээ. Хамгийн гол нь би авхаалжтай, ажилсаг хүн бүрэн дүүрэн амьдарч

чадах өнөөгийн энэ ардчилсан, зах зээлний нийгэмд баярлаж явдаг даа. Социализмын үед бол яагаад ч ийм амжилтанд хүрч чадахгүй байлаа шүү дээ. Хичнээн хайр сэтгэл байвч тэжээж тэтгэх мөнгөгүй бол нөгөө хайр сэтгэл чинь аажим аажмаар унтарчихдаг юм. Өнөө үед бодож сэтгэж хөдөлмөрлөж чадах юм бол сайхан амьдралыг цогцлоох дүүрэн боломж байна. Тэгэхээр мөнгө, хайр сэтгэл хоёр бол хоорондоо салшгүй холбоотой. Социализмын үед хэдий мөнгөтэй байсан ч хоёр эхнэртэй байх юм бол элдэв асуудалд орооцолдож мэдэх байсан. Энэ чинь социалист аж төрөх ёсонд харш шүү дээ. Намын гишүүн байлаа гэхэд үгүй ядаад намаасаа хөөгдөх жишээтэй. Өнөөдөр хоёр эхнэртэй байлаа гээд аль нэг нь намаас хөөгдөх болж байна уу? Харин хоёр эхнэрээ тэжээж чадахгүй мөртлөө хов жив хутгаад хооронд нь зодолдуулаад байдаг бол ёстой утгагүй. Иймэрхүү бодолтой хүн хоёр эхнэртэй байхын тухай санахын ч хэрэггүй. Аягүй бол хүн амины хэрэг тарьж хэн хэндээ гай болно.

**-Таны энэ байдал чинь тэгвэл сүүлрэх биш юмаа?**

-Юуны чинь сүүл. Битгий дэмий юм яриад бай. Сүүлэрнэ гэдэг чинь эхнэрийгээ гол гаргаж байна гэсэн үг. Сүүл гэдэг чинь нэг өөр, аргагүй амраг гэдэг чинь бас нэг өөр ойлголт. Завсарын биш заяаны хань гэдэг бол агуу. Хувь төөрөг маань заяаны хоёр ханьтайгаар зурагдсан юм байлгүй дээ. Үүндээ би үнэхээр баярлаж явдаг шүү.

## «Онгорхой» Барамсай Мааньтын чангад үнэхээр амьтан болжээ

Өвөрхангай аймгийн харъяат «Онгорхой» Барамсай хоёр ч удаа шоронд ял эдэлсэн бөгөөд анх тэрбээр тогоотой сүүнд цустай гараа угааснаас болж хожим гэмт хэрэгт байнга өртөх болжээ. Барамсай 1973 онд цэргээс халагдаад нутагтаа очиж хэдэн нөхдийн хамт айл хэсч, архи айраг эргүүлж явжээ. Тэгээд нутаг усандаа агсам зангаараа алдартай «Булуу» Тавхай гэгчийнд ортол тэр шал согтуу сууж байж. «Булуу» Тавхай нь Барамсайг цэрэгт байхад эцэг эхэд нь агсам тавьж байнга тогоо нэрүүлж уудаг байсан бөгөөд үүний өшөөг авахаар Барамсай ирсэн нь тэр байлаа. Ингээд бөөн зодоон болсон байна. Барамсай хэдэн нөхдийн хамт «Булуу» Тавхайг нэвширтэл нь зодоод гэрийн баруун хаяанд хураалгаатай байсан эсгийнээс нэгийг суга татаж түүнийг боож орхижээ. Харин зодоон болох явцад Барамсай хамар руугаа цохиулснаас их хэмжээний цус гарсан байна. Тэгээд усаар угаахын оронд «Булуу» Тавхайг хорлох сэтгэл өвөрлөж тогоотой сүүнд нь цустай гараа угаачихжээ. Гэвч энэ нь Тавхайг хорлох бус өөрийгөө хорлох үйлдэл байсныг тэр тухайн үед ойлгож ухаарсангүй. Энэ цагаас хойш Барамсайн ааш авир ихээхэн эвдэрч сав л хийвэл хүн зодох, биеийн амрыг харж хулгай зэлгий хийх, тэр ч байтугай дээрэм тонуулд хүртэл ихээхэн гаршжээ. Аав ээж нь ганц хүүгээ зөв замд нь оруулах гэж нэлээд тэмцсэн бөгөөд эцэстээ арга нь барагдаад нутгийн номтой лам Гэлэгжамц маарамбаас хүүгийнхээ талаар асуутал «Танай хүү чинь мал баялагийн эзэн сахиус Бисман тэнгэрийг хилэгнүүлсэн байна. Их муухай цээртэй юм хийж дээ. Буянт малын сүүгээр цустай гараа угаасан хүн ерөөсөө өөдөлдөггүй юм. Би л хувьдаа аргалж чадахгүй, миний мэдлээс хэтэрсэн байна» гэжээ. Аав ээж нь Барамсайд энэ тухай хэлтэл «Юу ярьж байгаа юм бэ. Тэр муу лам юу мэддэгтээ ингэж солиордог юм бэ. Би та нарыг өмөөрч яваад л «Булуу» Тавхайд хамраа тэс цохиулж тогоотой сүүнд нь цустай гараа угаачихсан юм. Тэр муу Гэлэгжамц маарамба чинь энэ тухай сонсчихоод өөрийгөө номтой хүн гэж харагдуулахын тулд ингэж хэлж байгаа юм. Ер нь тэр муу Гэлэгжамцтай учраа ололцоно» гэж учиргүй уурлаад мориндоо ташуур өгч тэднийх руу давхижээ. Тэгээд гэрт нь очоод зуухыг нь чулуудаж бөөн үнс, май болгоод зогсохгүй Гэлэгжамц маарамбыг заамдан авч «За чи тийм айхтар мэддэг юм бол миний хэзээ үхэхийг хэлээд өг» гэж шаарджээ. Гэлэгжамц маарамба түүнээс айхын эрхэнд зоос хаяж «За чи ямар ч гэсэн зуугийн талыг наслах юм байна. Гэхдээ их л зовж үхэх нь дээ. Харин ухаантай явах юм бол 93 насалж үр ач нараа тойруулаад амар амгалан нүд аних нь» гэсэн байна. Гэтэл Барамсай «Битгий худлаа хуц чи. Би чамайг хэлсэн хэлээгүй зуу наслах хүн. Бас намайг 93 наслуулж долоон жилийн өмнө үхүүлэх нь ээ. Алив танайд сүү байна уу» гэсэн байна. Гэлэгжамц маарамбынд сүү байсан боловч байхгүй гэсэн байна. Гэтэл Барамсай хажуу талын айлаас нь сүү гуйж авчираад «За чи намайг харж бай» гэснээ өөрийнхөө хамар руу цохиж цус гаргаад мөнөөх сүүгээр нүүр гараа угаачихсан байна. Энэ цагаас хойш Гэлэгжамц маарамба нэг их удалгүй таалал төгссөн бөгөөд ариун цагаан сүүгээр цустай гараа угаасан «Онгорхой» Барамсайн хараал хүрсэн бололтой. Ер нь сүү бол их ариухан идээ бөгөөд ёс мэддэг хүмүүс булаг шанднаас ус авахдаа ч сүүний шавхруутай шанагаа усанд дүрдэггүй. Харин Барамсай мэтийн арилсан дотортой амьтад усанд байтугай цусанд дүрсэн байна. Гэлэгжамц маарамбынд хүүгээ агсам тавьсныг аав, ээж нь сонсоод Барамсайг зөнд нь орхижээ. Барамсай сав л хийвэл зодоон нүдээн хийхээс гадна айлын мал хулгайлж зардаг ажилтай болсон бөгөөд байсхийгээд л аймгийн мөрдөнд очиж байцаагдана. Тэгээд хамгийн сүүлд өлзийт сумын Худалдаа бэлтгэлийн складыг ухаж их хэмжээний торго авч явах гэж



байгаад газар дээрээ баригдсан бөгөөд энэ хэрэгтээ зургаан жилийн ял авч өвөрхангайн Бат-өлзийн /Эдүгээ Хархорины/ шоронд очсон байна. Энд ирээд бас зүгээр байсангүй. Нэгэн атаман хоригдолтой зодолдож үүдэн шүднүүдээ цөм цохиулж насаараа онгорхой явах болж, тэр ч бүү хэл «Онгорхой» Барамсай гэж дуудуулах болжээ. Тэрбээр зургаан жилийнхээ ялыг ихээхэн хэл амтай дуусгаад нутагтаа ирсэн боловч бас л засарсангүй. Цаанаасаа л эз нь хатгаж ямар нэгэн гэмт хэрэгт яаж ийгээд л холбогдчихно. Энэ хугацаанд эцэг эх хоёр нь ч өөд болж Барамсайд таван ханатай гэр үлдсэн хэдий ч түүнийгээ зарж мөрийтэй тоглоод хамаг мөнгөө тавиад туучихжээ. Ингээд орон гэргүй гон бие гозон толгой өвөрхангай аймгийн хэдэн сумдаар чөлөөтэй сэлгүүцэх болов. Ингэж явахдаа хичнээн ч мал нааш цааш нь болгосныг бүү мэд. Ямартай ч малын хулгайнаас гадна өлзийт сумын хэсгийн төлөөлөгчийн тархийг хага цохьсон хэргээр аймгийн мөрдөнд хэдэн сарын турш байцаагдаж, уг хэрэгтээ найман жилийн ял аваад Мааньтын чанга руу илгээгджээ. Харин энд ирээд тэр нутгийнхаа шоронд байсан шигээ овгор товгор байж чадсангүй. Тэрбээр Мааньтын шоронд орохоосоо өмнө даалуу тоглож байхдаа «Нурсан овоо нуруутай, нутгийн шорон ээлтэй» гэж цэцэрхдэг байсан гэдэг. Мааньтыш чангад Барамсай үнэхээр «амьтан» болсон бөгөөд ууланд мод хийж байгаад модонд дарагдаж, үүнийг нь хамт мод хийж байсан ялтан нь мэдээгүйгээс Барамсай бүтэн гурав хоног модонд дараастай хэвгэж, маш ихээр тарчилж үхсэн байна. Нэгэн цагт « зуугийн талыг насалж маш их зовж үхнэ» гэсэн Гэлэгжамц маарамбын үг яг л биелэлээ олсон бололтой.

## Дулааны Балдансамбуугийн элэг задарч амьсгал хураажээ

Монголын шоронгуудад ноцтой осол аваарь мэр сэр гардаг. Соц нийгмийн үед Хар-Айрагийн онцгой дэглэмийн шоронд нэгэн ноцтой аваарь гарсан бөгөөд гурван хоригдол нас барж, тавь гаруй хоригдол бэртэж гэмтсэн гашуун түүх бий. Тухайн үед Хар-Айрагийн шоронгоос нэлээд зайтай жоншны үйлдвэр байсан бөгөөд хоригдлуудыг тийш нь машинаар зөөж ажил хийлгэдэг байж. Нэгэн өдөр гурван машинд хоригдол ачаад араас нь нэг машинд буутай харуулууд сууж 50 метрийн зайтай хөдөлцгөөж. Хэрэв хоригдол ачсан машин хурд хэтрүүлвэл пуужингаар дээш буудан зогсоож зай бариулна. Тэгээд хоригдлууд очих газраа очиж жонш буталж байгаад оройн 18 цагт машиндаа ачигдаад зоон руугаа хөдөлжээ. Гэтэл гучхан минут давхиад л зоон дээрээ хүрчих ёстой байтал хоёр гурван цаг саатжээ. Хорих ангийн жижүүр оройн 20 цаг хүртэл хулээгээд ирэхгүй болохоор нь «Ялтнууд оргож боссон байхаас зайлахгүй» гэж бодоод түгшүүр авч яаран сандран хөдөлтөл хоригдол ачиж явсан машин аваарьт орсон болох нь ойлгогджээ. Тухайн үед бүрэнхий болж гэгээ тасарч байсан бөгөөд харуул хамгаалалт хүчлэн тойрсон эргэн тойронд орилж хашгирсан 50 гаруй хоригдол талаар нэг тарсан байв. Тэднийг ачиж явсан ГАЗ-53 машин жонш ачиж явсан МАЗ-тай мөргөлдсөнөөс нэг бүтэн хөрвөөж дөрвөн дугуй нь дээшээ харжээ. Мөргөлдсөн МАЗ-ны хойд хашлагад нэг хоригдол тэгнэгдэж гэдсэн биеэрээ тас татуулан хоёр хэсэг болчихсон байсан нь үнэхээр дотор хирдхиймээр байсан гэдэг. Булган аймгийн харьяат Дулааны Балдансамбуу гэгч хоригдлын элэг нь задарсан тул нэг өндийгөөд л амьсгал хураажээ. Мөн Жанжив гэгч хоригдлын толгой нь задарснаас уураг тархи нь харагдаж байсан байна. Харин халхын шоронд нэгэн үе атаман гэгдэж байсан «Махан толгой» Мягмар 30 гаруй метр хол шидэгдсэн ч зүв зүгээр босч ирсэн гэдэг. Бусад хоригдлын гар хөл нь гэмтэж, тархи толгой нь хагарсан байсан бөгөөд тэднийг Дорноговийн эмнэлэгт яаралтай авчирч эрчимт эмчилгээнд оруулан оёдол тавьж дусал хийснээр амь аврагджээ. Энэхүү осол нь Монголын шоронгуудад гарсан осол авааруудаас хамгийн томд тооцогддог байна.

## Шоронд шуугиулж явсан Тогоогийн

### Отгон гэж хэн бэ?

Төв аймгийн харъяат Тогоогийн Отгоныг дал наяд оны хулгарууд андахгүй. Тогоогийн Отгон нутагтаа байхдаа шаггүй атаман байсан бөгөөд шоронд ирээд ч энэ зангаа тавьсангүй. Тэрбээр Цэвээний «хар» Лхамсүрэн, Эрдэнэ-Очирын Баттулга, Дашийн Мундаа нартай ана мана үзэлцдэг байж. Шоронд байхдаа янз бүрийн гэмт хэрэгт орооцолдож ялаа нэмүүлсээр жирийн дэглэмээс гяндан хүртэл дамжжээ. Тогоогийн Отгон хамгийн сүүлд Хар-Айрагийн онцгойгоос оргох гэж оролдоод бүтэлгүйтсэн гэдэг. өөрийн гал хам Эрдэнэ-Очир, Баасаажав нарыг ятгаж хамтарч оргохоор шийдсэн бөгөөд «Самосвал» машинд жонш ачиж байгаад гэв гэнэт л оргох төлөвлөгөөгөө хэрэгжүүлсэн байна. Эрдэнэ-Очир жолооч Доржийг машиндаа сууж байхад нь хаалгыг нь тогшиж «Бидэнд дэлгүүрээс тамхи авчирч өгөөч. Тамхи тасраад хэцүү байна» гэх зэргээр зовлон тоочиж мөнгө сарвайхад цаад хаалгаар нь Отгон, Баасанжав нар хүч түрэн орж ирж жолооч Доржийг цамцны захаар нь хоолойг нь боож айлган сүрдүүлээд хол байрладаг хөндий зай руу чихэж оруулан Отгон жолооны ард суужээ. Асаагчийн түлхүүрийг түлхэж үзтэл бензин дүүрэн зааж байсан тул тэд баярлан «Ямар ч байсан энэ үхээрийн газраас мултарад урагшаа хил давчих бензин байна. Ингээд бид Хятадын иргэн болох нь тэр. Монгол руу хэзээ ч зүглэхгүй» гэж хөөрцөглөөд машины, арааг газрын уруу руу мулталаад шууд хөдөлжээ. Доржийн тэрэг ачаагаа ачиж дуусгалгүй уруу газар өнхөрч явахад зуугаад метрийн зайд байсан харуулын цэрэг анзаарсангүй. Гэтэл машин газрын уруу руу нэг тоормослож, нэг хурдлаад бараг л онхолдох маягтай овгос овгос хийхэд харуулын цэрэг сэжиг авч араас нь хэд хэдэн удаа хий буудсан боловч машиныг алдчихжээ. Харин жолооч Доржийг замд буулгаж хаясан байна. Тэгээд тэр даруйдаа зоон даяар түргэн авч тэдний хойноос хоёр машин хөөсөн боловч сураггүй алдан буцаж иржээ. Төдөлгүй энэ тухай төв рүү мэдээлж нисдэг тэрэг дуудуулжээ. Энэ үйлдэл өдрийн 16 цагт болсон бөгөөд машин авч зугтсан оргодлууд үхэлтэй өрсөлдөж, буун сумтай уралдаж явсаар машинаа гүн жалганд оруулж хөдөлгөөнгүй болгосноор бүгд баривчлагджээ. Тогоогийн Отгон энэ хэрэгтээ ял нэмүүлж гяндлуулсан байна. Харин гянданд ирээд Цэвээний «хар» Лхамсүрэн нарын жинхэнэ атамануудтай учирч ана мана үзэлцсээр найз нөхөд болцгоожээ.

## 1979 онд Зүүнхараагийн шоронд болсон хачин явдал

1979 оны 12-р сард Зүүнхараагийн чанга дэглэмтэй хорих ангид нэгэн сонин явдал болжээ. Тухайн үед тус анги Польш руу вагоноор гуалин гаргадаг байж. Тэгтэл нэг удаа Польш руу ачигдсан гуалин замдаа нуралт үүссэнээр Сэлэнгэд гаалийн шалгалтанд орох боломжгүй болсон байна. Тиймээс тус хорих ангийн нэг ахмад ачааг засч ачихаар арав гаруй ялтан дагуулаад нуралт үүссэн газарт очжээ. Гуалинд нэгэнт л нуралт үүссэн бол бүгдийг нь буулгаад дахин ачих шаардлагатай болдог байна. Ингээд арав гаруй ялтан бүх гуалинг галт тэрэгнээс буулгажээ. Тэгтэл гуалингаар халхлагдсан байсан ачааны галт тэрэгний ханан дээр монгол, орос, польш, герман хэл дээр бичсэн баахан ухуулах хуудас наасан байж. Тэрхүү ухуулах хуудсанд «Дэлхийн аль ч улсад урьд хожид хэзээ ч гарч байгаагүй аймшигт яргалал БНМАУ-д болж байна. Ганц жишээ дурьдахад БНМАУ-ын Сэлэнгэ аймгийн Зүүнхараа хотын чанга дэглэмтэй шоронгийн удирдлага үйлдвэрлэл-ийнхээ төлөвлөгөөг биелүүлэх зорилгоор 1979 оны 12-р сарын 15-наас 22-ныг хүртэл 712 хоригдолыг 25-30 хэмийн хүйтэнд, жадтай буун дор тасралтгүй ажиллуулж хүний эрхийг ноцтой зөрчлөө. үүнийг уншсан хүн гадаадын хэвлэлийнхэн буюу капиталист орны элчингээр дамжуулж НҮБ-ын хүний эрхийн хороонд мэдэгдэж тусална уу? Таныг тэнгэр бурхан ивээнэ» гэж бичсэн байж. үүнийг харсан шоронгийн ахмад эвэртэй туулай үзсэн мэт гайхаж ангийнхаа удирдлага руу нэн яаралтай мэдэгдсэн бөгөөд тэрбээр “Манай хорих ангид социализмын эсрэг тэрсэлсэн бүхэл бүтэн эсэргүү бүлэг ажиллаж байна. Одоохон түгшүүр авч эсэргүү хэрэгтнүүдийг илрүүлэх хэрэгтэй. Мөн ачааны вагоны ханан дээр бичиж наасан ухуулах хуудаснуудыг шинжилж судлах хүмүүсийг нааш нь нэн яаралтай явуул” гэх зэргээр нэг л их том тагнуулын хэрэг илрүүлчихсэн аятай дөвчигнөсөн байгаа юм. Нээрээ ч төдөлгүй хорих ангийн удирдлага түгшүүр авч, зарим албан тушаалтныг хэргийн газар луу явуулсанаар дээрхи ухуулах хуудаснууд эсэргүү хэрэгтнүүдийн эд мөрийн баримт болж хувирсан байна. Гэхдээ тус ангийн удирдлага өөрсдийнхөө буруутай үйл ажиллагааг мэдэгдүүлэхгүйн тулд уг асуудлыг зөвхөн анги дотроо нууцлахаар шийдсэн байна. Тэгээд эсэргүү хэрэгтнүүдийг өөрсдөө илрүүлж арга хэмжээ авахаар болсон бөгөөд мянга гаруй ялтаныг толгой дараалан жагсааж байгаад бичиг үсгийн чадвар бүхий дээд боловсролтой 12 хоригдол, Хятад улсын харъяат» хоёр хүнийг сэжиглэн хорьж шалгажээ. Гэвч хэргийн эзэн тодорсонгүй. Учир ив дээрх ялтанууд дундаас орос, польш, германаар ярьж, бичдэг хүн олдоогүй бөгөөд эцэст нь хорихын удирдлага “Энэхүү эсэргүү гэмт хэрэг дотроосоо үйлдэгдсэн биш гаднаас үйлдэгдсэн байна” гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Тэгээд тэд тухайн үед Зүүнхараа хотод оршин сууж байсан боловсрол мэдлэгтэй, гадаадад сургууль дүүргэсэн хүмүүсийг хардаж сэжиглэсэн боловч харамсалтай нь бас л хэнийг ч илрүүлж чадаагүй аж. үнэхээр сонин юм шүү. Мөнөөх ухуулах хуудас орос, польш, герман хэлээр нэлээд углуургатай бичигдэхийг бодоход социалист системийн орнуудад олон жил суралцсан, юмны учир мэддэг, хөрөнгөт ертөшийн ахуй амьдралыг гадарладаг, тэр ч байтугай Гадаад явдлын яам мэтийн том газар ажилладаг хүмүүс бичиж өгөөд ялтануудаар ачааны вагоны ханан дээр наалгуулсанаас зайлахгүй. Зүүнхараагийн чангын удирдлага ийм нэг учир битүүлэг хэргийг илрүүлэх гэж бүтэн жил зууралдаад эцэст нь зөнд нь орхисон байна. Шоронгийн удирдлага уг хэргийг нам засаг байтугай удирдах газартаа ч мэдэгдэлгүй хав дарсан бөгөөд дээрхи явдлын тухай зөвхөн ялтанууд л хоорондоо ярилцдаг болж. Гэхдээ дээрхи явдлыг ярьж байгаад удирдлагадаа хар авахуулсан ялтан дор хаяад хорь хоногийн сахилгад суудаг байж. Хоригдолын ар гэрийнхэн

эргэлтээр очих үед хуягууд дэргэд нь заавал байх, эсвэл эргэлтийн байрны цэвэрлэгч нэртэй “бууны нохой” дэргэдээс нь салдаггүй байж. Энэ мэтийн явдлаас болж Зүүнхараагийн чанга дэглэмтэй шорон аливаа мэдээллийг гадагш нь дамжуулахгүй, хачин чанга харуул хамгаалалттай “нууцын авдар” байсаар 1990 онтой золгосон байна.

## Шоронгуудад хувьчлагдсан хоригдол гэж байдаг

Зүүнхараагийн чанга дэглэмтэй шоронд жилд дундажаар 1000-аад хүн орж 40-50 хүн өөр шоронд шилжиж, 20-30 хүн үхэх буюу эмнэлэгт хэвтдэг юмсанж. Олон жилийн ялтай хоригдолууд нэлээд байдаг болохоор хорих ангиас ялтан суллагдах нь өдрийн од ажээ. Ингээд тус хорих ангид 1990-2000 он хүртэл арван жил ял эдэлсэн Цээхүүгийн Эрдэнэбат гэгч эртэй ярилцсанаа толилуулъя.

**-Та Зүүнхараагийн чангад арван жил болсон болохоор бараг л энэ шоронгийн нэвтэрхий толь болчихоо биз дээ?**

-Нэвтэрхий толь нь ч юу юм бэ. Гэхдээ 1990-2000 онд уг шороуд болж өнгөрсөн элдэв сайн муу явдал, дарга нарынх нь бузар булайг мэднэ шүү. Гэхдээ зарим дарга нарын нэрийг жаахан өөрчилж ярина гэдгээ сануулчихъя. Яагаад гэвэл тухайн үед арга хэмжээнд орж байсан зарим хүн эдүгээ цагаадчихсан, зарим нь арга хэмжээ авахуулаад эдлэх ёстой үйлийн үрээ эдэлчихсэн яваа. Бусад шоронд ямар байна, Зүүнхараагийн шоронд яг л тийм. Намайг ял эдэлж байх үед нэгнээ дарамтлах, дээрэлхэх, бандидах, бие биенийхээ хувцас, хоол хүнсийг дээрэмдэх, хулгайлах гээд бүхий л зүйл ном журмынхаа дагуу явагддаг байлаа. Харин бусад шоронгоос харьцангуй илүү зүйл нь Зүүнхараагийн шоронд чөлөөтэй архидаж эрх дураараа авирлаж болдог байсан. Хуягууд юу харж суудаг юм бол гэж хэн бүхэн бодох байх. Тэгвэл тэдэнд зовлон их бий. Шоронд байгаа бүх хоригдол архидаж танхайрдаггүй нь ойлгомжтой. Цөөн тооны нөлөө бүхий хоригдолууд л архидана. Нөлөө бүхий гэдэг нь шоронгийн дарга нарын ивээлд багтсан рецедив гэмт хэрэгтнүүд. Ер нь тэдний санаа зорилгоор шоронгийн удирдлага ажлаа явуулдаг гэж зарим албан хаагчид, хоригдолууд үздэг байлаа шүү дээ. Ялангуяа «Наалданги» хочтой Оюунбаатар, Баясах, «Ногоон» Жагаа гэгч гурван хоригдол шорон доторхи бүхий л үл бүтэх, аймшигт явдлыг уриалан зохион байгуулдаг байсан. Дарга нар ч тэднийг улайм цайм өмөөрч, шаардлагатай үед зарим нэг хэл амтай офицер, албан хаагчдыг хүртэл ажлаас нь халж хоолноос нь салгасан удаатай. Ийм учраас жирийн хуягууд хоолтойгоо үлдэхийн тулд Оюунбаатар тэргүүтэй рецедивүүдтэй зууралддаггүй байсан юм. Би энд ганцхан жишээ дурдъя. 2000 оны 3-р сарын 5-ны өдрөөс Зүүнхараагийн шоронд Мартын наймны «настроение» эхэлсэн. Дан эрэгтэй хоригдлуудтай газар Мартын наймны баяр тэмдэглэхийг бодоход их л задгайрсан үе байлаа. Харин одоо бол өөр болсон байх аа. 3-р сарын 5-ны өдөр хоригдол Бат-Эрдэнэ гэгч ялтан архидан согтуурч хоригдол Дарханбаатарыг 22 удаа, Пүрэвжавыг 20 удаа хутгалсан бол орой нь шоронгийн овгорууд болох өлзийбат, Энхсайхан, Оюун-баатар, Энхжавхлан нар архидан согтуурч, Оюунбаатар хоригдол Дамдинсүрэнг хутгалж гэмтээсэн. Тиймээс ээлжийн дарга Бат-Эрдэнэ, Оюунбаатар хоёрыг сахилгад хорьсон. Тэгтэл шоронгийн дарга Шаагий /нэрийг нь нууцлав/ маш их уурлаж «Оюунбаатар миний хүн. Надаар оролдвол дэмий шүү» гэх зэргээр дарамт үзүүлж байгаад Оюунбаатарыг ямар ч ял шийтгэлгүй өнгөрөөж билээ. Харин нөгөө хоёр ялтаныг хорь гаруй удаа хутгалсан Бат-Эрдэнэ ялаа нэмүүлж гяндлуулсан даа. Оюунбаатар мэт нь нэгэнт дээрээ ийм хамгаалалттай юм чинь таихайраад байхаас биш яахав. Одоо тэр чухам хаана байгаа юм бүү мэд. Зүүнхараагийн шорон нэг иймэрхүү л байлаа. Зарим нь турж үхэж байхад зарим нь архи уугаад аагаа багтааж яддаг байлаа шүү дээ. Тэр ч байтугай Зүүнхараагийн шоронд хувьчлагдсан хоригдол байсан юм шүү.

## **-Юу гэсэн үг вэ? Ялтаныг чинь бас хувьчлаад авчихдаг хэрэг үү?**

-Зарим шоронд «Хувьчлагдсан хоригдол» гэдэг нэр томъёо байдаг юм. Зүүнхараа дахь 413-р хорих ангийн дарга нар хорих байгууллагын дүрмийг ноцтойгоор зөрчиж чанга дэглэмтэй ангид хоригдож байгаа онц хүнд гэмт хэрэгтэй ялтануудыг ямар ч чөлөө зөвшөөрөлгүй авч явж ял завшуулах, гэрийн ажлаа хийлгэх, тэр ч бүү хэл бусдаас хахууль авдаг ч юмуу айлд аваачиж зарцлуулж, ёстой нэг дураараа дургиж дунд чөмгөөрөө жиргэдэг байсан юм. Одоо харин олон улсын төсөл энэ тэр хэрэгжээд дарга нарынх нь ханд дарагдаа биз дээ. Тэгээд ч өнөөдөр дандаа шинэ дарга нар үүрэг гүйцэтгэж байгаа сураг дуулдсан. Миний үеийн хуучин дарга нар бүгд будаа болсон сурагтай. Тэд бол юу ч хийхээс буцахгүй дайчихсан амьтад байлаа. Хувьчлагдсан хоригдолыг гэртээ зарсаар байгаад сайн ажилласан гэж шагналын хоног өгөөд шоронгоос сулласан тохиолдол ч бий. Жирийн болон чанга дэглэмтэй шоронгоос хоригдол шилжүүлэн гэртээ байлгаж байгаад шагналын хоног олгодог байсан нь үнэхээр хачирхалтай. Харамсалтай нь энэ үйлдлээс болж нөгөө ялтанууд нь итгэл эвдэн оргох, дахин гэмт хэрэг үйлдэх, зуурдаар нас барах зэрэг гунигт явдлууд зөндөө тохиолдсон. Тухайлбал «Ерөнхийлөгчийн хүү» хочтой Төмөрчөдөр гэгч байна. Энэ ялтаныг хорих ангийн ерөнхий нябо Доогийгийн ивээлд байсан болохоор нь ингэж хочилсон. Хорих ангийн нябо түүгээр үхрээ маллуулж байгаад ажлын хоногоор шагнуулж 2000 оны 4-р сард ялын хугацаанаас нь өмнө суллаж байлаа. Мөн хорих ангийн дэд дарга асан Баагий гэгч хувьчлагдсан хор-игдол гэх хүн амины хэрэгтэй Баясахыг зоон руу хэзээ ч оруулдаггүй байлаа. Баясах сумын прокурорын машиныг барьдаг байсан юм. Нэг л их эрх чөлөөтэй хүн амины гэмт хэрэгтэн машин бариад л, архи ууж, хүүхэн эргүүлээд л цохиж явдаг байлаа шүү дээ. Энэ ялтаныг хорихын даргаас ч илүү эрх мэдэлтэй гэж албан хаагчид ярьдаг байлаа. Хорих ангийн дарга асан Шаагай нэг удаа Амгалан дахь жирийн дэглэмтэй ангийн хоригдол Алтанбат гэгчийг гэртээ авчирч хоёр сар байлгаад ажлын хоногоор шагнаад суллагчид билээ. Бодвол Алтанбат түүний хамаатных нь хүн байсан бололтой. Эсвэл ар гэрийнхнээс нь их хэмжээний хахууль авсан байхаас зайлахгүй. Мөн тэр урьд нь олон жил шоронгоор яваад суллагдсан Лочин гэгч хүний хувийн рам дээр таван удаагийн ялтай рецидив гэмт хэрэгтэн Пүрэвдорж гэгчийг ажиллуулдаг байлаа. Тэгтэл нэг өдөр Пүрэвдорж нь насанд хүрээгүй нэг охиныг хүчирхийлж үндсэн ялан дээрээ дөрвөн жилийн ял нэмүүлж билээ. үүнээс гадна тэр Дагвадорж гэгч айлын хадлан дээр таван удаагийн нахиур рецидив гэмт хэрэгтэн Чадраабалыг дур мэдэн өчнөөн хоногоор ажиллуулсан. Гэтэл Чадраабал нь хээр нас барчихаж билээ. Ар гэрийнхэнд нь юу гэж мэдэгдсэн бол доо. өөр нэг ноцтой асуудал гэвэл 1999 оны 11-р сард Зүүнхараагийн шоронд амиа хорлохоор долоо найман хоригдол цусаа ханаж байлаа. Рецидив гэмт хэрэгтэн Оюунбат гэгч УИХ-аас өршөөл үзүүлэхийг шаардаж өөрийн амиа егүүтгэхээр цусаа ханасан. Тэгтэл үүний дараахан Баярмагнай, Отгонбаатар, Баттулга, Зандан, Төгөлдөр нарын долоон ялтан ээлж ээлжээр цусаа ханаж хорихын удирдлагыг сандаргаж билээ. Эдгээр ажиллагааг “Дух” Батсайхан гэгч этгээд зохион байгуулсан гэж яригддаг боловч энэ асуудал нам жим өнгөрсөн.

## **-Та чинь тэр чигээрээ нэвтэрхий толь юмаа?**

-Энэ юу ч биш. Ярьж болохгүй юм гэж бас байна шүү дээ. Хохирогч нарын ар гэрийнхэн «Алуурчин шоронд орсон» гээд бага боловч гомдол нь нимгэрдэг байх. Гэтэл мөнгө төгрөгтэй, зальтай, сэргэлэн ялтанууд дээрх маягаар ял завшаад л явж байдаг юм шүү

дээ. Бусад шоронгуудад ч иймэрхүү явдал байдаг л байх. Шорон битгий хэл армид байгаа гэсэн. Ганц жилийн цэрэг хүртэл дарга нараа хахуульдаад бараг л гэрээрээ алба хаачихдаг гэж байгаа. Ер нь жирийн дэглэмтэй хоригдолууд чанга дэглэмтэй хорих ангийн гадуурхи аж ахуйнх нь ажлыг хийж баймаар юм. Жишээ нь дээр өгүүлсэн прокурор заавал хоригдолоор машинаа бариулах сонирхолтой юм бол рецидив гэмт хэрэгтнүүдээр биш цөөхөн жилийн ялтай жирийн дэглэмтэй хоригдолыг жолоочоор авах хэрэгтэй. Хэрэв хүн алсан алуурчид энэ мэтээр ял завшаад айлд зарагдаад байж болдог юм бол хорь гучин жилийн ялтай хоригдлуудыг боол болгоод баячуудад дуудлагаар худалдчихмаар юм. Тэгвэл адаглаад л төрийн ачаа хөнгөрнө.



## Нутаг орондоо дархлагдсан «Шармиан»

### Дагвадорж «согоот» хэмээх хөндийг ганцаараа эзэгнэж байна

Яруу найрагч Бавуугийн Лхагвасүрэнгийн нэг шүлгэнд «Тэлмэн зэрэглээнд эмнэг адуу шиг цовхчих, Тэр хөх мөнхийн уул миний хүүгийн уул» гэсэн мөр байдаг. Нутаг орныхоо уул усыг үр хүүхэддээ үүрд мөнх «хувьчилж» өгч байгаа сайхан шүлэг. Үүн шиг Төв аймгийн харьяат «Шармиан» Дагвадорж хэмээх эр нутгийнхаа «Согоот» хэмээх хөндийг «хувьчилж» авчээ. Мөн Ховд аймгийн Мөст сумын иргэдийг алж хядна гэж занаж зүхсээр байгаад тэдний зүрхэнд орсон «Чангас» хочит Эрдэнэсонин гэгч эрүүгийн элемент нутагтаа нэг уулыг тэр чигээр нь «хувьчилж» авсан гэх бөгөөд өөрийнх нь тогтоосон хил хязгаар луу бусдын мал орж ирэхэд шууд л буудаж унагадаг гэж байгаа. Дээр өгүүлсэн «Шармиан» Дагвадорж мөн л олон жил шоронд суусан нэгэн бөгөөд энэ утгаараа нутаг орондоо «дархлагдсан хулгайч» юмсанж. Тийм ч учраас «Согоот» хэмээх хөндийг тэр чигээр нь эзэгнэдэг юм байх. Гэхдээ уг хөндийг түүнд аймгийнх нь газрын алба албан ёсоор олгочихсон хэрэг биш. Дагвадорж өөрөө өөртөө уг газрыг «хувьчилж» авчихаад байгаа бөгөөд хэрвээ түүний тогтоосон хил хязгаар луу бусдын адуу мал орж ирвэл гэрийнхээ ойролцоо байх том хашаанд авчраад хашчихдаг аж. Соц нийгмийн үед Сангийн аж ахуйн манаач нар тариан талбайд орсон адуу малыг тусгай хашаанд хашиж байгаад эздээс нь торгуулийн мөнгө саадаг байсан. «Шармиан» Дагвадорж яг л энэ жишгээр мөнгө саадаг ажээ. Тэрбээр адуу малаа авах гээд ирсэн хүмүүсийг баахан аашилж зандарсаны дараа «Малаа хариулгагүй орхисон та нарын түмэн буруу. Малын хулгайчууд адуу малыг чинь хөөгөөд явчихсан бол та нар яах улс вэ. Би л та нарын малыг харж ханддаг боллоо. Надаас малаа авах гэж байгаа бол мөнгөө төлөөд ав» гэдэг аж. Мань эр нэг адууг гурван зуун төгрөгөөр үнэлдэг бөгөөд азарга адуугаа түүний хашаанд хориулчихсан хүн дор хаяад арав гаруй мянган төгрөг төлдөг ажээ. Тэр нийтдээ таван удаа шоронд орсон бөгөөд суллагдах болгондоо нөхөр нь нас барсан бэлэвсэн эмэгтэйг эхнэрээ болгодоогоороо онцлогтой. Тэгэхээр нийтдээ таван удаа гэрлэсэн гэсэн үг. Суусан хүүхэн бүрээ хүүхэдтэй болгоод орхидог гэж бодохоор эцэг нэгтэй, эх ондоотой таван хүүхэд байгаа бололтой. Тэдний зарим нь «Шармиан» Дагвадоржоор овоглодог бөгөөд бүгд л наадам болгоноор морь уяж, эцгийнхээ шийрийг хатаах гэж оролддог гэнэ. Учир нь Дагвадорж залуудаа морь уяж нутаг орондоо нэлээд нэртэй явжээ. Гэвч тэр хурдан морь нутаг дамнуулан зарж байгаад баригдсан байна. Төв аймгийн морьдыг хаа холын Завхан рүү, Завханы морьдыг Хөвсгөл рүү мөн ч олон гулгуулжээ. Наадам болоод ирүүт түүний сэтгэл хөөрч сав л хийвэл шоронгоос оргочих гээд байдаг байсан бөгөөд тэр болгонд хэнгэнэтэл санаа алдаад «Манай хорихын удирдлага хурдан морь уядаг ч болоосой. Тэгвэл би улсад түрүүлүүлж чадна. Гэтэл би энд нэг муу жонш ухаад сууж байдаг. Удирдлага ч гэж удирдлага, ялтан ч гэж ялтан» хэмээн үнэн сэтгэлээсээ гасалдаг байж. Түүний нэг сайн тал нь хурдан морь шинжихдээ гаргууд бөгөөд айлын адуун дунд ороод «За энэ чинь л ёстой нэг давхих адуу байна даа. Хойтон жил уяарай» гэж өөртөө таалагдсан унага руу заана. Адууны эзэн түүний хэлсэн ёсоор хойтон жил нь уяхад тэр нь эсвэл түрүүлнэ, эсвэл айргийн тавд баттай ирдэг байж. Ер нь түүний шинжсэн хурдан хүлэг Төв аймгийн сумдад нэлээд олон байдаг бололтой. Харин тэр өвөл морь уралдуулахыг хүчтэй эсэргүүцдэг нэгэн бөгөөд нэг хүү нь түүнийг шоронд байхад нь хурдан азаргаа өвөл уралдуулжээ. Үүнийг сонсоод Дагвадорж «өвөл морь уралдуулдаг өөдгүй хүүхэд надад хэрэггүй. Хурдан хээр азарга минь чиний гараар орж ингэж үрэгдэх хувьтай байж.

Чамайг би шоронгоос гарч байгаад ална аа» гэж занасан байгаа юм. Тэрбээр өнгөрсөн жил өршөөлийн зарлигаар шоронгоос суллагджээ. Тэгээд мөн л сурсан зангаараа мал хуйтай нэгэн бэлэвсэн авгайтай ханилан сууж, «Согоот» хэмээх хөндийг «хувьчилж» аваад, тэрхүү хөндийдөө хурдан морь уядаг болсон нь энэ аж. үүний хажуугаар хурдан морь шинжихээр энэ тэнүүгээр уригдаж, ёстой л нэгэн насныхаа жаргалыг эдэлж яваа бололтой. Харин хурдан азаргаа өвөл уралдуулсан хүүтэйгээ одоо хүртэл уулзаагүй, уулзахыг ч хүсэхгүй байгаа гэнэ. «Хүү чинь энэ жилийн наадмаар гурван ч морь уяж байна лээ. Чи очиж уяа сойлгыг нь тааруулж өгмөөр юм даа» гэж нутгийн хүмүүс Дагвадоржид хэлэхэд «үгүй шүү. өөрөө над дээр хадаг яндар, архи дарстай, хажуудаа бас нэг хурдан хүлэгтэй ирэх юм бол би түүнтэй эвлэрнэ. Түүнээс нааш би түүнтэй хэзээ ч эвлэрэхгүй» гэж аархдаг аж.

## Тувагийн дээрэмчин Мичид-Оол Улиастайн шоронд гунигтайгаар амьсгал хураажээ

1970 оноос эхлээд нутаг нутгийн шорон гээчийг гаргаж ирснээр гэмт этгээдүүдийг залхаан цээрлүүлэх хар савны тоо үлэмж нэмэгджээ. Бараг л аймгийн төв болгон өөрийн гэсэн шоронтой болохоос гадна Багануур, Тахир соёот мэтийн долоо найман шорон шинээр цэцэглэн хөгжсөн байна. Тэр үед хамгийн зэрлэг шорон нь «Ганц худаг» биш Төв аймгийн мөрдөн байж. «Ганцхудаг» болон Мааньтын чангад атаман байсан хүн Төв аймгийн мөрдөнд орж ирээд лууван идэж, амьтан болдог байсан гэдэг. Ингэж Төв аймгийн мөрдөн гэмт хэрэгтнүүдийн ганц авдаг газар болсон түүхтэй. Тухайн үед чанга хатуугаараа Төв аймгийн мөрдөнгийн дараа Шандын мөрдөн, Дорнодын мөрдөн ордог байж. Харин 1990-ээд оны дунд үед Завхан аймгийн Улиастайн шорон ид чангарч байсан гэх бөгөөд ямар сайндаа л «Ганц худаг»-т таван сар хоригдоод хэргээ хүлээгээгүй хоёр этгээд Улиастайн шоронд очсон өдрөө л долоон булчирхайгаа тоочсон гэдэг. Ингээд 2000 оны үед тус шоронд өрнөсөн нэг явдлын тухай өгүүлье.

ОХУ-ын Тува мужийн Мичид-Оол хэмээх танхай эр олон жил гэмт хэрэг үйлдэж нутаг орондоо харгис хэрцгийгээрээ нэрд гарчээ. Мань эр Тува улсын “Улаанхад” хэмээх шоронд хэд хэдэн удаа орсон, аргагүй л догширсон этгээд байж. Энэ ч утгаараа тус шоронгийн атаман байжээ. Тэгтэл мань дээрэмчин Монголын нутаг руу халдан довтолж Улиастайн шоронд ирмэгцээ амьтан болсоноор барахгүй нэг их удалгүй чадхийчихсэн байна. Мичид-Оол нь 1995 оноос эхлээд Увс, Завханы нутгаас мал хулгайлжээ. Гэвч олон хавар нэгэндээ гэгчээр тэрбээр 1999 онд Бодак хэмээх эрийн хамт Завхан аймгийн Тэс сумын нэг өвгөнийг хүлж хаячихаад адууг нь хөөж явтал манай хилчид саатуулан баривчилсан байна. Ингээд мань хоёр Завхан аймгийн мөрдөнд хоригджээ. Гэвч тун удалгүй Мичид-Оолыг аймгийн мөрдөнгөөс Улиастайн шорон руу шилжүүлсэн байна. Тэрбээр сахал үс нь бавайсан, далайн дээрэмчин шиг ханхар залуу байж. Гэвч Улиастайн шоронд очуутаа л сэтгэл санаа нь хямарч хачин байдалтай болчихож. Хааяа тува хэлээр баахан шулганах боловч тэрийг нь мэдэх хүн үгүй. Тиймээс тэр олон цагаар дув дуугүй суучихдаг байж. Сүүлдээ бүр өвлийн тэсгим хүйтэнд хоёр чих нь хөлдөөд зангидсан гар шиг ус гүйчихсэн явдаг болж. үүний зэрэгцээ зан ааш нь бүр хачин болж шоронгийн хулгайчуудыг хоолоо хийгээд дуусмагц гэнэт ухасхийж босоод өшиглөөд асгачихдаг болсон байна. Тэгээд савтай хоол шороон дээр асгарч шөл ус нь урсмагц хог чулуутай нь хаман гараараа самардаад бүгдийг нь идчихнэ. Тиймээс хоолгүй хоцорсон хоригдолууд “Энэ яасан муу ёрын хулгайч вэ” гэж уурлаад түүнийг хайр найргүй зодож нүддэг болжээ. Гэвч Мичид-Оол огт тоосон шинжгүй улайран мөлхөж газар асгасан хоолыг нэгд нэггүй хамаж иддэг байсан байна. Тав зургаан удаа ийнхүү савтай хоолыг нь газар өшиглөж унагаад шороотой холиод идчихсэн аж. Хэн газар асгарсан хоолыг нохой шиг долоох билээ дээ. үүнээс хойш Мичид-Оолыг хоол болох үед хөл гарыг нь хүлж баглаад нэлээд зайтай суулгадаг болжээ. Гэтэл яаж байгаад хүлээсээ тайлчихсан юм бүү мэд. Нэг оройн хоолны үеэр өнөө чинь шуугин орж ирээд л тогоотой хоолыг нь өшиглөөд унгачихаж. Тиймээс хэн нэг нь Мичид-Оолын зангидсан гар шиг дэлдийж хөлдсөн чих рүү цохиж орхижээ. Түүн шиг аймшигтай зүйлийг урьд өмнө хэн ч харж байсангүй. өнөө том чих нь зад үсэрч бөөн цус нөж гоожиход Мичид-Оол цус нөжөө алгаараа хутгаж аваад шууд л идчихсэн байгаа юм. Гэвч тэр оройдоо л түүний бие муудаж хэвтэрт оржээ. Шөнийн 24 цагийн үед нэг ялтан түүнийг унтаж байгаа юм болов уу гэж бодоод очиж үзвэл аль хэдийнэ чад хийчихсэн

байж. Хорихын эмч нар задлан хийнэ гэсэн тул цогцосыг нь хөлдөөхгүй гэсэндээ нааран дээр нь хоёр хонуулжээ. Энэ хугацаанд үхдэлийн дээд нааран дээр хөзөр тоглох нь тоглож, хажууд нь хоол ундаа идэж уун, хорихын амьдрал юу ч болоогүй юм шиг хэвийн үргэлжилж байсан байгаа юм. Мичид-Оолыг ийнхүү хачин жигтэй аашилсаар үхсэний дараа хам хэрэгтэн Бодак нь аймгийн мөрдөнгөөс Улиастайн шоронд орж иржээ. Түүнийг ирмэгц захын нинжа айлгаж “Намайг тэр гэдэг дуулсан уу. Мичид-Оол чинь үхчихсэн шүү дээ. Чи араас нь явах дуртай байгаа биз дээ” гэх зэргээр жижигрүүлж байгаад хувцас хунарыг нь мулталжээ. Сарын дараа дээд удирдлагаас шийдвэр ирж Бодакийг Улиастайн шоронгоос өөр тийш нь шилжүүлээгүй бол тэр Мичид-Оолын араас орох нь тодорхой болчихоод байж. Нэг нь үхчихсэн болохоор нөгөөг нь амьд үлдээх шаардлага гарсан нь мэдээж. Ер нь тухайн үед Улиастайн шоронд атаманууд олон байсан бөгөөд тэд байнга хоёр хутгатай явдаг байжээ. Хоёр хутгаа бие биед нь хавиран хурцалж суудаг “Цоохор” Сүхээ гэгч атаман байсан бөгөөд мань эр автобусанд согтуу суух гэж байхдаа өмнөө чихцэлдэж явсан хүнийг “Хурдан яваач” хэмээн хутгаар бөгс рүү нь ёвроод ял авч байсан хүнд гар юмсанж. Энэ этгээд дээр өгүүлсэн Мичид-Оолыг дарамталж байсаар ухаан санааг нь балартуулж орхисон байгаа юм.

## Хулгайч, хуяг хоёр нь боловсрол, хүмүүжлээрээ нэг болчихсон

### «Ганц худаг»-ийн мөрдөн өрөвдмөөр

Чингэлтэй дүүрэгт оршин суух Төмөрчөдөрийн Ивээлт хэмээх дөч гаруй насны эр халхын төдийгүй харь гүрний шоронд жаалж явсан танхай этгээд ажээ. Гэвч эдүгээ тэр архи дарсанд орж туйлын гундуу явна. 1990-ээд оны үед Бээжин-Москвагийн чиглэлд транзит наймаа хийж мөнгийг баруун солгойгүй цацаж байсан мань эр эдүгээ бусдаас архины мянган төгрөг гуйх хэмжээнд хүрчээ. Тэрбээр «Намайг хүмүүс 120 мянгатын атаман байсан Итгэлттэй эндүүрээд байдаг юм. Би Итгэлт нь биш Ивээлт нь шүү дээ» гэж яриагаа эхэлсэн юм.

**-Таныг найз нөхөд чинь «Тэр жил эргэж ирнэ гэж яваад л цаашаа алга болсон» гэж ярих юм. Ингэхэд та хэдэн онд, хаашаа алга болчихсон юм бэ?**

-Энэ бол 1994 оны үйл явдал. Би тэр үед Москвад казино тоглоод тухайн үед байсан бүх мөнгө болох 60 мянган доллараа алдчихсан юм. үнэнийг хэлэхэд жаахан гутарсан. Тэгээд байрандаа буцаж очоод гурав хоног зад архидаад дөрөв дэх хоногоосоо нэг юм сэхээ авч үлдсэн бүх бараагаа аваад Москвагийн зах дээр аваачиж зарсан. Бас хажуугаар нь найз нөхдөөсөө бага сага тусламж авч нийтдээ дөрвөн мянга гаруй доллартай болж аваад Орос-Москва-Санкт Петербургийн чиглэлээр турк бараа зөөж нэлээд хэдэн сарыг өнгөрөөсөн. үүнийг л манай найз нар «Тэр жил эргэж ирнэ гэж яваад л цаашаа алга болсон» гэж ярьдаг юм. Яагаад гэвэл би тухайн үед найз нараа Эрхүүд үлдээчихээд Москва орчихоод ирье гэж яваад тэр чигтээ алга болчихсон байхгүй юу. Би Москвагийн казинод орж тоглож амьдралдаа хийсэн том алдаа гэж одоо хүртэл бодож явдаг. Хэрэв тэнд орж тоглож цаашаа Чех, Польш явсан бол миний хувь заяа тэс өөрөөр эргэх байсан. өнөөдөр би Дэнжийн мянгын шороотой гудамжинд архи эргүүлээд явахгүй байх байлаа. Аягүй бол Америк гарчихсан ч байж мэднэ. Гэхдээ яахав. Ер нь тухайн үед манай ихэнх наймаачид Москвагийн казинод тоглодог байсан юм чинь. 5-10 мянган ногоон алдах бол юу ч биш байлаа шүү дээ. Би 1995 оны 2-р сар хүртэл турк бараа зөөсөн. Хэдийгээр рубль гэдэг маань будаа шороо шиг өсдөг мөнгө хэдий ч Оросын нутагт бизнес хийнэ гэдэг чинь алхам тутамдаа аюул осол, дээрэм, хулгай нүүрлэсэн ер нь бэрх даваа шүү дээ. Гэхдээ би боломжийн байсан. Наад зах нь 60 ногооноор авсан савхин курткийг 160 ногооноор Санкт-Петербургод зарж байгаа юм. Гэвч нэг удаа наймаагаа хийж дуусаад хэдэн монголтой нийлж архидаж байгаад хэрэг түвэгт орооцолдчихсон. өглөөний арван цагаас эхлээд уусан хүмүүс чинь орой долоон цаг гэхэд муудахгүй хаачих вэ дээ. Би бүр тасарчихсан. Бидний хажуу талын өрөөнд хоёр монгол оюутан охин байсан юм. Манай хэд нөгөө хоёр охиныг зулгаах санаатай хаалгыг нь эвдээд орчихож. Тэгсэн нэг нь гурван давхараас үсэрчихгүй юу. Ийм л юм болсон доо. Нэг мэдэхэд л баахан орос цагдаа нар ороод ирчихсэн өшиглөж босгоод гар гавлаад аваад явсан. Ингэж би Оросын шоронд орсон юм. Тэнд би гадаадынхны камерт байсан. Мөнгөтэй л бол дураараа. Оросын шоронгийн хуягууд авилгалын төлөө төрсөн улс. Ер нь тэнд хоригдсон хүмүүс хоосроод салж байгаа юм. Нэг аюултай нь банди шуумарын ажил их дэлгэрсэн, барьж авч нухчих гээд явдалтай шүү дээ. Нэг л банди болгочихвол ямар ч авралгүй. Би банди болохгүйн тулд үзэлцсээр байгаад л гарсан даа. Аз болж гэрчийн мэдүүлгээр нөгөө явдалд оролцоогүй

нь тодорхой болсоноор би суллагдсан. Хожим нь шүүх хурал болоход би гэрчээр оролцсон. Гурван найз маань харин 5-10 жилийн ял авсан. Нөгөө гурван давхраас үсэрдэг охиныг эхэлж өдсөн нь 10 жилийн ял авч байгаа юм. Гэхдээ тэр охин гурван давхраас үсэрсэн мөртлөө тэр даруйдаа үхээгүй. Нугасандаа гэмтэл авч хэвтэрийн байдалд хоёр жил болоод бурхан болсон гэнэ лээ. Ингэснээр манай найз нарын ял хүндэрсэн. 10 жилийн ял авсан нөхөр бараг л дээд хэмжээ авах дээрээ тулж байлаа. Гэвч Оросын шүүх манайхыг бодвол арай энэрэнгүй болохоор арай ч цаазлалгүй нэмж таван жилийн ял өгсөн.

**-Та гэрчийн мэдүүлгээр суллагдсаныхаа дараа хаана юу хийсэн бэ?**

-Шууд л Герман явсан. Гэмт хэрэгт холбогдож баларснаас хойш мөнгөжиж чадаагүй байсныг хэлэх үү. Виз, замын зардлаасаа хэтрэх юмгүй хоосон шахуу л хэдэн найзаа дагаад Герман руу зүглэж байлаа. Манай найзууд бол урьд нь явж байсан туршлагатай хүмүүс. Хэл сайн мэднэ. Тэдэнд найдаж байгаа юм. Тэнд жил гаран болсон. Янз бүрийн ажил хийсэн дээ. Сонин зарна, яндан цэвэрлэнэ. Бааранд сав угаагч, үйлчлэгч хүртэл хийж ёстой үйлээ үзсэн. Бээжин-Москвагийн хооронд транзит тээвэр хийж доллар гээч юмыг гарынхаа салаагаар урсгаж байсан хүн нэг муу бааранд сав угаагч хийнэ гэж байх уу даа. Эр хүн туг ч барьдаг, тугал ч хариулдаг гэдэг үнэн юм билээ. Гэхдээ би урьдынхаа алдаанд сургамж аваад ч тэр үү, ер нь амьдралын төлөө зүтгэх хандлагатай болсон юм. Хаана л үнийн хямдрал болно тэрнийг алдахгүй очиж өвөл, зуны хувцас хэрэглэж болох бүхнийг хамж цуглуулсаар 1996 он гэхэд Монгол руу нэг контейнер ачуулж чадсан даа. Тэгээд бас л шоронд орсон.

**-Яагаад тэр вэ?**

-Контейнерээ ачуулах гэж хөөцөлдсөөр ор мөнгөгүй боллоо. Ахиад нэг хоёр сар ажил хийсэн. Монгол руу буцах зардал олж болно л доо. Гэхдээ би нэгэнт визийн хугацаа хамаагүй хэтрүүлж хараар ажиллаж байсан болохоор Германы гааль дээр миний паспортонд буцаж хилээр нэвтрүүлэхгүй тэмдэг дарах л байсан. Тиймээс би Германы өөрийнх нь зардлаар буцах арга хэмжээ авсан юм. Тэгээд нэг орой гудамжны жижигхэн киоскны хаалга хөшиж ороод жаахан идэж уух юм аваад унтаад өгсөн. Шөнө дундын үед эргүүлийн цагдаа ирээд намайг авч явсан. Германы шоронд 17 хоносон. Германы шорон бол камертаа дивантай, телевизортой, душтэй, үндэсний онцлогоор нь хоол унд өгдөг, хүний эрхийг дээдэлдэг. Ер нь хүчирхэг гүрэн гэдэг нь илт мэдрэгддэг. Намайг хоригдож байх үед манай элчингээс нэг удаа уулзсан. Тэгээд л нэг сайхан өдөр онгоцонд суулгаад, халаасанд маань 50 марк хийгээд Монгол руу явуулчихаж байгаа юм. Буянт-Ухаа дээр намайг Монголын цагдаа нар барьж авсан. Германаас мэдэгддэг юм билээ. Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтэст 72 цаг саатуулагдаад даалтанд гарсан. Угаасаа хийсэн хэрэггүй болохоор ер нь яах вэ дээ. Удалгүй хэрэгсэхгүй болгосон. Энэ үеэр нөгөө ачуулсан контенейр маань ирж би ч ёстой бурзайлаа шүү дээ. Тэр үед одоогийнх шиг янз бүрийн комиссын бараа гэж байдаггүй байсан. Германы гэхээр хүмүүс шууртал авдаг байлаа. үйлдвэрийн бранк, тээвэрлэлтийн хадгалалтаас болж бага сага гэмтсэн цоо шинэ гутал хувцаснууд байсан юм. Жишээ нь 200 маркийн куртканд нэг жаахан тосон толбо болсон байсныг би 30 маркаар авсан. Энд зарахдаа 50 мянгаар өгч байгаа юм. Ер нь нийтдээ 20-иод мянган ногоон олсон юм даг. Унаатай ч боллоо. Амьдралаа овоохон төвхнүүлж авлаа. Тэгээд хүний шунал хязгааргүй хойно дахиж явахаар шийдлээ. Гэвч өөр нэрээр шинэ паспорт авч явахгүй бол намайг Герман руу оруулахгүй л дээ. Паспорт авах

асуудал нэлээд удах шинжтэй болохоор нь зүгээр суухаар зүлгэж суу гэгчээр Хятад руу нэг ухасхийгээд ирье гэж бодоод урьд нь хүнээс өрийн барьцаанд авсан 30 кг мөнгөн усыг аваад өмнийг зорьсон. Гэхдээ нөгөө алдартай улаан мөнгөн ус нь биш шүү. Цагаан мөнгөн ус бол үйлдвэрийн бүх салбарт өргөн ашиглагддаг түүхий эд. Эмийн, алтны, халуун савны үйлдвэрүүдэд хэрэглэдэг. Жишээ нь халуун савны дотрыг дулаан барих чадвартай болгоход цагаан мөнгөн усыг ашигладаг. Харин хятад улс өөрийн хэрэгцээний мөнгөн усыг өөрийн уурхайгаасаа хангадаг. Харин алтны мафийнхан Орос, Монгол мэтийн гадаадын орноос мөнгөн ус нууцаар худалдаж авдаг юм билээ. Тэгээд Эрээнд очиж хуучин танил нэг хужаатай уулзаж учир байдлаа хэллээ. өнөөх чинь “Чи хэд хоног манайд байж хүлээ. Би өмнөд Хятадад байдаг түншүүдтэйгээ холбоо барья. Наад бараа чинь баараггүй зарагдана” гэж хэллээ. Би ямар ар тийшээгээ яарна гэж байх биш дуртай зөвшөөрлөө. Сар гаруй ер нь сайхан л байлаа. Бэлэн хоол ундтай, үнэгүй байранд архидаж, хүүхэн эргүүлээд зугаатай нь аргагүй нэг сар өнгөрлөө. Энэ хооронд би нөгөө хужаагаас “Юу болж байна” гэж асуухад “Хүлээж бай, мөд хариу ирнэ” гэхээс өөр үг хэлдэггүй байлаа. Нэг удаа нэлээд халамцуу байр луугаа явахдаа тэрэгчин хөлсөлсөн юм. Тэгээд яахав согтуугийн харгайгаар “Хурдан яв” гээд тэрэгчинг араас нь өшиглөчихгүй юу. Нөгөөдөх чинь эргэж хятадаар баахан хараалаа. Би уурандаа босч ирээд хэд хэдэн удаа цохиод авсан. Тэгтэл нөгөөдөх чинь тоосго аваад дайрсан. Би тоосгыг нь булааж аваад толгой руу нь цохьчихсон чинь салбагас хийгээд хөсөр унасан. Гялс зугтаад байрандаа очиж түнш хужаадаа болсон явдлыг ярилаа. Тэр намайг нуухаар болж нэг хувийн зочид буудалд оруулж өгсөн юм. Гол алдаа тэр л болсон. Би тэр оройдоо л баригдаж Эрээний шоронд орсон. Түнш хужаад хэлээгүй бол баригдахгүй байсан гэж боддог юм. Тэр л намайг цагдаад матсан байх. Болсон явдлыг мэдэнгүүтээ намайг өөрийнхөө байрнаас холдуулж өөр байранд оруулаад цагдаад бариулчихгүй юу. Ингээд би паспортын зөрчилтэй, дээрээс нь тэрэгчин зодсон хэрэгт холбогдох нь тэр. Түнш хужаа маань миний энэ байдал дээр дөрөөлөөд надаас салж мөнгөн усыг өөртөө шингээе гэж бодсон юм билээ. Би Хятадын шоронд сар гаруй болсон. Сүрлэн гудсан дээр бүтээлэг нөмрөөд унтана. Усан ногооны шөл мантуутай өгнө. Тэнд хоригдогсод намайг их гадуурхдаг байсан. Хужаагийн хууль чанга гэдэг нь юм бүхэн дээр илт мэдрэгддэг. Гадаадын гэмт хэрэгтэнг тэжээж байснаас хөөгөөд гаргасан нь дээр гэдэг үзэл тогтсон газар байна лээ. Эрээний цагдаагийн Ван Тайван гэж дарга байдаг. Тэр намайг хоёр гурван удаа байцаагаад тэрэгчин хужаагийн эмчилгээний зардал болох 2000 юань төл гэж шаардсан. Ингээд би баригдаж орохдоо хураалгасан 3500 юанаас 2000-ыг төлсөн. Паспортын хугацаа хэтрүүлсэн 500 юаний торгууль бас төлж байгаа юм. Тэр үед Замын-үүдийн нэг залуу Эрээний шоронд хулгайн хэргээр орчихсон байсан. Нэг өдөр бид хоёрыг Замын-үүдийн цагдаад хүлээлгэж өгсөн. Тэндээсээ Улаанбаатар хот руу ачигдаж “Ганц худаг”-т 14 хоносон. “Ганц худаг”-ийн мөрдөн ёстой өрөвдмөөр. Хулгайч, хуяг хоёр нь амьдралын түвшин, боловсрол хүмүүжлээрээ нэг болчихсон. Хүнийг хүндлэх ямар ч ойлголт байхгүй. Надад Эрүүгийн хуулийн 239-ын нэгээр эрүү үүсгэсэн боловч хохирогч байхгүй гэдэг шалтгаанаар удахгүй хэрэгсэхгүй болгосон. Ингэж би Оросын, Германы, Хятадын шоронд суугаад үзчихсэн хүн дээ. Огт хийсэн хэрэггүй мөртлөө хэлмэгдээд яваад байсан юм бас биш. өөрийн илүү зан, хөнгөн авираасаа болж тэгж баларч явсан юм даа. Хэрэв төв түвшин явсан бол өдийд над шиг баян хүн цөөхөн л байх байлаа. Одоо яая гэхэв дээ. Би ийм л амьдрал туулсан хүн. Дахиж ийш тийшээ явахыг хүсээ ч үгүй. Тэгээд л архичны жишгээр амьдарч байна даа. “Ивээлтхүү ивээлээ хайрлаж байна” гээд л мөнгийг баруун солгойгүй цацаж явлаа. Нэгэн цагт хүмүүст ивээл буянаа харамгүй хайрлаж байсан болоод ч тэр үү, одоо би архины мөнгөөр тасардаггүй юм даа.

## Халхын шоронгийн «Том ах» Доржийн Цээхүү гэгч хэн бэ?

Барлаг, банди, шуумар зэрэг нь захиргаадалтын үеийн шоронгийн цол билээ. Эдгээр цол орчин нийгмээ дагаад эдүгээ бүгд өөрчлөгджээ. Ялангуяа шуумар цолыг бараг хэрэглэхээ байсан байна. Шоронгийн атамануудыг шуумар гэдэг байсан бөгөөд эдүгээ зарим шоронд босс буюу дарга гэж нэрлэдэг болж. Мөн зарим шоронд Солонгосын олон ангит кинонд гардагийг дуурайж «Том ах» гэж нэрлэдэг болсон байна. Тухайлбал Булган аймгийн харъяат Доржийн Цээхүү гэгч эр эдүгээ халхын шоронд «Том ах» болчихоод ялтанууд төдийгүй хянагч нараар хайрлуулж хүндлүүлдэг тун чухал хүн болж хувирчээ. Мань эр 1990 оноос эхлээд хулгай, залилан, дээрмийн хэргээр гурван ч удаа шоронд орсон байна. Түүний нэг онцлог чанар гэвэл гарын авьяастай, ялангуяа, машин механизм, цахилгааны эд хэрэгсэл засахдаа тун гаргууд нэгэн бөгөөд «Тахир соёот»-ын шоронгийн барилга байгууламжийн цахилгааны бүхий л тоног төхөөрөмжийг гардаж хийжээ. Тийм ч учраас хорих ангийн дарга, хянагч нарын албаны болоод хувийн бүхий л машин тэрэг, мотоцикль, хөргөгч, индүү, плитка энэ тэрийг үнэгүй засч өгдөг байна. Тиймээс мань эр ялтануудтай цуг жагсаж, цуг хоригдоод байдаггүй, тусгай өрөөнд тусгай хоол идээд л «Том ах» царайлаад хэвтэж байдаг гэнэ. Ялтанууд түүнийг «Том ах аа» гэж дуудахад «Юу гээ вэ, жижиг дүүгээ» гэж алиалдаг аж. Мөн тэр маш их арвигч хямгаач нэгэн бөгөөд барилга дээр ажиллаж байгаа хоригдолуудыг жагсааж байгаад «Та нар капиталист өмчийн эс ширхэг бүрийг алхам тутамдаа нүдлэн хамгаалж байх ёстой төрийн зараалууд шүү. Хүрз шавар, ширхэг тоосго, шанага шохой, халбага будаг ашиглалгүйгээр хаясан ялтануудын ходоод гэдэстэй ярина. Хир буртаг өчүүхэн ч хүргэхгүй нандигнан хайрлаж, тахиж шүтэж байх зүйл чинь нэгдүгээрт нийгмийн өмч, хоёрдугаарт наад салтаанд чинь байгаа бэлэг эрхтэн чинь шүү» гэж үүрэгддэг аж. Зарим ялтан түүнээс «Та нийгмийн өмчийг шүтэх чинь түмэн зөв. Харин хувийн өмч болох бэлэг эрхтэнийг яагаад шүтдэг юм бэ» гэж асуухад «Хөдөлмөрчин хүнийг үйлдвэрлэдэг хүчит зэвсэг шүү дээ, наадах чинь» гэж амыг нь тагладаг ажээ. Мөн тэрбээр соц нийгмийн үед «үнэн» сонинд сурвалжлагч хийж байхдаа хилс хэргээр шоронд сууж, 54 хоног өлсгөлөн зарласан Оршихын Цэдэндорж агсаныг ихэд хүндэтгэдэг бөгөөд түүний зохиосон «Цамаан зан дэгжих амьдралын таглаа, Цатгалан ходоод дээдлэх оюуны бөглөө» гэдэг алдарт мөрүүдийг байнга уншиж бэлэнчлэх сэтгэлгээтэй залхуу хоригдолуудын тархийг цэнэглэдэг байна. Ямар сайндаа л өрөөнийхөө ханан дээр «Цамаан зан дэгжих амьдралын таглаа, Цатгалан ходоод дээдлэх оюуны бөглөө» хэмээн модоор сийлээд тавьчихсан бөгөөд үүнийг нь хорих ангийн дарга нь харчихаад «Наадах чинь ямар аятайхан үг вэ. Чи наад үгээ барилга барьж байгаа хоригдлуудын байрны үүдэн дээр бичээд хадчих» гэж үүрэгджээ.



## «Доргио» Ганбаа гэгч хянагчийг ээлжинд гарахад

### Зүүнхараагийн хоригдолууд чичирдэг байж

Хэний ч хараанд өртмөөргүй нусгай бор жаал 1980-аад оны үед дунд сургуулиа арай чүү алтан гуравтай төгсөөд эр цэргийн албанд морджээ. Тэгээд армид ердөө ганцхан жил болоод эцэг эхийнхээ нүүрний буянаар «гоожуур» хэмээх эрхэм алдарыг хүртэлгүйгээр цэргээс халагдаж шоронд хянагч болсон байна. Түүнийг «Доргио» Ганбаа гэх бөгөөд мэдээ орсон цагаасаа мянган хоригдолын өмнө алхах шоронгийн дарга эцгийгээ бишрэн шүтдэг болсон аж. Тиймээс тэр бороохой барьсан хуяг болох юмсан гэж хар нялхаасаа мөрөөджээ. Ингээд эцгийнхээ шийрийг хатаахаар шийдсэн мань эр өмнөө баахан ялтан жагсаачихаад «Та нар гудамжинд ихэмсэг байдаг гэлүү, одоо гөлөг болжээ» хэмээн шүлсээ үсчүүлэн үүрэгддэг болж. Тэнгэр нь хүртэл баргар юм шиг санагдах Зүүнхараагийн шоронд олон эрсийг «бөөндөн» тамлах аймшигт яргалалын салхийг үе дамжсан цуут хуяг «Доргио» Ганбаа ийнхүү хагалжээ. Эцэг нь түүнийг ухаан орох цагаас нь эхлээд шоронгийн хашаагаар дагуулан явж «Ландага» буюу шоронгийн талх мэрүүлж өсгөсөн бөгөөд ингэж өссөн хүн чинь шоронг мэдэлгүй яахав. Гэхдээ зөөлөн бус хатуу чанга эрлэгийн элч, аймшигийн тамлагч болж өссөнийг эцэг нь мэдсэнгүй. 1984 онд Монгол улсын дээд шүүхээс «Давтан буюу гурван жилээс дээш ял оноосон бүх хэрэгтэнг чанга дэглэмтэй хориход хорьсугай» гэсэн тогтоол гарсан юм. Харин үүний үр дүнд «Ганцхудаг»-ийн мөрдөн чангын хоригдолуудаар дүүрч Мааньт, Зүүнхараа, Дүүрэн гэсэн шоронгууд руу мөглөн мөглөнгөөр илгээгдсэн байна. Арын хаалгатай нь Мааньт, анхны хэрэгтэн буюу азтай нь Дүүрэн, адгийн болоод хувыгүй новшнууд нь Зүүнхараа руу ачигджээ. Харин энэ үеэс Зүүнхараагийн ялтануудын дунд «Доргио Ганбаагийн ээлж» хэмээх айж хулганасан үг сонсогддог болсоноос гадна «Ахлагч Ганбаа шиг аймаар овгор хуяг Зүүнхараагаас өөр газар байхгүй» гэх яриа газар авчээ. Тэр ч байтугай тэр үед хоригдолууд «Гөөнгөө сайн ёдохгүй бол «Доргио» Ганбаагийн ётон болно. Ганбаагийн хүссэнийг биелүүлэхгүй бол тахианы байранд 30 хоногтой орж сожоомны ялтан болно» гэж ярьдаг байж. Соц нийгмийн үеийн шоронгуудад «Азтай нь амьд гар. Азгүй нь там руугаа үүрд баяртай» гэх бичигдээгүй хууль ноёрхож байсан болохоор «Доргио» Ганбаа мэт нь «Одоо яая гэхэв. Та нарыг зүгээр явахад чинь шүүх чихдэж авчираад ял өгчихсөн биш. Хохь чинь» гээд жинхэнэ доргиж өгөхөөс ч яахав дээ. Ганбаа ахлагч ээлжиндээ гарсан үедээ гартаа ташуур, ташаандаа буу зүүж гангардаг байж. Тэгээд хүн бүхнийг шоглохсон гэж хорхойсно. Мянган хоригдол оройн тоонд жагсчихаад байх үед зөвхөн Ганбаа ахлагчийн хромон гутлын ул чийхарах дуу л сонсогддог байж. Түүнийг байранд ороод ирэхэд невал маш том хүндэтгэл үзүүлэхгүй бол «Гараад суу, лаларууд аа» хэмээн Зүүнхараагийн шоронг доргитол хашгирдаг байж. Тэгээд л энд тэнд тавлаг амарч байсан эрс нүцгэн шахуу шахцалдан цасан дээр холхиндог гуталтай сууна. «Доргио» Ганбаа ташаан дахь буугаа гарган ирж сумлаад «Зүүнхараа дахь чанга дэглэмтэй хорих лагерийн Цэдэнбал дарга нь би байна. Та нар намайг Бал дарга гэж хүндлэх ёстой» хэмээн тухийдэг байжээ. Тэгээд жагсаал дотор өчүүхэн төдий хөдөлсөн ялтаныг шонгийн модонд хүлээд, өмдийг нь шувглаад бороохойддог байжээ. Мань эр хар нялхаасаа шоронгийн хашаанд өсч торнисон болохоор хүн тамлах баялаг туршлагатай байсан нь мэдээж. Ялтануудыг газар хэвтүүлж байгаад цээж рүү нь хатуу ултай гутлаар өшиглөх, нуруун дээрээс нь дэвсэх бол энүүхэнд. Ямар сайндаа л мань эр «Хүүхэн хүчиндэж шоронд ороод байдаг аварга Хадбаатар манай Хараагийн шоронд ирээсэй. Нэг

сайхан зодох юмсан» хэмээн алгаа үрээд шүлэнгэтдэг байсан гэдэг. Гэвч халхын заяа түшсэн ч юмуу Хадаа аварга маань түүний гар дээр очиж үйлээ үзсэнгүй. 1980-аад оны үед Зүүнхараагийн шоронд Игорь гэгч харгис хянагч алба хааж байсан бөгөөд тухайн үед «Игорийн дэглэм» гэгч юм гарч иржээ. Харин «Доргио» Ганбаа хянагч болсоноор Игорийн дэглэмийг устгаж оронд нь Ганбаагийн дэглэм» гэгчийг бий болгосон гэдэг билээ. Эдүгээ «Доргио» Ганбаа гэгч нь хаана яваа юм бүү мэд. Ардчилал, хүний эрх, зээл тусламж, зэрэг дэв ярьдаг ялтануудаар дүүрсэн Зүүнхараагийн шоронд л лав байхгүй нь ойлгомжтой.

## Гандангийн атаман Сэрээтэрийн Сэлэнгэ

### «Шоронгоо бараадья» гэж хэлээд цагдаа

#### дээр өөрөө очжээ

Энд өгүүлэх Сэрээтэрийн Сэлэнгэ гэгч эр 17 настайгаасаа эхлээд өргөст торны цаана суужээ. Түүний хүүхэд нас Улаанбаатар хотод өнгөрсөн бөгөөд Гандангийн дэнжийн атаман Цогтын Зандангийн баруун гар байсан гэдэг. Ер нь соц нийгмийн үед Гандангийн дэнжээс олон атаман төржээ. Цогтын Зандангаас гадна Гандангийн Пальдаг гэгчийг Дэнжийн мянга, Зурагтынхан андахгүй. Түүний жинхэнэ нэрийг хэн ч гэдэг юм бүү мэд, зүгээр л «Гандангийн Пальдага» гэхэд л «өө, нөгөө банди нарыг харцаараа хөдөлгөдөг Гандангийн атаман байна ш дээ» гэнэ. Сэрээтэрийн Сэлэнгэ нь Цогтын Завдан, Пальдага хоёрын нөмөр нөөлгөн дор Гандангийн дэнжид үнэхээр чанга байж. Хүүхэд байхдаа тэр хавийнхаа сургуулийн хүүхдүүдтэй ганцаараа зодолдож ид бахаа харуулдаг байсан юмсанж. Ямар сайндаа л 16 настай байхдаа Пальдагын хамт Гандангийн хойд талын 28-р сургуулийн үүдэнд очоод «Эр хүн юм бол цуваад ир. Нохойн гөлөг юм бол бүгдээрээ нэгэн зэрэг дайраад ир» гэж хашгирахад тус сургуулийн аравдугаар ангийн хүүхдүүд халдаж чадахгүй тойрч зугтаагаад байсан гэдэг. Гэвч тэр 17 нас хүрүүтээ найзынхаа нүдийг шилээр сохлоод хүүхдийн хорихын хаалга татжээ. Уг нь найзынхаа нүдийг сохлоё гэж бодсонгүй. Санамсаргүй архины шил чулуудсанаас болж найзынхаа нүдний цөцгийг хагалсан байна. Тэгээд хүүхдийн колонид очуутаа нэг бацааныг хутгалж Мааньтын чанга руу ачигджээ. Шоронгийн «овгор» болохыг мөрөөдсөн Сэлэнгэ төдөлгүй мөн л хутганы хэргээр дэглэм дээшилж Онцгой дэглэмтэй хориход очсон байна. Ингээд галзуу барын аманд гараа хийхээс ч буцахгүй насан дээрээ явсан Сэлэнгэд шорон гэдэг бол гэр орон нь болж хувирсан байна. Тэрбээр завсаргүй 10 жил шоронд суугаад 1982 оvd наранд гарчээ. 27 настай тэрбээр үеийнхнээ бодоход нэлээд буурь суусан тул төдөлгүй эхнэр авч хүүхэдтэй болж амьдралын мөр хөөсөн байна. Гэвч Сэлэнгэ ердөө гуравхан жил хүн шиг амьдраад цагдаа зодсон хэргээр дахин шоронд морилжээ. Таван жил чангад сууж авгай хүүхдээ санахын дээдээр санаж хоног хугацааны уртыг мэдэрсэн Сэлэнгийг 1987 онд шоронгоос суллагдахад ах дүү нар нь гэрийнхээ хамаг муу муухайг авч төрсөн зовлонт амьтан гэж сэтгээд нутаг сэлгэхийг санал болгожээ. Ингээд Гандангийн дэнж дээр төрж өссөн Сэлэнгэ Дорнод Монголын уудам талд гэрээ барих нь тэр. Тэгээд зах зээлийн эрин үед дүү нарынхаа дэмжлэг тусламжаар хэнээс ч гуйхгүй амьдрах болжээ. Сэлэнгийн эхнэр Дорнодын зах дээр наймаа хийж, харин Сэлэнгэ өөрөө УАЗ-469 машинтай Улаанбатаар, Дорнод хоёрын хооронд хүн тээвэрлэдэг болж. Тэрбээр орон шоронд хамт байсан Дорнодын олон «хүнд гарыг» үнэгүй тээвэрлэж чамгүй буян үйлджээ. Хоёр хүүхэд нь сургуульдаа гүйж амьдрал урсдагаараа урсаж байлаа. Гэтэл нэг өдөр Дорнодын захын улаан архичин Сэмжээхүү гэгч эр Сэлэнгээс архины мөнгө нэхжээ. Сэлэнгэ юм үзсэн хүний буйр зааж түүнд хоёр мянган төгрөг өгсөн байна. Гэтэл маргааш нь түүнийг эхнэртэйгээ явж байхад Сэмжээхүү дахиад архины мөнгө шаналгажээ. Сэлэнгэ өврөө ухаад түүнд мөнгө гаргаж өгөх гэтэл эхнэр нь ханцуйнаас нь дугтарч цааш аваачаад «Чи энэ муу улаан архичинаас айгаад байгаа юмуу. Гандангийн дэнжид байтутай шоронд атаман явсан гээд байсан чинь хаана байна. Нэг муу архичнаас айгаад өврөө тэмтчээд байхдаа яахав дээ» гэх зэргээр хорыг нь малтжээ. Сэлэнгэ үнэндээ Сэмжээхүүгээс айсан юм

огт байсангүй. Нэгэн цагт өөрөө бас хүн амьтанаас мөнгө төгрөг шаналгаж явсаны хувьд өрөвдсөн ч юмуу, өхөөрдсөн ч юмуу Сэмжээхүүд хэдэн төгрөг өгчихье гэж бодож л дээ. Гэтэл эхнэр нь үүнийг буруугаар ойлгож хорыг нь малтсанаар Сэлэнгийн уур омог дэгдээд ирэх нь тэр. Тэгээд тэр Сэмжээхүү рүү дөхөж очоод «Би чамаас айсан юм огт байхгүй шүү. Чам шиг муу жулдрай байтугай чамаас цаадах атамануудтай тэмцэлдэж явлаа. Муу новш минь чи эндээс зайл» гээд бөгс рүү нь амбаардаж орхижээ. Тэгээд эхнэртээ хандаж «За чиний санаа чинь амрав уу. Чи ийм л юм хүсээ биз дээ» гэж хэлээд эргээд хартал Сэмжээхүү хутга тулгачихсан зогсч байжээ. Энэ үед Сэлэнгийн эхнэр Отгонжаргал өнгөрсөн борооны хойноос цув нөмрөв гэгчээр буруу юм хийснээ гэнэт ухаараад «Сэмжээхүү, миний дүү боль. Сэлэнгээ ах нь шоронд зөндөө зовсон хүн шүү дээ. Иймэрхүү харьцаа сайн зүйлд хүргэхгүй» гэж царайчилсан байна. Гэвч нөгөө даварсан архичин «Чиний тэр орон шоронд байсан чинь огт хамаагүй шүү» гээд Сэлэнгийг хутгалах гээд дайрсан байна. Тэгтэл Сэлэнгэ «Ах нь чам шиг ингэж дутуу алдаг хүн биш» гэнгүүтээ яах ийхийн зуургүй хутгыг нь булааж аваад Сэмжээхүүгийн зүрхэнд зоож орхижээ. Тэгээд тэр «За, наранд амьдарч болдоггүй хорвоо байна. Яршиг зүгээр шоронгоо бараадья» гэж хэлээд цагдаа дээр өөрөө очсон гэдэг.

## Оросын шоронгуудад захиалгат

### аллага элбэгшсэн

Оросын шоронгуудын тухай олон янзын мэдээлэл бишгүй л цацагддагийг та бүхэн мэдэх биз ээ. Гэмт хэргийн тоо толгойгоор дэлхийд тэргүүлдэг том гүрний шорон ямар байх нь ойлгомжтой. Харгис хэрцгий хуяг хянагч, овгор товгор атаман хоригдолууд, хүйтэн нойтон камер, хүчирхийлэл дарамт гээд бүх л юм тэнд байдаг биз. Харин энэ удаа Оросын шоронгуудад гардаг захиалгат аллагуудын тухай өгүүлье. Оросын шоронд захиалгат аллага маш их үйлдэгддэг бөгөөд дотор нь бүр дөрөв ангилдаг аж. өөрөөр хэлбэл шоронгийн овгоруудын үйлддэг захиалгат аллагууд, зэвсэг хэрэглэн аллага үйлддэг зохион байгуулалттай дээрмийн бүлэглэлүүд, хүчний байгууллагууд буюу цагдаа, шүүх прокурор, шоронгийн удирдлагуудын захиалгаар хийгддэг аллагууд, хохирогчдын төрөл садангуудын захиалгаар хийгддэг аллагууд гэх мэт. Гэхдээ хохирогчдын талаас өш хонзонгоо авах зорилгоор аллага зохион байгуулдаг явдал тийм олон биш аж. Гэвч одоогоос арваад жилийн өмнө гарсан нэгэн хэрэг чамгүй дуулиан тарьсан юм. 18 настай хүүг нь алсан алуурчин анхан шатны шүүхээс хэдхэн жилийн ял авч жирийн дэглэмтэй хорих ангид ял эдлэхээр одоход хохирогч хүүгийн эцэг эх таг дуугүй сууж байсан гэдэг. Гэхдээ давж заалдаж байх хугацаандаа алуурчныг хохирогчийн эцэг танил талаараа дамжуулан мөн шоронгийн даргад их хэмжээний хахууль өгсөнөөр тусгай камерт шилжүүлж улмаар овгоруудын дарамтанд оруулан өдөр шөнөгүй зовоож амийг нь хорлуулсан явдал гарчээ. үнэн хэрэгтээ түүнийг яг өөрөө амиа хорлосон уу үгүй юу гэдгийг хэн ч тогтоохыг хүсээгүй байгаа юм. Түүний ар гэрийнхэн хорихын удирдлагад гомдол гаргахад нэг камерт байсан хоригдол нь хүчиндсэнээс болоод сэтгэл санаагаар унан өөрийгөө боомилсон байна гэх төдий шалтаг хэлээд таг дарсан гэдэг. Иймэрхүү хэрэг аль ч газрын шоронд гардаг болохоор ар гэрийнхэн нь яаж ч чадсангүй. Хичнээн заргалдаад ч «Мунаг нэгний дарамтанд орж золгүйгээр амиа алджээ» гэдэг үгээр амаа таглуулсаар аргагүй эрхэнд хэргийг нь хаалгасан байдаг. Хамгийн хачирхалтай нь ОХУ-ын хүчний байгууллагуудаас шоронд аллага захиалах тохиолдол их байдаг аж. Мөн шоронгийн ажилтнуудын гар хөл болсон «бууны ноход»-оороо дамжуулан олон хүний амыг барьдаг юмсанж. «Бууны ноход» хамт хоригдож байгаа хоригдлуудынхаа санаа бодол хүсэл зорилгыг байнга судалж хир чинээгээрээ тагнаж, аливаа нэг сэжигтэй мэдээлэл авуутаа шоронгийн ажилтнуудад дамжуулсанаас хүний амь үрэгдэх явдал байсхийгээд гардаг байна. Тэр ч байтугай бууны нохдын худал гүтгэлгээс болж хэлмэгдэн амиа алдах асуудал олноороо гарсанаас хоригдолууд эргээд шоронгийн ажилтануудын амь насанд халдах хэрэг их гарах болсоныг холбогдох газрууд мэдээлсээр удаж байгаа аж. Саяхан Москвагийн ойролцоох жирийн дэглэмтэй шоронд нэг хянагч бүх насаараа хоригдох ялтай хоригдолын гарт амь үрэгдсэн явдал үүний тод жишээ юм. Шоронгоос амьд гарахгүй гэдэгээ сайн мэддэг хоригдлууд иймэрхүү аллага дуртайяа гүйцэтгэдэг болох нь анзаарагддаг аж. Ер нь Оросын шоронгийн хоригдлууд дотроо хэд хэдэн бүлэг болон хуваагдан өөр хоорондоо маш их өрсөлдөж байдаг нь шоронд гарч байгаа хүн амины хэргүүдээс ч ажиглагддаг байна. Зооны овгорууд шоронгийн ажилчдын гар хөл болсон бууны нохойнуудыг хамгийн түрүүнд алах сонирхолтой байдаг бол насаараа шоронгоор явж шоронгоор гэр хийсэн архаг гэмт хэрэгтнүүд овгоруудыг яаж ийгээд нухчих гээд байдаг аж. Харин ийм архаг гэмт хэрэгтнүүдийг шинэ залуу гэмт хэрэгтнүүд нухчих гээд байдаг юмсанж. 1990-ээд оноос хойш

ОХУ-ын шоронгуудад тамирчид, зодооны урлагаар хичээллэдэг хүч чадалтай, бие бялдар томтой хүмүүс орох нь элбэгшсэн гэдэг. Тэгвэл яагаад ч юм бэ ийм хүмүүс хэнийг ч байсан хэнэг ч үгүй алж орхидог болсон байна. Эднийг шүтэн биширч тойрон хүрээлэгч олшрохын хирээр хэн нэгнийг алуулах захиалга ихээр гарч ирдэг болжээ. Бүр сүүлдээ өчүүхэн шалтгаанаас болж хүний амь хөнөөлгөх явдал ч гардаг болж. Жишээ нь: томоохон дээрмийн хэрэг үйлдэн их хэмжээний мөнгө эд хогшил хулгайлсан хэргээр шоронд орж ирсэн хулгайчийг «хармааны хулгайч» гэж дуудсаны төлөө захиалгат аллага хийлгэсэн байгаа юм. Түүнээс гадна аль ч шоронд мэргэжлийн алуурчин байдаг болсон байх юм. Оросод улаан, хар гэсэн хоёр төрлийн шорон бий. Улаан шоронд хүн алах боломж тун бага учраас алуурчид дотроо ямар нэг аллага үйлдэхийг эрмэлздэггүй байна. Гэвч тэдэнд гаднаас захиалга тасардаггүй юмсанж. Харин тэд хүн алахгүй ч захиалгаар хэн нэгнийг хүчиндэн сексийн дарамт үзүүлдэг байна. Гэхдээ ийм дарамтыг өөрсөдөө гардан хийдэггүй аж. Харин хар шоронгийн хувьд хүн алах явдал чөлөөтэй байдагаас мэргэжлийн алуурчид захиалганд дарагдаастай сууж байдаг байна. Хамгийн хачирхалтай нь тэд ийм хэрэг үйлдсэнийхээ төлөө ял нэмүүлдэггүй харин ч үхсэний хохь амьдын зол болон дуусдаг болохоор өдгөө олон шоронд орон тооны гэмээр мэргэжлийн алуурчид бараг цагаандаа гарчихсан захиалгат ажлаа хийсээр байна. үүнээс болсон ч юм уу гаднаас ирдэг захиалгуудын ханш сүүлийн үед маш их өсч, нөхцөл байдал үйл ажиллагаанаас шалтгаалан 50 мянган ам. долларт хүрчээ. Нэгэн нэртэй бизнесмэн ялихгүй хэрэгт орооцолдон ял эдлэхээр хоригдож байхад нь түүний эхнэр хөрөнгө мөнгийг нь булааж авах шуналын сэдэлтээр нөхрөө алах захиалга өгснийг шоронгийн нууц ажилтнууд олж мэдэн арга хэмжээ авсан байгаа юм. Тэр бизнесмений эхнэр нөхрийнхөө амийг жаран мянган ногоонд хүргэсэн байсан гэхээр бас л аймишгтай байгаа биз. өнгөрсөн жил Свердловскийн хорих ангийн хашаанд байдаг мебелийн үйлдвэр дотроос шатаж үхсэн хоёр овгор хоригдлын цогцос олдож байлаа. Тухайн үед хоёр хоригдол шөнийн цагаар үйлдвэр дотор юу хийж явсан, битүү үртсээр хучигдсан шал яагаад гэнэт шатав гэдэг ойлгомжгүй яаж ч бодсон захиалгат аллага гэдэг нь хэн бүхэнд ил байсан юм. Гэвч хорих ангийн удирдлагууд цахилгааны монтажнаас болж шатаж үхсэн байх гэж таамаглаад орхисон нь тэр хоёрын амь нас ямар хэмжээнд үнэлэгдсэнийг харуулсан хэрэг болсон гэхэд болно. Шоронд аллага үйлдэж байгаа хүн араа сайн даахын тулд хорихын удирдлага болон нөлөө бүхий харгалзагч хуягт их хэмжээний мөнгө атгуулдаг гэдэг сэжигийг энэ явдал баталсан билээ. Бас нэгэн дуулиант хэрэг бол «Уралмаш» компаний захирал Александр Хабаровын үхэл байв. Тэр 2005 оны 1-р сард хоригдож байхдаа Екатеринбург хотын шоронд тэлээгээрээ боомилон нас барсан юм. Гэвч түүнийг амиа хорлосон гэхэд хэн ч итгээгүй. Учир нь талийгаач амиа хорлосон байдлаар нас барахынхаа өмнө хотын нөлөө бүхий хэсэг хүн, шоронгийн удирдлагуудтай ширүүн маргаан үүсгэж хамаг булхайг нь дэлгэж байсан байдаг. Мөн Чечений салан тусгаарлагчдын нэг хээрийн цэргийн дарга Леча Сламов гэгч эр шоронд ял эдэлж байгаад ялихгүй өвчнөөр нас барсан хэрэг гарсан юм. Гэтэл тун удалгүй түүнд хор өгч алсан болох нь тодорсон юм. Эцэст нь өгүүлэхэд ОХУ-ын шоронгуудад бусдын нүдэн дээр ил аллага хийдэг алуурчид бас их болсон аж. Ийм алуурчид өрөө төлж байгаа ч юмуу, өш хонзонгоо авч бах таваа хангаж байгаагаа үзүүлэх гэж бусдын нүдэн дээр хүн алдаг юмсанж.

## «Ганц худаг»-ийн мөрдөн эд баялаг, эрх

### чөлөөгөөр бялхаж буй нь баярлууштай

УИХ-ын гишүүн Э.Бат-Үүл Дөчин мянгатын атамануудын нэг явахдаа доорхи онигоог зохиосон гэлцдэг. «Нэг нөхөр өөрийгөө Японы Сугато гянданд сууж байлаа гэж найздаа томорчээ. Тэгтэл найз нь «Тэгвэл чи чинь Рихард Зоржетэй хамт хоригдож байсан юм байна шүү дээ» гэхэд «Мэдэхгүй ээ. Зориг ч гэнэ үү, Орги ч гэнэ үү нэг нөхөр намайг үүдэн дээр дуудаад байна л гэсэн. Очоогүй» гэсэн гэдэг. Сугато бол дотроо олон хүнийг авсалсан дэлхийн зартай шоронгуудын нэг. АНУ-ын Техас дахь онцгой дэглэмийн гяндан, ОХУ-ын Архангельскийн төв шорон, БНХАУ-ын нэр бүхий олон шорон хүнд хэцүү, аюултай нөхцлөөрөө дэлхийд толгой цохьдог ажээ. Одоогоос хэдэн жилийн өмнө Бразилийн Сан Паулу хотын төв шоронд 5000 хоригдолын бослого гарч 150 гаруй хүнийг 10-аад хоног барьцаалж байлаа. Төв, өмнөд Америкийн шоронгууд хэдийгээр дэлхийд нэр алдар нь хадаагүй ч хамгийн аюултай дэглэмтэй болох нь ойр ойрхон гардаг бослого, үймээнээс тод харагддаг. Шоронгууд олон хүнийг хорьсон тоогоороо бус нөхцөл байдал, дэг диграмм, дотоод гадаад диктатур, зэргээсээ шалтгаалан зард гардаг ажээ. Жишээлбэл өнгөрсөн зуунд л гэхэд Освенцин, Бухенвальдийн хорих газруудтай Белгийн нэг жижигхэн хотын «Баанхооф» хэмээх шоронгийн нэр мөр зэрэгцэн бичигдэж байсан. Уг шорон эрийг эмлэх, хүнийг тарчилган зовоох, хоол ундны бохир балиар, байнгын дарамт, зодуур нүдүүрээрээ бөөнөөр хорих конциагеруудыг ардаа хол орхижээ. Тэгвэл өнөөдөр манай «Ганц худаг»-т тэдгээрийн тоонд орохоор тийм хүнд хэцүү нөхцөл бий юу? Эдүгээ АНУ-д чөлөөт цаггүй, номын сангүй, телевизоргүй урьдчилан хорих төв нэг ч үгүй болсон гэдэг. Харин манайд чөлөөт цагаас бусад нь үгүй. Гэхдээ чөлөөт цагаараа хөл бөмбөг өшиглөх ч юм уу гар урлал оролдож, ном зохиол унших бус бие биенээ янаглах, тамлах, зодох ажлыг урьтал болгодог байна. Манай шоронгийн дэг диграмм дотоод амьдрал хуучин ЗХУ-ын «социалист» шоронгуудын хэв маягийг хуулбарласан байдаг. Жишээ нь 1980-90 он хүртэлх хугацаанд гаднаас мөнгө залилсан хүн шоронд орж ирлээ гэж бодоход голдуу л 2000-3000 төгрөг гялгар уутанд боогоод залгичихсан орж ирдэг байж. Тэр үед хоригдолуудыг бараг л рентгэн дурангаар харж байгаа юм шиг нэвт шувт нэгждэг байсан тул мөнгө оруулах хамгийн найдвартай арга нь гялгар уутанд хийгээд залгих л байжээ. 70-80 оны үед бөгсөндөө лав шургуулах, гутлынхаа өсгийг ханзалж хийх зэргээр мөнгөтэй ордог байсан боловч сүүлдээ харгалзагч нар уг аргыг мэдчихээд хүн болгоны хошноого руу гараа дүрж, гутал болгоны өсгийг ханзлаад мөнгийг нь авчихдаг болсон байна. Гэвч тийнхүү залгисан мөнгөө доош хүндэрч байж гаргах хэрэг гарна. Шоронгийн хулгарууд үүнийг алтан тахиа өндөглүүлнэ гэж нэрийддэг бөгөөд «Алтан тахиа» маань шээлтүүрийн хувин дээр гурав дөрвөн цаг суусны эцэст сая нэг юм өндөглөнө. Зориудаар уг явдлыг түргэсгэхийн тулд тусгай жор ч бэлтгэдэг байж. Гэтэл мөнгө нуух уг аргыг анх Оросын хаант улсын шоронд ухуулах хуудас залгисан большевикууд бий болгосон нь сонирхолтой. Мөн тухайн үед тамхи шүдэнз оруулдаггүй байсан учир хөвөн үрж, эртний хүй нэгдлийн маягаар гал гаргадаг байж. Дотор нь бага зэрэг ханын шохой хийж чивчиртэл чинэрсэн хөвөнг шалан дээр тавиад хэн нэгний тайлсан гутлын өлмийгөөр хэдхэн үрээд л уугиулчихдаг сурамгай улс олон байжээ. Хоригдолууд халбага сэрээ ханцуйлж үлдээд уйгагүй үрж шовхолсоор хэнийг ч там руу илгээчихдэг хутгатай болдог байв. Энэ нь мөн л Оросын шоронгуудад аль Николай хааны үед бэлдэж байсан зэвсэг. Харин монгол ялтанууд 1974 онд

Архангельскт гарсан шоронгийн үймээний үеэр ганцхан шидээд л мөрдөгч нохойн толгойг тас огтолсон зэвсгийг бий болгож чадаагүй билээ. Тэр нь хоёр талаас нь ирлэсэн хоолны таваг байсан гэдэг. Гэхдээ л Монголын шоронгуудад халбаганы ишээр хутга хийхээс гадна хоёр утас хооронд нь холбож «коротоклуулаад» хоол цай түргэн буцалгагч «тень» хийчихдэг ур чадвартай хүмүүс олон байжээ. Тухайлбал 15 жил гянданд суусан «Хятад» Гаанжуур иймэрхүү зүйл хийхдээ гаргууд байж. Тэр ямар сайндаа л гяндангийн өрөөнийхөө сараалжин цонхон дээр будаа тавьж, тэрхүү будаан дээр нь тагтаа ирэхэд хөлийг нь утсаар оосорлон барьж аваад хоёр утас хооронд нь «коротоклуулаад» шар-аад идчихдэг байсан гэдэг. Гэхдээ дээрхи аргыг Гаанжуур анх гаргаж ирсэн хэрэг биш энэ нь мөн л аль цагаан хааны үеийн Оросын эрүүгийн гэмт хэрэгтнүүдээс гарч ирсэн уран бүтээл юмсанж. Хоолны хувьд «Ганц худаг»-ийн шорон шууд л дэлхийн бүх зартай шоронгуудын урд гишгэнэ. Гэхдээ Хятадын өмнөд мужийн нэг шоронд өдөрт ганц удаа усанд чанасан будаа өгдөгтэй зүйрлэвал арай ч хойгуур орж мэдэх юм. «Ганц худаг»-т хоригдож буй ялтан нэг өдөрт 300 грамм талх, нэг таваг бантангийн нормтой. Хүн нормоо хэн нэгэнд булаалгахгүй бүтэн идээд суулаа гэхэд л сар болоход 10-аад кг жин биенээсээ аваад хаячихна. Гоо сайхны тураах үйлчилгээний «Синди» гэх мэт төвүүд энэ талаар «Ганц худаг»-аас суралцвал зохино. За бөөсний талаар ярих юм бол Монголын шоронгууд дэлхийд толгой цохих нь ойлгомжтой. Гадаадын нэг судлаач тэр жил Монголын шоронгуудаар судалгаа хийснийхээ дараа «Танай шорон дэлхийд хамгийн харгис шорон байна. Яагаад гэвэл танай хоригдлуудын биед бөөс тоо томшгүй ихээр гүйлдэж байна» гэсэн гэдэг. Хэдийгээр ном зохиолд гардаг шиг «Ганц худаг»-ийн ханыг цоолоод оргочихсон хүн үгүй боловч хуучин мөрдөнгийн бүх камерууд хоорондоо тамхи, мөнгө дамжуулах цоорхойтой байлаа. 50 см-ийн зузаан ханыг залхуугүй өрөмдөж цоолсон эрхий хуруу л багтах хэмжээний жижигхэн нүхээр сонин хуйлж ороогоод үзүүрт нь ширхэг тамхи, эсвэл мөнгө хийж шургуулдаг байна. Энэхүү хана цоолж харьцах арга дэлхийн бүх шоронгуудад түгээмэл байдаг холбооны хэрэгсэл юмсанж. «Ганц худаг»-ийн шинэ мөрдөн ашиглалтанд ороогүй байхад эмч нар өвчтөнүүдтэй маш хэрцгий догшин харьцдаг байжээ. Ялтан этгээд халуураад бие нь галласан зуух шиг болчихсон, ухаан сөхөөгүй хэвтэж байхад эмч ирж үзчихээд «За яахав жаахан хүндэрсэн байхад буруугүй» гэж хэлчихээд явж байсан тохиолдол ч бий аж. Эрүүл энхийн ариун тангараг өргөсөн эмч хүн өвчин нь ахиад жаахан хүндрэхэд буруугүй гэж хэлж байсан түүх өөр хаана ч гараагүй биз ээ. Нэг талаар хоригдолууд баашилна гэдгийг ямар ч улсын гавьяат жүжигчнээс илүү харуулдаг учир эмч нар тийнхүү болгоомжтой ханддаг байсан биз. Бүтэн найман цаг галзуу хүний дүрд тоглоод гэнэт эдгэрч байсан «жүжигчин» ч бий. Хуучин мөрдөнгийн камерууд шалан дороо язганасан бясатай, агааржуулалт муутай байсан тул ялангуяа хаврын цагт гэнэт боссон хүний нүд харахдаа толгой нь эргээд шал түсхийн мөргөж унах нь олонтаа. Ийнхүү өмнө нь хүн шал мөргөн унаж байхад харгалзагч нар огтхон ч тоохгүй жаахан байж байгаад ухаан орно биз дээ гээд явчихдаг байж. Мөн «Ганц худаг»-т хоригдолуудтай наймаа хийдэг хүн жинхэнэ баяжих боломжтой байв. Дүнсэн тамхи л гэхэд гаднаас бараг гурав нугарсан үнээр орж ирэх бөгөөд хайрцаг шүдэнз 100 төгрөгийн үнэтэй байсан гээд бодчих. Тэгвэл АНУ-ын Техасын төв гянданд ар гэрийнхэнтэйгээ утсаар ярих боломж 500 ам.долларын хөлсөөр олддог аж. Энэ нь тэндэхийн харгалзагч нарын цалингаасаа гадуур олдог орлого юмсанж. Эдүгээ ОХУ-ын шоронгуудад хоригдолууд бие биенээ тамлах дэглэх явдал гаарч байгаа бол хятадын шоронгуудад харгалзагч нар нь илүү их дэглэдэг гэнэ. Жишээ нь хятадын Ухань хотын төв шоронд нэг нөхрийг пивоор дайлж байна гээд 10 литр шээс шахаж уулгаад алчихсан харгалзагч өөрөө камерт заларчээ. «Ганц худаг»-т ийм зүйл байхгүй ч гэлээ харгалзагч нар



уйдаагаа тайлахаар адарсан эцэнхий хоригдолуудын нуруун дээр хаймран бороохой буулгах боломж хэзээд нээлттэй байдаг. Одоогоос таван жилийн өмнөх «Ганц худаг»-ийн дүр зургаар жишвэл манай төв шорон дэлхийн зартай хорих газруудтай эн зэрэгцэх хэмжээнд байсан байна. Гэвч одоогоос энэ боломжоо алдан, эд баялаг, эрх чөлөөгөөр бялхаж буй дуулдах нь нэг талаар баярлууштай ч, нөгөө талаар ялтануудыг хэтэрхий давруулж байгааг нь бодохоор харамсууштай.

## **Д.Чимэдлхам: «Нялга» Жумдаан гэгч хүний**

### **үнэргүй амьтанаас болж хоёр хүүхдийн**

### **маань ирээдүй бүрхэг болж хувирлаа**

Чингэлтэй дүүргийн 8-р хороонд оршин суух Нямзагдын Жумдаан гэгч эр арав гаруй жил шоронд суусан нэгэн бөгөөд тэрбээр 2000 онд шоронгоос суллагдаад нэг дагавар хүүхэдтэй хүүхэнтэй дэр нэгтгэж удалгүй өөрийн гэсэн хүүхэдтэй болжээ. Гэвч тэр 2006 онд ганц биеийн жаргал хөөхөөр ханилсан хань, хүний өөрийн хүүхдээ хаяад зогсохгүй орон байрыг нь зараад арилж өгчээ. Ингээд түүний эхнэр Д.Чимэдлхамтай ярилцсанаа толилуулъя.

**-Та Нямзагдын Жумдааныг орон шоронд ял эдэлж байсныг нь мэдсээр байж яах гэж дэр нэгтэсэн юм бэ?**

-Орон шоронд орж зовлон үзсэн байж магадгүй гэж итгээд л суучихсан юм. өөрөө ч ярьдаг байсан. «Би олон жил шоронгоор явлаа, Одоо надад насны хань хэрэгтэй байна. Чиний хүүхдийг би ад шоо үзэхгүй. Тэгээд ч би өөрийн гэсэн үр хүүхэдтэй болмоор байна. Чи минь миний сэтгэлийг ойлгооч дээ» гээд л өдөр шөнөгүй гуйгаад байсан байхгүй юу. Тэгээд би бодлоо. Нээрээ ч зайлуул орон шоронд олон жил болсон болохоор хань ижил, үр хүүхдийг аргагүй л хүсч байна гэж. Жумдаан ч анхандаа ийм л байсан. Дагавар хүүхдээ ч үнсээд, өөрийнхөө хүүхдийг ч үнсэж үлгээд их аятайхан байсан. Гэвч шоронгийн хүн гэдэг шоронгийн л хүн байдаг юм байна. Одоо бодоход айхтар дотуур тамиртай, муу санаатай хүн байж. Түүнийг бэлэн зэлэн орон гэртээ оруулж, цай хоолоор дайлж байсан нь миний алдаа болж байгаа юм.

**-Та хоёрын дунд хэрэлдэх, зодолдох явдал байсан уу?**

-Гэр бүлд ямархуу хэрүүл маргаан гардаг билээ тэр бүгд гаралгүй л яахав. Гэхдээ нэг их зодолдож нүдэлдээд байдаггүй байлаа. Тэр уг нь тайван дөлгөөн уур уцаар багатай л даа. Хэзээ билээ дээ, нэг удаа согтуу ирчихээд намайг сандалаар цохих гээд арай онолгүй нугастай толь хагалчихсан юм даг. Түүнээс өөр зодож нүдэх гэж аашилж байгаагүй санагдана. Маргааш нь их л гэмшиж «Чамдаа би дахиж хэзээ ч гар хүрэхгүй» гэж уйлан дуулж байсан. Ер нь ч тэр цагаас хойш гар хүрээгүй, нэг их хэрэлдэж муудалцаа ч үгүй. Гэвч түүний сэтгэл зүрхэнд намайг голгүй хулхидах айхтар санаа явж байсан болохоор худлаа инээж ханиагаад, энхрийлж таалаад явж байсан байна. Би гэдэг тэнэг юм тэрийг нь мэдэхгүй «Миний Жумдаан ёстой сайн хүн» гээд найз нөхөддөө магтдаг байлаа. Одоо харин газар доогуур ортол муулах болчихоод байна.

**-Та тэгээд хажууд нь байж байгаад л орон байраа заруулчихсан хэрэг үү?**

-үгүй чишш. Нэг өдөр Жумдаан жигтэйхэн сайхан зантай халамцуу орж ирээд «Хөгшин чинь өнөөдөр маш чухал хүнтэй тааралдаад гэв гэнэт л мөнгөтэй болчихлоо» гээд өврөөсөө гурван зуу гаруй мянган төгрөг гаргаж надад өгөөд «Чи хоёр хүүхэдтэйгээ хэд хоног ээж дээрээ очиж амарчихаад ир. өнөө оройны суудлаар Зүүнхараа явчих. Хөгшин чинь та

гурвыг суулгаад өгье» гээд л сүйд болох нь тэр. «Юун мөнгө хаанаас олоод ирэв» гэж асуутал «Шоронд хамт байсан нэг нөхөр маань компаний захирал болчихсон манаргаж явдаг байгаа. Нэрийг нь Сэргэлэнбаатар гэдэг юм. Энэ хүн шоронд байхдаа миний гар дээр байсан юм. Би түүнийг 1992 онд тураалд ороод үхэх гэж байхад нь амийг нь аварч байсан юм даа. Одоо тэгээд тэр надад хариугаа барьж байна. Энэ муу гурван зуун мянган төгрөг юу ч биш. Цаашид би эдний компанид жолоочоор орохоор болчихлоо. Одоо жолооны курст сурдаг хэрэг. Курст суралцах мөнгийг Сэргэлэнбаатар өгнө гэсэн” энэ тэр гээд л бурж гарсан. Би үнэндээ үнэмшсэн. өчнөөн мөнгө гаргаж ирээд барим тавим ингэж яриад байгаа хүний ярианд үнэмшилгүй ч яахав. Ингээд л би түүний өгсөн гурван зуун мянган төгрөгөнд учиргүй баярлаад орой нь хоёр хүүхдээ дагуулаад Зүүнхараагийн галт тэргэнд суусан даа. Зүүнхараад очоод би ээждээ Жумдааныг хичнээн ихээр магтсан гээч. Ээж маань ч надтай үг нийлээд “цаадах чинь Дэлгэрдалайг бодвол /Дэлгэрдалай гэдэг нь Чимэдлхамын түрүүчийн нөхөр/ зовлон үзсэн хүн. Ийм нүнжиг буянтай эр хүнийг улам л ихээр хайрлаж явдаг юм шүү” гэж захиж байсныг яана. Тэгтэл ёстой нөгөө магтсан хүүхэн хуриман дээрээ пүдхийлгэв гэгчийн үлгэр болдог байгаа. Би ээж дээрээ арав гаруй хоночихоод хотод иртэл манай байранд тэс өөр улс байж байсан. “Юун улс вэ, би гэртээ ормоор байна” гэж хашгиртал гэрийн эзэгтэй нь бололтой нэг шар үстэй хүүхэн “Чи одоо өвчтэй солиотой юмуу. Энэ байрыг чинь манайх Жумдаан гэдэг хүнээс худалдаад авчихсан. Худлаа гэвэл ордер нь энэ байна” гээд өөрсдийнхөө нэр дээр болгосон ордероо үзүүлсэн. Зүрх палхийгээд л явчихлаа. Гэхдээ Жумдааныг арай ч голгүй алчихаагүй байх гэж итгэсэн хэвээр байлаа. Энэ үед манай хажуу талын айлын Оюунцэцэг гэдэг хүүхэн гарч ирсэнээ “өө, та нар хүрээд ирэв үү. Жумдаан та нарт нэг юм үлдээсэн” гээд гэртээ ороод нэг цаасанд боодолтой юм авчирч өглөө. Задлаад үзтэл баахан мөнгө байна. Тоолоод үзтэл нэг сая төгрөг байлаа. Нэг захиа байхаар нь задалж уншлаа. Тэр захианд ‘та гурав энэ сая төгрөгөөр гэр авч бариарай. Таван зуун мянган төгрөгөнд яая даа гэсэн гэр олдоно таван зуун мянгаар нь хоёр хүүхэддээ хувцас авч өгөөрэй. Чимэдлхам чи бол алзахгүй хүүхэн. Надтай надгүй амьдралаа аваад явчих чадалтай хүүхэн” гэх зэргээр хөөргөсөн байгаа юм. Би нөгөө айлын хаалгыг тогшоод “Манай нөхөр та нарт байраа хэдэн сая төгрөгөөр зарсан бэ” гэж асуутал “24 сая төгрөгөөр зарсан” гэдэг байгаа. Ёстой муухай. 24 сая төгрөгөөс бид гуравт ердөө ганцхан сая төгрөг үлдээж байгаа юм даа. Дагавар хүүхэд бид хоёрыг бодохгүй байж болно. Гэтэл өөрийнх нь төрсөн үр үлдэж байна шүү дээ.

**-Та тэгээд цагдаад хандсан уу?**

-Цаад Жумдаан чинь хаана байгаа нь мэдэгдэхгүй байна. Нэг хэсэг Эрээнд наймаа хийж яваа сураг сонсогдсон. Тэгтэл төдөлгүй Оросын холбооны улсад яваа сураг дуулдсан. үүний дараа Сөүлийн Түндэмүн зах дээр яваа сураг дуулдсан. Гэвч би энэ бүхэнд итгэхгүй байгаа. Энэ цуурхалыг Жумдаан албаар гаргаж намайг төөрөлдүүлж байгаа байх гэж би боддог. Тэр ердөө Улаанбаатарт залуухан хүүхэн тэвэрчихсэн, хүү бид гурвын байрны мөнгөөр тэр хүүхнээ зугаацуулаад л явж байгаа болов уу. Дотор гэж ёстой хонгио болсон хүн байж. Нөгөө Сэргэлэнбаатар гэдэг компаний захирлыг нь би хайгаад хайгаад олоогүй. Мэдээж тэр нь зохиомол хүн байх л даа. Надад гаргаж өгөөд байсан тэр гурван зуун мянган төгрөг нь хүртэл байр зарсаны урьдчилгаа мөнгө болж таарлаа. Тэгээд л бид гурвыг бөгс өндийнгүүт зарчихсан бололтой.

**-Жумдаан өмнө нь ямар хэргээр шоронд орж байсан юм бэ?**

-Залилангийн хэргээр орж байсан юм билээ. Залилан залиландаа бүр байрны ордер шүү. Энэ талаар бүр мэргэжсэн бололтой. Тэгээд л хотын төвд хоёр өрөө байртай намайг олзолж авсан байгаа юм. Итгэл үнэмшил төрүүлэхийн тулд хүүхэдтэй хүртэл болгож амжсан. Ийм муухай хүн гэж байх уу даа.

**-Танай нөхөрт нууц амраг ч юм уу, ер нь дотны харьцаатай хүн байсан болов уу?**

-Шоронд орохоосоо өмнө 1980-аад оны сүүлчээр нэг хүүхэнтэй сууж байсан юм билээ. Гэхдээ тэрэнтэйгээ аль хэдийн холбоо харилцаагаа тасалчихсан гэж ярьдаг байлаа. Тэр хүүхэн нь нэг удаа шоронд байхад нь эргэж очиж л дээ. Тэгтэл нэг хянагчтай явалдаж бариад сэтгэлд нь сэв суулгасан гэдэг юм. Жумдаан энэ хүүхнээ надад газар дор ортол муулдаг байсан. Гэвч тэр хүүхнийх нь явдал үнэн ч юмуу, худлаа ч юмуу хэн мэдлээ. Надад сайн хүн болох гэж түрүүчийнхээ эхнэрийг худлаа муулдаг байсан байж магадгүй юм. Ер нь Жумдаан их хүүхэмсэг хүн. Түүнийгээ нуудаггүй хэрнээ шалиг зангаа ил гаргаад байхыг хүсдэггүй байсан. Ямар сайндаа л хамт ял эдэлж байсан хүмүүс нь түүнийг “Нялга” Жумдаан гэдэг юм билээ.

**-Яахаар нь “Нялга” гэсэн хэрэг вэ?**

-Яахав дээ. Юу гэж ч хэлмээр юм бэ дээ. Шоронд байхдаа аятайхан эмэгтэй хүн харахаараа өмдөндөө нялайлгачихдаг байсан байгаа юм. Ийм хүн чинь залуухан бөгөөд царайлаг бүсгүй харвал нүдээ ухаад өгөхөөс ч буцахгүй шүү дээ. Гэхдээ арай ч нүдээ ухалгүйгээр байрыг минь зарчихсан байгаа юм. Сайхан хүүхний төлөө бол юу ч хийж мэдэхээр хүн. Цаад бүсгүй нь аягүй бол өөрөөс нь арав хорин насаар дүү оюутан байгаа болов уу. Тэгээд л түүндээ баян хүн болж харагдах гээд байр сав, хувцас хунар, сургалтын төлбөр энэ тэрийг нь даагаа биз. Ийм юмны төлөө хүү бид гурвыг амархаан золиосонд гаргаж мэдэхээр хүн байж. Даанч би хожуу ухаарлаа даа.

**-Одоо та тэгээд яаж шуухан амьдарч байна даа?**

-Жумдааны үлдээсэн сая төгрөгийн таван зуун мянгаар нь гэр авч айлын хашаанд амь зууж байна. Би ч дүүрсэн хэрэг. Тачаалын хэнээтэй «Нялга» Жумдаан гэгч хүний үнэргүй амьтанаас болж хоёр хүүхдийн маань ирээдүй л бүрхэг болж хувирлаа даа.

## **Хоёр хулгайчийн бэлэг эрхтэн гэмтээснээ би нүгэл гэж боддоггүй**

Монголын шоронд 23 жил ял эдэлсэн Навааны Галбадрах гэгч эр өнөөдөр аргагүй л томоожоод байна. Тэрбээр 16 настайдаа анх хүүхдийн колонид очжээ. Тэгээд 18 настайдаа гарч ирээд цэргийн албанд татагдаж Зүүнбаянгийн цэргийн ангид очсон байна. Тэнд байхдаа нэг хачин хэрэг өдүүлээд 13 жилийн ял авчээ. Тэгээд томчуудын шоронд очоод мөнөөх хачин хэргээ дахиж үйлдээд арван жилийн ял авсан байх юм. Тэрхүү хачин хэргийг өөрийнх нь ярианаас сонирхоно уу?

### **-Та анх хүүхдийн колонид ямар хэргээр орсон юм бэ?**

-1960,70-аад оны хүүхдүүд ер нь хулгай, дээрмийн хэргээр л шоронд орсон байдаг шүү дээ. Би ч бас тэр замаас гажаагүй. Би үеийнхээ хүүхдүүдийг удаа дараа дээрэмдсэн хэргээр Сэлэнгэ аймгийн Цагаан толгойн хүүхдийн колонид очсон. Намайг очиход Цагаан толгойн колони үнэхээр дэгтэй байлаа. Багш нар маань аймаар харгис байсан. Ёстой тамир тэнхээг маань тасартал дэглэдэг байлаа. өдрийн цагаар бид чинь орон дээр суух эрх байхгүй. Шөнийн 23 цаг хүртэл шалаа зүлгэнэ. Хааяа багш нарын сайхан ааш нь хөдөлбөл өдөрт нэг цагаар орон дээр унтуулдаг байсан. Хамгийн том харж үзэж байгаа нь энэ шүү дээ. Ер нь хуягуудад хүүхдүүдийг өрөвдөх сэтгэл үнэхээр байхгүй байсан. Бид хуягуудыг багш гэж дууддаг байлаа. Гэтэл нөгөө сүрхий багш нар маань биднийг өвлийн хүйтэнд малгайг маань гарт бариулаад номхон зогсооно. Зуны халуунд нар луу харуулаад зогсооно. Галуун цуваагаар алхуулна. Одооны хүүхдийн шорон харин их сайхан болсон сурагтай. Бараг л “Дахиж битгий гэмт хэрэг үйлдээрэй” гээд хоол ундаар бордоод, толгойг нь илж таалаад байдаг гэж байгаа. Хүүхдийн эрхийг хамгаалах олон янзын байгууллага гарч ирсэний л ач гавьяа байх. Харин захиргаадалтын үед хүүхдийн эрхийг хамгаалдаг байгууллага гэж байхгүй байж. Филатова авгайн толгойлдог байсан “Хүүхдийн төлөө фонд” гэж байсан боловч “Хүүхэд бол бидний баясгалант ирээдүй” гэж хуцахаас өөр ер нь юу хийсэн юм бүү мэд. За яахав, Хүүхдийн ордон энэ тэрийг бариулсан байх л даа. Харин шоронд ял эдэлж байгаа хүүхдүүдэд тусламжийн гараа сунгаж байсныг би л хувьдаа мэдэхгүй юм.

### **-Та хүүхдийн колониос суллагдаад шууд цэрэгт явсан хэрэг үү?**

-Тэгсэн. Хүүхдийн колонид хоёр жил аймшигтайгаар дэглүүлчихсэн болохоор цэрэгт очоод ёстой толгой өвдөхгүй гэж бодож байлаа. Тэгтэл нэг муу «Жа» харин намайг дэглэх гэж томордог байгаа. Тухайн үед Улаанбаатараас цэрэгт татагдсан хөвгүүдийг ихэвчлэн Зүүнбаян руу цөлдөг байсан юм. Энэ бол соц нийгмийн үеийн энгний явдал байлаа. Намайг Зүүнбаянд очиход Баатарзориг гэдэг «жа» угтаж авсан. Тэр аймаар харгис эр байлаа. Яахав би карентины 45 хоногийн хугацаанд Баатарзоригийн үгэнд ороод их аятайхан байсан. Харин карентин дууссаны дараа Баатарзориг биднийг мөн л нөгөө хуучин янзаараа дэглэх гэж томордог байгаа. Тэгэхээр нь би «Чи одоо хэн юм бэ. Чамайг бодвол би хүүхдийн колонид янз бүрийн юм үзээд ирсэн хулгайч шүү. Чиний энэ дэглэлт чинь хүүхдийн колоний дэглэлтийн хажууд цэцэрлэгний хүүхдийн тоглоом шиг санагдаж байна. Ёо ёо ёо. Би чамд дэглүүлээд аягүй бол үхчих юм байна л даа» гээд хэлээд тавьчихсан. Тэгтэл нөгөөдөх чинь» Яасан овоомуу гоожуур вэ» гээд надруу улаан галзуу юм давхиад ирлээ. Тэгэхээр нь толгойд нь ганц өшиглөөд унагасан. Баатарзориг шинэ цэргүүдийн хажууд үнэхээр шараа болж байгаа

юм. Тэгээд ичсэн нэрэндээ гараад гүйчихсэн. Төдөлгүй өөр ротын дөрөв таван «жа»-г дагуулаад орж ирсэн. Би дөрөв таван хүний өөдөөс аргагүй л ганцаардаж байгаа юм. Манай он жавууд үнэхээр юу ч үзээгүй амьсгаанууд байсан л даа. Уг нь би Баатарзоригийг гараад явуут он жавууддаа хандаж «Одоо цаадах чинь баахан юм дагуулаад орж ирнэ. Бүгдээрээ зэрэг дайрна шүү. Энэ муусайнуудаас ерөөсөө айж болохгүй. Айх л юм бол улам дордоно. За ойлгосонуу, бүгдээрээ зэрэг дайрна, мэдэвүү» гэхэд бүгд «Мэдлээ» гэж хуцсан байхгүй юу. Тэгтэл ахлах түрүүч погон зүүсэн хэдэн өндөр «жа» ороод ирүүт бүгд сүнс нь зайлж байгаа юм. Би амьхандаа он жавуудаа хөдлөх юм бодоод «Дайраад» гээд тэдэн рүү гүйсэн боловч бүгд миний ард үлдчихэж байгаа юм. Тэгээд би ганцаараа гүйж очоод таван «жа»-д нэвширтлээ балбуулж байгаа юм. Зөвхөн балбуулаад зогсохгүй он жавуудтайгаа цуг мөнхийн диграмманд орсон. Нөгөөдүүл чинь «Яасан овоо шинэ цэргүүд вэ» гээд л дэглээд байдаг болсон. Би үнэндээ ганцаардсан л даа. Он жавууд дотор маань тав зургаан зоригтой цэрэг байхад л тэдний хандыг хага дарчих байсан юм. Гэвч арми бол арми шүү дээ. Шинэ цэргүүд хуучин цэргүүдийн өөдөөс хичнээн тэрсэлдээд дийлэхгүй нь ойлгомжтой. Яагаад гэвэл хуучин цэргүүд чинь офицеруудтай хүртэл ходий болчихсон байдаг болохоор муусайн шинэковуудыг яаж ийгээд л дарж авна шүү дээ. Баатарзориг намайг олны хүчээр дарж авсаныхаа дараа байнга зоддог болсон. Би түүнд зодуулах болгондоо бас л мөчөөгөө өгөлгүй шазуур зуугаад “За яахав, чи намайг зодож л бай. Би хэзээ нэгэн цагт гэдсэн дээр чинь тоосго тавина даа” гэж зандаг байсан. Тэгээд нэг л өглөө санаснаа гүйцэлдүүлсэн дээ. Баатарзоригийг өглөө сэрэхэд нь би гэдсэн дээр нь тоосго тавьчихсан байхгүй хаачихав?

### **-Гэдсэн дээр нь тоосго тавина гэдэг чинь юу гэсэн үг вэ?**

-Баатарзориг тэр тоосгыг гэдсэн дээрээсээ авч чулуудах л юм бол бэлэг эрхтнээ тасална гэсэн үг. Учир нь түүний эрхтэнийг яг л тарваганы урхи шиг мяндсан утсаар гогцоо гаргаж уяад тоосгонд баглачихсан байхгүй юу. Энэ бол хүүхдийн колонид байхдаа дуулж сонссон хорон арга л даа. Гэхдээ хянагч нарын эрхтэнийг тасдах ямар ч боломж байхгүй. Тэд нар чинь хуяг нэрэндээ зохисон жинхэнэ хуяглагдсан хулгайчууд байхгүй юу. Тэгээд ч насанд хүрээгүй хүүхдүүд тэднийг ямар нэгэн байдлаар чадах сэтгэлийн тэнхээ дутна. Харин 60-аад оны үеийн ялтнууд ийм арга хэрэглэдэг байсан гэдэг. Гэхдээ чухам хүний эрхтэн тасалсан эсэхийг бүү мэд. Эрхтэнийг нь арай ч тасалчихдаггүй, арьсыг нь зумлаад мэс засал хийлгэж оёулах хэмжээнд хүргэдэг байсан бололтой. Баатарзориг сэрэнгүүтээ “Хэн ингэж гэдсэн дээр тоосго тавьсан бэ” гэж хашгирахаар нь би “Би тавьсан юм. Чи овоо юм бол наад тоосгоороо миний тархийг хага цохиоч дээ” гэж хашгирсан. Тэгтэл Баатарзориг нөгөө тоосгыг над руу байдаг хүчээрээ чулуудсан. Юу болсон нь ойлгомжтой. Муухай бархираад л явчихсан. Бэлэг эрхтэн нь бараг л тасарсан даа. Жаахан арьсан дээр л дэнжигнэж байсан. Яахав тэгээд сайн эмч нарын буянаар мэс засал хийлгэж оёулаад нэг муу эрхтэн шуу юмтай үлдсэн байгаа юм. Тэр нь их л эмзэг, хэврэг юм болсон дуулдсан. Олигтойхон хүүхэн цохиж ч чадахааргүй болсон гэнэ билээ. Харин энэ явдлаас болж Зүүнбаянгийн цэргүүдийн дунд “Гэдсэн дээр чинь тоосго тавина шүү” гэдэг үг нэг хэсэгтээ л амны уншлага болсон гэж байгаа. Би ч юугаа мэдэхэв. Тэр даруйдаа баривчлагдаад л 13 жилийн ял аваад томчуудын шоронд очсон юм чинь. Хүний эмзэг эрхтэн гэмтээсэн болохоор ийм олон жилийн ял авсан хэрэг. За тэгээд Мааньтын чангад очоод мөн л байр сууриа олж авах гээд овгор хулгайчуудтай ана мана үзэлцэж эхэлсэн. Бүтэн хоёр гурван жил цусаа гартал үзэлцэсний хүчинд арай гэж нэг юм байр сууриа олж авсан даа. Байр сууриа олж авна гэдэг чинь хэнд ч дээрэлхүүлэхгүй овгор

атаман болно гэсэн үг. Энд би нэг хэсэгтээ л азаргалсан. Харин энд долоон жил болоод дэглэм буурч өвөрхангайн Бат-өлзийн шоронд очсон. Тэр үед Бат-Өлзий шорон Хархорин руу нүүж байсан үе. Ер нь соц нийгмийн үед шинэ шорон байгуулагдахад энд тэндхийн овгор атамануудыг цуглуулаад тусад нь диграмманд оруулдаг байсан юм шүү дээ. Үүнийг хянагч нар «Шинэ шоронгийн мялаалга» гэж нэрлэдэг байсан. Нэг үгээр хэлбэл шинэ цэргийн карентин гэдэг шиг шоронгийн карентин гэсэн үг л дээ. Намайг Хархорины шоронд байхад Дарханы атаман Сүнкээ гэгч хятадын эрлийз залуу ял эдэлж байлаа. Энэ хулгайч надад их томорно. Яагаад гэвэл Мааньтаас би ганцаарханаа очсон, харин Сүнкээ Хар-Айрагийн онцгойгоос тав зургаан гал хамынхаа хамт очсон болохоор тэр намайг азаргалах гэж зүтгэсэн. Би ч мөчөөгөө өгөлгүй үзэж тараад тав зургаан гал хамуудад нь нэвширтлээ зодуулж байгаа юм. Ер нь би хаана ч очсон бөөн хулгайчуудад зодуулах тавилантай юм билээ. Гэхдээ би Сүнкээгийн гэдсэн дээр тоосго тавьж амжуулсан л юм даа. Мань эр бас л эрхтэн хагас болсон. Гэхдээ тэр нь арай ч тасарчихаагүй. Шөрмөс нь тасраад ямар ч мэдээгүй болсон гэж байгаа. Гэхдээ шээс бол гарна. харин нөгөө тожиг можиг нь гардаг ч байсан юмуу, үгүй ч юмуу хэн мэдлээ. Үүнийг зөвхөн Сүнкээ л өөрөө мэдэх байх. Сүнкээ одоо хүртэл амьд байдаг гэсэн шүү. Харин нөгөө Баатарзориг 1990-ээд оны үед хүнд алуулсан сураг дуулдсан. Би ийм л хоёр том нүгэл үйлдсэн хүн дээ. Гэхдээ би үүнийг нүгэл гэж боддоггүй. Хүний олноор түрий барьдаг муусайн онгиороо хулгайчуудыг л хөөрхөн чадчихсан болохоос биш ямар ч гэмгүй хэн нэгнийг чадчихсан юм биш. Үүндээ би сэтгэл бардам байдаг. Үүнийхээ ялыг ч хангалттай эдэлсэн. Сүнкээгийн хэргээс болж би арван жилийн ял нэмүүлж гяндлуулж байлаа. Харин гянданд очоод ёстой хүмүүжил гээчийг олсон доо.

## Пунсалмаа гэгч залхуу хүүхэн гэрийнхээ унийг түлж дуусгаад байна

Том том бөхчүүдийн хүүхэд эцгүүдээ дуурайгаад бөх болоод байгаа. Мөн яруу найрагчдын хүүхэд яруу найрагч болсон тохиолдол зөндөө байна. Тэгтэл хулгайчийн хүүхэд бас хулгайч болдог ажээ. Эдүгээ шоронд ял эдэлж буй Дамдингийн Доёддорж гэгч тавь орчим насны эр өөрийгөө 1950-иад оны цуутай гэмт хэрэгтэн «Шилэн» Дамдингийн төрсөн хүүхэд гэж хөөргөдөг аж. Тэр хулгай дээрмийн хэргээр дөрвөн удаа шоронд орсон ёстой л засаршгүй этгээд бололтой. Гэвч олон жил шоронд суусан Баатарын сугаа гэгч эр Доёддоржийг «Шилэн» Дамдингийн хүүхэд биш гэж үгүйсгэдэг аж. Түүнтэй саяхан уулзаж хэд гурван үг солилцсон юм. Тэрбээр «Доёддорж өөрийгөө «Шилэн» Дамдингийн хүүхэд гэж худлаа шааж байгаа юм. Тэр «Шилэн» Дамдингийн хүүхэд болж олон жил амиа аргацаасан. Ялангуяа Дашийн Мундаа, Цэвээний хар Лхамсүрэн нарыг шоронд байхад Доёддорж «Шилэн» Дамдингаар их түрий барьдаг байсан юм. Мундаа, Лхамсүрэн хоёр түүнийг Дамдингийн хүүхэд гэж итгэчихээд янз бүрийн зүйлээр харж үздэг байсан. Сайн эцгийн нэрийг гурав худалдаж иддэг гэгчээр Доёддорж муу эцгийнхээ муу нэрийг гурав битгий хэл арав худалдаж идэж байгаа хүн» гэсэн юм. Гэхдээ Баатарын Сугаагийн үгэнд бас бүрэн итгэж болохгүй. Тэр түүнийг «Шилэн» Дамдингийн хүүхэд биш гэдгийг баттай нотолж чадахгүй байгаа бөгөөд үгүй ядаад «Доёддоржийн эцэг «Шилэн» Дамдингаас өөр Дамдин гэдэг тийм хүн байсан» гэж хэлж мэдэхгүй байна. Харин Доёддорж «Шилэн» Дамдингийн талаар их зүйл мэддэг бөгөөд үйл, явдал, он цаг нь хүртэл яг таараад байдаг юмсанж. «Шилэн» Дамдин зөвлөлтийн зохиолч Алексей Ургановийн «Мөр хөөсөн нь» гэдэг зохиолыг амтархан уншиж ширээнийхээ номыг болгосноор гэмт хэргийн ертөнцөд анх хөл тавьсан гэдэг. Тэр анх 1950 онд хүн зодсон хэргээр зургаан сарын албадан хөдөлмөрт дайчлагдаад тэр цагаас хойш буруу зам руу хальтран орж огтхон ч засал аваагүй байна. Мөн энэ хугацаанд эхнэртэйгээ муудалцаж, айл ухсан хэргээр шоронд орж байжээ. «Шилэн» Дамдин тухайн үед Банкны гудамжинд суудаг Бадамханд гэдэг сайхан хүүхэнтэй толгой холбосон боловч сайн сайхан амьдралыг үзсэнгүй. Гэхдээ энэ Бадамханд гэдэг хүүхэн Доёддоржийн ээж биш бололтой. Энэ тухай Доёддорж «аав ээж хоёрыг тэр муу Бадамханд гэдэг хүүхэн салгасан юм гэнэ лээ. Миний ээж Цэндээхүү бол хойно сургууль төгссөн өндөр боловсролтой хүүхэн байсан. Гэвч намайг хоёр настай байхад аавыг тэр Бадамханд гэдэг хүүхэн эргүүлсээр байгаад аваад суучихсан гэсэн. Уг нь аав ээжтэй амьдарсан бол гэмт хэрэгт тэглээ уруу татагдахгүй байсан юм билээ. Учир нь ээж их үглэж яншдаг байж л дээ. Харин Бадамханд гэдэг хүүхэн бол үглэж янших нь битгий хэл харин ч бүр гэмт хэрэгт уруу татсан гэж байгаа. үнэндээ миний аавыг энэ Бадамхатан гэдэг хүүхэн л баллаад хаячихсан юм» гэж ярьдаг байна. Энэ нь бас ортой ажээ. Дамдин анх гэмт хэргийн ертөнцөд хөл тавиад байсан 16 залууг удирдаж барилга трестийн кассыг ухахдаа тэндхийн нягтлан «хар» Бэгзсүрэн гэгчээс мэдээлэл авсан гэдэг. «Хар» Бэгзсүрэн нь Бадамхандын хамаатан байснаас гадна «Шилэн» Дамдинтай хамт мөрдөнд сууж байжээ. Тэгэхээр Бадамхандын оролцоо энд бас байсан байгаа юм. Бадамханд нэг өдөр Дамдинд хандаж «Бэгзсүрэн чамтай яаралтай уулзах хэрэг байна гэж хэлүүллээ. Их л чухал юм ярих гээд байх шиг байна. Чи одоохон очоод уулз» гэжээ. Дамдин түүний хэлсэнээр яваад очтол Бэгзсүрэн «Манай кассанд үлдэгдэл мөнгө бий. та нар түргэхэн амжуул» гэсэн гэдэг. Ингээд Дамдин тэр оройдоо мөнөөх 16 залууг удирдаад барилга



трестийн кассыг цөлмөчихсөн байна. Гэвч төдөлгүй баригдсан бөгөөд шүүх хурал дээр Дамдингийн ээж Хорлоо гэх настай эмэгтэй ирж нулимс дуслуулан суужээ. Мөн эхнэр Бадамханд нь гэрчээр татагдсан байна. Шүүх хурал дээр хэлсэн Дамдингийн эцсийн үг нь өөрийг нь ялласан гэдэг. «Дамдин та эцсийнхээ үгийг хэл» гэсэн шүүгчийн асуултанд тэрбээр «За би арван жилийн ялтай байгаад оргосон хүн. Надад одоо 25 жилийн ял өгөөд хэрэггүй. Би ахиад л оргоно. үүнээс ч том хэрэг хийнэ. Бадамхандыг ч алж мэднэ. Ер нь энэ Бадамханд гэдэг хүүхнээс болж миний амьдрал орвонгоороо эргэсэн. Одоо надад тэр буудан гэдгээ өг. Харин хүсэх юм гэвэл надтай хамт хэрэгт холбогдсон энэ 16 сайхан залууг суллаад өгөөч» гэсэн гэдэг. Дамдин яагаад ингэж хэлсэн бэ? гэвэл монгол улсын хуулинд хулгайн хэрэгт дээд хэмжээ өгдөггүй байж. үүнийг нь дамдин мэддэг тул дээд хэмжээ өгч чадахгүй гэж боджээ. Нэг ёсондоо аархаж байгаад өөрийгөө дээд хэмжээнд оруулчихсан хэрэг. Ингээд шүүх өөрийнх нь хэлснээр дээд хэмжээ өгсөн гэдэг. Харин Дамдингийн түүх намтарт Доёддоржийн ээж гэх Цэндээхүүгийн тухай ер байдаггүй. Дамдин ч шүүх хурал дээр хоёр настай хүү Доёддоржийгоо дурссангүй. Ер нь түүний хүүхэд байдаг гэж ер дуулддаггүй байлаа. Харин олон жил ял эдэлсэн «Шулга» Сандаг гуай амьд ахуйдаа «Дамдин уг нь нэг хүүтэй байх ёстой. Гэхдээ тэр нь Доёддорж биш байх. Гэхдээ тэр нь Доёддорж биш байх гэж би боддог. Дамдин Бадамхандаас өмнө нэг хүүхэнтэй сууж байсан нь үнэн. Тэр нь Улаанбаатарын сайхан хүүхэн Цэрэндолгор байлаа. Гэхдээ тэр Дамдингийн хүүхдийг төрүүлээгүй. Харин үүнээс өмнө Дамдин Дархан хотод нэг хүүхэнтэй учирдаг байсан гэдэг. Тэрнээс нь нэг хүү төрсөн гэж байгаа. Гэвч Доёддорж Дарханых биш Улаанбаатарын унаган хүүхэд шүү дээ» гэж билээ. Ямартай ч өөрийгөө «Шилэн» Дамдингийн төрсөн хүүхэд гэж өргөмжилдөг Доёддорж гэгч засаршгүй гэмт хэрэгтэн өнөөг хүртэл шоронд сууж байгаа бөгөөд тэрбээр эцгийгээ дуурайгаад Алексей Ургановын «Мөр хөөсөн нь» гэдэг номыг байнга биедээ хадгалж явдаг юмсанж.

## Пунсалмаа гэгч залхуу хүүхэн гэрийнхээ унийг түлж дуусгаад байна

Залхуу хүний тухай нэг онигоо байдаг. Орон дээрээ хэвтчихээд босохоосоо хүртэл залхуурдаг нэг эр байж л дээ. Түүний дээхэн талд унинд дүүжлээстэй мах байж. Тэгтэл мань залхуу уг махыг өндийгөөд авахаасаа залхуураад «Энэ мах миний ам руу уначихдаггүй юм байхдаа» гэж бодсоор өлсөж үхсэн гэдэг. Энэ бол залхуучуудад зориулсан онигоо. Харин нэгэн цагт хулгайн хэргээр Луусангийн шоронд ял эдэлж байсан Пунсалмаа гэгч хүүхэн эдүгээ хулгай хийхээсээ, тэр ч байтугай хүүхэд гаргахаасаа хүртэл залхуурдаг болжээ. Өөрийн гэсэн орон гэргүй, хань ижилгүй, ах дүү хамаатан садан байхгүй мань хүүхнийг нэгэн төрийн бус байгууллага хараандаа авч одоогоос хоёр жилийн өмнө дөрвөн ханатай гэр өгчээ. Гэвч Пунсалмаа ажил төрөл хийж орон гэрээ өөд нь татах нь битгий хэл өдөржин залхуураад гэртээ хэвтчихдэг байна. Тэгээд эсэн бусын эрчүүдийг өвөртөө оруулаад, тэднээр хоол унд, түлээ тулшээ залгуулдаг аж. Хүүхэд шуухад ч байхгүй болохоор түүнд үнэндээ бодож санах юм байдаггүй бололтой. Түүнтэй явалддаг нэг эр «Чи чинь хулгайн хэргээр шоронд орж байсан гээ биз дээ. Чамд хулгай хийх боломж байна. Хажуу айлынхаа хашааг давж ороод түлээний мод хулгайлахад яадаг байна аа» гэхэд Пунсалмаа «Яршиг цаашаа, залхуу хүрч байна. Дуртай юм бол чи өөрөө аваад ир л дээ. Тэгээд миний өвөрт орохгүй юу» хэмээжээ. Мөн нэг эр «Чи наад спиралиа авахуулаад хүүхэд гаргахад яадаг байна аа» гэхэд мань хүүхэн «Яршиг цаашаа, хүүхэд гаргана гэдэг бөөн ядаргаа. Над шиг залхуу амьтан шөнө босч хөхүүлэхээсээ залхуураад хөхөөрөө дараад алчихаж магадгүй» гэж донгосчээ. Тэр үнэндээ орноосоо босоод аяга таваг, хувцас хунараа угаах, гал түлж хоол ундаа хийхээс хүртэл залхуурдаг бөгөөд энэ бүхэнд өвөртөө оруулдаг эрчүүдээ байнга зарчихдаг байна. Ямар сайндаа л нэг эр түүний дотоожийг угааж өгсөн байгаа юм. Саяхан мань хүүхнийх гэнэт түлээ нүүрсгүй болсон бөгөөд өвөрт нь ордог эрчүүд ч тэр үед хаагуур явж байсан юм бүү мэд. Тэгтэл Пунсалмаа хөлдөж үхэхгүйн тулд хажуу айлынхаа хүнийг дуудаад «түлээ нүүрс байхгүй хэцүүдлээ. Нөгөө хэдэн хар юм чинь үзэгдэхээ байлаа. Чи манай гэрийн унинаас хэдийг хугалаад өгөхгүй юу» гэж гуйжээ. Ер нь мань хүүхэн ноднингоос хойш гэрийнхээ унинаас түлж эхэлсэн бөгөөд эдүгээ 88 унинаас ердөө дөчөөдхөн ширхэг үлджээ. Тиймээс тун удалгүй мань залхуу хүүхэн гэрийнхээ унийг бүгдийг нь түлж дуусгаад эсгий туургандаа дарагдаж үхэж магадгүй болжээ.

## Самар цайруулах машинаас болсон хүн амины хэрэг

Хэнтий, Төв, Булган зэрэг аймгуудад сүүлийн үед самар цайруулдаг бага оврын машин ихээхэн ач тусаа өгч байгаа юмсанж. Уг машиныг монгол хүн зохион бүтээсэн бөгөөд уг машиныг хийхэд хялбар, бас эдэлгээ удаантай ажээ. Уг машиныг зохион бүтээхэд самар хийх сав, гаднах ясыг нь няцлах шүд бүхий гол, түүний бариул, тосгуур, тулгуур хөл зэргээс бүрддэг байна. Тэгээд самар хийх саваа боргоцойгоор дүүргээд голыг нь эргүүлнэ. Самарын боргоцойноос няцарч цайрсан самар савны доод нүхээр тосгуур дээр унана. үүний дараа саванд үлдсэн ашиглагдахгүй хэсгийг цэвэрлээд, дахин боргоцойгоор дүүргэнэ. Энэ аргаар өдөрт 20-30 кг самар цайруулах боломжтой юмсанж. Машиныг зөөж тээвэрлэхэд хялбарханаас гадна хаягдлаа нэг дор бөөгнүүлдэг болохоор байгаль орчин бохирдуулахгүй сайн талтай ажээ. Гэвч сайны хажуугаар саар гэгчээр уг машинаас болж нэгэн хүн амины хэрэг гарсан байх юм. Ер нь ямарваа нэг асуудалд заавал нэг гэмт хэргийн шинж агуулагдаад байдаг нь хачин юм шүү. Энд өгүүлэх Сэрээнэн гэгч эр самар цайруулах машинтай болох гэж хэдэн жилийн турш зүтгэжээ. Тэгээд арай гэж нэг юм самар цайруулах машин бүтээгээд байтал хажуу айлынх нь Батцэнгэл гэгч залуу түүнд атаархаад эхэлсэн байна. Сэрээнэн өнгөрсөн жил уг машинаараа 3000 гаруй кг самар цайруулаад хятадуудад өгч овоо хэдэн төгрөгтэй болжээ. Тэгтэл Батцэнгэл нэг өдөр Сэрээнэнд хандаж «Чи надад нэг машин хийгээд өгчихөөч дээ. Уг нь айл хүний амь нэг гэдэгсэн. Тэгтэл чи хужаануудтай амь нэг болчихлоо» гэжээ. Энэ үгийг сонсоод Сэрээнэн уурлаж «Чи битгий хачин юм яриад байгаарай. хужаануудад самар зарсаны төлөө тэдэнтэй амь нэг болчихдоо яахав дээ. Харин ч би тэднийг шулж байгаа хүн шүү. Чамайг ч гэсэн шулахыг хэн байг гэсэн юм бэ. Чадалтай юм бол чи тэр машинаа өөрөө хий. Би чамд тусалж чадахгүй» гэж адарсан байна. үүнээс болж Батцэнгэл Сэрээнэнд гомдоод маргааш нь гэрээ ачаалаад өөр тийшээ нүүжээ. Тэр явахдаа «Чам шиг новшийн амьтантай айл хунар байж хэзээ ч чадахгүй. Чиний сайн явахыг харна аа. Уулын мод бузарлаж, лус савдаг хилэгнүүлээд байгаа чи цаашид олигтой амьдарна гэж түүхэнд байхгүй» гэх зэргээр занажээ. Энэ явдлаас хойш хоёр сарын Сэрээнэнг ууланд самар цайруулж байхад Батцэнгэл нэлээд халамцуу давхиж ирээд «за, хужаа Сэрээнэнгээр юу байна. Чи ч манай нутгийн хамаг самрыг урагш нь гаргаад дуусч байх шив дээ. Ганцаараа идэхээр гахай таргалдаг юм, харин олуулаа идэхээр оготно таргалдаг юм даа. Чи ч яг гахай шиг таргалж байх шив дээ» гэж тавлажээ. Тэгтэл Сэрээнэн «Чиний наад яриад байгаа чинь аль захиргаадалтын үеийн зүйр үг шүү дээ. Олуулаа идэж огтоно таргалуулах ер нь хэнд хэрэгтэй юм бэ. Оготно таргаллаа гээд олон түмэнд ямар ашигтай юм бэ дээ. Харин гахай таргалах бол өнөөгийн зах зээлийн нийгэмд их ашигтай. Чам шиг муу ядарсан юманд хүртэл зүсэм өөх олдоно. Харин энэ зүсэм өөхийг олж идэж чадахгүй бол тэр тарган оготноо шарж идэхгүй юу» гээд хэлээд тавьчихаж. Батцэнгэл энэ үгэнд дэлбэртлээ уурлаад Сэрээнэнгийн самар цайруулдаг машины ёрдгор төмрийг хуга татаж аваад түүний толгой руу буулгаж орхижээ. Цаадах нь муухай чарлаад л гэдэргээ савж унасан байна. Батцэнгэл түүнийг цохиод зогсохгүй самар цайруулах машиныг нь хэдэн хэсэг болгоод хаячихаж. Тэгээд мориндоо ташуур өгөөд ум хумгүй зугтжээ. Энэ үед уулнаас самар татаад уруудаж байсан Сэрээнэнгийн хоёр хүү мориндоо ташуур өгөн зугтаж яваа Батцэнгэлийг харж амжжээ. Тэд аав дээрээ гүйж иртэл дөнгөж амьсгаатай төдий байж. Гэвч тэр удаан тэссэнгүй. Тэгээд ч хөдөө газар эмнэлэгээс хол байсан болохоор тархиндаа хүнд гэмтэл авсан Сэрээнэн нэг цагийн дараа гэхэд л амьсгал хураажээ. Харин Батцэнгэл түүнийг үхчихнэ чинээ огт санаагүй бөгөөд тэр

эрчээрээ давхисаар яваад сумын төв дээр ирж хэдэн нөхрийн хамт архидаж байхдаа «хөгшин чинь сая маш том гавьяа байгуулчихаад ирлээ. өнөө муу шуналын хүүдий Сэрээнэнгийн самар цайруулдаг машиныг би хэдэн хэсэг болгоод хаячихсан. Одоо тэр нэг хэсэгтээ л хөдөлж чадахгүй. Харин энэ хооронд нь хэдүүлээ ууланд гарч самар түүе» гэхэд цаадуул нь «болж байна. тэр муу Сэрээнэнг ингэж хорлох ёстой байсан юм. Нутгийихаа олны төлөө чи маш зөв юм хийлээ» хэмээн бараг л ардын баатар мэтээр өргөмжилсөн байх юм. Энэ нь ёстой л нөгөө тамын тогооны Монголчуудын амьдрал бололтой. Гэвч Батцэнгэл хэдхэн цагийн дараа хүн амины хэргээр баривчлагдсан бөгөөд тэр үнэндээ ийм юм болно чинээ огт төсөөлсөнгүй.

## **Арав гаруй жил ял эдэлсэн Хятадын эрлийз**

### **Найданжавын Чангаанз гэж хэн бэ?**

Өөрийгөө Хятадын эрлийз гэдгийг хэнээс ч нуудаггүй Найданжавын Чангаанз гэгч энэ эр 1991-2002 он хүртэл арав гаруй жил шоронд ял эдэлжээ. Илэн далангүй түс тас яриатай энэ эр улс төрд хүчээ үзэхээр шийдсэн байна. Тэрбээр 2008 оны УИХ-ын сонгуулиар аль нэг намаас нэрээ дэвшүүлэх бололтой. Хэрэв ийм боломж гарч ирэхгүй бол бие дааж нэр дэвшинэ гэж ярьж байна. Одоогоор тэр зураг хөргөө хэвлүүлж олны анхаарал татахыг хусэхгүй байгаа бөгөөд «би 2008 оны сонгуулиар монголчуудад хэн болохоо бүрэн таниулна. Харин одоо бол үзэл бодлынхоо өчүүхэн хэсгийг дэлгэе» гэсэн юм. Түүнтэй ийнхүү ярилцлаа.

### **-Та өөрийгөө Хятадын эрлийз гэдгийг хэнээс ч нуудаггүй юмаа даа?**

-Монголоор дүүрэн Хятадын эрлийз байхад юуг нь нуух юм бэ. Хятадын эрлийз гэдэг чинь хүн биш юмуу. Би хэдийгээр Хятадын эрлийз ч гэсэн Монгол улсын иргэн. Тиймээс сонгох, сонгогдох эрх эдлэх ёстой. Одоогоор би зөвхөн сонгох эрхээ л эдэлж байна. Нэгэнт сонгох эрхээ эдэлж байгаа юм чинь сонгогдох эрхээ бас эдэлж болно биз дээ. Тийм учраас би 2008 оны УИХ-ын сонгуульд нэрээ дэвшүүлнэ гэж бодож байгаа.

-Манай зарим үндсэрхэг үзэлтнүүд “Хятадын эрлийзүүдийг төрийн толгойд хэрхэвч гаргаж болохгүй” гэж ихээхэн дургүйцдэг. Гэтэл та яасан зоригтой байх юм бэ? үүнд ямар нэг учир байна уу?

-Учир байгаа болоод л би ингэж ярьж байгаа юм. Өнөөдөр цэвэр Хятад хүнийг таньж цэрвэхээсээ илүү эрлийзүүдийг таньж мэдэх дэндүү хэцүү болсон. Тэр тусмаа эрлийз, монгол цус холилдсон хурлийзуудыг танина гэвэл ёстой үлгэрийн далай. Ингээд бодохоор жинхэнэ цэвэр монгол цус аль эрт булингартаж үе дамжсаар байгаа. Манайхан аливаа нэг сонгууль дөхөөд ирэхээр л хэн нэгэн улс төрчийг Хятадын эрлийз энэ тэрээр нь дууддаг, бас гүтгэдэг. Гүтгэгдээд, яригдаад байгаа улс төрчид үнэхээр л Хятадын эрлийз мөн юм бол үнэнээ мэдэгдэж яагаад болдоггүй юм бэ. Би иймэрхүү байдалд цэг тавихын тулд улс төрд хүчээ үзэхээр шийдэж байгаа юм. Нэг ёсондоо Хятадын эрлийз улс төрчдийн эрх ашгийг хамгаална гэсэн үг. Өнөөдөр манай улс төрд Хятадын эрлийзээрээ дуудагдаад, гүтгэгдээд явж байгаа олон хүн байна. Эд нарыг Хятадын эрлийз мөн эсэхийг нь тодруулаад улс төрийн хүрээнд байх уу, үгүй юу гэдгийг нь нэг мөр шийдэх хэрэгтэй байна. Тэгэхгүй бол насаараа Монголд амьдарсан эх оронч сэтгэлгээтэй зарим эрлийзүүдийн эрх ашиг зөрчигдөөд байна. Миний хувьд гэвэл хэдийгээр Хятад эцэгтэй ч Монгол эх хүнээс төрж, Монголд өсч торнисон, Монголоо гэсэн сэтгэлгээтэй хүн. Тийм учраас би Хятад улсыг биш Монгол улсыг шүтэж амьдардаг. Эцэг маань 1960-аад оны соёлын хувьсгалын үеэр монголд цагаачлахаар явган нүцгэн үйлээ үзэн байж ирсэн боловч До яамныхан Хятадын тагнуул гэж сэрдээд гурван жил шоронд хорьсон байгаа юм. Тэгээд яахав Сэлэнгийн шаамарт нутаг заагдаж миний ээжтэй суугаад намайг төрүүлсэн. Үүнд би ямар буруутай юм бэ.

**-Таныг арав гаруй жил ял эдэлсэн гэж сонссон. Хэдэн онд ямар хэргээр шоронд орсон**

## юм бэ?

-Миний шоронд орсон асуудал бол Хятадын эрлийз гэдэгтэй холбоотой. Би 1991 онд Эрээн, Улаанбаатар хоёрын хооронд ганзагын наймаа эрхэлдэг байлаа. Нэг удаа Эрээнд очоод бараагаа татчихаад нэг буудалд хоноглохоор болдог юм байна. Тэгтэл тэр буудалд өмнө таньдаг байсан Насанбат гэдэг монгол залуутай тааралдсан. Насанбат тэр үед хоёр найзтайгаа явж байсан. Тэгээд бид жаахан архи дарс ууцгаалаа. Тэгтэл Насанбат над руу гэнэт л агсраад эхэлсэн. Тэр Эрээний хоёр хужаад хамаг юмаа дээрэмдүүлчихсэн юм байна л даа. Тэр уурандаа над руу агсарч «Танай муусайн Хятадууд ёстой новш. Миний хамаг юмыг дээрэмдсэн тэр шархаа би чамаас л нөхнө дөө» гэх ухааны юм ярихаар нь би “надад ямар хамаатай юм бэ. Би Хятад хүн биш, Хятадын эрлийз хүн. Битгий олон долоон юм донгосоод бай” гэж хэлээд цааш эргэтэл зүүн дал руу шууд хутгалчихдаг байгаа. Тэгэхээр нь миний уур хүрээд хутгыг нь булааж аваад түүнийг хэд хэдэн удаа дүрчихсэн. Тухайн үед нэлээд халамцуу байсан болохоор чухам юу хийж байгаагаа ч сайн ойлгож ухаараагүй. Нэг л мэдэхэд хүн амины хэрэгтэн болчихсон эрээний цагдаагийнханд байцаагдаж байсан. Би аргагүй хамгаалалт хэтрүүлсэн гэдгээр цөөхөн жилээр яллагдсандаа баярлаж явдаг. Шоронд байхдаа Хятадын эрлийз энэ тэрээрээ дуудуулж мөн ч их дарамтлуулсан. Гэхдээ энэ бол миний ярих сэдэв биш. Харин би улс төрийн талаар жаахан донгодмоор байна.

**-Та түрүүн цэвэр монгол цус аль эрт булингартаж үе дамжсаар байгаа гэж ярилаа. Таны тооцоолсоноор бол Монголд Хятадын эрлийз тийм олон байгаа хэрэг үү?**

-Маш олон байна. Зарим судлаач зуу гаруй мянган хятадын эрлийз байна гэж ярьдаг. Миний тооцоолсоноор бол үүнээс их. үүн дээр хурлийзууд болон Монголд ажиллаж амьдарч байгаа цэвэр Хятадууд нэмэгдэх юм бол Монгол улсын хүн амын тэн хагасыг эзэлнэ. Тэгэхээр бид өнөөдөр Хятадын эрлийз хурлийз гэж туйлшрах хэрэггүй болж байгаа юм. Ер нь эрлийзүүд үүссэн анхны үе шат нь Сэлэнгийн Шаамар шүү дээ. Бүр ардын хувьсгалын өмнө ногоо ургах гол үржил шимтэй газар Шаамарыг таньсан Хятадууд тэнд суурьшиж өргөн их талбайг ногооны хүлэмж болгон хувиргаснаар тэдний амьдрал цэцэглэсэн түүхтэй. Залуу хятад эрчүүд Монгол охидыг, зарим халх банди нар хятад охидыг мэдээж сонирхоно шүү дээ. Ер нь ажиглаад байхад эрлийз цусны хүн цэвэр монголыг бодвол илүү авьяас чадвартай, амьжиргаагаа зохицуулах гүйлгээ ухаан давуу хөгжсөн байдаг юм. Харин дотоод муу тал нь гэвэл сохор зоосыг ч тооцдог нарийн ухаантай. Энэ нь өнөөгийн зах зээлийн уур амьсгалд яг тохироод байгаа юм. үүнийг соц нийгмийн үед Хятадуудын өмхий санаа гэж ярьдаг байлаа. Харин өнөөгийн нөхцөлд бизнес сэтгэлгээ болоод явчихаж байгаа юм. Хятадын эрлийзүүд цэвэр Монголчуудтай тэр бүр харьцаад байдаггүй голдуу эрлийз эрлийзтэйгээ л харьцаж эдийн засгийн нарийн ширийнээ ярилцдаг. Монголд бизнесийн чиглэлээр толгой цохиж яваа эрлийзүүд зөндөө байна. Тэд монгол эхнэртэй, хурлийз хүүхдүүдтэй сайхан амьдарч байна. Мэдээж хурлийзууд насанд хүрэхээрээ монгол охидтой сууна. Ингээд бодоход цэвэр монгол цус аюулын ирмэг дээгүүр урсаж байгаа байхгүй юу. Мөн нэг сонин зүйл хэлье. Хятад, Монгол цусны эрлийзээс гадна орос хятадын эрлийзүүд Монголд олон байсан юм. Голдуу хятад төрхтэй орос авгайчуул хүүхэд төрүүлж амьдарч байсан. Тэд хар тамхины төрөл болох морпин тариаг хэрэглэн мансуурдаг байлаа. Энэ тариагаа хийхгүй л бол хамаг бие нь салганан чичирч хэвтэрт ордог байв. Харин хүүхдүүд нь яаж эрүүл саруул өсч өндийдөг байсан юм бүү мэд. Мэдээж үр хүүхдүүд нь Монголчуудтай л гэр бүл болно шүү дээ. Ингээд

бодохоор монголчууд Чингисийн цэвэр цусных гэж цээжээ дэлдэн онгирох нь шал инээдтэй. Аягүй бол урд ах нар маань “Еэ энэ тэнэгүүдийг ээ. Аль эрт бидний цустай холилчихоод” гэж хөх инээд нь хүрдэг байлгүй дээ. Ер нь Эрээн, Хөх хотод очиход Хятадууд болон өвөрмонголчуудаас иймэрхүү үг цухалздаг. үүнийг манай улс төрчид ухаарч мэдрэх сөхөө алга. Харин ч бүр Хятадуудыг олон зуугаар нь Монголд оруулж ирж ард иргэдийг бухимдуулж байна. За яахав цаг нь болохоор би мэдрүүлээд өгнө өө.

**-Та яаж мэдрүүлэх талаар ярьж байна вэ?**

-Улс төрч болж мэдрүүлэх талаар ярьж байна. Гэхдээ Хятадтай сүлбэлдэнэ гэсэн үг огт биш. Харин ч бүр Хятадуудыг Монголоос хөөж гаргах төсөл боловсруулна гэж бодож байгаа. үүгээр зогсохгүй өөрийгөө Хятадын эрлийз гэдгийг албан ёсоор зарлаад, ядарсан монголчуудыг ингэж өөд нь татдаг юм гэдгийг Хятадын эрлийз хүний нарийн ухаанаар мэдрүүлэх хэрэгтэй байна. Эрлийз цусны хүн цэвэр Монголыг бодвол илүү авьяас чадвартай, амьжиргаагаа зохицуулах гүйлгээ ухаан давуу хөгжсөн байдаг гэж би түрүүн хэлсэн. Би энэ давуу чанараа Монголын ард түмний сайн сайханд зориулж болно биз дээ. Тэгэхгүй бол манай улс төрчид үнэндээ юу ч хийж чадахгүй байна. Нөгөө л хоорондоо хэрэлддэг, хэн нэгнээ тамын тогооноос татаж авах биш улам цааш нь түлхдэг, нөгөө л юм үзээгүй бэлэнчлэх сэтгэлгээгээрээ албан тушаал, алдар нэр, хээл хахуулийн хойноос улайран хөөцөлддөг хачин муухай араншин манай улс төрд ноёрхоод байна. үнэнийг хэлэхэд МАХН, Ардчилсан нам хоёр бие биенээсээ дээрдээд байх юм алга.

**-Та хэрвээ улс төрч болчихвол бусад улс төрчдөөс давуу байх ямар чанар гаргаж ирэх вэ?**

-Үндэсний үйлдвэрээ хөгжүүлэх ёстой гэж улс төрч болгон ярьдаг боловч үнэндээ энэ тал дээр дорвитой юм хийж чаддаггүй. Би үндэсний үйлдвэр хөгжүүлэх тал дээр илүү анхаарна. Ингэхгүйгээр Монгол улс цааш хөгжихгүй. Одоо би хувьдаа эсгий боловсруулах үйлдвэр байгуулчихаад байгаа. Манай малчид Эрээний хужаануудаас бэлэн зэлэн юм авсаар байгаад эсгийгээ хүртэл хийж чадахаа байсан байна. Монголчууд ингэтлээ доошоо орж болохгүй. Эрээний хужаанууд малчдын гэрийн эсгий туургыг хүртэл бэлдэж өгдөг болчихоод байна шүү дээ, цаана чинь. Гэтэл манай дээдсүүд Эзэнт гүрэн байгуулагдсаны 800 жилийн ой энэ тэр гэж хийрхээд хөшөө дурсгал, суварга мэтийг босгох шив дээ. Хөшөө дурсгалыг бол хэзээ ч босгож болно. Харин ч Монгол улс хоёрхон сая хүнтэй мөртлөө мундашгүй их хөшөө дурсгалтай. Бүх аймгуудад янз бүрийн хөшөө дурсгал байна. Сүүлийн жилүүдэд сумын төвд хүртэл хэнд ч хэрэггүй хөшөө, суварга сүндэрлэн шувууны баас болдог болсон. үүний оронд малчдынхаа эсгий туурга энэ тэрийг чанарын өндөр түвшинд хийх санаа дэвшүүлмээр санагдах юм. Тэгсэн мөртлөө манай эрхэм дээдсүүд гадаад дотоодын хурал зөвлөгөөн дээр «Олон зууны турш уламжлагдаж ирсэн эсгий туургатны амьдрал» энэ тэр гэж сүржигнэхийг яана. Улс төрчид өө, одоо больё оо. Цаана чинь улс эх орон, ард түмэн чинь хэцүүдлээ.

## Төлгөн хурга нядлах хорлонтой ажилд

### Дарханбаатар мэтийн «алуурчид» ханцуй шамлан оржээ

Өнгөрсөн жил засгийн газар Араб руу хонины мах гаргах гэрээ хэлцэл хийсэн билээ. Үүгээр далимдуулж арабын зарим бизнесмен Монголоос хонины мах тээвэрлэх бизнест бас хошуураад байгаа юмсанж. Арабчууд хонины маханд нугасгүй дуртай бөгөөд ялангуяа хоёр настай төлгөн хурганы мах хамгийн хүндэтгэлтэй зоог болдог ажээ. Учир нь Арабын ертөнцөд эцгийн эрхт ёс ноёрхдог бөгөөд тэнд эр хүн болж төрвөл тэнгэрийн умдаг атгалаа л гэсэн үг. Эдний ёс заншлаар нуган үрээ хоёр нас хүрмэгц боовных нь хөвчийг таслах том ёслол болж айл аймаг, ахан дүүсээрээ цуглаж олон хоног найр наадам болцгоодог аж. Энэ үед иддэг гол хоол нь хоёр настай төлгөн хонины мах юмсанж. Арабын ертөнц хэдэн зуун сая хүнтэй, хичнээн эрэгтэй хүүхэд төрж, хэд нь хоёр нас хүрч байгаа билээ. Тийм ч учраас Монголоос хонины мах бөөндөж авах талаар гэрээ хэлцэл хийсэн байна. Энэ ажилд эрхэлсэн тодорхой ажилгүй Монгол залуус дайчлагдсан бөгөөд тэдний дундаас ноднин жил шоронгоос суллагдсан Балжирын Дарханбаатар гэгч залуу хоёр настай төлгөн хурга цуглуулах ажилд толгой цохиж байгаа юмсанж. Дарханбаатар нь 1990-ээд оны үед Сонгинохайрхан дүүрэгт хүн амины хэргээр дуулиан дэгдээж байсан нөхөр юм. Тэр үед Дарханбаатар 18 настай байсан бөгөөд аравдугаар ангид байхдаа архины мөнгө нэхэж дарамталсан нэг залууг долоон удаа хутгалж амь насыг нь бүрэлгэж байжээ. Тэгээд энэ хэрэгтээ 14 жилийн ял авч байсан аж. Дарханбаатар шоронд байхдаа мал нядалгааны цэг дээр ажиллаж байсан бөгөөд хонь мал төхөөрөхдөө дэндүү гаршсан нэгэн юмсанж. Нэг үе монголд ресторан ажиллуулдаг байсан туркууд үхэр нядлахдаа толгойг нь амьдаар нь огтолж төхөөрдөг байж. Энэ нь цаанаа нарийн учир жанцантай байдаг бололтой. Энэ ажилд хоригдлууд дайчлагддаг байсан бөгөөд Дарханбаатар үхрийн толгойг амьдаар нь огтлохдоо нэг номер байжээ. Тэгээд мань эр шоронгоос суллагдаад сурсан зангаа тавилгүй мал нядалгааны газруудаар хэсүүчилжээ. Тэр эхлээд налайхын цаад талын элсэн карьерийн хавьцаа байх мал нядалгааны газар ажиллаж байснаа төлгөн хурга нядалж байгаа Арабчуудын сургаар 22-ын товчооны цаахан талд байх мал нядалгааны газрыг зорьжээ. Гэтэл тэнд очоод ёстой «од» болсон байна. Мань эр хоёр настай төлгөн хонийг үс ноостой нь хутгалгүй маш цэвэрхэн нядлахаас гадна өөрөө төлгөн хурганы эрэлд морджээ. Гэвч монголчууд төлгөн хурга тэр бүр нядалж идээд, идшинд нийлүүлээд байдаггүй. 1960-аад оны үед Орос улсад төлгөн хонь ихээр гаргадаг байсан нь манай эдийн засагт муугаар нөлөөлж, нэг үгээр хэлбэл нөхөн үржих чадвараа алдаж үлэмж хохирол амссан байна. Үүнийг манай хөдөлмөрийн баатар малчид болон эх орныхоо төлөө цохилох зүрхтэй зоотехникч нар маш ихээр эсэргүүцэн байж таслан зогсоож байсан удаатай юмсанж. Гэтэл өнөөдөр Арабчууд дахиад л төлгөн хурга нядалж эхэлжээ. Хэдэн хурганы оронд хэдэн халтар доллар Монголд орж ирж байгаа нь сайн хэрэг боловч цаашид нөхөн үржих чадвараа алдаж Монголын хонин сүрэг сүйрэлд хүрэх юм биш биз. Энэхүү хорлонтой ажилд Дарханбаатар мэтийн «алуурчид» нэлээд идэвх зүтгэл гаргаж байгаа бололтой. Учир нь Арабчуудад Монгол малчдыг сэнсэртэл панаалдах хүн хэрэгтэй болж л дээ. Үүнд Дарханбаатар яг тохирсон юм байх. Мань залууг Арабчууд жийп машиндаа байнга л дагуулж явдаг бөгөөд Дарханбаатар малчдын хотонд очоод «бид хоёр настай төлгөн хурга өндөр үнээр худалдаж авна. Гурван төлгөн хурга өгсөн хүнд нэг Орос бахиал зүгээр өгнө» гэдэг аж. Сүүлийн үед Монголчууд бусдаас сул юм хожих их дуртай болсон. Үүнийг пүүс компаниуд



соргоогоор мэдэрч бараа бүтээгдэхүүнээ зарж борлуулахдаа заавал нэг сул юм дагалдуулдаг болсон билээ. Дарханбаатар ч үүнийг анзаарсан бололтой. Тэр жийп машинаас баахан орос бахиал гаргаж ирээд «энийг азтай аавын хүү л өмсөнө дөө. Жинхэнэ ориг гутал шүү» гэхэд малчид төлгөн хургануудаа барьж аваад түүн рүү хошуурдаг болжээ. Гэвч Дарханбаатарын сул өгөөд байгаа орос бахиал нь бараан захын гуталчдын хасч танаж, дууриалгаж хийсэн хулхи гуталнууд юмсанж. Дарханбаатар тэднээс хямдхан үнээр баахан гутал бөөндөж аваад малчдад зүгээр өгч хэдэн төлгөн хурга олж өгсөнийхөө шанд Арабчуудаас чамгүй ногоон хүртдэг бололтой.

## Залилангийн хэргээр долоон жил ял эдэлсэн

### «Гахай» Цогоо дахиад л залилан хийсээр явна

Энд өгүүлэх «гахай» Цогоо гэгч эр 1998 онд албан газрын тамга тэмдэг хуурамчаар үйлдэж нэлээд хэдэн пүүс компаниас их хэмжээний мөнгө залилж долоон жилээр яллагджээ. Тухайн үед Чойрогийн дүгэрээ зарим компаний төлбөрийн даалгаврыг хуурамчаар үйлдэж «Голомт» АПУ, Элба зэрэг газруудаас их хэмжээний мөнгө залилаад яллагдаж байлаа. Тэгвэл тэр үед «Гахай» Цогоо бас ийм аргаар залилан хийж явжээ. Мань эр 2005 онд шоронгоос суллагдаад овоо засарсан шинжтэй байж гэтэл цаанаа үгүй юмсанжээ. Албан газрын бичиг баримт, төлбөрийн даалгавар хуурамчаар үйлдэж залилан хийдэг арга аль хэдийн эл дол болж пүүс компаниуд дархан хамгаалалт, нууцдалтай болсон болохоор «Гахай» Цогоо мэтийн хүмүүс эдүгээ энэ талаар толгойгоо гашилгахаа байсан байна. Харин тэр найз нөхдийнхөө хүрээнд бяцхан заль хэрэглэсээр яваа аж. Гэхдээ тэр нь шүүхийн хаалга татах хэмжээнд биш. Саяхан Цогоо хэсэг найз нартайгаа архиджээ. Тэгтэл Цогоо нэг найзынхаа садан төрөл болох Төгсөө гэгч залуугийн гар утсыг хөөрхөн заль хэрэглэж байгаад шомбодчихсон байна. Төгсөө нь Дархан хотод амьдардаг бөгөөд архидалт болсоны маргааш Дархан руугаа буцах ёстой байж л дээ. Тэд архидсаар байгаад сүүлдээ мөнгөө дууссан тул Төгсөө 100 гаруй мянган төгрөгийн үнэтэй гар утсаа ойролцоох дэлгүүрт тавиад хоёр шил архи авчээ. Түүнийг архи авах үед Цогоо болон бусад нөхөд нь бүгд хамт явсан байна. Тэр үед Цогоо худалдагчид хандаж «за бид нар зуун мянган төгрөгийн гар утас тавилаа шүү. Ядах юм байхгүй, маргааш өглөө авчихна» гэж яг л өөрөө тавьж байгаа юм шиг жүжиглэжээ. Ингээд тэд шөнийн 24 цаг хүртэл архидаад унтацгаажээ. Харин өглөө болоход Цогоо аль хэдийн босоод явчихсан байж. Энэ үед Төгсөө «Ёоёо, шартаж үхлээ дэлгүүрээс дахиад нэг шил архи зээлье. үдээс хойш мөнгө бүтмэгц гар утсаа авчихъя» гэхэд бусад нь уухайн тас зөвшөөрчээ. Тэгээд дэлгүүрт очоод архи авах гэтэл худалдагч өөдөөс нь «юу ярьж байгаа юм бэ. өчигдөр та нартай цут явсан найз чинь өглөө хоёр шил архиныхаа мөнгийг төлөөд гар утсаа аваад явчихсан шүү дээ» гэсэн байна. Төгсөө учиргүй уурлаж «Чи яах гэж хүний гар утас ямар ч хань хамаагүй хүнд өгч байгаа юм бэ. Тэр чинь зуун мянган утас. Чамаар төлүүлнэ» гэж агсарчээ. Гэвч ямар ч нэмэр болсонгүй. Нөгөө худалдагч «Та нар тэр хамт явсан найзаасаа утсаа олж авахгүй юу. Хэнийх нь утас байсныг би яаж мэдэх юм бэ. Анхнаасаа хэлж сануулахгүй яасан юм бэ. Ерөөсөө цагдаа дуудаж тэр найзыг чинь баривчлуулья» гэхэд Төгсөө тээр шаагаад зөнд нь орхисон байна. «Гахай» Цогоо ер нь эвгүй арга заль сурсан байгаа биз. үүнээс болж шоронд орохгүй, Төгсөөг шүүх сэргийлэх болж заваарч чадахгүй гэдгийг тэр эртнээс мэдэрсэн бололтой. Мөн өнгөрөгч 12-р сард «гахай» цогоо мөн л нэг найзтайгаа архидаж яваад бага хэмжээний залилан хийх боломжтой нэг яриа сонсчээ. Тэр найз Галт-Очирыгоо дагаад нэг найзынд нь орсон байна. Гэтэл тэр нь мань хоёрт хандаж «би ёстой замарч байна. Залаатын амралтанд энэ зунжингаа нэг боссын барьж байгаа байшинг сахиж зуслаа. Гэтэл саяханаас хятад барилгачид өвлийн хүйтэнд ажиллаж чадахгүй гээд буугаад явчихлаа. Би ч бас буугаад ирсэн. Гэхдээ сууж байсан хамаатныхаа таван ханатай гэрийг үлдээчихээд ирсэн. Дотор нь телевизэр, плитка мэтийн ойр зуурын юм байгаа. Одоо тэнд хүн амьтан гэхээр юм байхгүй. Нөгөө гэрийг нь хулгай аваад явчихаагүй л байгаадаа» гэж ярьжээ. Тэгтэл «Гахай» цогоо энэ яриаг сонсуугаа маргааш нь залаатын амралтанд «портер» машин хөлсөлж очоод мөнөөх гэрийг нь ачиж авчраад зарчихсан байгаа юм. Гэвч сүүлдээ баригдаж найзтайгаа тангараг

тасраад зогсохгүй мөнөөх үг алдсан хүнд хоёр зуун мянган төгрөг өгч шүүх сэргийлэх бололгүй өнгөрсөн байна. Түүний хажууд үнэндээ хэр баргийн юм ярьж болохооргүй болжээ. Ер нь хамаа намаагүй хүнд нарийн ширийн нууцаа дэлгээд байвал эцэстээ хохирол амсаж мэдэхээр болсон байна.

## Орос, Монгол, Хятад гурав Москва, Улаанбаатар,

### Хөх хотод хамтарч дээрэм хийсэн итгэмээргүй явдал

Өсөхдэлгэр хөдөөнөөс ирээд ахындаа ердөө хоёр гуравхан хонож байлаа. Тэгээд нэг өдөр ахынхаа гэрийг сахиад байж байтал хаалга тогшжээ. «хэн бэ» гэтэл «хажуу айлын чинь ах байна, утсаар ярих гэсэн юм» гэх эрэгтэй хүний дуу гарчээ. Өсөхдэлгэрийг хаалга нээхэд богино савхин хүрэмтэй, нарийхан жинсэн өмдтэй, насаар өөртэй нь ойролцоо туранхайвтар бор залуу зогсож байж. Өсөхдэлгэр ямар ч бодож санах юмгүйгээр тэр залууг ахындаа оруулжээ. үл таних залуу утсаар ярьсаныхаа дараа тамхи гаргаад «шүдэнз байна уу» гэхэд Өсөхдэлгэр жижиг өрөөнд орж цувныхаа халааснаас асаагуур гаргаад түүнд өгөх гэтэл гэрт нь дахиад хоёр залуу ороод ирсэн байж. өсөхдэлгэр эхний орж ирсэн залуугийн тамхийг асааж өгмөгцөө «за одоо гарцгаа» гэхэд тэдний арай өндөр нь мөрөн дээрээс нь барьж аваад баруун бөөрний тус газар нь хутга тулгаж «Чимээгүй бай, ална шүү» гэж сүрдүүлжээ. өндөр залуу хутга тулгасан хэвээр түүнийг дагуулан унтлагын өрөөнд оруулаад шанаа руу нь хоёр удаа хүчтэй цохиход Өсөхдэлгэр орон дээр унажээ. Дараа нь түүнийг диван дээр суулгаад хажууд нь байсан индүүг авч зүүн далны нь орчим цохиод доош харуулан хэвгүүлж индүүний утсаар хоёр гарыг нь ард нь хүлсэн байна. Тэгээд түүний толгой дээгүүр орны бүтээлэг нөмрүүлээд хоёр үзүүрээр нь толгойг нь боож зангиджээ. Төдөлгүй дээрэмчид хамаг юмыг нь онгичиж эхэлжээ. Ногоон хүрэмтэй өндөр залуу нь Өсөхдэлгэрийн баруун далны орчим хутгаар хатгаж «мөнгө байгаа газраа хэл, хэлэхгүй бол ална шүү» гэж сүрдүүлэхэд хүчинд автсан хөөрхий залуу «би хөдөөнөөс ахындаа ирсэн хүн. үнэхээр мэдэхгүй» гэж үнэнээ хэлжээ. Тэгтэл түүнийг хүлээтэй чигээр нь жорлон руу чирч оруулаад хаалгыг нь түгжсэн байна. Түүний ах Өсөхбаяр гадуур ажил төрөл хөөцөлдөж явсаар 17 цагийн үед гэртээ иржээ. Гэрийнхээ үүдэнд ирээд хаалгаа онгойлгох гэтэл түлхүүр нь эргэж өгсөнгүй. Дүүгээ түлхүүрээ сугалалгүй дотроос нь түгжчихэж гэж бодоод хаалга тогштол «хэн бэ» гэх үл таних хүний дуу гарчээ. «би өсөхбаяр байна. наана чинь Өсөхдэлгэр байна уу» гэтэл хариу дуугарсангүй. Яагаад хэн бэ гэхихээд хаалга тайлахгүй байгаа юм бол гэж бодоод дахиад хаалга цохьтол орос царайтай намхан шар эр хаалга тайлж өгмөгцөө түүнийг заамдаад авчээ. Тэгээд дотогш нь чирч оруулсан байна. Өсөхбаяр заамдсан гарыг нь угз татан тавиулаад духных нь орчим цохиход шар залуу гэдэргээ савж унажээ. Тэгээд тэр гарч зугттал хойноос нь дээрэмчид гарч ирээд зүүн даланд нь хутгалж, хоёр нь гарнаас нь, нэг нь хөлнөөс нь чирч оруулжээ. Ингээд түүнийг том өрөөний хана руу харуулаад телефон утас огтолж хоёр гарыг нь ард нь хүлж, мөн зурагтны антений цагаан утасыг хоолойгоор нь оруулаад гараас нь татаж уясан байна. Мөнөөх өндөр залуу түүний цээж рүү хутгаар чичиж «Чи мөнгөө хаана хийсэн бэ. Дүү чинь мэдэхгүй байна» гэхэд Өсөхбаяр «надад мөнгө байхгүй. Байгаа мөнгөө кассанд хийчихдэг юм» гэхэд өндөр залуу зүүн энгэрийнх нь халааснаас түрүүвчийг нь гаргаж дотроос нь гучин мянган төгрөг авчээ. Тэгээд гарынх нь хүлээсийг чангалж ванны өрөөнд оруулахдаа «за хөгшин минь, их юм яриад байвал авгай, хүүхдүүдийг чинь ална шүү» гэж заналхийлжээ. Арван минутын дараа дээрэмчдийг гарч явахад өсөхбаяр сэхээ орж ванны өрөөнөөс гарах санаатай хаалга өшиглөтөл нойлын өрөөнөөс дүү нь «ах аа, би энд хүлэгдчихсэн байна. Миний хүлээс тайлагдах гэж байна. Одоохон» гэж дуугарчээ. Төдөлгүй мань хоёр хүлээсээ тайлаад шууд л цагдаагийнханд мэдэгдсэн байна. Цагдаагийнхан тэднээр ам зураг гаргуулж дээрэмчдийг шуурхай эрэн сурвалжилжээ. Тиймээс гурван дээрэмчин тун

удалгүй баригдсан байна. Яллагдагч Сүхбат мэдүүлэхдээ «уг хэргийг би ОХУ-ын харъяат Пантин, Хятадын харъяат Яншинь буюу зуунаа нартай бүлэглэж үйлдсэн. Би энэ хоёрт хандаж «мөнгөтэй айл байгаа, хулгай хийе» гэсэн санал тавьсан. Тэгээд хаалгыг нь хөших гэж байтал дотор нь хүн байсан. Тэгэхээр нь би утсаар ярьж гэж хаалгыг нь тайлуулаад дотогш орсон. Пантин, Зуунаа хоёр ч хойноос орж ирсэн. Тэгтэл төдөлгүй хаалга тогшсон. Би Пантин руу «хаалга онгойлго» гэж дохиод өөрөө хаалганы ард нуугдсан. Нэг танихгүй хүн орж ирээд Пантиныг цохиж унагаад буцаад зугтсан. Зуунаа бид хоёр хойноос нь гарч гуйн барьж аваад гэрт оруулсан. Ингэж байхдаа би түүний зүүн даланд хутгалсан. Бид гурав дээрэмдсэн бүх зүйлээ хамтдаа зарж борлуулаад идэж уусан. Бүх эд зүйлсийг нь хариуцана» гэжээ. Мань гурав 1997 онд ОХУ-д наймаа хийж байхдаа танилцсан бөгөөд тэр үед «нутгийн индиан» Пантин мань хоёрт мөнгөтэй айл зааж өгдөг байж. Харин мань гурав 2000 онд Өвөрмонголын Хөлөнбуйр аймагт очиж дээрэм тонуул хийжээ. Энэ үед «нутгийн индиан» Зуунаа мань хоёрт зуучилдаг байж. Харин энэ удаад аяганы хариу өдөртөө, агтны хариу жилдээ гэгчээр Сүхбат мань хоёрыг Монголд дагуулж ирээд бас л «нутгийн индиан» царайлжээ. Хэрэгтэн Яншинь буюу Зуунаа мэдүүлэхдээ «би хэдийгээр хятад гаралтай, хятадын иргэн ч гэлээ бараг Монгол хүн. Бага насаа Өвөрмонголын хөх хотод өнгөрөөсөн болохоор Монгол хэлийг сайн сурсан. Тийм ч учраас Сүхбат, Пантин хоёр намайг «Монголжсон хужаа» гэж шоолдог юм. Пантиныг ч Сүхбат бид хоёр «местний орос» гэж шоолдог. Харин Сүхбатыг Пантин бид хоёр «шинэ орос» гэж шоолдог. Анхандаа бид гурав Орос, Монгол, Хятад гурван улсын найрамдалт харьцааг бэхжүүлэх гэж үерхдэг байсан. Тэр үед бид гурав ОХУ-д хамтарч наймаа хийдэг байсан юм. Гэтэл 2002 оноос эхлээд бид цаашид наймаа эрхлэх боломжгүй болсон. Энэ үед бид гурав шинэ оросуудад хамаг байдгаа дээрэмдүүлсэн. Сүхбат бид хоёр Пантинд хандаж «танай оросууд их өөдгүй юмаа. Чамайг орос хүн гэж огт тоохгүйгээр дээрэмдчих юм» гэхэд Пантин «харин тиймээ. Оросууд ийм новш болчихсон шүү дээ. Тэгэхээр адилхан л новшрох хэрэгтэй. Намайг Орос гэж хүндлэхгүй байгаа бол би Оросуудыг хүндлэх хэрэг байна уу. Гурвуулаа хамтраад Орос айл ухъя, Оросуудыг дээрэмдье» гэсэн санал тавьсан. Сүхбат бид хоёр ч зөвшөөрсөн. Тэгээд ОХУ-д долоо найман айл ухсан. Тав зургаан хүн дээрэмдсэн. Сүүлдээ цагдаагийн хараанд орсон. Энэ үед Пантин «одоо хэдүүлээ эндээс зайлмаар байна. Монгол явах уу, өвөрмонгол явах уу» гэхэд нь би «Өвөрмонгол явъя. одоо би та хоёрт туслах ёстой. Та хоёр манай нутагт очсон байхад алзахгүй» гээд тэднийг дагуулаад нутагтаа очсон. Гэвч бид очоод олигтой хулгай хийж чадаагүй. Өвөрмонголчууд ар Монголчуудыг бодвол их яхир улс. хулгайчуудад барагтай бол юмаа алдахгүй. Гэхдээ л бид гурав тав зургаан айл ухсан. Даанч тэр нь юм болдоггүй байлаа. Нүнжиг муутай гэх үү дээ. Тиймээс нэг өдөр Сүхбат бидэнд хандаж «Танай өвөрмонголчууд нүнжиг муутай юм. Орон гэртээ мөнгө төгрөгөө хадгалахгүй, олигтой зүйл эдэлж хэрэглэхгүй, тэгсэн мөртлөө аймаар яхир юм. Харин манай ар монголчууд бол нүнжигтэйгээс гадна их гэнэн улс байгаа юм. Одоо би та хоёрт тус болох ёстой» гээд Пантин бид хоёрыг дагуулаад армонголд ирсэн. Харин бид энд олигтой хулгай хийж чадаагүй байж байгаад баригдлаа. Энэ утгаараа монголчууд их азтай улс» гэж солиорчээ. Харин Пантин юу гэж мэдүүлсэнийг сонирхоё. Тэрбээр «манай аав социалист нийгмийн үед монголд цэргийн дарга байсан. Би 1978-89 он хүртэл монголд амьдарсан. Тиймээс монгол хэл сайн мэднэ. Би 1997 онд Москва хотод Сүхбат, Зуунаа хоёртой танилцсан. Зуунааг би анхандаа Хятадын иргэн гэж мэдээгүй. Хоёр Монгол явж байна гэж бодоод л «найрамдал-дружба» гээд танилцсан. Ер нь бид гурав уулзах болгондоо «найрамдал-дружба» гэж мэндэлдэг байлаа. Сүүлдээ хамтарч наймаа хийсэн. Тэгээд юу болсон тухай зуунаа сая тодорхой ярилаа. Харин

нэг зүйлийг нэмж хэлэхэд «шинэ оросууд та нар бид гурвыг хулгай дээрэм хийхэд уриалан дуудсан шүү» гэж сануулъя. Та нарыг би занаж зүхэж байна. Хэрэв бид гурав Оросуудад юмаа дээрэмдүүлээгүй бол хэзээ ч ингэж хулгай дээрэм хийхгүй байх байсан. Энэ дээрэмчид чинь хүнийг гэмт хэрэг рүү өөрийн эрхгүй түлхчихдэг юм байна. Зуунаа, Сүхбат бид гурав уг нь Турк руу гарч наймаа хийх бодолтой байсан. Тэр үед бид гурвын дундын сан хөмрөг долоон мянган ам.доллар хүрч байсан юм. Гэтэл нэг л өдөр энэ их мөнгө шинэ оросуудын хоол болсон. Бид гурав шархаа нөхөх гээд хулгай, дээрэм хийсэн боловч тосч идсээр байгаад дуусгачихдаг байлаа. үнэнийг хэлэхэд шинэ оросууд бид гурвыг дахиж босч ирэх сөхөөгүй болтол муужруулсан. Одоо муужирсан дээрээ бүр муужирлаа. Би дахиж орос руу хэзээ ч очихгүй. Монголд ялаа эдлээд Монголд ясаа тавина» гэх ухааны юм ярьжээ.

## Гүнсэлмаагийн нүдэнд бөөн доллар харагдаад болж өгсөнгүй

Монголд өнөөдөр гадаадын аль нэг оронд сурах, ажиллах, амьдрах сонирхолгүй хүн бараг байхгүй болсон гэж хэлж болно. Залилан мэхлэгчид хүмүүсийн яг энэ хэрэгцээ, сохирхол дээр тоглож Англи, Америк, Герман, Япон, Солонгос зэрэг улс орнуудын виз гаргаж өгөх, ажилд зуучлах нэрээр их хэмжээний мөнгийг залилж авсаар байна. Гэвч зөвхөн мөнгөө зальдуулаад өнгөрч байгаа хэрэг биш. Үүнийг дагаад хуурамч паспорт, бичиг баримтын хэрэг маш их гарч байгаа ажээ. Цагдаагийн байгууллага залилан мэхлэх гэмт хэргийн 90 шахам хувийг илрүүлж байгаа гэх боловч амьдрал дээр шийтгэл хүлээж, зохих ялаа эдэлж байгаа нь хэд вэ гэдэг нь тодорхойгүй байна. Ганцхан жилийн дотор үйлдсэн залилангийн гэмт хэргийн улмаас улсад 1,2 тэрбум, иргэдэд 2,1 тэрбум төгрөгийн хохирол учирсан жишээ бий. Цагдаагийн байгууллага залилагчдыг илрүүлж, баривчилсан ч хохирогчдод эргэж төлөгдөх мөнгө, эд зүйл бараг байдаггүй бололтой. Учир нь залилан мэхлэгчид эд зүйлийг түргэн борлуулж, мөнгө төгрөгийг үрж тансаглах, эсвэл өмнөх өр ширээ дараагийн хүнээс залилсан мөнгөөрөө төлөх буюу түүний дундаас ашиг олох, нөөцлөх, нуун дарагдуулах зэргээр эд бад хийчихээд хоосон хүний хоёр чихний үлгэр яриад суучихдаг болжээ. Тиймээс иргэд хохирсон чигээрээ л үлдсээр байна. Сүүлийн жилүүдэд залилангийн хэрэг нарийн зохион байгуулалттай болсон бөгөөд залилан мэхлэгч хэн ч бай найз нөхөд, ах дүүстэйгээ хуйвалдан нэг нь захирал, нөгөө нь нарийн бичиг, менежер гэх мэтээр дүр бүтээдэг болж. Гэвч манай гэнэн цайлган иргэд ямар ч нотолгоо баримтгүйгээр зөвхөн үгэнд нь итгээд мөнгөө өгөөд, эцэст нь цагдаа руу давшлан бухимдлаа тайлцгаадаг. Мөн залилан мэхлэгчдийн нэг нь үнэмшилтэйгээр худлаа ярьж, нөгөөх нь яг тийм гэж итгүүлэхээр дэмжиж, гурав дахь нь нөгөө хоёрынхоо ярьсан яриа, үйлдлийг хамгаалах гэх мэтээр нарийн зохион байгуулалттай болж байна. Эцэс сүүлд нь хэрэг бишдвэл залилсан эд баялагаа нөөцөлж, хуулийн цоорхойг ашиглан хариуцлагаас мултрах арга зам хайдаг аж. Зарим нь амьдралын баталгаа муутай, төлбөрийн чадваргүй болж жүжиглэх, эсвэл жирэмсэн болон настай эмэгтэйчүүдээ шүүх, хуулийн байгууллага руу түлхэж өршөөлийн зарлиг горьддог болж. Мөн ар өврийн хаалга хэрэглэх, эсвэл хуулийнханд хээл хахууль өгч гэмт хэргээ, өр ширээ аргалахыг оролдож, зарим нь шүүгчдэд элдэв зовлон тоочиж ядуу зүдүүгээ дуудан уйлж унжин жүжиглэж байгаад үйлдсэн гэмт хэргээ цөөхөн сар, жилийн тэнсэн буюу торгуулиар аргацаан өнгөрөөх нь ердийн үзэгдэл боллоо. Тиймээс залилан мэхлэх гэмт хэргийн тухай хуулийн заалтуудыг жаахан чангалж өгмөөр санагдах юм. Ингээд 1990-2004 он хүртэл залилангийн хэргээр хоёр ч удаа шоронд орсон Цэвээний Гүнсэлмаа гэгч эмэгтэйн үйлдсэн хэргийн талаар өгүүлье. «Хүмүүний сэтгэлийг хөдөлгөж эс чадваас, хөнгөн бийрийг хөшиж юу хийнэ» гэж манай эртний их бичгийн хүн Ванчинбалын Инжиннаш хэлсэн билээ. Энэхүү алдартай хоёр мөр эрин зууныг өртөөлөн өнөөг хүртэл бидний чихэнд дуурсагдсаар байна. Гэтэл Цэвээний Гүнсэлмаа энэ алдартай үгийг урвугаар ашиглаж бусдыг залилан мэхлэх уриа лоозун болгожээ. Тухайлбал тэр «хүмүүний сэтгэлийг хөдөлгөж эс чадваас хөнгөн бийрийг хөшиж юу хийнэ» гэдэг үг сайн л бол хоёр гурван зуун жилийн настай. Харин миний зохиосон «хохирогчийн сэтгэлийг урвуулж эс чадваас, хоосон панаалыг урсгаж юу хийнэ» гэдэг үг бол мөнх настай. Яагаад гэвэл хүн төрөлхтөн байсан цагт бие биенээ залилж мэхлэх асуудал байсаар л байх болно. Тиймээс би Инжиннашаас илүү суут хүн шүү» гэж томордог аж. Мань хүүхэн 1990 онд Эрээн рүү явж наймаа хийх нэрийдлээр тухайн үеийн ханшаар долоо найман хүний гурван зуун мянган төгрөгийг үрэн таран хийжээ. Тэр

үед Гүнсэлмаа найз нөхөд, таньдаг хүмүүстээ хандаж «за надад юм захиx хүн байвал нэрээ бичүүлээд мөнгөө өгөөд байгаарай. Эрээнээс бараа татна гэдэг бол хэр баргийн хүний хийх ажил биш. Та нар явах юм бол хятадуудад мөнгөө дээрэмдүүлээд, эсвэл шал хэрэгцээгүй бараа өндөр үнээр аваад ирнэ. Харин би бол өөр хүн шүү. Эрээнд хэд хэдэн танилтай болсон. Хөгшин чинь муусайн хужаануудыг харцаараа хөдөлгөдөг болсон шүү дээ. Энэ утгаараа би эрээнд Монголын консулаас илүү эрх мэдэлтэй» гэж томорчээ. Тэггэл эрээн битгий хэл Замын-үүд ч орж үзээгүй цаадуул нь түүний үгэнд итгэж дор бүрнээ нэрээ бичүүлж, хамаг байдаг мөнгөө Гүнсэлмаад гардуулаад баахан бараа захижээ. Ингээд Гүнсэлмаа гурван зуун мянган төгрөгтэй болсон бөгөөд 1990-ээд оны гурван зуун мянган төгрөг одоогийн гурван зуун сая төгрөгтэй тэнцэх биз. Гэвч мань хүүхэн энэ их мөнгөөр бараа татсан ч юм байхгүй Бээжин, Шанхай зэрэг хотуудаар бүтэн жилийн турш зугаалж яваад иржээ. Түүнийг ирүүт мөнөөх мөнгөө өгсөн хүмүүс бариад авалгүй хаачихав. Тэд Гүнсэлмааг захисан барааг нь аваад ирнэ гэж нүдээ чилтэл харуулдсан бөгөөд зарим нь бүр ТҮЦ байгуулж, лангуу түрээсэлчихээд байж тэгээд хоосон ТҮЦ, хоосон лангуунд Гүнсэлмааг харуулдаад бүтэн жилийн турш суусан байгаа юм. Гэтэл Гүнсэлмаа өөдөөс нь тэс өөр юм ярьжээ. Тэрбээр «Та нар хэдэн халтар төгрөгнөөс болж намайг барьж идэх нь үү. Би та нарын мөнгөнөөс болж Хятадын мафийнхны хараанд орж хамаг мөнгөө дээрэмдүүлээд зогсохгүй тэдний гарт бүтэн жил тарчилж байгаад арай гэж мултарч ирлээ. Нэгнийхээ зовлонг ойлгодоггүй яасан хачин улс вэ. Би ийм муухай найз нөхөдтэй байсан юмуу» гэх зэргээр цамнаж гарчээ. Найз нөхөд нь эхэндээ түүний учир байдлыг ойлгоод мөнгө төгрөгөө нэхэж сүйд болсонгүй. Гэтэл Гүнсэлмааг Бээжин, Шанхайгаар тансаглаж явахыг нь харсан монгол наймаачид гарч ирсэнээр хохирогчид Гүнсэлмаа руу дахиад хошуурчээ. Ингээд тэр залилангийн хэргээр шүүхийн хаалга татсан байна. Түүнийг 1995 онд шоронгоос суллагдахад Солонгосын визний асуудал ид мандаж байсан бөгөөд үүнийг мэдэрсэн Гүнсэлмаагийн нүдэнд бөөн доллар харагдаад ер болж өгсөнгүй. Мань хүүхэн Луусанд байхдаа засарч хүмүүжих талаар огтхон ч бодоогүй бөгөөд бусдыг залилан мэхэлж шоронд орсон эмэгтэйчүүдээр хэргийг нь яриулж таашаал авдаг байж. Нэг ёсондоо залилан мэхлэгчийн дамжаанд суралцаж мэргэжил дээшлүүлээд гарч ирсэн байна. Тэгээд хамт ял эдэлж байсан Нарантунгалаг гэгч хүүхэнтэй нийлээд Солонгосын виз гаргана гэж нэг хэсэг манаргажээ. Мань хүүхэн 1995-96 оны хооронд 12 иргэнээс хорь орчим сая төгрөг гол гаргажээ. Эднийг гол гаргаад зогсохгүй хамтарч залилан хийсэн Нарантунгалагаа бас гол гаргаж хамаг мөнгийг нь аваад ОХУ руу гараад явчихаж. Тэгээд бүтэн жилийн турш Москва, Санктпетрбург, Свердловск хотуудаар доншуучлан тансаглаж байгаад 1997 онд Монголын цагдаагийнханд баригдаж иржээ. Ингээд хоёр дахь удаагаа шоронд орсон байна. Давтан хэрэг болоод ч тэрүү мань хүүхэн найман жилээр яллагджээ. Гэвч тэр «би аймаар олон жилийн ял авчихлаа» гэж уйлж байжээ. «Банкны» цолмон хүртэл арван жилийн ял авчихаад «Би энэ хар савнаас хэзээ гарна гэж хүлээх юм бэ. надад аймаар олон жилийн ял өгчихлөө» гэж уйлж байсан удаатай. Аймаар олон хүний аймаар олон сая төгрөгийг үгүй хийчихсэн болохоор аймаар олон жилийн ял авах нь аргагүй шүү дээ. Хуйхтай юм ургаж, хугацаатай юм дуусдаг хойно Гүнсэлмаа 2004 онд шоронгоос суллагджээ. Гэвч тэр хоёр удаа шоронд орсоньгоо хоёр дээд сургууль төгссөн гэж тунхагладаг болж. Нэг ёсондоо залилангийн гэмт хэргийн ертөнцөд нэлээд нарийн мэргэжлийн «боловсон хүчин» болсон бололтой. Чухам энэ үед л түүний толгойд «хохирогчийн сэтгэлийг урвуулж эс чадваас, хоосон панаалыг урсгаж юу хийнэ» гэсэн «алдартай» хоёр мөрт нь орж иржээ. Залилан мэхлэх арга ухаан нь ч нэлээд нарийсчээ. Тухайлбал мань хүүхэн худалдаа наймаа хийж байгаа хүний эд барааг зальдах, чинээлэг



хүмүүсийн өмсч зүүсэн болон эдэлж хэрэглэж байгаа үнэт эдлэл, хашаа байшин, орон сууц, түүнийг өмчлөх эрхийн бичиг баримтыг барьцаалж авах цоо шинэ суваг нээсэн байна. Өөрийнх нь хэлсэнээр хоёр ч дээд сургууль төгссөн болохоор арга ч үгүй юм. Ингэхийн тулд мань хүүхэн пүүс компаний бичиг баримтыг хуурамчаар үйлдэж менежерийн дүрд тогложээ. Мөн банкны өр барагдуулах буюу барьцаалан зээлдэх товчооны ажилтан болж жүжиглэжээ. Анх тэр найз нөхдийнхөө мөнгийг улаан цайм авч байсан бол дараа нь Солонгосын виз энэ тэр гэж хөөрхөн заль хэрэглэсэн. Сүүлдээ энэ нь хуучраад, олон түмэн сэрэмжлээд ирүүт менежерийн дүрд хувирч байгаа нь энэ. Аргагүй л дээд боловсрол эзэмшсэн хүний үйлдэл бололтой. Ингээд мань хүүхэн банкны ажилтан болж албан газруудаар явж эд хогшил барьцаалаад мөнгө зээлэх хүмүүстэй уулзаж учирчээ. Хүмүүс түүнийг бүчээд авалгүй хаачихав. Тэгээд тэр хам хэрэгтэн Оюунцэцэгийнхээ хамт баахан телевиз, хөгжим, хивс, алт мөнгөн эдлэл цуглуулжээ. Гэнэн итгэмтгий манайхан л болсон хойно банкны ажилтан гээд бичиг баримтаа үзүүлэхэд нь итгэж бишрээд эхлээд мөнгөө авалгүйгээр эд хогшлоо өгчихсөн байгаа юм. Энэ бүхэнд Гүнсэлмаагийн урсгадаг хоосон панаал тус болсон нь мэдээж. Ямар сайндаа л хам хэрэгтэн Оюунцэцэг нь нэг өдөр түүнд хандаж «Чи айж ичихийг мэдэхгүй ямар аймаар ярьдаг юм бэ. Худлаа залж байгаад яг баригдах болоод ирүүтээ томчуудын нэрийг барьж байгаад л итгүүлчих юм» гэхэд Гүнсэлмаа «мэдээж шүү дээ. юун төлөө хоёр дээд сургууль төгслөө. Хохирогчийн сэтгэлийг урвуулж эс чадваас, хоосон панаалыг урсгаж юу хийнэ» гэж томорсон байгаа юм. Гэвч түүний урсгасан хоосон панаал эргээд өөрийг нь шүүхийн хаалга татуулжээ. Эдүгээ тэр байцаагдаж байгаа бөгөөд гурав дахь дээд сургуульдаа суралцахаар явахдаа дахиад уйлах биз.

## **Арын хаалга, танил талаар дулдуйдсан хүн амины хэрэгтнүүдийг цусан өшөө гэгч юм залхаан цээрлүүлдэг**

1992 онд Монголын хоёр хилчний амь насыг зэрлэгээр хороосон онц аюултай хэрэг гарсан билээ. Хэргийн газарт хийсэн үзлэгээр хоёр хилчнийг Хөвсгөл аймагт байхгүй ангийн бууны сумаар буудсан болохыг шинжээч эмч хөтөлбөргүй тогтоожээ. Энэ нь явцын дунд бүр батлагдаж уг гэмт хэргийг Буриадын иргэн Самбалхаан, Жамбалов нар үйлдсэн болох нь тогтоогджээ. Хүний биед үүсч үлдсэн шархны байдлаас «Ангийн бууны үрлэн сумнаас үлдсэн ором байна» хэмээн дүгнэлт гаргана гэдэг хэн хүний шуудхан нотолчих зүйл биш. Энэ хэрэгт хамгийн гол нь буудсан бууны сумыг зөв тогтоосноор гэмт этгээдийг Монголоос бус гадны хүмүүсээс хайх зөв сэжүүр гаргасанд байгаа юм. Туршлага муутай шинжээч бол буудсан бууны сумыг тогтоохоос урьтаж талийгаачийн найз нөхдийг л хардаж сэрдэх байсан биз. Хэргийн газар шинжээч эхэлж очих нь эцсийн үнэнийг тогтоох гол шижим бөгөөд гаргасан дүгнэлт нь хүний хувь заяаг дайрч өнгөрдөг. Тиймээс шинжээч эмч хамгийн хариуцлагатай, бас үнэнч шударга, гярхай байх ёстой. Буриадын иргэн Самбалхаан, Жамбалов хоёрыг манай цагдаагийнхан тэр даруйдаа баривчилж авчраад «Ганц худаг»-т хорьжээ. Гэвч Самбалхаан нь нэлээд овсгоо сүйхээтэй, арын хаалга, танил тал ихтэй нэгэн байсан тул Жамбаловыгоо уг гэмт хэрэгт гүтгэчихээд өөрөө огт гэмгүй царайлаад Буриад руу одсон байгаа юм. Ингээд Жамбалов 15 жилийн ял аваад Мааньтын чангад очжээ. Гэвч тухайн үед Монголын шоронд өлсгөлөн ид хүчээ авч байсан тул Жамбалов 1994 онд өлсгөлөн тураалаар нас баржээ. Ингэснээр хэргийн эзэн хэнгэрэгийн дохиур Самбалхаан хожмын нэг өдөр өөрийг нь үнэн зөвөөр илчилж мэдэх хамгийн аюултай гэрчээ үхүүлж санаа амарсан байна. Гэвч түүнд буудуулж үхсэн хоёр хилчний ар гэрийнхэн Самбалхааныг мартсангүй. Нэг хилчнийх нь төрсөн ах болох Гантөмөр гэгч тухайн үед ОХУ-д наймаа хийж байсан бөгөөд төрсөн дүүгээ буриадуудад буудуулж үхсэнийг дуулаад маш их харуусчээ. Тэгээд хоёр алуурчныг барьсаныг дуулаад нэг хэсэгтээ тайвшраад байж байтал нэг алуурчин нь арын хаалга, танил талын шугамаар нутаг буцсаныг дуулаад дахиад л хямарч эхэлсэн байна. Ер нь арын хаалга, танил талаар дулдуйдсан иймэрхүү юман дээр цусан өшөө гэгч юм сэргэж ирдэг юмсанж. Тиймээс Гантөмөр Самбалхааныг хорхой идсэн араандаа зуужээ. Гэвч мань эр нэгдүгээрт, Буриад руу явах боломж гарсангүй, хоёрдугаарт, Самбалхааныг устгах бэлтгэлээ базаах хэрэгтэй байсан тул 1999 он хүртэл тийшээ зүглээгүй аж. Тэгээд 2000 оны 6-р сард Буриад руу явж Самбалхааныг сурагласаар байгаад «Балжин толгой» гэдэг газар зусч байхад нь очжээ. Дашрамд өгүүлэхэд Буриад улсад «Балжин толгой», «Балжин хөл», «Балжин гар», «Балжин нуруу» гээд маш олон газар байдаг бөгөөд Чингисийн алтан ургийн Балжин гэгч царайлаг хатныг 16-р зууны үед ойн иргэд хүчээр богтолж авчээ. Ойн иргэд гэдэг нь одоогийнхоор бол буриадууд бөгөөд Балжин хатан хадам эцэг Хантайгаа тэрсэлдэн цаазлуулсан юмсанж. Хадам эцэг Хан нь түүнийг хүүтэйгээ хувааж эдэлдэг байж л дээ. Балжин хатанг зүгээр нэг цаазлаагүй бөгөөд бүх биеийг нь мөчилж хуваагаад дөрвөн зүг, найман зовхист тараасан гэдэг. Тэгээд л “Балжин толгой”, “Балжин хөл”, “Балжин нуруу” гэх мэтийн нэртэй газар бий болсон юмсанж. Гантөмөр “Балжин толгой”-д очихдоо ганзагын наймаачны дүрээр очжээ. Тухайн үед манай наймаачид буриадуудаар дамжуулж оросоос калибрийн сум зөөдөг байлаа. Гантөмөр ч ялгаагүй калибрийн сум ярьсаар Самбалхаантай учирсан байна. Тэр түүнд хандаж “би хөвсгөл аймгаас яваа хүн. Манай Хөвсгөлийнхөн Буриадуудаас калибрийн сум авдагийг та мэднэ биз дээ” гэхэд Самбалхаан “мэдэлгүй яахав.

Би хүртэл танайханд калибрийн сум гаргаж өгч л байлаа. Даанч би сүүлийн үед мөнгө төгрөг муутайгаас болоод суманд явж чадахгүй байна” гэж учирлажээ. Тэгтэл Гантөмөр “би таньд сум олж ирэх мөнгө өгнө. Ер нь хоёулаа түнш болбол яасан юм бэ. Та ерөөсөө надад 300 мянган рубльд тааруулаад сум олоод өг. Шагналд нь би таньд 100 мянган рубль өгье” гэхэд Самбалхааны нүд нь сэргээд иржээ. Тэгээд түүнтэй хамт Улаан-Үд орохоор явжээ. Мань хоёр мориор Улаан-Үд ороод тэндээсээ галт тэргэнд суугаад Свердловск орохоор төлөвлөсөн байна. Гэвч Гантөмөр “Балжин толгой”-гоос холдов уу, үгүй юу Самбалхааны нуруу руу хутгалж орхижээ. Түүнийг ёолоод эргэнгүүт морин дээрээс нь татаж унагаад дээрээс нь дарж “Чамайг би зүгээр нэг алчихгүй, тарчлааж ална Чи тэр жил миний дүүг буудаж алчихаад Монголын шоронгоос бултаж амжсан Самбалхаан шүү дээ. Би чамайг олон жилийн турш судалсан. Одоо цусан өшөө авч байгаа нь энэ” гээд гуя, дал нуруу зэрэг амин бус газар луу нь хутгаар сийчиж эхэлжээ. Самбалхаан чадалтай хүн байсан тул түүнд хутгалуулсан мөртлөө л дээр дороо орон ноцолдоод байж. Тэгсээр байгаад сүүлдээ их хэмжээгээр цус алдаад газар дээрээ мажийжээ. Гантөмөр түүний морийг тавьж хөөчихөөд Улаан-үд рүү зүглэсэн хэдий ч нэг их удалгүй буриадын цагдаа нарт баригджээ. Уг хэрэг ОХУ-ыш нутаг дэвсгэрт гарсан болохоор Гантөмөр Мордовын шоронд хоригдсон байна. Харин түүнийг хэдэн жилээр ялласан нь одоогоор тодорхойгүй байдаг юм.

## Хэрцгий зангаасаа боаж яг л хонь шиг төхөөрүүлжээ

Монголчууд уг нь харь газар очоод бие биенээ хайрлаж баймаар. Гэвч тиймгүй юм байна. Улай үзсэн хэрээ шиг бие биенийхээ олз омгийг булаацалдаж, Улмаар амь насанд нь халдахыг яана. ОХУ-д бие биенээ хөнөөлөө гэж мөн ч их дуулддаг. Гэтэл сүүлийн үед солонгост очоод нэгнийгээ хөнөөсөн талаар чих дэлсэх боллоо. Яасан үйлийн лайтай улс вэ. Хятадууд Монголд ирчихээд бие биенээ хөнөөгөөд байгаа юм огтхон ч алга. Тэд харин ч бүр эв найрамдалтайгаар Монголчуудыг цөлмөх үйл ажиллагаанд гар хөл нийлэн хошуурч байна. Гэтэл Монголчууд харь оронд очоод бие биенээ цөлмөхийг л урьтал болгодог нь хачирхалтай. Энэ утгаараа Монголчууд хамгийн арчаагүй сэтгэлгээтэй ард түмэн болж хувирч байна. 2005 онд Хөвсгөл аймгийн харьяат Саруулсайхан гэгч танхай этгээд Солонгост очиж элэг нэгт Монголчуудаа дарамталж байгаад Намхайцэрэн гэгч залуугийн гарт амь үрэгджээ. Намхайцэрэн түүнийг яг л хонь алж байгаа юм шиг «төхөөрсөн» байна. Харгис зангаасаа болж алуулсан бол хохь чинь гэж хэлэлтэй нь биш. Гэхдээ л хохь болоод өнгөрчээ. Намхайцэрэнг 2003 онд Солонгост очиход Саруулсайхан нэлээд хүчээ авчихсан, тэнд байгаа зарим нэг хүнээс татвар аваад сурчихсан байж. Ер нь тэр Солонгост очоод огт ажил хийгээгүй бөгөөд 1997 онд шоронгоос суллагдаад Солонгос явахдаа л «би Солонгост очоод гараа хөдөлгөнө гэвэл номонд хазгай. Халхын шоронд гараа хөдөлгөж үзээгүй хүн Хан үндэстний нутаг дэвсгэрт очоод гараа хөдөлгөнө гэвэл ёстой гонжийн жоо байлгүй. Тэнд бусдаас татвар аваад хялбархан амьдарчих боломж байдаг юм байна» гээд Сөүлээс баруун урагш байх Сувон хэмээх жижиг хотод очжээ. Тэнд нийтдээ мянга гаруй монгол ажиллаж амьдардаг бөгөөд Саруулсайхан дөнгөж очуутаал хоёр зуу гаруй Монголоос татвар авч эхэлжээ. Гэвч сүүлдээ тэд нар нь түүнд татвар өгөхөөсөө бултах нь их болсон байна. Зарим нь бүр түүн рүү «Чи яахаараа биднээс татвар авдаг юм бэ» гээд давшилж эхэлсэн байгаа юм. Тиймээс Саруулсайхан байнга татвар төлдөг хорь гучаадхан хүнтэй болжээ. Тэд нар нь хүч чадал доройгоос гадна Солонгост дөнгөж очсон болохоор өөрсдийгөө бас хамгаалуулах бодолтой байсан тулдаа л Саруулсайханд татвар өгсөн хэрэг. Саруулсайхан ч тэдэнд хандаж «энэ Солонгост чинь мафи их хүчтэй хөгжсөн газар шүү. Эндхийн мафиуд нэг л өдөр та нарыг цөлмөж мэднэ. Би эндхийн мафиудыг таньдаг болохоор та нарыг хамгаалж чадна. Тэгэхээр та нар надад татвар төлнө үү, байна уу өөрсдөө л мэдээрэй. өгөхгүй бол их л эвгүй юм болох байх шүү» гэж сануулсан байна. Анхандаа тэр Сувон хотод очоод мянган хүнээс татвар авч цулайтлаа баяжина гэж бодож байжээ. Солонгост нэлээд олон жил болсон Эрдэнэбат гэгч залуу нэг өдөр түүнд хандаж «Чи бид нараас татвар авна гэж байхгүй. Харин одоо татвар авч байгаа хорь гучаадхан хүнээ л алдчихгүйхэн шиг татвараа авч байна биз. Мөн дээр нь шинээр ирж байгаа Монголчуудаас татвар авах хэрэгтэй. Бид чамд саад болохгүй. Тиймээс чи шинээр ирж байгаа хүмүүс дээр анхаарлаа хандуул гэж зөвлөжээ. Эрдэнэбат бас л өөдгүй эр бололтой. Би л болж байвал бусад нь хамаагүй гэсэн байр суурьтай байдаг иймэрхүү амьтад л Саруулсайхан мэтийн улсыг өөгшүүлээд байдаг бололтой. Ингэж байтал дээр өгүүлсэн Намхайцэрэн тэргүүтэй арваад Монгол Сувонд очжээ. Саруулсайхан Эрдэнэбатын зөвлөснөөр шинэ хүмүүс дээр анхаарлаа хандуулж дээр өгүүлсэн мөнөөх үгээ тоть шиг давгаж байсаар Намхайцэрэнтэй хамт очсон есөн хүнээс татвар авч эхэлжээ. Харин Намхайцэрэн түүний өөдөөс салаавч өгсөн байна. Тэр Саруулсайханд хандаж «Чи надаас татвар авах юмуу. хуцваа. Чи намайг хамгаална гэж юу байсан юм бэ. Миний төрсөн ах Сөүлд байдаг юм. Олон жил болж байгаа. Аягүй бол чамаас татвар авч мэдэх байх шүү. Хоёулаа

зүгээр хэн хэндээ хал балгүй явья. Хэрэв татвар авах дуртай байгаа бол энийг аваарай» гээд өөдөөс нь салаавч гаргасан байгаа юм. Саруулсайхан ч түүнтэй нэг их юм ярьсангүй. Ингэж байтал 2004 он гарчээ. Тэгтэл Солонгост олон жил хараар ажилласан Намхайцэрэнгийн ах нэг л өдөр солонгосын цагдаа нарт чихдүүлэх нь тэр. Тэгээд Солонгосын шоронд хэд хоног хоригдоод Монгол руу ачигджээ. Саруулсайхан энэ тухай дуулж сонсоод Намхайцэрэнг шууд заамдаж аваад «одоо чи надад татвар өгөх болж дээ. Чамайг хамгаалдаг ах чинь Монгол руу ачигдчихлаа. Жилийн өмнө чи юу гэж томроод байлаа. Надад өгөөд байсан нөгөө том салаавчаа одоо өгөөч дээ» гээд нэвширтэл зоджээ. Энэ цагаас хойш Саруулсайхан Намхайцэрэнг байнга дээрэлхэж хуруу хумсаа хугалах шахам олсон хэдэн төгрөгийг нь шууд л дээрэмдчихдэг болж. Олон удаа дээрэмдүүлсэн Намхайцэрэн аргаа барахдаа нутаг буцахаар шийдсэн боловч Саруулсайханы хүчтэй савраас хаашаа ч мултарч чадсангүй. Сүүлдээ Саруулсайхан түүгээр дээрэм тонуул хийлгэхээр шийджээ. «би элэг нэгт нөхдөө дээрэмдэж чадахгүй» гэхэд нь «ална шүү. Чи миний боолын боол, босгоны зарц болсоноо мэдэж байна уу» гээд байнга шанаа өгдөг болсон байна. Тэр ч байтугай «Чамайг нутаг буцах юм бол хойноос чинь очоод голомтоор чинь хүйс тэмтэрнэ шүү» гэж сүрдүүлжээ. Намхайцэрэн ийм л хэцүү байдалд орчихжээ. Харь газар олз омог горьдож ирсэн биш, харин ч бүр яс цоожинд орчих нь тэр. Нэг удаа тэр Намхайцэрэнд хутга өгөөд «за чи сая ирсэн тэр Монголыг сүрдүүлээд хамаг юмыг нь сэгсэрчих. Хэрэв эсэргүүцвэл шууд дүрчих» гэж ятгажээ. «би чадахгүй дуртай юм бол чи өөрөө дээрэмд» гэж Намхайцэрэнг дургүйцэхэд «за, тэгвэл чамайг өөрийг чинь дүрнэ шүү! харь газар чамайг алчихсан байхад хэн ч чамайг эрж хайхгүй. Сайн л бол цогцос чинь моргийн өрөөнд очно. Тэгээд хэд хоногийн дараа эзэнгүй цогцосын тоонд орж чандар болоод үлдэнэ. Хэрэв чи чандар болохыг хүсээгүй юм бол өнөө шөнийн дотор тэр Монголыг дээрэмд» гэж тулгажээ. Ийм аргагүй байдалд орсон хүн яахаас ч буцахгүй нь мэдээж. Тэгээд Намхайцэрэн арга буюу хутгыг нь авч нөгөө залууг дээрэмдсэн байна. Түүнд 50 мянган вон авчирч өгөхөд Саруулсайхан хэнэг ч үгүй шүүрч аваад цүнхэлчихжээ. Ийм маягаар Намхайцэрэнгээр олон хүнийг дээрэмдүүлжээ. Нэг ёсондоо хүний гараар могой бариулж, өөрөө цаана нь гэдсээ илээд хэвтдэг туйлын бусармаг этгээд аж. Саруулсайхан алуулахынхаа урьд орой Намхайцэрэнгийн өрөөнд бараа бологчийнхоо хамт орж ирээд «за, чи яагаад өнөөдөр надад мөнгө авчирч өгсөнгүй вэ. Ер нь би чамайг ойрд загнаж зандраагүй шүү. Тэгэх тусам давардаг новш байна чи. Одоо чамайг залхаан цээрлүүлнэ» гээд түүнд нүүр гарын саван атгуулжээ. «За чи наадахаа ид. Хэрэв идэхгүй бол өрөөнд чинь алаад дөрвөн давхараас чулуудчихна шүү» гэж сүрдүүлжээ. Намхайцэрэн айхын эрхэнд мөнөөх савангаас нь нэг хазсан боловч шууд бөөлжсөн байна. Тэгээд далан таваар бууж өгч «маргааш би мөнгө олж ирнэ. Хэрэв мөнгө олж ирэхгүй бол та намайг алаарай!» гэж ам тангараг тавьжээ. Саруулсайхан хүйтнээр инээгээд гарч оджээ. Яг энэ үед Намхайцэрэнд түүнийг алах санаа төрсөн байна. «Ер нь ингэж зовж байхаар энэ мууг цааш нь харуулчихъя. Хэдий болтол дарлуулж байх юм бэ» гэж бодоод үүр цайлгажээ. Тэгээд өглөө эртлэн босч зах дээрээс урт хутга худалдаж аваад цүнхэн дотроо хийчихэж. Тэгээд үдийн алдад Саруулсайханы өрөөнд явж оржээ. Саруулсайхан түүнийг харснаа «за, мөнгө олж ирсэн үү» гэхэд Намхайцэрэн «өнөөдөр ер нь маш их одтой өдөр байна. Би бүр баян солонгосыг дээрэмдсэн гээд бод. Та надад их гоё арга зааж өгсөн байна шүү. Намайг шагнах юм байгаа биз дээ» гэжээ. Тэгтэл Саруулсайхан маасайтал инээж «дүү хүү овоо ш дээ. Ингээд байвал би чамайг яах ч үгүй. Ер нь хоёулаа гал хам болно байгаа. Тэгээд шинээр ирсэн Монголчуудын зүрхэнд шар ус хурууля. Чамайг одоо архиар дайлна» гээд түүнд архи аягалаж өгчээ. Намхайцэрэн зүрхээ чангалахын тулд өгсөн архийг нь шууд л гулгуулчихсан байна. Энэ үед

Саруулсайхан «за дүү хүү суу. Алив мөнгөө тоол» гэхэд Намхайцэрэн цүнхээ уудалснаа урт хутга гаргаж ирээд «май чи» гээд зүрхэнд нь хутгалчихжээ. Тэгээд улаан галзуу юм угсруулан хутгалж «Чи яасан их хүн дарамталдаг новш вэ. май чи, май чи» гээд хамаг биеийг нь сийчээд хаячихсан байна. Хүчирхийлэл хүчирхийллийг төрүүлдэг гэж энэ дээ. Ер нь хүн дээрэлхэж, доромжилсон хүн хэзээ ч олигтой явдаггүй. Одоо яая гэхэв. Хэрцгий зангаасаа болж яг л хонь шиг нядлуулсан Саруулсайханы хохь болоод өнгөрч байгаа нь тэр.

## **Тувагийн зэвсэгт дээрэмчидийн цуутай толгойлогч айдас монголын хил дээр ясаа тавьжээ**

Тувагийн зэвсэгт дээрэмчидийн цуутай толгойлогч Айдасыг хэн буудсан нь одоохондоо тодорхой бус. Хилчид зурвас газрын эргүүлд гарахдаа хил зөрчин орж ирсэн морьтонгуудтай нэг бус удаа буудалцдаг аж. Харилцан хэсэг буудалцсаны дараа хил зөрчигчид буцаж зугтах ч юм уу, шархадсан нэгийгээ үүрээд бур хилийн гүн рүү цөмрөн ороод мөрөө буруулах тохиолдол ч байдаг байна. Харин иймэрхүү тохиолдолд тэр даруйдаа өдөр тутмын сонины нэгдүгээр нүүрэнд бичигддэг аж. Тэрнээс биш холын зайнаас бие бие рүүгээ хэсэг буудалцаад салах тохиолдолд тэр болгон сонин дээр мэдээ болж гардаггүй байна. 1998, 99 оны үед бол «Тува-Монголын хил дээр буудалцаан болов» гэсэн тодоос тод гарчигтай мэдээ ойр ойрхон гардаг байсан. Хариу түүнээс хойш цаг хугацаа ч урсан өнгөрч, хилчид ч тиймэрхүү харилцан буудалцааныг суртэй юманд бодохоо больжээ. Тиймээс Айдас хилчидтэй мөргөлдөн харилцан буудалцаж байгаад нас барсан байх магадлал өндөр байна. Тува нар дандаа мэргэн бууддаг гэж юу байх вэ. 2005 оны 11-р сарын 9-ний шөнө хилийн шонгийн 1309-р дугаар тэмдэгтийн орчим болсон харилцан буудалцаанаас долоо хоногийн дараа Оросын талаас Тувагийн Орто хошууны иргэн «Айдас» буюу Хакас гэгч Монголын хилийн зүгээс үхлийн шархтай орж ирээд заставын эмнэлэгт нас барлаа гэсэн мэдээ орж ирсэн байна. Эсвэл тэр өөрийнхөө Тува нарт хөнөөгдсөн байж ч болно. Эсвэл манай хил рүү биш нутгийн гүн рүү аль эрт цөмрөн орж ирээд адуу мал хулгайлах гэж яваад манай малчдын суманд оногдсон ч байж болно. Тува нар өс хонзон ч юм уу, эд хөрөнгө, заримдаа гартаа барьж яваа буу, унаж яваа морио хуртэл булаацалдан хоорондоо маргалдан нэгнийгээ шууд л алчихдаг хөгийн улс. Дээрмийн замд дөрөө харшуулан явж байхдаа хүртэл нэгнийхээ нуруу руу хутга шаадаг юм гэсэн. Тэгээд л Монголчуудын суманд өртлөө, Монголчууд хутгалчихлаа гэсээр морийг нь хөтлөөд очдог юм гэсэн. Эсвэл хилчдэд сэжиг авахуулахгүй хилийн гүн рүү нэвгэрч ороод адуу малаа манаж буй нутгийн залуустай мөргөлдөж, шөнийн дуран хараатай бууны суманд өртөж шархтай хүмүүсээ аваад хилийн дээс давж арилах удаатай. Юутай ч нэгэн үе буюу 1990-2000 оныг хүртэл Тува-Монголын хил дээрхи малын хулгай, хилийн дээрмийг зохицуулан удирдаж байсан Айдас гэгч цуутай эр Монголын хил дээр тэнэсэн ч юм уу, зорьсон ч юм уу суманд амь насаа алджээ. Ингээд Айдас хийгээд Тувагийн зэвсэгт дээрэмчдийн талаар тодруулга өгөх үүднээс Ганхүү хэмээх залуутай хүүрнэлдсэнээ толилуулья.

### **-Өөрийгөө товч танилцуулна уу?**

-Би Завхан аймгийн Тэс сумын уугуул. Хилийн зурвас орчмоор нэг үе нутагладаг байсан. Одоо бол манай тэндэхийн айлууд цөм Тэсийн голынхоо урд биед гарчихсан. Голын ар талаар нэг ч айл нутаглахаа больсон доо.

### **-Яагаад тэр вэ?**

-Тэсийн голын хойд бэлээр нутаглана гэдэг одоо маш аюултай болсон. Тувагийн зүгээс хилийн дээрэмчид үргэлж довтолдог. Тийм болохоор айлууд нь голынхоо урд биед гарсан. Гэвч энэ найдвартай хамгаалалт биш бөгөөд одоо ч манай нутгийнхан дээрэмдүүлсээр л байгаа шүү дээ.

**-Өөрийг чинь хил зөрчин мал хөөсөн хэргээр шоронд ороод гарсан гэж сонссон юм байна?**

-Тиймээ. Миний адууг Тува нар хөөгөөд хил давуулсан. үүний дараа би адууныхаа хойноос хил давж яваад өөрийнхөө адууг олохгүй болохоор нь замд тааралдсан адууг нааш нь хөөсөн юм.

**-Монголчууд Тувагийн нутагт явж байгаад баригдах тохиолдол бий юу?**

-Байлгүй яахав. Тувачууд бол ёстой жинхэнэ новшнууд. Тувачуудад баригдаад есөн шидээр тамлуулж үйлээ үзсэн залуус цөөнгүй. Бүр чихийг нь огтлоод, шөрмөсийг нь таслаад хаячихсан тохиолдол ч бий. Лав л миний нэг танил залуу ‘Тува нарт баригдаад баларсан. Түүний аманд хазаарын амгайг улайсгаж байгаад хүчээр зуулган морь болгон унаж доромжилсон байсан. Ер нь Тува нар архи их уудаг. Дээр нь харанхуй бүдүүлэг. Тэр Кызыл гэдэг том хотод нь хүртэл бараг ажилчдынхаа цалинг архиар тавьдаг гэсэн шүү дээ.

**-Монголын нутагт мал хөөж яваад баригдсан Тува нар гэж байдаг уу?**

-Байлгүй яахав. Намайг Завханы 451-р ангид ял эдэлж байхад лав л хоёр хилийн дээрэмчин Тува ирж байсан. Гэхдээ Монголчууд юу гэж тэдэнтэй адилхан харгислах билээ дээ. Зохих ном журмын дагуу эдлэх ёстой ялыг нь эдлүүлж байсан. Вандан Уран-Оол Вонович гэдэг нь Завханы шоронд үхсэн юм. Бас Алейк гэж нөхөр байсан юм. Тэр ч бас шоронд тураалд ороод нүднээс гарч ялнаасаа өмнө ах дүү нарынхаа хөөцөлдлөгөөгөөр нутаг буцаж байсан. Нас бардаг Тува нь хилийн дээрмийн нөлөө бүхий томчуулын нэг байсан юм гэсэн. өмнө нь Тувагийнхаа Улаан хадын шорон гэдэгт нь ял эдэлж байсан юм гэнэ лээ. Хилийн дээрмийн толгойлогч Айдас гэгч нь түүний ойрын гар хөлийн хүн байсан гэж дуулдаж байна лээ. Бас хоёр дээрэмчинг хилийнхэн баривчлаад Завханы мөрдөнгөөр дамжуулан “Ганц худаг”-т хориж байгаад нутагт нь буцаасан гэж дуулдаж байсан. Бас нэг алба хашдаг найзаасаа “Яагаад эднийг бүр хот руу авч явсан мөртлөө буцаагаад Тувагийн талд өгчихөж байгаа юм бол” гэхэд “Яахав дээ, жаахан юм үзүүлж нүд тайлуулж байгаа хэрэг. Эд нар очоод нөгөө Тува нартаа Монголын шоронгийн талаар жаал юм ярина шүү дээ” гэж билээ.

**-Тэр хоёр Тувагийн нэг нь үхээд нөгөө нь тураалд ороод нутаг буцсан гэлээ. Монголчууд тэднийг хэтэрхий их дарамталж байсан юм биш биз?**

-Үгүй. Тэд бусадтайгаа л адилхан байсан. Завханы шоронд хүн өлсөж үхлээ гэж би л лав дуулаагүй. Тэд бусад хулгаруудын адил хоол идэж, адил ял хийж байсан. Тэр нас бардаг нь үнэндээ сайхан эр байсан. Сэтгэл санаагаар л явчихдаг юм шиг байна лээ. Их л хурдан турж эцсэн юмдаг. Харин ч шоронгийн удирдлага, Завханы шүүх прокурорынхон тэр хоёрыг хэд хэдэн удаа аймгийн төв эмнэлэгт хэвтүүлж, эмчлүүлж байсан. Бодвол хоёр улсын хоорондын асуудал гэж байдаг биз. Гэвч яалт ч үгүй нэг өглөө босоход л амьсгал хураасан байсан. Энэ нь өмнө нь хил дээр гарсан нэг аллагатай холбоотой байж магадгүй гэж би боддог.

**-Хэдийд гарсан ямар аллагатай холбоотой гэж?**



-Тэр Тува цагаан сарын өмнөхөн нэг сард нас барсан юмдаг. Энэ явдлын дараахан манай Баянтэсийн нэг айлын малыг зэвсэглэсэн Тува нар дээрэмдэхдээ гэрийнх нь гаднаас нь буудаж гурван хүнийг хүйс тэмтэрсэн юмдаг. Тэд автомат буугаар шүршилгүй малыг нь туугаад явчихаж болох л байсан. Тэгтэл зориуд тийм аллага үйлдсэн юм. Тэр нас бардаг тува чинь дээрэмчдийнхээ дунд нөлөө бүхий хүн байсан гэж байгаа. Айдасын ойрын шадар хүн байсан гэж мэдэх хүмүүс ярих юм билээ. Тэгэхээр тува нар тэр үхдэг хүнийхээ өшөөг монголчуудаас авсан байх гэж би харддаг юм. Гэхдээ энэ бол миний хувийн бодол шүү дээ.

### **-Ер нь тэр Айдас гэдэг чинь ямар учиртай хүн бэ?**

-Айдас гэж Тувагийн дээрэмчдийн гол толгойлогч юм гэсэн. Тэр Тувагийн цагдааг худалдаад авчихсан нөхөр шиг байгаа юм. Завхан, Увсын хилийн сумдынхан бол мэднэ. Хэдэн жилийн өмнө Завханы Тэс суманд түүнийг хутгалж байсан хэрэг гарч байсан. үнэндээ Тувагийн хулгайч нартай нийлчихсэн Монголчууд ч байдаг юм. Ганхүү бид хоёрын ингээд яриа өндөрлөсөн юм. Эндээс тувагийн дээрэмчид, тэдний толгойлогч Айдасын талаар товчхон ч атугай мэдээлэл гарч ирж байгаа биз ээ. Тувагийн зэвсэгт дээрэмчид гэдэг нь хил орчмын нэн ядуу отгийн анчид ажээ. Тэд заримдаа Оросын хилийн заставынхантай хуйвалдаад Монголын хил рүү орж адуу хөөдөг байна. 60-аад адуу хөөгөөд аваачлаа гэхэд ашгийг нь 40-60-аар заставын даргатай нь наймаалаад хуваачихсан юмсанж. Сүүлдээ Монголын малын хулгайч нартай тохиролцон наадуул нь гаргаж өгдөг, цаадуул нь угтаж авдаг болсон аж. Монголчууд тэднээс голдуу акаа буу, дуран хараатай ТОЗ-8 винтов авч эргээд малчдад дамладаг сурагтай. Сүүлдээ тэр бууны суманд Тува нар өөрсдөө оногдож үхдэг болжээ. Жишээ нь Айдас байна. Энэ хүний талаарх товч мэдээлэл гэвал Афганы дайнд оролцож гавьяа байгуулсаны улмаас шагнагдаж явсан. 1988-1990 онд орос Монголын хил дээр заставын дарга хийж байгаад 1991 оноос хулгайн анчидтай холбогдон эхний шийтгэлээ хүлээж шоронд гурван жил болоод гарсаны дараа хилийн дээрэм толгойлж 1995-2000 оны хооронд л гэхэд Монголын нутгаас Тува руу орсон 1300 орчим адуу түүний гараар орсон гэдэг. Ийм л нэгэн цуутай дээрэмчин Монголын зүгээс ниссэн суманд амь насаа алджээ.

## **Мафийн гишүүд сахил хүртэхдээ үнэнч явахаа цусаараа андгайлж, хүний хохимой толгойтой дүрсийг зулын дөлөнд шатаадаг аж**

«Мафи» хэмээх үг өдгөө Монголчуудын амны уншлага болжээ. Тухайлбал хоёр хүн хоорондоо арсалдаад аль илүү танхайрсан нь мафи болчихно. Эсвэл залилан мэхлэгчид «Хадгаламж зээлийн хоршоо» гэх мэтийн хуурамч юм байгуулж, ард олны их хэмжээний мөнгийг хамж аваад гадаадад оргон зайлангуутаа бас л мафи гэгцгээх болж. Тэгвэл хэн дуртай нь хэсэг бүлгээрээ танхайран түрэмгийлж, муу аргаар хөлжөөд, баяжаад байдаг ямар нэг байгууллагыг мафи гэдэггүй бололтой. Тиймээс мафи гэж чухам юуг хэлдэг, хэзээ хаана үүсч хөгжөөд эдүгээ 20-р зуунд уламжлагдан ирсэнийг уншигчиддаа сонирхуулъя. Хар бараан мөртэй, цус асгаруулсан аймшигт дүр зурагтай, Сицили нутгийг олон улсын мафийн гал голомт хэмээдэг. Сицили арал дээр амьдрагсад олон зууны турш ноёрхсоор ирсэн цусан төрөл, хүй ураг, ёс журам нь эрлэгт очихоосоо өмнө зоригтой тэмцэгч байхыг номлодог сонин заншилтай бөгөөд түүнд тухайн нийгмийн ямар ч хууль үйлчилдэггүй. Гэвч энэ нь бүр тус арлын өвөрмөц хэвшил болсоноор эвсэл бүлэг болон хөгжжээ. Уугуул нутгийнхан Сицилийнхээ мафийг «Буянт нийгэмлэг» хэмээн нэрийдэж өөрсдийгөө буян үйлдэж буй буянтай хүмүүс гэж тооцдог юм байна. Бас мафийн гишүүдийг «Лупарын баатрууд» гэж нэрлэх нь ч бий. Лупара нь хорголжин сумаар цэнэглэсэн нэн эртний ангийн буу бөгөөд уламжлалт заншлаар тэр буугаар өөрийн дайсан гэж үзсэн бүхнээ устгадаг ажээ. “Лупарын баатар” сахил хүртэхдээ үнэнч явахаа цусаараа андгайлж, хүний хохимой толгойтой дүрсийг зулын дөлөнд шатааж зан үйлээ гүйцэтгэдэг байна. Мафийн гол хуулийг омерта гэдэг ба энэ хууль зөвхөн гишүүдэд үйлчлээд зогсохгүй гэр бүлийн төрөл төрөгсөдөд ч үйлчилнэ. Хуулиар оногдуулах ял нь мэдээж алах. Мафийн гишүүд нь “амьсгал хураасан гишүүд л амаа хамхиж чадна” гэсэн хатуу зарчимтай байдаг. 18-р зуунд Европын цагаачдын цуваа Америк руу цуггаж байх үед хүсэл булаасан энхжингийн орон руу Сицилийн мафийнхан ч хүрч очицгоожээ. Ийнхүү Сицилийн мафи улиран хувьсаж буй цаг үеэ даган 19-р зууны капитализмтай зэрэгцэн хөгжих болжээ. Ингэж Сицили арлын тосгоны хөдөөх болхи гишүүдээс эрс өөр мафийн шинэ гишүүд төрсөн бөгөөд тэд хатуу чанд гойд зохион байгуулалттай болж нууц ажиллагаа нь нарийссан байна. Тиймээс ч АНУ-д зохион байгуулалттай гэмт хэрэг Сицилийн мафийнхан орж ирсэн тэр цагаас эхэлсэн гэж үздэг юм. Авилга хээл хахууль, айлган сүрдүүлэлт бол Сицилийн мафийн мэргэжсэн ялт хэрэг юм. Сицилийн мафи АНУ-д хоромхон зуур цэцэглэн эрч хүчээ авч шүүх, цагдаагийнхныг ч сандралд оруулсан ба Америкийн цагдаагийн газрын хар дансанд орсон Сицили мафийн шинэ түүхийн анхны хэргүүдийн нэг нь 1890 онд гарчээ. Сицили гаралтай дээрэмчдийн оролцсон өрсөлдөөн, хүчирхийллийн шуугиан АНУ-ыг цочирдуулсан аж. Энэ нь юу вэ гэвэл мөрдөн байцаах явцад цагдаагийн нэг ажилтан гэрчийн маш чухал мэдүүлэг өгөхөөсөө нэг хоногийн өмнө алагдсан байна. Сицилийн мафийг АНУ-д анх нүүлгэн шилжүүлж, зохион байгуулагч нь Вито Каша Феррогийн удирдсан “хар гар” мафийн бүлэглэл дээрх анхны ялт хэргийг өдүүлсэнээс хойш олон ялт ажиллагаа үйлдэж АНУ-ыг байлдан дагуулж, эзэгнэжээ. Мафи судлаач Панталеуне 1962 онд бичихдээ “сицилийн мафийн гол төлөөлөгч В.К.Ферро нь өндөр нуруутай, намбалаг дүртэй. Энэ хүнийг харсан хэн боловч бичиг үсэгт тайлагдаагүй, ясны дээрэмчин гэж бодохгүй. Түүний өмнө тансаг зочид буудлуудын хаалга үргэлж нээлттэй байдаг. Тэр бас өндөр хэргэмтнүүдийн талархлыг үргэлж хүлээнэ. Мань эр мөнгийг яаж олдоогоо бодолцдоггүй. Ихэмсэг, өгөөмөр, үрэлгэн” гэж тэмдэглэжээ. 1920-1933

онд мөрдөгдсөн зохион байгуулалттай гэмт хэргийн ихэнхийг Ферро гүйцэтгэжээ. Архи, хар тамхийг худалдахыг хориглосон АНУ-ын “хуурай хууль” гэгчийг их гарын дээрэмчин овжиноор ашиглаж, үлгэрийн хаан мэт баяжсан гэдэг. Ингэж ашиг хонжооны төлөө, борлуулалтын зах зээлийг хүч түрэмгийлсэн тулалдаанд Сицили арлын мафийнхан ялжээ. Түүний цус, үхэл дагуулсан хэргийг АНУ-ын том толгой гэмт хэрэгтэн Ж.Массерия, Слуглано, Д.В.Женовезе, С.Маранзано, Аль Капоне зэрэг их гарынхан толгойлж Нью-Йорк, Чикаго, Бостон зэрэг хотуудыг өөрийн үйл ажиллагааны хүрээний дагуу 27 хэсэг болгон эзэгнэжээ. Мафийн бүлэглэлүүд өөрсдийн эрх мэдлийг давуу хүчирхэг байлгахын төлөө ямагт хоорондоо тэрсэлдэн алалцаж цаг тутам үхдэл хүүрээр хотыг дүүргэдэг байсан аж. Мафийн “бүл”-ийн толгойлогчид синдикат гэдэг “хороо”-нд элсдэг бөгөөд тэр нь 5000 шахам гишүүдтэй гээд бодоход ямар олон мафийн бүлгүүд ялт үйл ажиллагаа эрхэлж байдаг нь ойлгомжтой юм. Синдикат нь зөвлөхүүд, орлогч нар, “дэслэгчид”, “байлдагчид”-аас бүрдэнэ. Ийм дээрэмчид бүгд саятанууд, толгойлогч дээрэмчин нь тэрбумтан байдаг аж. Мафийнхны жилийн орлого 120 тэрбум ам.долларт хүрч байсан удаатай. үүнтэй АНУ-ын аль ч корпорацийн орлого дүйхгүй бөгөөд их гүрний улсын төсвийн тавны нэг хувьтай тэнцэх хөрөнгө аж. 1957 оны 11-р сарын 14-нд дээрхи мафийн толгойлогчид Нью-Йорк хотод хуралджээ. Их гарын хөгшин дээрэмчин Жозеф Барбар гэгчийн фирмийн дэргэд гоё ганган суудлын тэрэгнүүд өдий төдийгөөрөө шавааралдсан байхыг нэг цагдаа харуутаа мафийнхан цуглаж гэж зөнгөөрөө мэдрээд тусламж дуудаж байлдаан эхэлжээ. Ихэнх нь алагдаж, цөөн нь баривчлагдсан тэр үеэс Сицилийн мафийн хүч суларч АНУ-ын цагдаагийнхны бүрэн мэдэлд оржээ. Мафийнхнийг баривчилсны дараа Барбарын эдлэн газрыг нэгжихэд тансаг сууцны нь гурван метрийн гүн хонгилд аймшигт шорон байсан нь илэрсэн байна. Тэнд хүүр шатаадаг газар байсан байна. “Урвагч”-ийг 19-р зууны хамгийн харгис аргаар эрүүдэн тамалж, шатаадаг байсан аж. Тамлагдсан арваад хүүр байсны тэн хагас нь амьдаараа арьсаа хуулуулж үхсэн байжээ. Тэд бүгд мафийнхан байсан гэдэг. Мафийн энэ Синдикат Америкийн хамгийн хүчирхэг нэгдэл байсаар 1979 оны 7-р сард толгойлогч Карл Галантег гэгч нь бие хамгаалагчдаараа хүрээлүүлчихээд зоогийн газарт хооллож суухдаа амиа золиослогчийн бөмбөгөнд өртөн амиа алдсанаар ямар ч удирдлагагүй болж бутарчээ. Улсын доторхи улс гэгч энэ байсан аж. үүнээс хойш АНУ-д ийм олон жил ноёрхсон мафи дахин зохион байгуулагдаагүй гэдэг. Алан хядагч, амиа золиослогч, хүч түрэн эзэгнэгч мафи гэдэг ийм л байдаг аж.

## **Ламаахүүгийн Мөнхбат гэгч гаж донтон ахынхаа нэгэн адил хоёр эмэгтэйн амийг маш зэрлэгээр хөнөөжээ**

Эмэгтэйчүүдийг ангуучлан хороох нь нэгэн айлын ах дүү хоёрын ургийн тангараг байсан болов уу гэлтэй аймшигт явдал гарчээ. Ламаахүүгийн Мөнхбат гэгч 29 настай эр ахынхаа замналаар хоёрын хоёр эмэгтэйгийн амийг егүүтгэсэн аймшигт хэрэг өвөрхангай аймагт гарсан байна. Нийслэл хотод эрхэлсэн ажилгүй ганхаж явсан тэрбээр аав ээжийнхээ нутаг өвөрхангай аймгийн Богд суманд очоод удалгүй Пагмадулам, Гэрлээ гэдэг хоёр эмэгтэйтэй танилцжээ. Шинэхэн танилууд аймгийн төв, сум хоёрын дунд гэр орноороо ирж очин, хааяа нийлж архидан, баар цэнгээний газарт цагийг хамт өнгөрөөн их дотносох болсон байна. Пагмаа, Гэрлээ хоёр тэр нэгэн өдөр аймгийн төвөөс сум орох унаа хайж яваад Мөнхбаттай тааралдахад цаадах нь их л тусархуу царайлан ахынхаа унаж байсан хуучин суудлын жижиг тэргээр тэднийг хүргэж өгөхөөр болжээ. Найз хоёр эмэгтэй үнэ төлбөргүйгээр явах болсондоо баярлан ум хумгүй ачаа тээшээ баглан машинд нь суугаад замд гарсан аж. Насаар тэднээс ахимагдуу ч анхнаасаа л зугаа цэнгэлийн хөнгөн яриагаар бие биесээ егөөдөн цаашлуулж, хормой хотны явдлыг ч ичгүүр сонжуургүйгээр бурдаг Мөнхбатаас тэд огт бишүүрхэн цэрвэж байгаагүй юм. Зам зуурт тэд юу эсийг ярих билээ. Тэгтэл Мөнхбат хүн амьтны бараа харагдахгүй зэлүүд газар очоод машин эвдэрчихлээ гээд дээгүүр доогуур нь шагайж баахан зогсож гэнэ. Тэгснээ аян замын жаахан идэх уух юмаар тэднийг дайлж сууснаа хэдүүлээ энд хонохоос яахав гэжээ. Мөнхбатын далд санааг ойлгосон Гэрлээ бухимдан ойр орчимд айл байгаа эсэхийг ажин зогссоноо үүргэвчээ авч үүрэн Пагмаадаа эндээ үлдвэл үлд гэж хэлээд яваад өгчээ. Тэр найздаа ийн хэлсэн нь ч бас учиртай байлаа. юу гэвэл, Пагмаа нэг удаа түүнд Мөнхбаттай шөнөжин загас наадуулж хоносноо сайрхсан шинжтэй ярьж байсан юмсанж. Тиймээс ч энэ өдөр машин эвдэрснээр шалтаг болгон хээр хонохдоо түүний дэргэд эр эмийн ажлаа хийх нь гэж түүнд бодогдсон тул шууд л тэднийг хаяж явсан юмсанж. Нөгөөтэйгүүр Мөнхбат бэлгийн гаж донтой юм шиг байсан хэмээх Пагмаагийн ам халан хэлсэн үг Гэрлээг нэлээд гайхахад хүргэж байсан удаатай тул тэр ийн огцом шийд гаргасан биз ээ. Тэгээд ч Мөнхбат замд явахдаа “ийм сайхан хоёр амьтныг авч яваа эр хүний аз дутаагүй л байгаасай” хэмээн тоглоом шоглоомоор хэлсэн нь ч Гэрлээд огт таалагдаагүй ажээ. Харин хожим нь Гэрлээ харамсаад ч баршгүй их гай зовлонд унана гэж бодоогүй байв. Түүнийг явсны дараа найз Пагмадулам нь Мөнхбатын хүчирхийлэл, бэлгийн гаж харилцааг тэвчихгүй эсэргүүцсэнээс амиа алдахад хүрчээ. Пагмадуламыг Мөнхбат 34 удаа хутгалж алаад цааш давхихдаа хэрэв Гэрлээ тааралдсан бол гэрч үлдээхгүйн тулд алах л байв. Ийм зэрлэг байдлаар эмэгтэй хүний амийг хороосон Мөнхбат сумын төвд дөхөж явснаа гэнэт эргэн аймгийн төв рүү буцаад давхижээ. Замдаа нэг удаа түр зогсон хувцас, нүүр ам руугаа үсэрсэн цусыг дутуу хагас цэвэрлэсэн болоод шууд явсаар “хобби” хэмээх зочид буудалд иржээ. үүдээр нь явж ороход жижүүр эмэгтэй тааралдсан боловч урьд нь үйлчлүүлж байсан хүн ирлээ гээд олон зүйл ч асуусангүй, харин түүний сурагласан хүн буюу хамт ажилладаг эмэгтэйгийнхээ байгаа өрөөг зааж өгөөд дотогш оруулсан байна. Цаг нэгэнт орой болсон ч түүний хамтран ажиллагч эмэгтэй нь хүнгүй өрөөнүүддээ цэвэрлэгээ хийгээд явж байсан ажээ. Ингээд нэлээд хэсэг хугацаа өнгөрөхөд өнөөх Мөнхбат гарч ирэхгүй удаад байхаар нь жижүүр араас нь явах гэтэл тэр гартаа хутга барьчихсан үүд рүү ухасхийхдээ “би та нарыг цөмийг чинь ална шүү” гэж хашгираад гадагш зугтаасан байна. Жижүүр айн балмагдаж утсаар цагдаа дуудан найз эмэгтэйнхээ байсан өрөөнд гүйн ортол

шалан дээр дээш харан хэвгэх тэр эмэгтэй амьсгал нэгэнт хураачихсан байжээ. Нарийхан даавуугаар түүний хоолойг боож, хамаг хувцсыг тайчин, хоёр хөхний нь хооронд хутгаар зүссэн байлаа. Энэ хэргийн араас хэдэн сарын турш хөөцөлдсөн аймгийн цагдаагийн хэлтсийнхэн сүүлдээ Мөнхбатыг баривчилж чадахгүй болохоороо 1993 онд шоронгоос оргоод ор сураггүй болсон түүний ах хаа нэгтээ түүнийг орогнуулж байгаа, эсвэл Улаанбаатар хотод ч бүгэж байж магадгүй гэсэн таамаг дэвшүүлж эрэн сурвалжлах ажлаа улсын хэмжээнд зарлан зохион байгуулж эхэлсэн байна. Гэвч аймшигт хэргийг үйлдсэн алуурчин Мөнхбат аймгийнхаа нутгаас бараг холдоогүй байсан ажээ. Тэр саяхан тус аймгийн төвийн нэгэн байшингийн дээвэр дээр амиа хорлон нас барсан байсныг цагдаагийнхан олсон байна. Дашрамд өгүүлэхэд түүний ах Төмөрбаатар урьд нь мөн л хоёр эмэгтэйгийн амийг хорлохдоо нэгнийх нь хамаг биеийг хутгаар сийчиж, нөгөөг нь хүчиндэж, зодсоор байгаад алсан байжээ. Энэ хэрэгт тэр цаазын ял сонсох ёстой байсан ч оргож амжсан бөгөөд одоо болтол сураг нь гарахгүй байгаа ажээ.

## **Эрэн сурвалжлагдаж буй террорист алан хядагчдын нэрсийн жагсаалтын 69-рт Монгол хүний нэр бичигджээ**

Хятад хүний очоогүй газар байдаггүй гэдэг. Хойд туйл орчим оршдог мөсөн орон буюу Исландын нийслэл Рейкьявикт нэг хятад зоогийн газар ажиллуулж байхад өөр нэг хятад Африк тивийн гүнд оршдог Чад хэмээх улсын Нджамена хотын захад жуулчны газар ажиллуулж байх жишээтэй. Тэгвэл эдүгээ хоёр сая гаруйхан монгол маань хүртэл дэлхийгээр нэг цацсан будаа шиг тарж хөл хүрээгүй газар үгүй болсон бололтой. Гурван жилийн өмнө Мадагаскар, Шинэ Зеландад, бүр ариун Еленагийн арал дээр хүртэл Монгол хүмүүс ажиллаж амьдарч буй мэдээлэл гарч байсан. Харин энд дурдах Монгол хүн бол их өвөрмөц адал явдалтай нэгэн. Гэхдээ тэр өөрийгөө ганцаараа гэж хэлээгүй байгаа юм. Түүнтэй адилхан гурав дөрвөн Монгол хүн яг түүнтэй адилхан амьдрал туулж яваа ажээ. Ямар амьдрал вэ гэдгийг дараахь ярианаас сонирхоцгооё. Гантөмөр хэмээх бизнесмен залуу 2003 онд Хорватын нийслэл Загреб хотноо ажлаар явж байгаад Энхтөгс хэмээх Монгол залуутай уулзжээ. 32 настай Энхтөгс их л сонин амьдрал туулсан нэгэн байв. Ингээд Гантөмөртэй тэр залуугийн талаар хүүрнэлдсэн яриагаа толилуулъя.

### **-Чи ер нь Загребт яах гэж очсон юм бэ?**

-Бухарест дахь ЭСЯ-ны ажилтан Анхбаярын буруугаас л болсон хэрэг. Тэр Австрийн нийслэл Вена руу шилжүүлэх ёстой бидний хэдэн бизнесмений албан бичгийг Загреб руу явуулчихсан байсан. Ингээд би өөрөө хөөцөлдөхөөр шийдээд Хорват руу ирсэн юм. Тэгэхэд Югославын дайны нөлөөгөөр Серби, Словени, Албани, Хорват ер нь эвгүй байсан шүү дээ.

### **-Энхтөгстэй чи хаана тааралдсан юм бэ?**

-Тэр их сонин. Би гурван ширхэг үнэгэн лоовууз, нэг ширхэг ирвэсний арьс зарах гэж очсон юм. Загреб чинь худалдааны олон төвтэй. Хамгийн том нь Титоград нэртэй, манайхаар бол “нарантуул” зах л гэсэн үг. Нэг өдөр намайг Титогийн арьсны мухлагуудаар явж байтал ирвэсний арьсыг маань нэг Грек хүн сонирхоод буудалд уулзаж үнээ тохирохоор болсон. Намайг ганцаараа болохоор тэд нар яаж ч мэднэ шүү дээ. Би 1980-85 онд Чехсловакт суралцаж байсан болохоор хэлний зовлон байхгүй байсан л даа. Тухайн үед би Вышеград гэдэг буудалд буусан байсан. Тэр буудалд уулзаж арьсаа өгч авалцья гэсэн юм. Оройхон нөгөө Грек чинь хоёр хүн дагуулаад ирсэний нэг нь монгол хүн байсан. Ингэж л танилцсан. Энхтөгс маргааш нь над дээр ирж намайг Титогийн захаар дагуулж явахаар тохиролцсон юм. Бид хоёр бүтэн өдөржин хамт явахад тэр надад амьдралаа ярьсан л даа. Би сонсоод их гайхсан. Чихэндээ ч итгээгүй. Харин саяхан Киргизэд ажиллаж байгаад ирсэн нэг Монгол хүнтэй уулзсан чинь Атрек хэмээх нууц нэртэй Энхтөгсийн тухай нэлээд үнэн зөв бодитой мэдээлэл өгсөн шүү.

### **-Ямар мэдээлэл өгсөн гэж?**

-Атрек нэртэй монгол залуу Энхтөгс нь “Исламын дайчин ахан дүүс” лалын Террорист бүлгийн дээрээсээ гурав дахь хүн болсон юм байх. Босни, Афган, Чечень, Ирак улсад Исламын туган дор тулалдаж явсан. Мөн Ливид өөрийн гэсэн хувийн эдлэн газартай.

“аль кайде” алан хядагчдын сүлжээнд хамрагдсан энэ тэр гээд л надад мэдээлэл өгсөн. Энэ тухай ярьсан хүн бол худлаа хэлэхээргүй Киргизид хүчний байгууллагын шугамаар очсон ажилтан л даа.

**-Лалын алан хядагч нартай Энхтөгс яагаад мөр зэрэгцэн тулалдах болсон юм бол?**

-Тэр Загребт надтай хамт Титогийн захаар бүтэн өдөржин явахдаа энэ тухайгаа ярьсан л даа. 1990 онд Энхтөгс Киргизийн Бишкек хотод уул уурхайн чиглэлээр суралцаж байсан юм билээ. Ингээд 1991 оны орчим тамхины наймаа эрхэлж яваад Узбекийн “Джизак” нэртэй шашины хэт даврагч бүлгийнхэнтэй холбоо тогтоож, Оросуудаас зэвсэг зөөж наймаалах осолтой бизнес рүү орсон гэсэн. Энэ үедээ Энхтөгс зэвсэгийн наймаанаас нэлээд их мөнгө олсон байж л дээ. Гэвч Омонынхонд баригдаж Махачкалын шоронд хоригдож байтал 1994 онд Шамиль Басаев тэргүүтэй Чечений салан тусгаарлагчид тус шоронг чөлөөлсөн байна. Энхтөгс зэвсэг худалдаж байх үедээ бүх төрлийн зэвсэг эзэмшиж сурсан учраас Чечений үндэсний гвард гэгчид сарын 1000 ам.долларын цалинтайгаар элсэж орсон гэсэн.

**-Энхтөгс ер нь аль нутгийн хүн байсан юм бэ? Лалын шашин шүтдэг байсан юм уу?**

Говь-алтай аймгийн төвд төрж өссөн гэсэн. Бүтэн өнчин юм билээ л дээ. Тэгээд ахындаа амьдарч байгаад арван жилээ алтан медальтай төгсөөд муис-ийн хими физикийн ангид суралцаж байгаад Киргиз явсан гэсэн. Киргизэд зэвсэг, тамхи наймаалж байхдаа усыг нь уувал ёсыг нь дага гэдгээр лалын шашныг хүндэтгэж, зарим үед бишрэн шүтдэг байсан гэсэн. Харин 1994 онд тэр Жохар Дудаевыг Оросуудад алуулсаны дараа Испамын шашинд албан ёсоор орж, өөрийгөө лалын цэрэг болгосон байгаа юм. Аслан Масхадовыг ерөнхийлөгч болсоны дараа Чеченьд нэг хэсэг байдал намжсан тул Энхтөгс Афган руу очиж Талибаны нэгэн бааз дээр зургаан сар бэлтгэл хийж жинхэнэ лалын хөлсний цэрэг болсон гэдэг. Тэндээсээ Туркт очиж Курдуудын зэвсэгт отрядад оролцож 1996 онд Тебриз хотод АНУ-ын есөн жуулчинг барьцаалсан үйл ажиллагааг гардан гүйцэтгэсний дараа “Исламын ахан дүүс” байгууллагаас 300 мянган ам.доллар авсан гэдэг. 1996-98 оны хооронд Ахтаб нэрээ Атрек болгон өөрчилж Пачестины Хамас байгууллагад Израйлийн эсрэг сарын 2500 ам.долларын цалинтай тулалдаж, нэг удаа бүр амиа золиослох дөхсөн гэдэг. Ингээд 1999 онд Чеченьд эргэн ирж Иорданы харьяат Хотгабын удирдлаган дор Оросын тусгай ангийнхантай 2001 он хүртэл тулалдсан гэсэн. Лалын хөлсний цэрэг болсон хүн чинь энэ дэлхийн хаа сайгүй мусульман шашинтануудыг дарлан зовоож байгаагийн эсрэг тэмцэлд оролцож явах ёстой юм байна л даа. Мөн тэр 2001 онд Испанид болсон Мавруудын террорист ажиллагаанд оролцсон гэдэг. Тэгээд тэндээсээ Тамилийн цэргүүдтэй хамт засгийн газрын цэрэг бүхий галт тэрэгний цувааг дэлбэлж, сүүлдээ бүр Угандад НүБ-ын цэнхэр дуулгатны эсрэг тулалдаж явсан байгаа юм. Тэр 2001 оны сүүлээр Афганд ирж Омарын хамт Талибаны хээрийн цэргийн отрядыг толгойлон АНУ-ын цэргүүдтэй тулалдсан гэдэг. Тэндээсээ хүчинд автагдаж Пакистан руу очсоныхоо дараа Кашмирын салан тусгаарлагч нартай нэг хэсэг орооцолдоод авсан гэсэн. Шинжан-Уйгарт хүртэл ирж ХАЧА-ын эсрэг террор зохион байгуулахад оролцож байсан гэж байгаа юм даа. 2002 оны эцсээр Пентагоны тусгай албанд Атрек буюу Энхтөгсийг эрэн сурвалжилж буй онц ноцтой алан хядагчдын нэрсийн жагсаалтын 69-т оруулсан гэсэн. Ойрхи Дорнод, Европ, бага азийг дамнасан асар том хар тамхины сүлжээ байдаг юм байна л даа. Сүүлд 2003 онд Загребт надтай уулзахдаа уг сүлжээний нэг хэсгийг

хянаж явсан юм гэнэ лээ.

**-Энхтөгс эх орноо санах ч юм уу, Монголдоо ирэх тухай ярьж байсан уу?**

-үгүй. Тэр өөрийнхөө хувь заяаг аллахтай холбогдсон гэж үздэг юм билээ. Тэгээд ч тэр үү “би лалын цэрэг хэвээрээ тулалдаж яваад л үхнэ. лалынхан эхлээд АНУ-ыг, дараа нь Хятадыг устгана” гэж ярьж байсан. Гантөмөр бид хоёрын сэтгэлд багтамгүй яриа ийнхүү өндөрлөсөн юм. Исламын хүчний бригадад ганц Энхтөгс ч биш өөр гурав дөрвөн Монгол хүн хөлсөөр тулалдаж яваа гэдгийг эцэст нь ахин дурдая.



## Бэлгийн гаж донтны шоронгоос бичсэн захидал

Энэхүү захидлын эзэн нь авдрантад ял эдэлж байгаа ажээ. Тэр хоёр ч удаа эмэгтэй хүнийг зэрлэгээр хүчиндсэний улмаас 18 жилийн ялтай нарсанд өдөр хоногийг өнгөрөөж байгаа юмсанж. Саяхан тэр найз бүсгүй Э-дээ нэгэн захидал бичсэнийг харгалзагч нар нь замаас нь авчихсан байна. Ингээд саваагүй хянагч нарын гар дамжин ноолорсон тэрхүү захиаг та бүхэнд сонирхуулья.

Эндэхийн байдлын тухай бараг бүгдийг нь бичлээ. Хэрвээ би сэтгэцийн өвчтэй байсан бол яалаа гэж энд суух билээ. Чи над руу бичсэн захидлаа хамгийн сүүлийнх нь гэсэн байна. Чиний сүүлийн захиа байж болно. Гэвч би бол чам руу бичсээр л байх болно. үүнийг хэн ч хорьж чадахгүй. Мөн өнөөдөр би хийсэн хэргээ детальчлан бичиж явуулахаар шийдлээ. Анхны хэргийг ч яахав. Би ганцаараа биш гурвуулаа үйлдсэнийг чи мэднэ. Харин Аагий, Баяраа муу хоёр новшийг би хаацайлаад өөрөө бүгдийг үүрч гарсан шүү дээ. Надад анх тэр хүүхнийг хүчиндье гэсэн санаа огт байгаагүй. Уг нь тэр муу хоёр новш л анх сэдсэн шүү дээ. Гэхдээ би урьд өмнө хүчиндүүлж буй хүүхэн амь авраарай гэж орилж, айж балмагдсандаа эсвэл дуугарч чадахгүй байдаг байх гэж төсөөлж байлаа. Гэтэл тэр хүүхний аймаар муухай газар хүчиндүүлж байсан ч айж жигшиж муухай чарлах нь бүү хэл харин ч бүр таатайяа гиншин орилж, жаргалтайгаар дур тавьж байсан юм. Энэ байдал миний сэрэл тачаалыг асааж тэр хоёрыг ажлаа дуусгаад явахад нь би ганцаараа үлдсэн. Магадгүй чи намайг сэтгэл мэдрэлийн хурц өвчтэй гэж хэлсэн чинь үнэн ч байж болох юм. Гэхдээ миний гаргасан гаж үйлдлүүдийг тэр хүүхэн өөрөө хүсээд байгаа юм шиг санагдсан юм шүү. өөрөө намайг улам хүчтэй эдлээд өгөөч, зовоогоод өгөөч гэх шиг санагдсан. Би нэг үе галзуу юм шиг дур тавин хүсэл ханасан боловч хүүхнийг зовоох хүсэл маань оргилсон хэвээр л байлаа. Ингээд нэг мэдэхэд би түүнийг хүлээд гартаа архины шил барьчихсан зогсож байсан. Тэгэхэд тэр хүүхэн яаж орилсон гэж санана. Одоо ч хүртэл орилох дуу нь чихэнд сонсогдсоор л байна. Тэр дууг сонсоод би биеэ барих ямар ч чадваргүй болж яг л рок сонсож байгаа юм шиг зөвхөн тэр дууг л сонсоод баймаар санагдсан. Нэг мэдэхэд баахан хүн гараад ирчихсэн, намайг цохиж унаган барьж хүлсэн. үүнээс хойш юу болсоныг чи мэднэ шүү дээ. Харин дараа нь шоронгоос оргож явахдаа яагаад хүүхэн хүчиндсэн бэ гэвэл байна шүү. Замд маань ойн цагдаагийн эзэнгүй байшин дотор самар түүж явсан тэр хүүхэн надтай учраагүй бол хэзээ ч баригдахгүй байсан. Хаа нэгтээ сэмээрхэн бүгчихсэн бол би ямар хүн алсан биш намайг тийм сүртэй эрж хайхгүй л байсан байх. Би одоо шоронд тэр бүхнийгээ эргэцүүлэн бодож суухдаа яагаад хүнээс гажууд төрсөнөө ухаарах гэж заримдаа оролдох боллоо. Тэрхүү анхны гэмт хэргээ үйлдэхээс өмнө би чамтай нэг удаа унтсаныг чи санаж байгаа биз дээ. Тэгэхэд хоёулаа жаргалтай сайхан байсан ч надад нэг юм дутагдаад байсан. Юу болохыг би одоо ч мэдэхгүй л байна. Чиний хоёр гарыг орны толгойноос барьж хүлмээр, чамайг өөрийн дураар эзэмдмээр, өөрийн дураар эзэмдэнэ гэдэг нь хүлж баглахыг хэлдэг ч юм шиг. Жинхэнэ дур хүслийг гүйцэд хангахын тулд ямар нэгэн өвдөлт хэрэгтэй юм шиг санагдаж байсан. Тэгэхдээ би чиний гуянд хумсаа шигтгээд чамайг орилуулж тэр орилох дууг чинь сонссоны дараа л сая жинхэнэ хүсэл оргилж дур тавьсанаа тэр үед чамд хэлээгүй юм. Гэхдээ би чамаас хойш тэр бузар хэргийг хийтлээ өөр ямар ч эмэгтэй хүнтэй хавьтаагүй юм шүү. Бузар хэрэг гэж өөрийнхөө үйлдсэн хэргийг яагаад нэрлэв. Одоо буруугаа ойлгон гэмшиж, засрах нь гэж чи бодож байж магадгүй. Яг нарийндаа бол тийм биш. Гаж зэрлэгээр үйлдсэн хүчингийн гэмт хэргийг манай өнөөгийн

нийгэмд бузар гэж нэрлэдэг шүү дээ. Би тэр дагуу л ингэж нэрлэж байгаа юм. Шоронгоос оргосны гурав дахь оройгоо би тэр нэгэн байшинд хоноё гэж шийдээгүй бол магадгүй чамтай уулзаж, өөрийнхөө юунд ч баригдахгүй хүсэл шуналын дагуу чамайг ч гэсэн зовоож тарчлаан байж эзэмдэж байх байсан биз. Тэр шөнө бороо орж магадгүй байсан учир би байшинд хоночихоод өглөө эрт гаръя гэж бодсон юм. Байшин гэх нэрнээс цаашгүй тэр муу амбаар дотор олигтойхон наар ч байгаагүй. Би нэг буланд нь эвхрэн хэвгээд яг унтах гэж байтал самар түүж яваад төөрсөн нэг хүүхэн хүрч ирсэн юм. Би ч бас адилхан төөрсөн самарчин болж жүжиглээд их л аятайхан танилцаж сүүлдээ хоёулаа эв зүйгээр нэг нэгнээ тэврээд унтахаар болсон юм. Би худлаа хэлээгүй юм шүү. Эзэнгүй хоосон байшинд уулын мухарт таарсан тэр бүсгүйг би хүчиндээд яахав. Мэдээж хүүхэн дургүйцэж барина гэж байхгүй шүү дээ. Гэвч би улангасан тачаалаа барьж дийлэхгүй хөөрхий бүсгүйг хэтэрхий зовоосон байна лээ. Тэр бүрийг нэг бүрчлэн тоочоод яахав. өглөөгүүр нөгөө хүүхэн чинь надаас айж, бараг зугтаад явчихсан. Би шөнөжингөө түүнийг талхилж, элдэв янзаар зовоож хоносон болохоор жаахан унтаад босъё гэж бодсон юм. Гэтэл хүүхнийг байшингаас холдож амжаагүй байтал галынх нь хүмүүс хайгаад олж авсан гэсэн. Тэгээд буцаад над дээр дагуулж ирсэнээр би баригдсан юм. Тэр хүүхэн эхлээд маш их сэтгэл ханамжийг надаас амсаж байсныг би санаж байна. Гэтэл сүүлдээ сэтгэл ханамж нь эцэстээ хүрч дур хүсэл нь шавхагдчихсан байхад нь би эсрэгээр нь улам ч аймшигтайгаар хүчирхийлсэн гэж уйлж байсан. Би тэр тухай сонсоод их гайхсан. надад бол тийм зүй бусын юм болоогүй юм шиг л санагдаж байсан. Тиймээс би ер нь хүн биш юм болов уу гэж нэг үе бодлоо. Гэтэл надаас илүү гаж донтой нэгэн залуу бас энэ шоронд байдаг юм. Тэр залуу миний зовлонгоос хуваалцаж чамд энэ захидлыг бичих санааг хэлж зөвлөж тусалсан юм шүү.

жич: энэхүү үл ойлгогдох захидлыг уншсан нэгэн сэтгэл судлаач жинхэнэ цэвэр гаж донтон “садист” хүн байна хэмээн тодорхойлсон билээ. Манай нийгэмд оршиж байгаа олон мянган бузар нүгэлтэй этгээдүүдийн нэгнийх нь нууцыг сөхөхөд ийм байна.

## Гарамгай баатар Л.Дандар цаазын ялтай байхдаа

### Туул голд салаар мод татаж яваад даруулж үхэх дөхжээ

Хэдхэн жилийн өмнө Дандар баатарыг мэдэхгүй хүмүүс ховор байлаа. Харин одоо бол түүнийг мэдэхгүй хүүхдүүд олон болжээ. Ерээд оноос хойш төрсөн хүүхдүүд Дандараас илүү Рембо, Супермен, Бетменийг мэддэг болж. Тэгвэл нэгэн цагт Монгол улсынхаа төлөө ардын самурай нарын гавлыг ган сэлмийн ирээр ярж явсан гарамгай баатар Дандарыг нэхэн дурсахад илүүдэхгүй болов уу. «Дандар баатар дайраад ирлээ. Дайсны цэргүүд зугтаад одлоо» гэж дал, наяд оны хүүхдүүд дуулдаг байв. Нэгэн ёж шүлэгч энэ хүний нэрийг оруулсан дөрвөн мөрт уншаад улсынхаа хамгийн тэргүүн найрагчид олгодог «болор цом»-ыг гардан авч байсан нь саяхан. БНМАУ-ын гарамгай баатар Лодонгийн Дандар 1914 онд Булган аймгийн Бүрэгхангай сумын Рашаант гэдэг газар төржээ. 1935 онд ардын цэргийн албанд татагдаж Улаанбаатар хотын харуулын суманд дөрвөн сар алба хааж байтал нь ЗХУ-ын морин цэргийн дунд сургуульд явуулжээ. С.М.Будёныйн нэрэмжит тэрхүү сургуулийг дэслэгч цолтой төгсөн ирсэн Дандар 1938 онд Матадын хадан хөв дэхь 8-р дивизийн 22-р морьт хорооны байлдааны даргаар томилогдон очсон аж. Тэгснээ удалгүй 1939 оны дөрөвдүгээр сард Тансагбулагт төвлөсөн 6-р морьт дивизийн 17-р хорооны даргаар дэвшин очжээ. Түүний хороо БНМАУ-ын хилийг зөрчсөн япончуудад анхны цохилтыг өгч байсан бөгөөд байлдааны хамгийн хүнд хэцүү даалгаварыг биелүүлдэг байсан учир тэдний дивизийг Баянцагааны тулалдааны дараа ард түмэн бахдан ярих болсон юм. Нээрээ ч Дандар баатрын “ялагдашгүй” дивиз амьд хэл олохоор улаан гараараа япончуудтай ноцолдож, тэр өөрөө халх голын фронт дээр улаан тугийн одонгоор хоёр удаа шагнуулан “баатар” гэж алдаршиж байсан юм. 1939 оны 9-р сарын 7-нд Дандарт БНМАУ-ын баатар цол олгосон бөгөөд тэр дайны дараа фрунзийн академид суралцахаар явсан билээ. Гэвч тэр академид төгсөж ирээд 8-р дивизийн захирагчаар томилогдон хурандаа цолтой ажиллаж байхдаа “сахилгагүйтсэний” харгайгаар цолныхоо нэг мөнгөн өлзийг мултлуулаад хороон дарга болсон аж. Улсын гарамгай баатар, улаан тугийн хоёр удаагийн одонтой, хурандаа цолтой Дандар хэрхэн яаж сахилгагүйтсэн талаар олон янзын хувилбар яриа бий. үүнээс хамгийн сонирхолтойг нь сонирхуулбал Дандар баатар маань Монголд ажиллаж байсан зөвлөлтийн мэргэжилтэн, эмч Галина гэгч хүүхэнд сэтгэл алдарч дурлажээ. Тэгээд сэтгэлээ барьж дийлэлгүй нөгөө хүүхнээ ажил дээрээс нь хүчээр хулгайлан гэртээ аваачжээ. Тэр хооронд зөвлөлтийн мэргэжилтэнүүд нөгөө эмчээ эрж хайгаад япончууд хулгайлаад явчихлаа хэмээн бөөн эрэл сурал болсон аж. Хүүхэн Дандарын тавьсан саналыг эрс няцааж явах гэсэн боловч ааг хүчиндээ эрдсэн баатар маань хүч хэрэглэн “янзалж” өөрийн болгосон гэдэг. Гэвч Оросын комиссарууд өрлөг жанжин Чойбалсангийн ганц хайртай цэргийн дарга, Монголчуудын бахархал болсон хүнийг яаж ч чадсангүй. Цолных нь нэг мөнгөн өлзийг мулт татан баруун хязгаар луу хороон захирагчаар цөлүүлээд л орхисон гэдэг. Харин яг энэ үед 1942 оны орчим хэлмэгдсэн улсын баатар хорооны захирагчийг япончууд сонирхож байсан тухай тагнуулын нууц мэдээлэл хожим нь НАХЯ-ны архиваас гарч ирж байсан нь сонирхолтой. 1945 оны чөлөөлөх дайнд Дандар баатар 5-р дивизийн 13-р морьт хороон даргаар оролцож, түмэн газрын цагаан хэрмийг давалцаж, энгэртээ “алтан гадас” ЗХУ-ын байлдааны гавьяаны улаан тугийн одонтой буцаж ирсэн юм. Гэвч ирсэн даруйдаа бас л “сахилгагүйтэж” цаазын ял цэргийн шүүхээс сонссон боловч өрлөг жанжин маршал Чойбалсан наагуур цаагуур гүйсний эцэст 15 жилийн ял

сонссон түүхтэй. Энэ “сахилгагүйтлийн” талаар энгийн олон дунд бас л домог болон тархсан нэг яриа бий. үүнийг сонирхуулбал: зөвлөлт, монголын дарга нар ялалтын баяраа тэмдэглэж зад наргиж байжээ. Энэхүү найран дээр Дандар баатар ЗХУ-ын хошой баатар, хурандаа цолтой нэгэн эрхэмтэй юунаас ч болсон юм маргалдсан аж. Маргаан нэлээн хурцдаад ирмэгц ЗХУ-ын хошой баатар ташаан дахь гар буугаа гэрнээс нь суга татан гаргаад иржээ. Дандар баатар ч адилхан буугаа суга татаад урдаас нь онилж л дээ. Энэ үед нэлээн дээгүүр тушаалын хүмүүс тэр хоёрын дундуур орж элдвээр ятган хориглосон байна. Тэгэхэд ЗХУ-ыш баатар шал руу нулимаж амандаа баахан хараал тавиад гар буугаа буцаан хийжээ. Харин Дандар буулгасангүй. “Оросын баатар гараа буцаадаг бол. Монголын баатар буцаадаггүй юм” гэж хэлээд гохоо дарж орхитол сум нөгөө даргын яг зүрхэнд тусч газар дээрээ амь насаа алджээ. Ингээд байлдааны цагийн хуулиар Дандар баатрыг хээрийн цэргийн онц шүүхэд шууд шилжүүлэн өгч цаадуул нь буудан хороох зарлиг гаргасан аж хэрвээ Чойбалсан гуйгаагүй бол иргэний дайныхаа баатруудыг жагсаалаар нь алж байсан Оросын хээрийн онцгой шүүх өршөөхгүй байсан нь лавгай. Ингээд Дандар баатар хороогдох хүнд ялтануудын тоонд орж туул голоор нийслэл рүү сал модоор гуалин цагаалах хунд ажилд оногджээ. Салын урт нь 20 метр өргөн нь 5 метр байсан гэдэг. Мөн дээр нь овоолсон модоо дийлэхгүй сал нь эрэг рүү цохин мөргөж, түрж явсан хоригдолуудаа цөмийг нь алах удаа ч цөөнгүй гарч байжээ. Нэг удаа голын хүчтэй ширүүн урсгалтай газар салаар мод түрж явсан 40 гаруй хоригдол модонд цохиулан үхсэнээс хоёрхон хүн золоор амьд үлсэний нэг нь Дандар, нөгөө нь зохиолч Ням-Осор байсан гэдэг. Гэвч цэргийн эрдэмд нэвтэрхий суралцсан улсын гарамгай баатраар усанд салаар мод түрүүлээд байхыг маршал хүссэнгүй. Тиймээс Османы дээрэмчдийн эсрэг, баруун хилийн цаана гарч зарим нэг урван тэрслэгчдийг баривчлах тусгай ажилд томилон явуулжээ. Л.Дандар нь энэ мэтээр дотоод яамнаас даалгасан хэд хэдэн үүргийг амжилттай биелүүлсэн учир 1951 онд хугацаанаасаа өмнө ялыг нь тэнсэн сулласан гэдэг. Гэвч Дандар баатраар ял эдэлж байсан болон хэрэг үйлдсэн талаар үнэн мөнөөр нь ярьж болохгүй. Хэрвээ тийм тохиолдол гарвал амь насаараа төлнө гэсэн гэрээ маягийн бичиг хийлгэж аваад хаа байсан Чойбалсан хот руу галын аюулаас хамгаалах байгууллагад цэргээр томилон нэг ёсондоо нутаг заан хөөсөн байна. үүнээс хойш хэсэг хугацаанд улсын гарамгай, сум даадаггүй баатар маань авто баазын хэлмэрч, авто баазын даргын ажил хийж байснаа, гэнэтхэн жолооч больё гэж шийдээд бэрхийн уурхайд ирж жолооч болжээ. Уурхайн жонш хоёр жил зөөх хугацаандаа төлөвлөгөө нормоо байнга биелүүлж явсан учир баазын тэргүүний жолооч болж удалгүй халх голын ялалтын 20 жилийн ойгоор тушаал дэвшиж Дорнод аймгийн авто засварын баазын дарга болж “Байлдааны гавьяаны улаан туг”-ийн одонгоор гурав дахь удаагаа энгэрээ цоолуулсан аж. Түүний эхнэр Юндэн гэдэг шаавайхан бүсгүй тэр үед аймгийн эмнэлэгт ажиллаж байсан гэдэг. үнэхээр ард түмний дунд домог болон мөнхөрсөн энэхүү хөлөг сайн эрийн талаар үнэн бодит амьдралыг нь харуулсан түүхэн кино гараасай гэж залбираад энэхүү дурсамжийг өндөрлөе.

## Тууварчдын ангууч эрийн нүгэл нүдээрээ гарч төрсөн хүүгээ хөнөөсөн түүх

Энэхүү гунигт явдал одоогоос арваад жилийн өмнө Завхан аймгаас Улаанбаатар хот руу мал тууж явсан тууварчин гэр бүлд тохиолджээ. Нийт замынхаа хагасыг туулаад өвөрхангайн Баян-өндөр сум хавьцаа буудалд аж. өвс ургамал тэгш сайхан газарт хэд хоног тууврын үхрээ бэлчээрлүүлэхээр шийдсэн Цэрэнтогтох нэг орой үхрийнх нь хагас хаана ч юм тасарч үлдсэнийг анзаарчээ. Ингээд хүүтэйгээ үхрээ хайн олохоор морджээ. үдшийн харуй бүрий нөмрөх үед мөнөөх тасарч үлдсэн хэдэн үхрээ ч олж, хүү нь ойролцоох уснаас морьдоо услахаар явж. Цэрэнтогтох үхрээ хараад хоцорчээ. Төдөлгүй хүү хоёр морио усалчихаад эргэн ирж явтал аав нь нэгэн үл таних хүнтэй ноцолдоод байгаа харагджээ. Гайхсан хүү сайн анзааран хартал бөх баймаар нэг булиа залуу аавыг нь унагачихсан багалзуурыг нь шахаад байжээ. Самданхорол хүү дөнгөж 13 настай жаахан байсан тул энэ байдлыг хараад айсандаа хөтөлж явсан морио хаячихаад ум хумгүй зугтан давхижээ. Нэг мэдсэн чинь хонхордуу газар бараадан буусан ганц гэр айл тааралдаж. Орвол хоёр жаахан эрэгтэй хүүхэдтэй нэг эмэгтэй байжээ. Самданхорол болсон явдлыг нэгд нэггүй ярьтал мөнөөх эмэгтэй «дүү минь шөнө болсон хойно одоо яагаад ч нэмэргүй. Уг нь манай нутагт ийм муухай явдал гардаггүй л юмсан. Яадаг ч байсан чи манайд хоно. Маргааш учрыг нь хоёулаа явж олъё» гэж ятгасаар хоол унд өгч унтуулжээ. Унтуулахдаа түүнийг шөнө босоод явчихаж магадгүй гэж бодоод хоёр хүүхдийнхээ дундуур хэвгүүлж л дээ. Мөн морийг нь өөрөө аргамжиж, эмээл хазаарыг нь гэрийнхээ гадаа тавьжээ. Аавыгаа яасан бол гэхээс санаа нь зовж түгшсэн хүү унтаж чадахгүй хэвтэж байтал морин төвөргөөн сонсогдож гадаа шон дээр хүн буух шиг болжээ. Удалгүй гэрт хүн орж ирж «баларсаан, хэдэн тарган үхэртай тууварчинг цааш нь харуулаад, харин хамт явсан чацгыг ий алдчихлаа. Тэр л гай тарих нь дээ» гэсэн эр хүний дуу гарчээ. Хүү ч унтчихсан дүр үзүүлж хэвтээд л байж. Гэтэл эмэгтэй «тэр хүү чинь энд унтаж байгаа. Хоёр хүүхдийн дундуур. шөнө дунд бөх нойрссон үед аваад гараарай» хэмээн шивнэх нь сонсогджээ. Хэрэг биш болж байгааг ойлгосон Самданхорол хүү эр эм хоёрыг унтсан бололтой хурхирч эхлүүт сэмээрхэн босч хоёр хүүхдийнх нь захаар ороод хэвгжээ. Тэгтэл шөнө дундаас хойхно эр эм хоёр босч дундуур нь унтаж байсан өөрийнхөө хүүг аваад гэрээс гарчээ. Тэгээд тэд гэрийнхээ урдхан байх жижиг толгойг даваад явчихаж. Тэгмэгц Самданхорол гэрээс гарч аргамжаатай морио зайдан чигээр нь унаад харсан зүгтээ давхижээ. Ингээд үүр цайхын алдад нэг айлд ирж л дээ. Мэдээж болсон явдлыг цөмийг нь ярьснаар гэрийн эзэн Баян-өндөр сум руу мэдэгдэж тууварчдын ангуучныг баривчилжээ. Тууварчдыг ангуучилж малаас нь сум аймаг дамжуулан худалдаж ашиг олж гаршсан эрийн хар түүх үүгээр цэг болжээ. Нүтэл нь нүдээрээ гарна гэдэг шиг эр эм хоёр гэрийнхээ урд толгойн цаана төрсөн хүүгээ боомилж алсан байжээ. Цовоо хүү Самданхорол ингэж өөрийгөө ч, цаашид түүгээр явах тууварчдыг ч аварч чадсан байна.

## Оргодол эрийн паян

Шоронгоос оргосон хүнийг хулгай, дээрэм хүчин, хүн амины гэмт хэргүүд даган явдаг гэсэн утгатай үг бий. 70-аад оны үеийн цагдаа нар гаргасан үг л дээ. Ерөнхийдөө ортой голоор нь хэлчихсэн зүйл. Гэхдээ оргодол бүхэн хүн алж дээрэм хийгээд явахгүй. үүний тод жишээ нь амьдрал нь кино болчихсон уулын төмөр байна. Доор дурдах явдал ч бас кино болгочихоор нэгэн оргодолын хувь заяатай холбоотой юм. Баянбат хэмээх залуу 16 настайдаа эмнэг сургалтын улсын аварга болж байжээ. Адуу малд эртэй, уурга татан баривал урдуураа ямар ч адгуусыг гаргадаггүй тэрбээр цэргээс халагдаж ирсэнийхээ дараахан малын хулгайч болжээ. Түүнийг одоо ч Хан Хэнтийн ой хөвчид бүгэж, ан гөрөөсөөр амьдралаа залгуулж явдаг, заримдаа оросын хилтэй залгасан хөвчөөр дамжаад Чита хүртэл тэнэж явдаг гэсэн домог яриа ч бий. Гэхдээ нутгийн улс түүнийг хоёр жилдээ нэг л олж хардаг гэнэ. Баянбат Хэрлэн Баян Улаанаас 20 үхэр нийсэл хот руу хулгайлж тууж авчирал баригдсан гэдэг. Энэ явдал 1994 онд болжээ. Малын хулгайн хэргийн хууль ид чангарч байсан үе. Мань эр зургаан жил чанга дэглэмтэй шоронд ял эдлэхээр шийтгэгдэн Зүүнхараад очмогцоо ердөө л ганц сар болоод оргосон байна. Ингээд л Хан Хэнтийн их хөвчийг бараадан жинхэнэ орчин үеийн шилийн сайн эр болж. Гэхдээ амьтны адуу мал хулгайлахаа болиод зөвхөн ан гөрөөсөөр хөөцөлддөг болсон байна. Нутгийнхаа хэд хэдэн найдвартай айлуудад хааяа ирж хонохдоо ангийн үс, баавгайн доньд, бугын чив авчирч цаадуул нь борлуулж өгөөд хэрэгтэй зүйлээр нь хангадаг байжээ. 1997 оны үед Баянхудагт уулын энгэрт өвөлжиж байсан Эрдэнэбат гэгчийнд ирж хонохдоо Баянбат 500 сумтай ТОЗ-8 винтов, тайрсан хоёр амтай шувууны буу, тохой хэрийн урт хутгаар зэвсэглэсэн явсан гэдэг. Тэгээд нутгийн улстай хөөрөг зөрүүлэх зуураа «Баян хангайгаа түшээд Баянбат хүү алзахгүй явна. Саяхан хоёр баавгайн арьс борлуулж хэрэгтэй зүйлээ аваад хэдэн төгрөгтэй болсон юм. Надад ямар мөнгөний хэрэг нэг их гарах биш та нар хэрэглэж байгаад сүүлд нь буцаагаад өгчихнө биз. Аяндаа надад ямар нэгэн юмны хэрэг гарвал би өөрөө та нарыг гуйгаад л ирнэ» гэж хэлээд гэрийн эздэд 200 мянган төгрөг бэлнээр нь тоолж өгсөн гэдэг. Түүнийг Хан Хэнтийн хөвчид гурван агуй, нэг том дүнзэн байшин эзэгнэн амьдардаг гэж ярилцдаг боловч хаана яг ямар газар шивээлдэгээ хэнд ч зааж өгдөггүй ажээ. Эдүгээ дөч гарч яваа авдар шиг дөрвөлжин цээжтэй, тайгад амьдарсаар яваад өлчир чийрэг нь элдсэн сур шиг болсон энэ хүдэр эрийг Хэнтий ханы лус савдагтай нөхцсөн, тиймээс одоо хуртэл гон бие гозон толгой тэнэж яваа юм. Тиймгүй бол эм хүний хэрэг гаралгүй яахав хэмээн хүүхнүүд цуурдаг байна. Хааяа нэг уулнаас бууж ирээд айлд хонож өнжихдөө өөртөө тохиолдсон сонин хачныг үүр цайтал хуучилж амыг нь ангайлан шүлсийг нь савируулж орхидог байна. Түүний яриаг сонссон жаахан хүүхдүүд Баянбат шиг ууланд оргож хээрээр гэр хэцээр дэр хангайгаар хань, хадаар орд хийж амьдрахсан хэмээн мөрөөддөг ажээ. Түүний яриа яг л үлгэр домог шиг. Оросын хил рүү нэвтэрч ороод амар мөрний шугуйг даган явсаар Уссурын бар гэгч амьтаныг авлаж, арьсыг нь Читагийн буриадуудад зарсан тухай ярихад хүмүүс итгэж үл чадна. Гэвч түүний хүзүүнд барын хумс, монголд огт байдаггүй далайн нохой гээч амьтаны соёо /үүнийгээ тундрийн нэг цаатнаас авсан гэдэг аж/ зүүлттэй байдаг ажээ. Нэг удаа мөнгөн морьтын Гэндэн хэмээх айлд гучин хэрэмний арьс, 10 минж, 12 бугын арьс авчирч өгөөд хонохдоо маш сонин зүйлийг ярьсан гэдэг. Шоронгоос оргож ууланд гарсаны хоёр дахь жилд нь юмсанжээ. Хэнтийн их хөвчийн аглагаар ороо нь орсон бугын зуулт солгой өвсийг газар унамагц нь авахаар шийдэж мөрөөр нь мөшгиж явсан байна. Маш хурц эхүүн үнэртэй мушгирсан сул өвсийг бугын амнаас газар

мултран унамагц дээр үеийн анчид мөрөөр нь мөшгөсөөр олж аваад урьд хөрш рүү асар өндөр үнээр зардаг байсан аж. Баянбат ингэж явсаар хэвтсэн бугын ойролцоо хонохоор эвтэйхэн газар хайж явтал хадан дунд доошоо орчихсон баавгайн ичээ шиг газар олж авчээ. Баянбат буугаа бэлэн барьсаар доошоо буувал дотроо том гэрийн буурийн дайтай хүнхийсэн том адартай агуй байжээ. Тэр өвөртөө бэлэн авч явсан лаагаа асаан гийгүүлтэл хананд нь модон хаалга байгаа харагджээ. Ямар ч байсан эртний сайн эрийн бүгж байсан газар луу орчихлоо гэдгээ мэдэрсэн байна. Хаалгыг нь маш болгоомжтой доошоо тонгойж байгаад онгойлготол хоёрын хоёр хурц үзүүртэй сум мулт үсрэн нисч ирээд арынх нь хананд зоогдсон байгаа юм. Баянбат дээр үеийн сайн эрчүүд орон байрныхаа үүд хаалганд нууц оньс, сааль сум тавьдагийг хүнээс дуулсан байж л дээ. Игнээд лаагаа барьсаар босгыг нь даван ортол ердөө нэг том танхим руу яваад орчих шиг болсон байна. Харанхуй чийг даасан тэрхүү том өрөөний голд тавьсан ширээн дээр хориод оны үеийн хүрээний баячуудын асаадаг аяга шиг том лаанууд өрөөтэй харагджээ. Тэр бүх лааг асаамагц танхим шиг том агуйн дотор тал гэрэлтээд ирж гэнэ. Уг шуйд гурван том авдар, дээр үеийн хийцтэй модон ор, бас болоогүйээ Оросын цагаан хааны үеийн босоо тольтой ширээ, хананд нь баахан ирвэсний арьс дэлгээд хадчихсан, нэг мухарт нь жижигхэн тулга байгаа нь харагджээ. Бурхан шүтээн гэх зүйл байсангүй. Харин орны дээд талынх нь хананд цул мөнгөн бөгжтөй хоёр баримын бүдүүн тэнзэн ташуур өлгөсөн байж. Баянбат тэр ташуураас адис аваад өрөөн доторхи зүйлийг уудлан нэгжиж эхэлсэн гэдэг. Нэг том модон авдарт нь модон хуйтай 12 үсэрдэг маузер буу 300 орчим сумтай, нэг карбин 1200 сумтай, амаар нь сүмбэдэж бууддаг цахиур буу ууттай хорголжин сумтайгаа, далхийн 1-р дайны үеийн орос винтов жадны хамт 500 сумтай, гурван том сэлэм, янз бүрийн шигтгээ ур хийцтэй 12 хутга байсан аж. Хоёр дахь модон хайрцагыг онгойлговол торгонд ороосон баахан түвд, хуучин монголоор бичсэн ном судар байжээ. Гурав дахь хайрцагыг уудалбал хорхолж авсан чулуу шиг энд тэндээ аргар баргар өнцөгтэй арвын бидоны хэмжээтэй цул алт байсан аж. Энэ яриаг сонсож суусан улс Баянбатаас «та тэр алтаа хэдий хэрийн үнэ хүргэж зарсан бэ» гэж шууд асуусан гэдэг. Тэгэхэд нь тэр «би зараагүй ээ. тэр бол агуйн өөрийнх нь баялаг» гэж хариулсан байна. «Одоо та тэр газраа байнга амьдардаг уу» гэж асуухад «хэн гэж сайн эр амьдарч байсныг би мэдэхгүй. одоо тэнд байнга очдоггүй ч гэсэн хааяа эргэж тойрч гал түлж чийгийг нь хөөдөг юм. Надад тэндээс авсан ганц зүйл гэвэл сэлэм л байна даа, Би өөрийн гэсэн амьдрах оромжтой учир тэр газрыг зөвхөн шүтээн маягаар харж хамгаалдаг» гэж хариулсан байна. Энэ яриаг сонсож суусан хүмүүс чихэндээ төдий л итгээгүй гэдэг. Уул хаданд ганцаараа тэнэж явдаг хүн уйдаад янз бүрийн юм зохиож ярьсан ч юм бил үү хэн мэдлээ. Уншсан таньд ч гэсэн ингэж санагдаж байгаа биз дээ.

## Шоронгийн дуу дуулсанаас болж нүсэр зодоон болжээ

Ховд аймгийн харъяат Гандиймаа, Бадамсүрэн гэгч дөч орчим насны хоёр хүүхэн хар багын найзууд юмсанж. Гэвч Бадамсүрэн нь 1998 онд хулгай, залилангийн хэрэгт холбогдож долоон жилийн ял авчээ. Ингээд 2006 оны намар суллагдаад долоон жил уулзаагүй хоёр хүүхдийнхээ барааг харахаар шууд л нутаг руугаа явахаар шийджээ. Мань хүүхэн шоронд ял эдэлж байхдаа удирдлагаасаа даатгаж өгсөн ажилд ихээхэн хүчин чармайлт гаргасан тул дансандаа зуу гаруй мянган төгрөгтэй болсон байна. Тэгээд энэ мөнгөө огт үрэлгүй байсаар шоронгоос суллагдахдаа аваад гарчээ. Мань хүүхэн долоон жил уулзаагүй хоёр хүүхэддээ юм авч очих гэж л энэ мөнгийг хадгалсан бололтой. Ингээд тэр хоёр хүүхэддээ жаал жуул юм авахаар «нарантуул» захыг зорьжээ. Тэгтэл тэнд багын найз Гавдиймаатайгаа тааралдсан байна. Арав гаруй жил уулзалдаагүй мань хоёр тэврэлдэн уулзаж бөөн баяр хөөр бололгүй хаачихав. Энэ үед Гандиймаа «за, найзыгаа уучлаарай. Чамайг эвгүй газар хоригдсон гэдгийг би дуулсан. Гэвч эргэж тойрч үнэндээ чадсангүй. Яагаад гэвэл найз нь солонгост таван жил болоод саяхан ирсэн л дээ. Хэрвээ энд байсан бол чамайг эргэлгүй яахав дээ» гэхэд цаадах нь «зүгээр, зүгээр. найз нь харин сайн хүмүүсийн дэмжлэгээр шоронд нэг их ядарч зүдэрсэнгүй. Маргаашнаас нутаг руугаа явах санаатай байна. Тэгээд хоёр хүүхэддээ жаал зугаа юм авах гээд явж байна» гэж учирлажээ. Тэгтэл Гандиймаа «хоёулаа манайд очиж жаахан хууч хөөрье л дөө. Найз нь нөхрөөсөө салаад гурван жил болж байна. Чи манайд хоёр гурав хоносон ч яадаг юм бэ. Тэртэй тэргүй суллагдсан л юм чинь хүүхдүүд дээрээ хэзээ ч очсон яадаг юм бэ. Тиймээс хүүхдүүдийнхээ юмыг заавал одоо авах гээд яахав. Манай найз нар урдаас бараа оруулж ирдэг юм. Би тэднээс хямдхан бараа аваад өгье. Одоо хоёулаа манайд очье» гээд түүнийг шавдуулж гарчээ. Бадамсүрэн түүний үгэнд ороод гэрт нь очсон байна. Гандиймаа багын найздаа ёстой л гараа гарган хоол хийж өгчээ. Төдөлгүй нэг шил архи гаргаж задлаад багын найзтайгаа өдөржин хуучилжээ. Харин оройхон хирд Гандиймаа руу найз хүүхэн нь утасдсан байна. Тэр найзтайгаа ярьсаны дараа Бадамсүрэнд хандаж «манай найз хүүхэн намайг хүрээд ир гээд болдоггүй. Төрсөн өдөр нь болж байгаа юм байх. Ерөөсөө хоёулаа хамт очье. Найз маань хувийн дэлгүүртэй, амьдрал нь цэгцэрчихсэн, архи уучихдаг, тамхи татчихдаг, ер нь л яавал яачихдаг танхай хүүхэн байгаа юм. Гэхдээ чи айж эмээсний хэрэггүй. Танхай гэдгийг би арай өөр утгаар хэлж байгаа юм шүү. Наргиж цэнгэх дуртай л хүүхэн байхгүй юу. за хувцсаа өмс» гэж шавдуулсан байна. Шоронд долоон жил хүний эрхэнд байсан Бадамсүрэн дахиад л хүний эрхэнд орчихсон бололтой. Гэхдээ Гандиймаа түүнийг ашиглах гэсэндээ биш шоронгоос дөнгөж суллагдсан болохоор нь жаахан баяр цэнгэл амсуулья гэж бодож л дээ. Тийм ч учраас түүнээс мөнгө төгрөг, элдэв юм шаналгасангүй. Харин ч бүр хуучин муу хувцсыг нь тайлж хаяулаад өөрийнхөө өнгөтэй өөдтэй хувцаснаас өмсүүлжээ. Ингээд мань хоёр Гандиймаагийн найз Чука гэгчийнд очсон байна. Чука мөн л нөхөр сүүдэргүй бөгөөд аливаа хүнийг ихээхэн голж шилдэг, зөвхөн таалагдсан эрчүүлтэйгээ л учир ургуулдаг, ёстой л өөрийнхөө эрхээр жаргаж яваа баян тарган хүүхэн юмсанж. Чука мань хоёрыг угтаж авахдаа нэлээд боловсон байрын залуу хажуудаа суулгачихсан, архи дарс, идээ будаа сөгнүүлчихсэн байж. Тэгээд дахиад нэг найз руугаа утасдаж «Чи яагаад удаад байна аа. Бадамсүрэн хүрээд ирлээ. хурдлаач дээ» гэж шавдуулжээ. Төдөлгүй Мөнхцэцэг гэгч найз хүүхэн нь нэг залуу дагуулаад орж иржээ. Ингээд дөрвөн хүүхэн, хоёр залуу нийлсэн нүсэр архидалт эхэлсэн байна. Чука энэ үед та нартай ойрд уулзсангүй, ойрд архи уусангүй. Тэгээд л төрсөн өдрөөрөө далимдуулан ууж байгаа нь энэ»



гээд өөрөө ч архи цөлөөд, бусдыгаа ч архиар шахаад байж. Тиймээс тэд нэг их удалгүй бүгд л халамцаад иржээ. Энэ үед эхнээсээ дуу дуулахаар болсон байна. Тэгээд Гадиймаагаас эхлээд дуу дуулсаар бангаад Бадамсүрэн дээр иржээ. Долоон жил шоронд суусан Бадамсүрэн архинд халаад, бас гэнэт наргиж цэнгэж байгаа болохоор сэтгэлд нь баяр гуниг давхцаад нэгл хачин болчихож. Гэхдээ гунигийн сэтгэл нь давамгайлж байсан тул тэрбээр

«Эх орон минь түлхээгүй

Эцгийн ухаан дутаагүй

Эхийн энэрэл дундраагүй

Энхрий хань минь адлаагүй

өдөр шөнө шиг хорвоогийн

өнгө мөнгөнд хууртаад

Сархад самуунд халуурч

Сайхан амьдралаас хадуурлаа” гээд л луусангийн шоронгийн оройн тоон дээр нийтээрээ дуулдаг байсан харууслын дуугаа уянгалуулж гарчээ. Тэгтэл нэлээд халамцсан Чука «танай энэ хүн чинь одоо огт дуулж сонсоогүй ямар юмаа дуулаад байгаа юм бэ» гээд Гандиймаа руу ширүүн харц чулуудсан байна. Ер ив Чука согтохоороо нэлээд агсам зантай юмсанж. үүнийг нь хэзээнээс мэдэх Гандиймаа аль болох тайвшруулах аядаж “за уучлаарай. манай энэ найз хүүхэн саяхан эмэгтэйчүүдийн шоронгоос суллагдсан юм. Тэгээд яахав зайлуул жаахан гуниж гутраад л шоронгийн дуу аялчих шиг боллоо” гэж учирлажээ. Шоронгоос суллагдсан гэнгүүт л тэнд байсан хүмүүсийн харц Бадамсүрэн дээр төвлөрсөн байна. Чука хамгийн түрүүнд ам нээж “энэ хүүхэн чинь тэгээд ямар хэргээр шоронд орсон юм бэ” гэхэд Гандиймаа “за тэр нь ямар хамаатай юм бэ. Яахав зайлуул алдаж эндээ л биз. Хэн ч алдаж энддэг юм. бусдын хэрэгт битгий хөндлөнгөөс оролцож байгаач дээ” гэж уурлах аяджээ. Гэтэл энэ үг агсам зантай Чукагийн гэдэнг улам хөдөлгөж орхисон байна. Түүний нүд ам нь эргэлдэж хачин болсоноо “Ямар хэргээр шоронд орсонг нь би заавал мэдмээр байна. Алив чи өөрөө хэлээтэх. Хэрэг хийж болсон юм чинь хэлж яагаад болдоггүй юм бэ” гээд л Бадамсүрэн рүү агсарч гарчээ. Бадамсүрэн нэг хэсэгтээ шоконд орсон боловч агсам зантай Чукагийн дарамтаас гарахын тулд “би хулгайн хэргээр шоронд орсон юм. Одоо тэгээд санаа чинь амрав уу” гэж хэлжээ. Тэгтэл Чука улам уурлаж Гандиймаа руу хуруугаараа чичин “Чи яахаараа манайд хуруу урттай хулгайч хүүхэн дагуулж ирсэн юм бэ. Чамд шоронгийн хулгайчаас өөр юм олдсонгүй юу. Тэгээд миний төрсөн өдрийн баярыг бусниулах гэж байгаа аятай “өнгө мөнгөнд хууртлаа, сархад самуунд халуурлаа, хадуурлаа, баларлаа” гэх мэтийн балай дуу дуулуулаад байхдаа яадаг юм бэ” гээд л агсарч гарчээ. Харин энэ үед түүний нууц амраг болох Гансүх гэгч залуу “Чука чи аятайхан байгаач дээ. Яахав нэг тиймэрхүү дуу дуулаа л биз. Юун сүртэй юм бэ” гэхэд Чука түүнийг шууд цохиж аваад “Чи очиж очиж энэ муу шоронгийн хулгайчийн талд ороод байхдаа яахав дээ. Одоохон манайхаас зайл. Чам шиг ажил төрөлгүй тэнэмэл юм надад хэрэггүй” гээд нууц амраг руугаа агсарч гарсан байна. Гэтэл дайран дээр нь давс нэмэв гэгчээр Мөнхцэцэг гэгч хүүхэнтэй хамт ирсэн Нямдаваа

гэгч залуу Чукаг өмөөрч тэнэгтжээ. Тэрбээр “ер нь шоронгийн дуу дуулах ямар шаардлага байсан юм бэ. Хэнийг доромжлоод байгаа юм бэ. Чукагийн хэлдэг зөв. Хэн ч гэсэн гэр орондоо балай дуу дуулуулахыг хүсэхгүй шүү дээ. Гансүх чи зүгээр аятайхан л байгаарай. Чамайг хэн болохыг чинь мэднэ шүү” гэж агсарчээ. Ингээд нэг муу шоронгийн дуунаас болж наргиж цэнгэхээр цугласан улс бие биедээ агсарч, сүүлдээ бүр зодоон болж хувирсан байна. үүнд агсам зантай Чукагаас гадна Нямдаваа гэгч залуу буруутай бөгөөд тэр үнэндээ хэрүүлийг тордож зодоон болгохдоо тун гаршсан этгээд юмсанж. Нямдаваа энэхүү хэрүүлээр далимдуулж өмнө нь өш хонзонтой байсан Гансүхийг сайн гэгч балбаад авахыг урьтал болгожээ. Тэгээд Чукаг өмөөрч байгаа дүр эсгэж Гансүхийн хор шарыг улам малтаж орхисон байна. Тэр Гансүхийн мөрөн дээрээс татаж эргүүлээд ”Чи одоо Чукаг юу гэж бодоод байгаа юм бэ. Чи Чукагийн дунд идэж уухаас гадна түүнийг эдэлж хэрэглэж байгаа биз дээ. Чамд Чука шиг энэрэнгүй хүүхэн олдохгүй шүү. Муу бөөс минь чи аятайхан л байгаарай” гэхэд цаадах нь шарлахсандаа гараа зангидаж байгаад нүүрэн дундуур нь буулгаж орхижээ. Тэгтэл Чука “Чи хүн зоддог хэн юм бэ” гэж хашгирч босч ирээд Гансүхийн үснээс зуураад авсан байна. Энэ үед Нямдаваа боломжийг ашиглаж Гансүхийг толгой түрийгүй нүдэж гарчээ. Чука ч мөн нүд нь улаанаар эргэлдээд Гансүхийг үсэдсэн чигээрээ элэг бөөр рүү нь байдаг чадлаараа өшиглөсөн байна. Мөнхцэцэг, Гандиймаа, Бадамсүрэн гурав тэднийг салгах гээд үнэндээ дийлсэнгүй. Энэхүү зодооны улмаас Гансүх ухаангүй эмнэлэгт хүргэгдсэн бөгөөд нэг хүнийг хоёулаа нийлж ухаан алдтал зодсон Чука, Нямдаваа хоёр “ганц худаг” руу ачигджээ. Тархиндаа нэлээд хүнд гэмтэл авсан Гансүхийн бие эдүгээ тун тааруу байгаа бөгөөд чухам түүний мэдүүлгээр л Чука, Нямдаваа хоёрын асуудал шийдэгдэх бололтой. Харин шоронгийн дуу дуулж хэрүүлийн эх үндсийг тавьсан Бадамсүрэн гэгч эмэгтэй нутаг руугаа явсан ч юмгүй гэрчийн мэдүүлэг өгөөд л явж байдаг болж. Гэхдээ тэр долоон жил уулзалдаагүй хоёр хүүхдээ хотод авчруулан уулзаж амжсан байна.

## Дээрэмчин Цогбадрах хамаг буруугаа хар амиа хичээсэн ард иргэд рүү чихжээ

Сэлэнгэ аймгийн харьяат Дангаагийн Цогбадрах, Раднаагийн Буянхишиг нар одоогоос гурван жилийн өмнө Улаанбаатарт доншуучилж ирсэн бөгөөд тэд хүн ихээр цугладаг захууд дээр улайм цайм дээрэм хийдэг байсан байна. Уг нь дээрэмчид аль болох хүнгүй газар дээрэм хийдэг байтал энэ хоёр этгээд хүн ихтэй газрыг сонгож авсан нь хачирхалтай. Учир нь тэд нутаг орондоо хэрэгжүүлж байсан бяцхан арга залиа хэрэглэдэг байж. Тухайлбал тэд хэн нэгэн гайгүй хувцастай, ганцаараа яваа, мөн жаахан доожоо муутай, хармаандаа мөнгөтэй байж мэдэх хүнийг олны дундаас олзолж аваад шууд л таньдаг хүн нь болж хувирдаг байна. Ингээд тэдний үйлдсэн хэргээс толилуулъя. Гуч гаруй настай Мэндбаяр гэгч залууг нэг өдөр «нарантуул» зах дээр олны дунд явж байтад өмнөөс нь хоёр танихгүй хүн угтаж аваад «Чи одоо хаашаа алга болчихдог новш вэ. Алив бидний мөнгийг аваад ир. Чи биднээс бултчихна гэж бодоо юу» гээд шууд л заамдаж аваад чиржээ. Мэндбаяр тэдний өөдөөс тэрсэлдэнгээ «та нар юу яриад байгаа юм бэ. би та нарыг танихгүй юм байна шүү» гэхэд Буянхишиг «хүмүүсээ энийг хар аа. энэ хулгайч миний мөнгийг зальдаж авчихаад одоо танихгүй хүн болж жүжиглэж байна. Алив чи наашаа хүрээд ир. Хэдүүлээ зайдуу гарч байгаад ярилцъя» гээд цааш чирч гулдарчээ. Эргэн тойрны хүмүүс нь тэднийг бие биенээ таньдаг хүмүүс гэж бодсон бололтой, мөн ашгүй нэг зодоон гарч нүд баясгах нь уу гэсэн байртай бүгд л сонирхон харцгаажээ. Харин энэ үед Мэндбаяр эргэн тойрныхоо хүмүүст хандаж «та нар юугаа хараад байгаа юм бэ. энэ хоёр дээрэмчнийг надаас салгаад өгөөч. шал худлаа таньдаг хүн болж улайм цайм дээрэм хийх гэж байна шүү дээ. Алив цагдаа дуудаадахаач» гэж хашгирчээ. Тэгтэл сониучирхсан хүмүүсээс хэн нь ч хөдөлсөнгүй. Ер нь Монголчууд ийм л хар амиа хичээсэн арчаагүй, өөдгүй улс шүү дээ. Хажууд нь хэн нэг алуурчин хүн алж байсан ч «Надад л хамаагүй бол болох нь тэр. Амьд хүний гэрч болсоноос үхсэн хүний дэр болсон нь дээр» гэх ухааны юм бодоод бушуухан зайлж одох жишээтэй. Иймэрхүү арчаагүй сэтгэлгээтэй хүмүүс сүүлийн үед бүр олширч байна. Бүр өөрт нь хамаатай юмны төлөө хүртэл дуугарч чадахгүй гөлөлзөөд суудаг болж. Тухайлбал микроавтобусны кондуктор, жолооч хоёрт ямар ч шаардлага тавьж чадахгүй хэзээ явахыг нь хэдэн цагаар ч хамаагүй хүлээгээд суучихдаг болсон байна. Ухаандаа тэднийг хүлээж байхын оронд бөөнөөрөө нийлээд таксидчих л ёстой байхгүй юу. Ингээд эхэлбэл микроавтобусны жолооч, кондуктор хоёрын хулхи нь бууж зорчигчдыг зуун төгрөгөөр ч хамаагүй ачаад хурдлах биз. Цогбадрах, Буянхишиг хоёр Мэндбаярыг чирч гулдарсаар олны хөлөөс зайдуу аваачаад өвөрт нь байсан түрийвчийг нь гар утастай нь цуг аваад ум хумгүй зугтжээ. Гэгээн цагаан өдөр, олны дунд ингэж улаан цагаан дээрэмдүүлнэ гэж байх уу. Дээрэмчид хар амиа хичээсэн арчаагүй сэтгэлгээтэй ард иргэдийг юм хэлж, шаардлага тавьж чадахгүйгээр нь далимдуулж ингэж л ил цагаан доромжилдог болсон байна. Цаадуул нь ч хар амиа хичээсээр байгаад бүр дөжирчихөж. Хоёр дээрэмчнийг мөрөөрөө яваа хүнийг танимхайран барьж аваад чирч гулдарч байхад үнэндээ хэн ч дуугарсангүй, хэн ч Мэндбаярын талд орсонгүй. Тэгээд гэмгүй явсан нэгнээ бүгдээрээ харсаар байгаад чонын аманд өгчихсөн байгаа юм даа. Мань хоёр иймэрхүү маягаар арав гаруй хүнийг дээрэмдсэн байна. Тэд хамгийн сүүлд “хархорин” зах дээр Төрсайхан гэгч гайгүй хувцастай, ганцаараа явсан нэг залууг олзолж авчээ. Цогбадрах түүний хажууханд очсоноо ойролцоо байсан Буянхишигийнхээ гараас татаж “хөөш, нөгөө хулгайч чинь энэ байна. Яг мөн байгаа биз дээ. одоохон цагдаад бариад өгчихье” гэж хашгирчээ. Тэгмэгц Буянхишиг нь “нээрээ яг мөн байна ш дээ. Хүмүүс ээ, энэ

манай хивсийг хулгай хийгээд зугтсан хүн байгаа юм” гээд бариад авчээ. Төрсайхан түүний гарыг цааш түлхэнгээ “Чи болиоч дээ. хүн андуураад байгаа юм биш үү” гэхэд Цогбадрах “битгий худлаа жүжиглээд бай чи. Одоо танайд очно. хивсээ олж авна” гээд гараас нь угзран чиржээ. Хавь ойрын хүмүүс бүгд гайхаж Төрсайханыг нээрээ л хулгайч юм байхдаа гэж бодсон бололтой. Яагаад гэвэл тэднээс хэн нь ч Төрсайханыг өмөөрч дуугараагүй бөгөөд хэрэв мань хоёр дээрэмчнийг худлаа жүжиглэж байгааг мэдсэн бол Төрсайханыг эрх биш өмөөрөх байсан биз. Тэгтэл ёстой санаанд оромгүй юм болсон байна. өмнө нь “нарантуул” зах дээр мань хоёрт яг ингэж дээрэмдүүлж байсан Ганбат гэгч залуу огт гэмгүй нэг залууг мөн л дээрэмдүүлэх гэж байгааг харуутаа “хүмүүс ээ, наад хоёр дээрэмчнээ бариад аваарай. Наад хоёр чинь ингэж худлаа жүжиглэж байгаад хүн дээрэмддэг юм. Би өмнө нь бас ингэж дээрэмдүүлж байсан юм. Гурвууланг нь цагдаад аваачаад өгчихье” гэж хашгирчээ. Энэ чимээнээр Буянхишиг, Цогбадрах хоёр Төрсайханыг тавьчихаад олны дундуур ум хумгүй зугтсан байна тиймээс тэнд байсан хүмүүс мань хоёрыг дээрэмчин гэдгийг ойлгуутаа бүгд л барьж авах гээд хойноос нь хуйларчээ. Хаа очиж хар амиа хичээсэн Монголчууд яг ингэж хуйлрахдаа жинхэнэ улайрдаг гээч. Ёстой л өнгөрсөн борооны хойноос цув нөмрөв, ниргэсэн хойно нь хашгирав гээч нь болж. Тэгээд тэнд байсан хэсэг хүн мань хоёр дээрэмчнийг барьж аваад тал талаас нь балбаж гарчээ. Энэ үед Ганбат ‘та нар одоо болиоч дээ. Наад хоёрыг чинь цагдаад барьж өгч учраа олох хэрэгтэй байна. өмнө нь дээрэмдүүлж байсан би хохирлоо төлүүлнэ. Гай болж наадуул чинь үхчихвэл яах юм бэ” гэж хашгирчээ. Төдөлгүй цагдаа ирж хоёр дээрэмчнийг Төрсайхан, Ганбат нарын хамт аваад явжээ. Хоёр дээрэмчин баригдаад ирүүтээ долоон булчирхайгаа тоочсон аж. Цагдаагийнхнаас гаргасан зарлалын дагуу нэгэн цагт “нарантуул” зах дээр улаан цагаан дээрэмдүүлж байсан Мэндбаяраас гадна долоо найман хүн ирсэн байна. Мөрдөн байцаагч “Чи хаана ингэж улаан цагаан дээрэм хийж сурсан юм бэ” гэж Буянхишигээс асуухад “намайг бага байхад ах нар маань Сэлэнгийн вагонд ороод шууд дээрэм хийдэг байсан юм. Ялангуяа хойноос орж ирж байгаа оюутнуудыг их дээрэмддэг байсан. Тэднийг дээрэмдэж байхад хажуу талын хүмүүс нь юу ч хэлдэггүй байсан юм. Тиймээс миний сэтгэл зүйд бусдыг дээрэмдэхэд хажуу талын хүмүүс нь үнэндээ яаж ч чаддаггүй юм байна гэсэн ойлгоц төрсөн. Сэлэнгэд байхдаа ч би ийм маягаар дээрэм хийдэг л байлаа. Гэхдээ тэнд осолтой. Бүгд бие биенээ таньдаг учраас гэгээн цагаан өдөр олны дунд дээрэм хийхэд их хүндрэлтэй байдаг байсан. Харин 2003 онд Цогбадрахтай хамт Улаанбаатарт ирсэнээсээ хойш энд тэндхийн захууд дээр дээрэм хийж эхэлсэн. Хэн нэгнийг олзолж аваад шууд таньдаг хүн нь болоод жүжиглэчихээр тэр хүн яаж ч чаддаггүй байсан. Бид хоёр олон түмнээс итгэл олж авахын тулд “энэ хүн хулгайч байгаа юм. Цагдаа дуудаарай” гэж хашгирдаг байсан. Ард иргэд цагдаа гэдэг үгнээс айдаг болохоор бид хоёрт итгэдэг байсан” гэж мэдүүлжээ. Харин дээрэмчин Цогбадрах мэдүүлэхдээ “Монголчууд таньдаг бурханаас таньдаггүй чөтгөр дээр гэж ярьдаг. Тиймээс Буянхишиг бид хоёр таньдаггүй чөтгөрийг олзолж авахаар шийдсэн. Гайгүй хувцастай, өвөртөө мөнгөтэй байж мэдэх хэн нэгнийг олзолж аваад гэнэтхэн таньдаг хүн нь болоод жүжиглэчихээр хажууд байсан хүмүүс нь итгэчихдэг байсан. Итгэхгүй байлаа ч Монголчууд ер нь хар амиа бодсон улс шүү дээ. Эцсийн эцэст Монголчуудын энэ хар амиа хичээсэн сэтгэлгээ намайг дээрэмчин болгож даамжруулсан. Тиймээс би өөртөө гомдохоос илүү хар амиа хичээсэн Монголчуудад гомдож байна” гэж хамаг буруугаа хар амиа хичээсэн ард иргэд рүү чихсэн байх юм. Буянхишиг, Цогбадрах хоёр шиг олны дунд хэн нэгнийг яах ч аргагүй болгож дээрэмддэг хүмүүс одоо ч бидний дунд байсаар байна. Иймэрхүү хүмүүс хэн нэгнийг харуутаа шууд таньдаг хүн нь болж жүжиглээд эхэлдэг. Ялангуяа найгаа алдсан архицид хэдий улаан цагаан дээрэм

хийхгүй ч гэлээ таньдаг хүн нь болж худлаа саймширч байгаад архины мөнгө салгачихдаг тал бий. Ямартай ч олон нийтийн газар Цогбадрах, Буянхишиг мэтийн этгээдүүд хэн нэгнийг шууд танимхайраад элдэв долоон юм яриад эхэлбэл хажууд нь байгаа хүмүүс дуугүй байж болохгүй нь. Ерөөсөө үнэн ч ярьж байсан, худлаа ч ярьж байсан бүгдээрээ нийлээд шууд л цагдаад бариад өгчих хэрэгтэй. Тэгээд цагдаа дээр очоод учраа ололцоно биз. Ингэхгүй бол цагаандаа гарсан дээрэмчид хар амиа хичээсэн ард иргэдийг шаардлага тавьдаггүйгээр нь далимдуулж дэндүү элэг бариад байна шүү дээ!

## «Ганц»-ийн шоронгийн загалмайлсан эцэг болох

### Батгүн шоронгийн тухай тэмдэглэл

1924-48 он хүртэл Монгол улсын төв шоронг Батгүн гэж нэрлэдэг байв. Тэнд анхандаа малын хулгайч, хүн амины хэрэгтэн, оргодол хулгайчийг хорьдог байснаа 1929 оноос эхлээд хувьсгалын эсэргүү том толгой лам нарыг, 1932 оноос Японы тагнуул гэж сэрдэгдсэн хүмүүсийг хорьж эрүүдэн шүүдэг байжээ. Их зохиолч Дашдоржийн Нацагдорж, улсын арслан Лхагваа, улаан хувьсгалч Жадамба, Элдэв-Очир нарыг хорьж байсан энэ газар 1926 онд Төв аймгийн Лүн сумын харьяат Дашчийрэв гэгч атаман эр хоригдож байжээ. Хүн амины хэрэгтэй, шоронгоос хоёр ч удаа оргохыг завдсан тэрбээр 1950 онд маршал Х.Чойбалсангийн өршөөлөөр суллагдан хөдөө мал маллаж байгаад 1969 онд нас баржээ. Түүний хүү Д.Ганчулуун тухайн үеийн шоронгийн диаграм, До яамныхны эрүү шүүлтийн талаар эцгийнхээ амьд сэрүүндээ ярьж байсан зүйлийг хуучилсан юм.

**-Батгүн шорон ердөө л ганц давхар цагаан байшин байсан гэж сонссон. Тиймээс оргоход их амар хялбар газар байсан гэж ярьдаг, Энэ үнэн болов уу?**

-Яалаа гэж тийм амархан байх билээ. Хэрвээ тийм байсан бол тэнд хоригдож байсан хүмүүс бүгд л оргочихно шүү дээ. Батгүн шорон Богд хаант засгийн сүүл үеэр баригдсан, Европ загвартай, газар дороо нүхэн зорьтой тэр нь их хүйтэн байсан гэдэг. Одоо Баянзүрх дүүргийн хүнсний захын махны хэсэг бол яг тэр Батгүний салбар байшин юм шүү дээ. Уг шоронг Богд хаант засгийн үед ердөө дөрөвхөн буутай цэрэг хамгаалж байсан гэдэг. Тэр үед голдуу шилийн сайн эрчүүдийг, бас алах ялтай ч юмуу онц хүнд гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг хорьж байсан байгаа юм. Зарим сайн эрс Батгүн шоронгийн метр зузаан ханыг нүхлээд тоосгыг нь нэг нэгээр нь сугалж тавьсаар байгаад оргож байсан гэдэг. 1918 онд Баруун Монголын Жума гэж нэг сайн эрийг арван тавны цагдаа нар Ховдоос баривчлахдаа шар үхрийн хатсан арьсанд ширлээд нааш авч явсан юм байх. Тэгтэл замдаа Жума ‘Ганц сайхан тамхи татмаар байна’ гэхэд цаадуул нь шоолж инээлдээд амыг нь асууж тавлаж л дээ. Тэгсэн чинь Жума “Би төрийн хуулинд л захирагдаж яваа болохоос биш энэ муу бярууны арьсанд чинь баригдаж яваа юм биш” гээд нөгөө ширийг нь цуу татаад босч ирсэн гэдэг.

**-Тэгээд оргочихсон уу?**

-Үгүй. Хээвнэг босч ирээд нэгнийх нь гаансыг шүүрч аваад тамхи татсан гэж байгаа. Тэгээд тэр «Би ямар Манжийн хааны зарлигаар хүлэгдэж яваа биш, Богд эзнийхээ зарлиг лүндэнг зөрчихгүй» гээд сул шахам дагаж ирээд Батгүнд хоригдсон гэдэг. Тэр үед Батгүн шорон баригдаад удаагүй, ёстой л будаг шохой нь ханхалсан цоо шинэ шорон байж. Жумаг Ховдын шоронд байхад нь есөн эрүү тулгасан ч давж гарсан гэдэг. Харин түүнийг Батгүн шоронд авчирч хорьсоны дараа мөчилж алах гэлүү, огтолж алах гэлүү их л хатуу харгис цааз оноосон юм байх. Уг нь өөрөө бол хаан эзний өршөөл горьдож ирж л дээ. Тэгтэл 1918 оны хаврын нэг шөнө уг шоронгийн үүдний дөрвөн хамгаалагч руу үл таних морьтой хүмүүс дайрч хүлээд Жумаг сулласан гэдэг. Энэ үеэр уг шоронд хоригдож байсан бүх хоригдол дагаад оргочихсон гэсэн. Батгүн шорон түүхэндээ нэг удаа ингэж суларсан гэдэг юм. Хойтон жил нь манай эцгийг нутаг дамнуулж мал хөөсөн хэргээр баригдаж ирэхэд харуул хамгаалалт гэж

жигтэйхэн, энд тэндгүй л буутай цэргүүд зогсч байсан гэдэг.

**-Танай эцэг чинь тэгэхээр шилийн сайн эр явсан хэрэг үү?**

-Одоо тийм л юм даа. Сэлэнгэ, Минж, Харуулаар Оросын буриад руу адуу мал хөөдөг байсан гэж өөрөө ярьдаг байлаа. Харин 1919 онд Батгүн шоронд хоригдож байхад нь хятадууд орж ирээд Монгол хамгаалалтыг татан буулгаж оронд нь хятад цэргүүдийг тавиад голдуу Монгол ноёдыг хорьж байсан гэсэн.

**-Эцэг чинь тэр үед нөгөө Хатанбаатар, Манлайбаатар нартай хамт хоригдож байсан хэрэг үү?**

-Хятадууд анх орж ирээд л өөрийн цэрэгт орох хүмүүсийг суллаад байсан гэсэн. Аав маань хэдэн хүний хамт хар Хятадын цэрэгт орохгүй гэсний улмаас шорондоо үлдсэн гэдэг. Тэр үед Жамьян гүн тэдэн дээр орж ирсэн гэдэг шүү. Харин Хатанбаатар, Манлайбаатар хоёрыг бүр сүүлд нь баривчлаад гэрийн хорионд байлгаж байсан байгаа юм. Аав маань амьд байхдаа “Манлайбаатар Манжийн шоронд босоогоороо үхсэн гэдэг шал худлаа. Зүгээр л гэрийн хорионд архи ууж суугаад зүрх нь зогсоод өнгөрчихсөн юм. Тэр мундаг хүн гэрийн хорионд орсоноор сэтгэл санаагаар унаа биз” гэж ярьдаг байлаа. Тэр үед Богд хааныг ч гэсэн өргөөнд нь хорьж байсан гэдэг шүү дээ. Харин нөгөө Оросоос тусламж гуйх гэсэн дугуйлан мугуйлантай холбогдсон хүмүүсийг нь Батгүн шоронд хорьж байсан гэсэн.

**-Эцэг чинь тэгээд Батгүн шоронд суугаад байсан хэрэг үү?**

-1920 он хүртэл суусан гэдэг. Тэгтэл нөгөө цуутай Барон Унгерн чинь нийслэл хүрээг чөлөөлөхгүй юу. Тэр үеэр Батгүн шоронд хоригдож байсан 100 гаруй Монгол эр цөмөөрөө суллагдсан гэсэн.

**-Дараа нь тэгээд нөгөө “Тунгалаг Тамир”-ын Эрдэнэ шиг л байлдаж эхэлсэн үү?**

-үгүй ээ. Манай эцэг чинь ясны сайн эр, хулгайч хүн байсан болохоор суллагдаад л тэр зам мөрөө хөөсөн юм гэнэ лээ. Харин ч Бароны, Гамингийн аль алины нь цэргийн агтуудыг хулгайлдаг байсан гэсэн шүү. 1921 оны зун гэсэн байх аа. Сэлэнгэ рүү цөмөрч орж ирсэн улаан армийн агтыг дөрөв тавуулаа нийлж байгаад туучихсан гэдэг. Баахан тоомсог морьд хөөсөөр Завханы Улиастай оруулж байж нэг нөхөртөө дамжуулаад цаадах нь хурандаа Казграндын цагаан оросуудад зарсан юм гэдэг.

**-Хувьсгалын дараа ч гэсэн бас л хулгай хийсээр байсан хэрэг үү?**

-Тэгэлгүй яахав. Хиагтын баян оросуудтай гэрээ хийчихээд адуу хөөж аваачдаг байсан гэсэн. Шилийн сайн эрсийг чинь манайхан баян айлаас малыг нь хулгай хийж аваад л ядуучуудад тараагаад өгчихдөг өгөөмөр хүмүүс байсан гэж ярьдаг шүү дээ. Манай эцэг тийм зүйл огт ярьдаггүй байлаа, тэгээд ч ардын хувьсгал ялсаны дараахнаас бүгд ижил тэгш эрхтэй болсоноор голдуу сүм хийдийн жас, өртөөний малыг хамдаг байсан шиг байгаа юм. Мэдээж шилийн сайн эр гэдэг чинь хэдэн үхэр ч юм уу, хонь туучихаад одооны хулгайчууд шиг бөв бөв шогшуулж явахгүй биз дээ. Хаа байсан өвөрхангай, Баянхонгорын ламын гэгээний адууг

туугаад хиагт орж оросуудад адуугаа өгөөд оронд нь голдуу хөөрөг, үнэт чулуу, алт мөнгөн хутга, буу авдаг байсан гэдэг.

**-Эцэг чинь 1926 онд дахиад баригдсан гэл үү? Юунаас болоод шоронд орсон юм бэ?**

-Манай хошууны даамлын оронд ирсэн Эрэгдэн гэж ташаандаа буутай, тархиндаа лоозунгтой улаан хувьсгалч байсан гэнэ лээ. Бас болоогүй ээ тэр чинь суман цэргийн захирагч байсан ч гэл үү. Эцэг маань заамарын хөндийн хэдэн луухааны пүүсийг хоосолж байгаад өнөөх Эрэгдэнтэй улаан халз тааралдчихаж л дээ. Тэгээд мөнгөн тоногтой бүдүүн яргай ташуураар түүний нуруу руу савчихсан чинь нугас нь тасраад үхчихгүй юу. Ингээд хувьсгалт улаан цэргийн суман даргын амийг хороосон хэргээр баригдаж Батгүн шоронд хоёр дахиа орсон нь тэр байхгүй юу. Эхлээд энэ шоронгоос оргоно доо гэж бодож байсан чинь харуул хамгаалалт нь богд хааны үеийнхээс шал өөр болчихсон, хурдан буу, хуягт машинтай 30 орчим цэрэг манаж байсан гэсэн. Хувьсгалч Баваасан эцэгтэй минь нэг өрөөнд хоригдож байгаад цаазлуулсан гэдэг. 120-иод хүн 20 орчим өрөөнд пиг дүүрэн чихээстэй байсан гэнэ лээ. 1929 оноос эхлээд хутагт хувилгаад, том лам нар тэнд орж ирсэн байгаа юм. Эцгийн яриагаар бол тэдний зарим нь мөрдөнгийн өрөөнд суугаагаараа өөд болчихдог, зарим нь орхимжоороо толгойгоо бүтээчихээд хэнтэй ч юу ч ярихгүй ном бясалгаж байсаар дуудсан үед нь дуулгавартай нь аргагүй гараад буудуулчихдаг байсан гэдэг. Хамгийн алдартай нөгөө Халхын Зая Гэгээн 1930 онд Батгүнд дөрвөн сар хоригдсон гэдэг. Зая Гэгээнтнийг хана цоолоод гараад явчихна гэсэн яриа тэр үед гадуур их тарсан тул түүнийг барьж хорьсноос хойш Батгүн шоронгийн дээвэр дээр буутай цэрэг сууж байдаг болсон гэдэг юм.

**-Заяын гэгээнийг чинь нугагт нь хороогоогүй бил үү. Тийм яриа байдаг шүү дээ?**

-Японы цэргийн эрхтнүүдтэй хуйвалдсан гэж 1929 онд түүнийг баривчлан Архангай аймгийн төвд анх хорьж байхад нь сүсэгтэн олон тийм яриа гаргасан гэсэн. Түүнээс биш маш нууцаар Улаанбаатарт авчирч Батгүнд хорьж байгаад сүүлд нь бөөн лам нартай хамт буудчихсан юм билээ. Манай эцэг их сонин зүйл ярьдаг байсан л даа. 1930 оноос эхлэн хүн амины болон хулгайн гэмт хэрэгтнүүдийг нэг нэг камерт тараан байрлуулаад «Хэрвээ та нар өрөөндөө орж ирсэн Японы эсэргүү хулгай нарыг илрүүлэн, хэргийг нь яриулж чадвал ялыг чинь хөнгөлнө» гэсэн байгаа юм. Ингээд зарим нэг нь яг л До яамны байцаагч шиг өрөөндөө орж ирсэн хүмүүсийг тамлан зовоож, жинхэнэ бууны нохой болсон гэдэг. Зарим нь бүр цаанаасаа цалин пүнлүү авч байсан гэсэн шүү. Мятав гэж нэг хулгайч «Японы 14 эсэргүү»-г улайлгасныхаа шагналд шоронгоос суллагдаад шууд л До яамны ажилтан болчихсон маргааш нь ногоон хувцас өмсөөд шоронд орж ирээд хүмүүсийг зодож нүдэж байсан гэдэг. Эцэг маань харин тийм юманд гар дүрэлгүй хоригдсоор байгаад 1941 онд Батгүнээс шилжиж Хурхын шоронд очиж мод бэлтгэж байгаад тэндээсээ 1950 онд суллагдсан юм.

**-Тэгэхээр До яамныхан торонд яг л одооны мөрдөн байцаагч нар шиг бие биеэр нь дарамтлуулж байсан болж таарах нь ээ?**

-Яг тиймэрхүү л юм хийж байсан юм билээ. Одоогийнхоор бол хүн амины хэрэгтээ шийдчихсэн амьтан дээр улс төрийн хэрэгтэн оруулаад л цаадах нь элдвээр яргалан зовоож бүх хэргийг нь тулган хүлээлгэх жишээтэй. 1938 онд гэлүү дээ, «Урт гарт» Лхагва арслан шоронд хилсээр ороод өөрийг нь дарамтлах гэсэн нэг нөхрийг нударгалж алаад хүн амины



хэрэгтэн болж 1948 он хүртэл шоронд суусан гэдэг шүү дээ.

-Танай эцгийг улаан хувьсгалчийг алсан гээд шуудхан буудчихалгүй яагаад өршөөсөн юм бол?

-Эцгийг маань 1926 онд баригдсаны дараа 1928 онд нөгөө Эрэгдэн чинь зүүний нугалаатан гэгдэж /үхчихсэн хойноо шүү дээ/ буруутсан юм гэсэн. Ингээд л бараг эсэргүүт цохиж алсан хүн болоод хэрэг нь хөнгөрөхгүй юу.

**Д.Цэрэнбалжид: би ханилсан ханиа төрсөн хүү нь алчихаад байхад хашаандаа гурван жил нуусан нүгэлтэй хүн**

Тавин хэдэн нас гэдэг амьдрал тогтворжиж ачийн зулай үнэрлэх налгар үе. Толгойн үсэнд нь цагаан сор сууж, чалх нь харьж яваа цийлгэр нүднээс нь гунигийн манан сүүдэртэж, түмэн үрчлээт нүүрэнд нь цөхрөл харамсал нэвт шингэсэн энэ эмэгтэй одоо тавин хэдэн настай ч ганц үрийнхээ, түүний улаан цурав хүүхдийн төлөө байнга шаналсан нэгэн. Уйлсаар байгаад нулимс нь ширгээд дуусчихав уу гэлтэй ганц ч дусал нулимс гарахаа болижээ. Түүнийг Дондогийн Цэрэнбалжид гэнэ. Тэрбээр Монгол улсын эрүүгийн хуулийн тусгай ангийн 86-ын 2-оор зүйлчлэгдэн нажидаа эдэлж сууна. Тэрбээр хүүтэйгээ, хамаатан залуутайгаа хамтран ханийхаа амийг хөнөөж гурван жил хашаандаа нуусан бөгөөд энэ тухай нэг хэсэг телевизээр гарч байсан. Цэрэнбалжид мөрдөнд хоригдож байхдаа байдагчийнхаа асуултанд ийнхүү хариулжээ.

**-Энэ хэрэгт холбогдох нөхцөл шалтгаан үнэхээр танд байсан уу? Таныг хараад ийм хэрэг үйлдсэн гэхэд нэг л итэж өгөхгүй байна.**

-Хүн болгон тэгдэг юм. Би ганц хүүтэй хүн л дээ. Түүнийг маань Алтанбат гэдэг юм. Одоо бас энд сууж байгаа. Манай бэрийн дүү нь бас энд байгаа. Тэр хоёр л уг нь энэ хэргийг үйлдчихсэн юм. Яг тэр үед нь би юу болсныг мэдэхгүй ч хүүгээ хэрэгт орохоос айгаад мөрдөн байцаагчид «Би алчихсан юм» гээд хэлчихсэн юм. Ингээд л хүүтэйгээ хамтарч би нөхрөө, хүү маань эцгийнхээ амийг хөнөөсөн хэргээр энд сууж байна.

**-Та анхнаас нь мөрдөн байцаагчид үнэнээр нь хэлээгүй юм байна шүү дээ. Тийм үү?**

-Харин тийм. Тэнэг толгой чинь ингээд хэлчихвэл хүүгээ хэрэгт хийхгүй байх гэж бодсон юм. Ер нь энэ хүн амины хэргийг би даая. Би хаашдаа өнгөрсөн хүн. Ингэж бодоод л байцаагчид би алчихсан юм гээд хэлчихсэн. Тэгэхэд хүү маань Мөнгөнморьтод хоригдож байсан. Ард нь нялх балчир дөрвөн хүүхэд үлдсэн байсан. Тэднийг нь бодоод л ...

**-Яг хэрэг үйлдэгдэж байх үед та тэнд байгаагүй юмуу? Анхны мөрдөн байцаалтанд ер нь яг үнэнээ хэлсэн үү?**

-Уг нь тийм л дээ. Би байцаагчдаа үнэн байдлыг ярьсан. Манай байцаагч юмны наана цаадахыг олдог сайн хүн байна лээ. Гэсэн ч би ханилсан ханиа төрсөн хүү нь алчихаад байхад хашаандаа гурван жил нуусан нүгэлтэй хүн шүү дээ. Ямар ч байсан ял эдлэх нь зөв гэж бодож байна.

**-Таныг талийгаачтай ханилж байгаад салаад эргээд ханилсан гэж дуулсан.**

-Тиймээ. Рагчаа бол миний хамгийн анхны хань. Юу ч мэдэхгүй арван хэдэн настай охин байхдаа би түүнтэй ханилсан. Би угаасаа заяа муутай хүн л дээ.

Миний ээж, аав арван хэдэн хүүхэд гаргасан боловч ихэнхийг нь хүнд өргүүлчихсэн юм билээ. Намайг ч мөн айлд өргүүлсэн. Миний заяа муугаас тэр байх л даа. өргөж авсан

ээж, аав маань намайг бага байхад ойр ойрхон өнгөрч би 14 настай байхдаа төрсөн аавындаа эргэж ирсэн. Муу ээж минь л намайг гэхээс эцэг маань намайг нэг нүдээрээ ч үздэггүй байсан. үүнээс залхахдаа л талийгаач Рагчаатай хар нялхаараа шахам ханилсан юм. Даанч жаргал гээчийг би үзсэнгүй. Амьдрал маань зовлонгоор эхлээд шоронгоор дуусах байх гэж би бодож байна.

**-Төрсөн хүү чинь төрүүлсэн эцгээ хөнөөж, хамгийн дотны хоёр хүн чинь нэг нэгнийгээ бүрэлгээд үүнд та бас оролцоод одоо энд байж байдаг. Энэ хэрэг чухам юунаас болж гарав аа?**

-Яах юу байх вэ? Манай талийгаач биднийг дэндүү дарамталдаг байсан. Сав л хийвэл агсам тавина. Намайг барьж авч зодно. Бүр миний хажууд өөр хүүхэн авчираад хонодог байсан. Багаасаа хүү маань эцгийнхээ энэ занг тэсвэрлэж чаддаггүй байлаа. Би арга ядахдаа салсан. Боломжийн гайгүй хүнтэй ханилж байтал тэр маань нас барсан. Хүү маань хойд эцэгтээ их хайртай байсан. Бага байхын л төрсөн эцгээсээ ухаангүй айдаг, ороод ирэхэд нь орох байх газраа олж ядан бүлтгэнэдэг хачин хүүхэд байсан. Сүүлчийн ханилсан ханийг минь өнгөрснөөс хойш л талийгаач манайхаас салахаа больсон. Намайг түүнтэй эргэж ханилсан гэж ярьцгаах юм. Би түүнтэй ханилаагүй, яв гэхээр явдаггүй. Би чам дээр ирээгүй хүү дээрээ ирсэн гээд хөдөлдөггүй байсан. Тэгсэн хирнээ согтуу ирэх тоолондоо хүү бид хоёрт агсам тавьж зовоодог байсан. Эцэг, хүү хоёрын энэ харьцаанаас муу юм болох вий гэж би их айдаг байлаа. Яг л боллоо доо. үхсэн хүнийг би гүтгэж байгаа юм биш. үнэхээр биднийг дарамталдаг байсан. Тэр үйлт өдөр ч бас согтуу ирж агсагнаж хэлэх хэлэхгүй үгээр хүүгээ болон бэрийнхээ дүүг дайрч доромжилсноос ийм явдал болсон.

-Хүү чинь, хамаатангийн залуу чинь хүний амь хөнөөчихөөд байхад хашаандаа тэр чигээр нь булчихсан байдаг нь санаанд багтамгүй юм. Тухайн үед нь цагдаагийнханд мэдэгдсэн бол арай л хөнгөн тусах байж дээ.

-Хэлээд яахав. Ингээд нуучихвал хэн ч мэдэхгүй гэж тэнэглэж бодсоных шүү дээ. өтөлтлөө ухаан суудаггүй тэнэг толгой би тэгж ухаараагүй байхад хүүхдүүд яаж ухаарах билээ дээ.Талийгаачид харамсаж өрөвдөж байсан ч, нулимсаа мөн ч их урсгасан ч ганц хүүгээ шоронд хийхгүй гэж тэнэглээд л хашаандаа булчихаад дуугүй өнгөрсөн юм. Одоо өөрөө нажидаа эдлэх цаг ирж байна.

**-Хашаанд чинь хүний цогцос булаатай байгаа шүү гэж айж жийрхэх бодол таньд төрж байв уу?**

-Бэр, ач нарын маань хэн нь ч мэдэхгүй. Тэдэнд огт мэдэгдэхгүйгээр хийсэн юм. Харин би хар дарж зүүдлэхээс эхлээд цочиж айх, заримдаа нүдний үзүүрт хий юм харагдах шиг болж тайван сууж чадахаа больсон. Энэ тамлал хурдан дуусаасай гэж боддог байсан. Сүүлийн үед гэртээ харихаас ч дургүй хүрч ажил дээрээ хонодог байсан.

**-Ер нь бид болохгүй юм хийчихсэн. Очиж цагдаагийнханд хэлье гэх ч юмуу, баригдах байх гэж айж байсан уу?**

-Надад их зовлонтой байсан. Цаг үргэлж айж түгшиж, баригдах байх гэж айдаг байсан.

Хоригдож байна гэж зүүдэлдэг ч байсан. Одоо бүх юм илэрч нэг талаар сэтгэл амраад байна.

**-Хүний амь санаатайгаар хөнөөсөн. Бас нууж дарагдуулсан зүйл ангиар та шийтгэгдэнэ. Хүлээх ял шийтгэлийн талаар юу бодож байна вэ?**

-Би яах вэ. Ялнаас айх юм алга. Амьдралын маань төгсөл шорон байх гэж би түрүүн хэлсэн. Харин хүү минь, бас бэрийн минь дүү л хэцүү байна. Хоёулаа залуу улс. Хойч ирээдүй, үлдэж байгаа үр хүүхдийг нь бодож тэдэнд оногдох ялыг нь харж үзээсэй. өөрөөр хэлбэл энэ хоёр хүүхдийн амийг өршөөгөөсэй л гэж төрөөсөө хүсч байна. Бас би наранд гарах заяа байвал ажилгүй бэрдээ хамжаа болж нэг хүүхдийнх нь ч гэсэн гараас хөтөлж явахсан гэж бодох юм даа.

Цэрэнбалжид ийнхүү мэдүүлээд мэгшүүлэн уйлжээ. Хүний амьдралд ганцхан тохиолдох хань гэдэг амьдралын тулах цэг ноён нуруу байдаг. Хатуу эцгийн бахим гараас зугтсан хөөрхий эмэгтэйн сонгосон анхны хань түүнд аз жаргал биш нулимс дагуулсан гашуун зовлон байсныг бие даасан амьдралд дэндүү яарсан цэл залуухан Цэрэнбалжид тэрхэн үед яахан мэдэхсэн билээ. Төрсөн үр нь төрүүлсэн эцгийнхээ аминд хүрсэн үзэн ядалт, уур бухимдал гэдэг бага юм биш. өрх гэрийнхээ тулах багана болсон талийгаач эцэг хүний ёсоор хань ижил, үр хүүхэддээ ухаант гэрийн эзэн, хүүгийн халамжит аав байсан бол өнөөдөр ийм эмгэнэлийн хар нөмрөг энэ гэр бүлийг бүрхэхгүй байх байлаа. Ер нь хань ижил үр хүүхдээ байнга дарамталдаг эрчүүд олон байдаг бөгөөд тэд үүнийг уншаад нэгийг ухаарах биз ээ.

## **Хүн алж, банк дээрэмдэх гэж байгаа нөхрүүдээ үг зааж өгч, ул мөрийг нь арилгасан нүгэлт хоёр эмэгтэй**

Хар багаасаа хүний халаас ухаж янз бүрийн гэмт хэрэг өдүүлж байсаар шоронд олон жил ял эдэлсэн Ч.Түмэннаст гэгч этгээд одоогоос хэдэн жилийн өмнө Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “Төв ази” хувийн банкны хадгаламжийн кассны харуул Б-г олон удаа хутгалж амь насыг нь хороосон нүгэлтэн билээ. Тэрбээр энэ хэргийг найз Баярмандахын хамт үйлдсэн бөгөөд харуулыг хутгалж алсныхаа дараа банкны мөнгөтэй төмөр сейфийг онгойлгох гэж нэлээд зүтгэсэн боловч чадаагүй байна. Тэгэхээр нь барьцаат үйлчилгээнд тавигдсан телевизор, хивс, магнитофон зэргийг аваад явжээ. Уг нь мань хоёр сейфнээс их хэмжээний мөнгө аваад эхнэрүүдээ дагуулан гадаад руу гарах бодолтой байж. Тийм ч учраас улаан цагаандаа гарч хүний амь нас бүрэлгэсэн хэрэг. Гэвч чамлахаар чанга атга гэгчээр телевизор, хивс, магнитофон зэргээ зах дээр боломжийн үнээр зарж борлуулан овоо их мөнгөтэй болжээ. Гэхдээ түүний цаана хамсаатнууд байж. Тэд нар нь мэдээлэл өгөх, ул мөрийг нь арилгах овжин арга зохиосон байна. Хэрэг болсон газар Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтсийн шуурхай албаныхан болон эрүүгийн цагдаагийнхныг очиход өчүүхэн ч ул мөр байсангүй. Алуурчныг илрүүлэх ажлыг хурандаа Жамъянсэнгээ биечлэн удирджээ. Тэрбээр томоохон төлөвлөгөө гаргаж хэрэг гарсан газар болон түүний ойролцоо газруудад эрэн сурвалжлах ажлыг өргөн цар хүрээтэй зохион байтуулсан байна. Мөн тухайн үед гарч байсан зарим ноцтой хэргийн холбогдогчдийг ч шалгаж байцаасан байна. Тэгээд уг гэмт хэргийг үйлдсэн байж болзошгүй гэсэн 100 гаруй хүнийг хараандаа авч тэднийг нэг бүрчлэн шалгаж эхэлжээ. Эдгээр хүмүүсээс уг хэрэгт холбогдолгүй болох нь тогтоогдсоор байгаад хамгийн сүүлд тус банкны захиралаар ажиллаж байсан Б-гийн хүү Баярмандах, түүний найз Түмэннаст хоёр дээр тулж иржээ. Учир нь Баярмандах нь эд мөнгөний шуналтай, орон гэрээсээ мөнгө төгрөг хулгайлж байсан, сав л хийвэл үл бүтэх хүмүүстэй нийлж янз бүрийн хэрэг түвэгт орооцолдож тэнсэн ял авч байсан, тэр ч байтугай “төв ази” банкаар үе үе ирж ямар нэгэн юм судлаад байсан зэрэг нь цагдаагийнхны аихаарлыг татсан байна. Тиймээс түүнийг баривчлан хорьж байцаасан бөгөөд тэрбээр мөрдөнд хоёр ч хонолгүй хам хэрэгтэн Түмэннастыгаа илчилжээ. Тэгээд цагдаагийнхан Түмэннастын эрэлд гарч сар гаруй цөхрөлтгүй хайсны эцэст түүнийг зуун айлаас баривчилсан байна. Түмэннаст мөрдөн байцаалтын явцад өөрийн үйлдсэн жигшүүрт хэргээ хүлээснээс гадна “энэ хэргийг гол зохион байгуулсан хүн нь Баярмандах” гэж мэдүүлжээ. Тэр ч байтугай Баярмандахын эхнэр Оюунцэцэг, Түмэннастын эхнэр Ганчимэг нар мань хоёрыг банкны харуулыг алж мөнгө дээрэмдэх гэж байгааг мэдсэн байгаа юм. Тэд мэдээд зогсохгүй ‘та хоёр хурууныхаа мөрийг үлдээж хэрхэвч болохгүй шүү. Тэгвэл та хоёр балрахаас гадна бид ч бас балрана. Юуны чинь гадаад руу гарах, шоронгийн тав болно гэсэн үг. Тэгэхээр та хоёр бидний үгэнд ороод энэ бээлийг өмс’ гэх ухааны юм ярьж мань хоёрт дэлгүүрээс таван хурууны бээлий авч өгсөн байгаа юм. Мань хоёр тооцооны кассыг хаахаас өмнө шатны доод хонгилыы юм хадгалдаг жижиг өрөө цоожгүй байхаар нь дотор нь орж нуугдсан байна. Энэ өрөөг цоожгүй байлгахыг хоёр эхнэр нь хариуцсан юмсанж. Тэгээд мань хоёр ажил тарахыг хүлээсэн байна. Төдөлгүй ажил тарж бүх хүмүүс уван цуван гарч явсаар чимээ тасрахад хоёр алуурчин эхнэрүүдийнхээ авч өгсөн бээлийг өмсөөд мөнөөх жижиг өрөөнөөс сэмээрхэн гарчээ. Энэ үед банкны харуул сандал дээр буруу хараад телевизор үзэж суусан бөгөөд мань хоёр араас нь сэмээрхэн очоод нэг нь амыг нь дарахад нөгөө нь нуруу руу нь хэд хэд хутгалж амь насыг нь хороосон байна.

Тэгээд мөнгө хадгалсан төмөр сейфтэй гучаад минут ноцолдсон байна. Барьцаат үйлчилгээнээс авсан тэдний эд зүйлсийг хоёр эхнэр нь зах дээр хамт заралцсан байгаа юм. Ингээд бодоход зах зээлд орсноос хойш манай зарим эмэгтэйчүүдийн хүн чанар, нинжин сэтгэл үнэхээр муудсан гэлтэй. Хүн алж, банк дээрэмдэх гэж байгаа нөхрүүдээ хорьж болиулахын оронд харин ч бүр үг зааж өгч, ул мөрийг нь арилгах талаар санаа тавьж байдаг Оюунцэцэг, Ганчимэг нар ч ёстой дүүрчихсэн улс юмаа.

## «Элсний 13» гэгч хулгай, дээрмийн бүлэглэлд

### Боорой оролцож явсан

Өмнөговийн «хар» Боорой гэхэд Дундговь, өмнөговь аймгийн хэдэн сумдынхан андахгүй. Тэрбээр анх танхайн хэргээр 22 настайдаа шоронд орж нийтдээ арав гаруй жил ял эдэлжээ. 1970-80 оны үед өмнөговь аймгийн төв Даланзадгад хотод Боорой шиг хүчтэй эр ховор байсан бөгөөд тус аймаг даяар зард гарсан «элсний 13» гэгч хулгай, дээрмийн бүлэглэлд Боорой бас оролцож байсан гэдэг. Ер нь Бооройг шоронд илгээх сонирхолтой хүмүүс өмнөговь аймагт маш олон байсан байна. Цагдаа нар нь хүртэл янз бүрийн жижиг шалтгаанаар сав л хийвэл баривчлах гээд байдаг байж. Нэгэн удаа Боорой цэргээс ирсэн бандид хутгалуулчихаад Даланзадгадын төв гудамжаар цусаа гоожуулаад алхаж явтал цагдаа нар хутгалсан хүнийг нь бус Бооройг баривчлаад аймгийн мөрдөнд хийчихжээ. Гэтэл угийн атаман зантай, бас тэгээд хор шартай, хүч тэнхээтэй Боорой улангассан бух шиг улайран мөрдөнгийн төмөр хаалгыг хэмх өшиглөөд гарч одсон байна. Түүний атаман зан сүүлдээ дийлдэхээ байгаад хүн хутгалсан хэргээр хэдэн жилийн турш шоронд ял эдэлж олон арван хүний сэтгэлийг амраажээ. Боорой өмнөговиор тогтохгүй Дундговийн урд талын сумдынхныг ч бас дарамталж, айлын гаднаас дуртай морио унаад явчихдаг байж. Тэрбээр 1980-аад оны сүүлчээр шоронгоос суллагдаад овоо хүн шиг амьдрахаар тус аймгийн Цагаан-Овоо суманд очиж мал маллахаар шийджээ. Тэгээд авгай авч эхний ганц жил давгүй амьдарч байж. Гэвч түүний атаман зан бас л цухалзаж саахалт айлынхаа Батжаргал гэдэг залууг байнга дарамтлах болжээ. Учир нь Бооройгийн суусан авгайтай Батжаргал урьд өмнө нь сууж байсан бөгөөд нэг ёсондоо хардалтаас болж түүнийг ингэхэд хүрсэн байна. Нэгэн удаа Боорой Батжаргалын ботготой ингийг дээрэмдэх шахуу өөртөө авчээ. Ингээд зогсохгүй түүгээр малаа услуулах, хашаа хороогоо цэвэрлүүлэх гэх мэтийн есөн жорын ажлаа хийлгэж бараг л өөрийнхөө боол болгожээ. Ганц Батжаргал ч бус ойр хавийн өөр бусад хүмүүс Бооройгоос үхтлээ айдаг байсан бөгөөд «хар боорой ирж байна» гэж хүүхдүүд гадаа хашгирахад гэрт даалуу тоглож байсан эрчүүд даалуугаа хамаад тал тал тийшээ бутран оддог байж. Учир нь Боорой тэдэнтэй даалуу тоглоод хожигдсон ч мөнгөө өгөхгүйгээр үл барам архины мөнгө нэхэж шаналгах, аатай нэгнийг нь зодох гэх мэтээр зүйл бүрээр дарамтална. Гэвч иймэрхүү араншинтай хүн нутаг орондоо нэг их удаан тогтдоггүй. Батжаргал түүнд байнга өс санаж явсаар цагаан сараар түүнтэй золгохоор гэрт нь очтол Боорой шал согтуу, эхнэр нь худаг дээр малаа усалж байж. Гэтэл Батжаргал шууд Бооройгийн хүзүү рүү хутгалж, улмаар толгойг нь аман хүзүү, хатан хүзүү хоёрын дундуур нь зааж салгаад гэр дээр нь тавьчихаад яваад өгчээ. Бооройгийн эхнэр малаа усалчихаад иртэл нөхрийнх нь толгой гэр дээрээ байж байтал хирдхийн цочиж эгээтэй л ухаан алдаж унасангүй. Байнга хүн дарамталдаг шазруун эр Бооройг ийнхүү алуулсанд нутаг нугынхан нь үнэхээр баярласан гэдэг. Харин хэрцгий аллага үйлдсэн Батжаргал уг хэрэгтээ 25 жилийн ял авсан бөгөөд нутгийн ардууд түүнийг сайн өмгөөлсний хүчинд цаазаар авахуулаагүй бололтой. Ер нь Боорой мэтийн эрчүүд дээхэн үед 18 аймагт мэр сэр байсан бөгөөд Увсын атаман Төрсайхан, «хилэгнүүр» Володя, Архангайн Хайрхан сумын атаман Хүдэр, Дундговийн атаман «нацист» Болдоо, Дорнодын атаман Чулуунбаатар, Хэнтийн атаман «нохой» Сэвдэн, Сэлэнгийн атаман «Яргачин» Цоодол, өвөрхангайн атаман Бэгзжав нар бүгд л бусдыг дарамталж байгаад алуулсан билээ.

## Гурван удаа буудуулсан эрийн гунигт хувь заяа

Гурван удаа буудуулж, хорь гаруй жил ял эдэлсэн «татанхай» Давгадорж эдүгээ туйлын хүнд амьдарч байна. Түүнд орох орон байхгүй, хань ижил, үр хүүхэдгүй, харж хандах хамаатан садангүй болохоор урьд өмнө шоронд хамт ял эдэлж байсан найз нөхдөө бараадан найрка ууж, хаа тааралдсан газраа хоноглож явдаг бололтой. Давгадорж анх хулгайн хэргээр шоронд оржээ. Эхэндээ тэр цагаан цайлган сэтгэлтэй, хэн нэгний үгэнд оромтгой хүн байж. Гэвч шорон түүний ааш авирыг эвдэж орхисноос хулгай хийхээс гадна дээрэм тонуул хийдэг болжээ. Тэгээд дахин давтан хэргээр Мааньтын чанга руу илгээгдсэн байна. Чанга дэглэмтэй шоронд анх удаа очиж байгаа хүн эхэндээ нэлээд зовлон туулдаг аж. Харин овгор товгор гэсэн сэтэр зүүчихсэн, ийм хэмжээнд очих чадвартай хүмүүс бол нэг хэсэгтээ тэсээд гарна. Давгадоржийн хувьд ийм юм байхгүй тул шууд л барлаг болсон байна. Амарцогт гэгч атаман хоригдол түүнийг барлагаараа авч хөл гараа угаалгахаас эхлээд бөгсөө хүртэл арчуулсан байгаа юм. Давгадорж энэ бүхнийг тэсвэрлэж чадалгүй Мааньтын чангаас оргохоор сэтгэл шулууджээ. Тэгээд нэг орой шууд л өндөр хэрмэн хашаа өөд ухаан жолоогүй авирч орой дээр нь гарсан ч дээгүүр нь гүйлгэсэн төмөр утсан торонд өмд нь орооцолдчихжээ. Өөрийгөө торноос салгаж авах гэж амь наана, там цаана тэмцэлдэж байтал буун дуу тас хийх нь тэр. Тухайн үед Давгадорж юу ч мэдэрсэнгүй. Арай гэж торноос салаад цаад руу нь үсрэн буугаад ганц хоёр алхтал гуаыг нь дагаад ямар нэгэн шингэн юм урсах шиг болж. Тэмтрээд үзтэл цус. Түүний оргох гэсэн анхны оролдлого ингээд бүтэлгүйтлээ. Баруун талынхаа хонго руу буудуулсан Давгадорж шоронгийн эмнэлэгт хүргэгджээ. Аз болж харин амин газар нь сум таарсангүй. Тэрбээр удаан хугацаагаар эмнэлэгт хэвтэж эдгэрээд өмнөх ял дээрээ ял нэмүүлээд Хар-Айрагийн онцгой руу ачигджээ. Энд харин хэдэн жил яс ажилласан байгаа юм. Ажлын хоног ч нэлээдийг авчээ. Бас хэнд ч дээрэлхүүлэхгүй овоо нэр хүндтэй болсон нь тухайн үед тус шоронгийн хоригдлуудыш зөвлөлийн дарга асан «шулга» Сандагийн ач гавьяа юмсанж. Учир нь тэрбээр 1970-аад оны үед «Тулга» Сандагтай хамтарч халаас суйлдаг байж л даа. Давгадорж төдөлгүй шоронгоос суллагдаж нэг хэсэг овоо хүн шиг амьдарчээ. Тэгтэл хоёр гурван жилийн дараа «шулга» Сандаг нь бас шоронгоос суллагдаж мань хоёр хулгай, дээрмийг нэг хэсэг хойш тавиад байнга архидах болж. Ингэж явахдаа хороо хорины хараанд орж ерөөгийн архичин согтуучуудын арми руу илгээгдсэн байна. Мань хоёрын хэн хэн нь шоронгийн диктатурын дор хүмүүжсэн болохоор ерөөгийн албадан тэдэнд дэндүү зөөлөн санагдаж өөрсдийнхөө эрхээр туйлах болжээ. Тэгээд нэг өдөр мань хоёр хот ормоор санагдсан тул Дарханы нэг машинд суугаад шууд хөдөлжээ. Гэтэл хойноос нь ерөөгийн цагдаа нар нэхэн хөөж Дарханы машиныг замд нь саатуулаад мань хоёрыг баривчилжээ. Цааш явах замдаа мань хоёр ихээхэн эвгүй зан гаргасан тул цагдаа нар хэн хэнийх нь хөл рүү буудсан байна. Сандагийн зөвхөн хөлийн хоёр хуруу буудуулж, харин Давгадорж шилбэ рүүгээ буудуулсан тул нэлээд хүндэрч Сэлэнгийн эмнэлэгт хүргэгджээ. Ийнхүү хоёр дахь удаагаа буудуулсан Давгадорж сүүлдээ бүр догширч буунаас ер айхаа больсон гэдэг. Тэрбээр үхсэн хойноо буудуулах ер нь юу юм бэ. Би хоёр удаа буудуулчихаад амьд л явж байна. Дайн болох юм бол над шиг зоригтой хүн олдохгүй. Эцсийн эцэст буудуулна гэдэг чинь зүгээр л нэг чавхаар харвуулахтай адилхан юм» гэж томордог болжээ. Тэрбээр Ерөөгийн албаданд хоёр жил шахам болоод хотод ирсэн боловч дахиад л гэмт хэрэгт орооцолдож дасал болсон Мааньтын чанга руугаа ачигджээ. Энэ үед тэрбээр нэлээд догширсон, бас ч гэж шорондоо овоо нэр хүндтэй болсон тул «шулга» Сандагийн нөмөр нөөлгө түүнд хэрэггүй болсон байв.



Тэрбээр Мааньтын чангад очоод бригадын дарга болж хоригдлуудыг ёстой умалзуулдаг байж. Тэгээд сайн ажиллаж дэглэм буураад сантын мал баазад очжээ. Энд хойшоо гаргах гэж буй агтны адууг галт тэрэг рүү шахаж өгдөг ажилтай болж. Ингэж байхдаа нутгийн ардуудын тарган адууг туранхай адуугаар сольж өгч нэг хэсэг манаргажээ. Тэр ч байтугай бүдүүн морины оронд хариугүй туранхай шүдлэн үрээг хэд хэдэн удаа чихэж, сүүлдээ бүр асуудалд орсон байна. Учир нь Оросын талаас гомдол мэдүүлсэн хэрэг. Тэгээд асар их найраатай энэхүү ажлаасаа хусагдаж уурын зууханд галч болжээ. Энд байхдаа тэр гурав дахь удаагаа буудуулсан байна. Бас л нутгийн ардуудад нүүрс гаргаж өгч байнга архидах болсон бөгөөд нэгэн архичин эртэй муудалцсанаар тайрсан кадибраар мөр рүүгээ буудуулж эгээтэй л үхсэнгүй. «Буудуулна гэдэг чавхаар харвуулахтай адилхан» гэж томорч байсан энэ эр их хэмжээний цус алдаад үхэнгээ алдаад ирүүт л бүхнийг ойлгожээ. Тэр цагаас хойш тэрбээр «за одоо ер нь буутай хүнээс л хол явж байя. Тэнэсэн сум хүн алдаг юм байна. Эхний хоёр буудуулалт маань намайг зүгээр л шүргээд өнгөрсөн. Сүүлдээ энэ сум чинь аягүй хорлонтой тусдаг боллоо. Дараагийн удаад бол тархийг минь зад буудах юм байна» гэж аргагүй л буулт хийжээ. Эдүгээ тэр олон удаа буудуулсан болоод ч тэр үү, татанхай болсон бөгөөд нэг юм яриад л мөр нь татгасхийдэг, өвлийн хүйтэнд даарснаас болж буудуулсан газар нь өвчин орж хөндүүрлэдэг, энэ зовлонгоос ангижрахын тулд найрка ууж ухаанаа алддаг, ийм л нэг зовлонтой хүн хэзээ үхэх нь мэдэгдэхгүй тарчилж явна. Саяхан тэрбээр «миний үхэх цаг улам л ойртоод байх шиг байна. «шулга» Сандаг маань надаас түрүүлээд явчихлаа. Хамт архиддаг байсан Цэвээний «хар» Лахмсүрэн, «бүлтүүш» Базарсад, Данигайн Дэмбэрэл, «төлөөн» Цэрэндондог гээд «алтан үеийн» хамаг л сайхан хулгарууд бүгд талийж одлоо. Гэтэл гурав буудуулсан би ерөөсөө үхэж өгөхгүй юм. Эсвэл би ер нь буудуулж үхэх тавилантай юм болов уу. Тэгвэл ч одооны сум яг л тархинд тусах байх» гэж сэрэмжилсэн янзтай өгүүлсэн юм.

## **Шоронгоос суллагдсан хүмүүс хулгай зэлгий хийлгүй амиа аргалах боломж зөндөө байна**

Нийслэлийн зургаан дүүргийн аль ч хүнсний зах дээр хаягдал хүнсний ногоо түүж зардаг хүмүүс байдаг. Тэдний зарим нь машин дээрээс ногоо буулгаж өгөх, лангуу руу дөхүүлж өгөх зэргээр худалдагч нараас хэд гурван төмс, ганц хоёр сонгино гуйж авдаг аж. Мөн машин доогуур унасан төмс, сонгиныг гялгар уутанд түүж цуглуулна. Зарим нэг явуургүй этгээд шууд л хулгай хийнэ. Тэгээд жижиг хэмжээний гялгар уутанд төмс, сонгино, манжин, лууван зэргээр «набор» хийж дөрөв таван зуун төгрөгөөр зараад найрка аваад уучих жишээтэй. Тэрхүү «набор» нь хямд болохоор ядмаг хүмүүс авах нь их байдаг бөгөөд хаягдал хүнсний ногоо түүж зардаг хүмүүсийн өдрийн орлого дор хаяад 3000 төгрөг байдаг аж. Өнгөрсөн жил шоронгоос суллагдсан «Баацгар» Төмөрөө, «наримаан» Сүхбат гэгч хоёр гал хам хэн хэндээ «хоёулаа алийн болгон хулгайгаар амьдрах юм бэ. Дахиж хэзээ ч хулгай хийж шоронгийн хаалга татахгүй» гэж андгай тавиад ажил хайж эхэлжээ. Гэвч ямар ч мэргэжил боловсролгүй мань хоёрт боломжийн ажил олдсонгүй. Гэхдээ л хэн хэн нь өөрсдийгөө болгоод байх «хөөрхөн» ажил олчихож байгаа юм. «баацгар» Төмөрөө нь дээр өгүүлсэн хаягдал хүнсний ногоо түүж зарахаар шийдсэн бол «наримаан» Сүхбат нь энд тэндхийн очер дараалалд зогсч хүмүүсээс мөнгө тоншдог ажил олжээ. Тухайлбал сарын сүүлчээр гэрлийн мөнгөө тушаах гэсэн хүмүүс кассанд бөөн бөөнөөрөө оочерлож махаа иддэг. үүнийг Сүхбат мэдчихээд хар өглөөгүүр оочерт зогсч, сүүл хавьцаа яарч сандран зогсч байгаа хоёр гурван хүнийг өөрийнхөө оронд шургуулаад тус бүрээс нь мянган төгрөг тоншчихдог аж. Түүнийг дэнжийн мянгынхан андахаа байсан бөгөөд гэрлийнхээ мөнгийг тушаах гээд яарч сандарсан хүмүүс «нөгөө нармиан нөхөрт мянган төгрөг атгуулчихъя» гэж ярих нь их болжээ. Энэ нь нэг төрлийн бизнес болчихож. Мөн тэр заримдаа энд тэндхийн элчин сайдын яамны үүдэнд очиж визэнд оочерлодог бөгөөд виз авах гээд яарч сандарсан баячууд түүнд дор хаяад гурван мянган төгрөг хаядаг юмсанж. Тиймээс энд тэндэхийн элчингийн үүдэнд нармийсан шар нөхөр оочерлоод зогсч байвал Сүхбатыг гэж ойлгох хэрэгтэй. үүнийг ажил гэж хэлэхэд хэцүү, бизнес гэж хэлэхэд хэцүү. Гэхдээ хэн нэгний хэрэгцээг хангаж байгаа болохоор бизнес л юм даа. Шоронгоос суллагдсан, мэргэжил боловсролгүй хүмүүс хулгай, дээрэм хийж голоо зогоох нь их байдаг. Харин Төмөрөө, Сүхбат хоёр шиг хулгай зэлгий хийлгүй хэдэн төгрөг олж өөрсдийгөө аргалаад байх боломж зөндөө байна.

# Table of Contents

<a href="#">Соц нийгмийн үед мардай руу нэвтэрч чадсан ахмад хуульчийн яриа</a>	
<a href="#">Чойрогийн Дүгэрээ болбоос туйлын өрөвдөлтэй бие хүн бөлгөө</a>	
<a href="#">Соц нийгмийн үеийн шоронгийн цуутай дарга нар</a>	
<a href="#">Атамануудын тэмцлээс болж Авдрантын шорон татан буугдсан уу?</a>	
<a href="#">Орчин үеийн «Уулын» Төмөр 24 жилийн ял авсан</a>	
<a href="#">«Ганц худаг»-ийн мөрдөнд байгаа сэжигтнүүд камерийнхаа хогийг шүүрдэх гэж зүтгэдэг болжээ</a>	
<a href="#">Заргын цагаан солиотой Галсангийн Баянсан халхын шоронд дүүрэн жаргалтай амьдарч байна</a>	
<a href="#">Шоронд хар перец зарж баяжсан Б.Цэгээн хурандаа Санжаасүрэнг хүндэлдэг</a>	
<a href="#">Олон жил орон шоронгоор явсан хүн байнга цагдаагийн хараанд байдаг</a>	
<a href="#">Сайхан эр хүн муухай гаж зуршилтай болох шиг хөгийн юм байхгүй</a>	
<a href="#">Хүн худалдаалах гэмт хэрэг Монголд 15-р зуунаас эхэлсэн</a>	
<a href="#">Эвдэрхий аппаратаар тавин хүн залилсан Э.Зуунайгийн ээдрээт амьдрал</a>	
<a href="#">Шорон дотроос тодорсон өшөө авагч</a>	
<a href="#">Хянагч Баагий члтануудад эхнэр, охин хоёрынхоо биеийг үнэлүүлж байгаад азаартжээ</a>	
<a href="#">Мал адгуустай хурьцал үйлддэг хүмүүс төрсөн охиноо хүчиндэхэд хэзээд бэлэн байдаг</a>	
<a href="#">Уйдаж цөхөрсөн ялтанууд өширхөж хорссон хянагч нараа юу гэж доромжилдо вэ?</a>	
<a href="#">Г.Намжаа: Би шоронд 15 жил болсоноо аз гэж боддог</a>	
<a href="#">«Онгорхой» Барамсай Мааньтын чангад үнэхээр амьтан болжээ</a>	
<a href="#">Дулааны Балдансамбуугийн элэг задарч амьсгал хураажээ</a>	
<a href="#">Шоронд шуугиулж явсан Тогоогийн Отгон гэж хэн бэ?</a>	
<a href="#">1979 онд Зүүнхараагийн шоронд болсон хачин явдал</a>	
<a href="#">Шоронгуудад хувьчлагдсан хоригдол гэж байдаг</a>	
<a href="#">Нутаг орондоо дархлагдсан «Шармиан»</a>	
<a href="#">Тувагийн дээрэмчин Мичид-Оол Улиастайн шоронд гунигтайгаар амьсгал хураажээ</a>	
<a href="#">Хулгайч, хуяг хоёр нь боловсрол, хүмүүжлээрээ нэг болчихсон «Ганц худаг»-ийн мөрдөн өрөвдмөөр</a>	
<a href="#">Халхын шоронгийн «Том ах» Доржийн Цээхүү гэгч хэн бэ?</a>	
<a href="#">«Доргио» Ганбаа гэгч хянагчийг ээлжинд гарахад</a>	
<a href="#">Гандангийн агаман Сэрээтэрийн Сэлэнгэ</a>	
<a href="#">Оросын шоронгуудад захиалгат</a>	
<a href="#">«Ганц худаг»-ийн мөрдөн эд баялаг, эрх</a>	
<a href="#">Д.Чимэдлхам: «Нялга» Жумдаан гэгч хүний</a>	
<a href="#">Хоёр хулгайчийн бэлэг эрхтэн гэмтээснээ би нүгэл гэж боддоггүй</a>	
<a href="#">«Шилэн» Дамдингийн төрсөн хүүхэд халхын шоронд ял эдэлж байна гэв үү? 116</a>	
<a href="#">Пунсалмаа гэгч залхуу хүүхэн гэрийнхээ унийг түлж дуусгаад байна</a>	
<a href="#">Самар цайруулах машинаас болсон хүн амины хэрэг</a>	
<a href="#">Арав гаруй жил ял эдэлсэн Хятадын эрлийз</a>	
<a href="#">Төлгөн хурга нядлах хорлонтой ажилд</a>	
<a href="#">Залилангийн хэргээр долоон жил ял эдэлсэн</a>	

Орос, Монгол, Хятад гурав Москва, Улаанбаатар,  
Гүнсэлмаагийн нүдэнд бөөн доллар харагдаад болж өгсөнгүй  
Арын хаалга, танил талаар дулдуйдсан хүн амины хэрэгтнүүдийг цусан өшөө гэгч юм  
залхаан цээрлүүлдэг  
Хэрцгий зангаасаа боаж яг л хонь шиг төхөөрүүлжээ  
Тувагийн зэвсэгт дээрэмчидийн цуутай толгойлогч айдас монголын хил дээр ясаа тавьжээ  
Мафийн гишүүд сахил хүртэхдээ үнэнч явахаа цусаараа андгайлж,  
Ламаахүүгийн Мөнхбат гэгч гаж донтон ахынхаа нэгэн адил хоёр эмэгтэйн амийг маш  
зэрлэгээр хөнөөжээ  
Эрэн сурвалжлагдаж буй террорист алан хядагчдын нэрсийн жагсаалтын 69-рт Монгол хүний  
нэр бичигджээ  
Бэлгийн гаж донтны шоронгоос бичсэн захидал  
Гарамгай баатар Л.Дандар цаазын ялтай байхдаа  
Тууварчдын ангууч эрийн нүгэл нүдээрээ гарч төрсөн хүүгээ хөнөөсөн түүх  
Оргодол эрийн паян  
Шоронгийн дуу дуулсанаас болж нүсэр зодоон болжээ  
Дээрэмчин Цогбадрах хамаг буруугаа хар амиа хичээсэн ард иргэд рүү чихжээ  
«Ганц»-ийн шоронгийн загалмайлсан эцэг болох Батгүн шоронгийн тухай тэмдэглэл  
Д.Цэрэнбалжид: би ханилсан ханиа төрсөн хүү нь алчихаад  
Хүн алж, банк дээрэмдэх гэж байгаа нөхрүүддээ үг зааж өгч,  
«Элсний 13» гэгч хулгай, дээрмийн бүлэглэлд Боорой оролцож явсан  
Гурван удаа буудуулсан эрийн гунигт хувь заяа  
Шоронгоос суллагдсан хүмүүс хулгай зэлгий хийлгүй амиа аргалах боломж зөндөө байна